

ХУУЛЬ САХИУЛАХЫН ИХ СУРГУУЛЬ



ГЭМТ ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХ АСУУДАЛ

ОНОЛ, АРГА ЗҮЙН УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛ

**2016 №4 (58)
14 дэх жилдээ**

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

ЭРХЛЭГЧ

Д.ЗҮМБЭРЭЛЛХАМ
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

Б.БАТ-ЭРДЭНЭ
МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ШҮҮГЧ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Б.БАТЗОРИГ
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА, ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Б.БОЛДБААТАР
МОНГОЛЫН КРИМИНОЛОГИЧДЫН ХОЛБООНЫ ГҮЙЦЭТГЭХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Н.ГАНБАДРАЛ
ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ОЛОН НИЙТ-ЦАГДААГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТӨВИЙН ДАРГА, ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Ж.ДОЛГОРСҮРЭН
ДОКТОР (Sc.D), ПРОФЕССОР

Н.ЖАНЦАН
МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

А.ЛХАГВА
МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Г.ЭРДЭНЭБАТ
УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ОРЛОГЧ, ТӨРИЙН ХУУЛЬ ЦААЗЫН ШАДАР ЗӨВЛӨХ

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

С.ГАНТУЛГА
ХУУЛЬ САХИУЛАХЫН ИХ СУРГУУЛИЙН ХЭВЛЭЛ, РЕДАКЦИЙН ХЭЛТСИЙН ДАРГА, ДОКТОР (Ph.D)

Б.ЭНХБОЛД
ХУУЛЬ САХИУЛАХЫН ИХ СУРГУУЛИЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН ЦАГДАА СУДЛАЛЫН ТӨВИЙН ЭРХЛЭГЧ, ДОКТОР (Ph.D)

ДУГААРЫГ ЭРХЛЭН ГАРГАСАН:

С.ГАНТУЛГА
ДОКТОР (Ph.D)

Гарчиг.....

ГЭМТ ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХ ТӨРИЙН БОДЛОГО

- Багануур дүүргийн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөл” криминологийн судалгааны тайлан-зөвлөмж

КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

- Зам тээврийн осол ба авто замын нөхцөл байдал анхаарах зарим асуудал.....Б.Эрдэнэхуяг
- Цагдаагийн алба хаагчийг авлигад өртөхөөс урьдчилан сэргийлэх зарим асуудал.....А.Энх-Амгалан
- Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх курсын сургалтын эрх зүйн орчинд хийх дүн шинжилгээ.....Б.Энхболд

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

- Эрүүгийн эрх зүй дэх хууль зүйн факт, түүний мөн чанар, ангилал, төрөл.....Г.Гантөмөр, Г.Лхагвамаа
- Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах, саатуулах үед гэм хор учруулах үйлдлийг гадаадын зарим орнуудын эрүүгийн хуульд хуульчилсан байдал..... Г.Гантөмөр, Л.Бат-Очир
- Превышение пределов необходимой обороны в разъяснениях пленумов верховного суда ссср и Российской Федераций..... Тараканов И.А
- 2015 оны эрүүгийн хууль /шинэчлэн найруулга/ дахь өсвөр насны хүнд ял оногдуулах асуудал.....Г.Ганчимэг

КРИМИНАЛИСТИКИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

- ДНХ-ийн мэдээлийн сан, түүнийг шүүхийн шинжилгээнд хэрэглэх нь.....С.Ганболд, Ж.Оюунаа, Ш.Пүрэвдулам

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

- Цагдаагийн байгууллага, албан хаагчийн эрх зүйн зохицуулалтыг сайжруулах зарим асуудал..... Л.Нямдаваа
- Цагдаагийн байгууллагын хөгжлийн стратеги, түүний хэрэгжилтийг хангах арга зам.....Ц.Баасанхорол

ТӨР, ЗАХИРГАА, ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

- Пределы независимости судей.....Б.Улзийсайхан
- Влияние учения Конфуция на философию права..... Балданцэрэн Амгалан
- Манж Чин Улсын үеийн Монгол орон дахь хууль тогтоолын онцлог.....Б.Жаргалсайхан
- Монгол Улсын Иргэний хуулийн 499 дүгээр зүйлийн зүйлчлэл, онол, практикийн асуудал.....Э.Чулуунцэцэг
- Хоршооны тухай ойлголт, түүний үүсэл хөгжил.....Ц.Мөнхдэлгэр

ГЭМТ ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХ ТӨРИЙН БОДЛОГО

БАГАНУУР ДҮҮРГИЙН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН ШАЛТГААН НӨХЦӨЛ”

КРИМИНОЛОГИЙН СУДАЛГАА

Хууль сахиулахын их сургуулийн Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэнгийн Цагдаа судлалын төв, “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх Монголын сан” төрийн бус байгууллага хамтран Багануур дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Цагдаагийн хэлтсийн захиалгаар “Багануур дүүргийн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөл” криминологийн судалгааг 2016 оны 05-11 дүгээр сард хийсэн байна.

Судалгааг хийхдээ Багануур дүүрэг дэх гэмт хэргийн нөхцөл байдал, түүний шалтгаан нөхцөл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж ирсэн байдал, орон нутгийн аюулгүй байдал болон цагдаад итгэх олон нийтийн хандлага гэсэн хэд хэдэн асуудалд анхаарал хандуулж, судалгааны арга зүйн орчин үеийн аргачлалаар дүн шинжилгээ хийсэн нь бусад дүүрэг, аймгуудад жишиг болохуйц шинэлэг ажил болжээ. Судалгааны үр дүнд үндэслэн дүүргийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх зөвлөмжийг хүргүүлжээ.

ЗӨВЛӨМЖ

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах эзэн
	Нэг. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр:		
1.	Багануур дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн, энэ ажлыг хариуцах орон тооны ажилтан бий болгож, дүүргийн хэмжээнд урьдчилан сэргийлэх ажлыг нэгтгэн зохион байгуулж, үйл ажиллагааг идэвхжүүлэх	2016-2017 оны I улирал	Багануур дүүргийн ИТХ-ын Ажлын алба
2.	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийнхэрэгжилтийг бодитой, үр дүнтэй хэлбэрээр өргөн хүрээнд хууль сахиулах, прокурор, шүүх болон төрийн захиргааны байгууллага, хороодын засаг дарга, аж ахуйн нэгж, иргэдийн тэгш оролцоотойгоор зохион байгуулж ажиллах	Тогтмол	Багануур дүүргийн ГХУСАЗСЗ
3.	Эдийн засаг, нийгмийн 2017 оны зорилтод гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар дүүргийн хэмжээнд бүх төрийн байгууллагын үүрэг оролцоог нарийвчлан тодорхойлж оруулах, шүүх, цагдаа, прокурор, цагдаагийн хэлтэс, хороод, мэргэжлийн хяналт, худалдаа үйлдвэрлэл үйлчилгээний хэлтэс, боловсрол, соёлын байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллага г.м.	Тогтмол	Багануур дүүргийн ГХУСАЗСЗ
4.	Нийслэлийн харьяа шүүх, прокурор, хуулийн байгууллагуудын харилцан хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах	Тогтмол	Багануур дүүргийн ГХУСАЗСЗ
5.	ХЗДХЯ-ны дэргэдэх Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Нийслэлийн салбар зөвлөл, бусад аймаг, дүүргийн зохицуулах зөвлөлтэй хамтын ажиллагааг өргөжүүлж, ажиллах	2017 оноос	Багануур дүүргийн ГХУСАЗСЗ
6.	“Нийслэл хотын телекамерын хяналтын техник, технологийн өнөөгийн байдлыг эрс шинэчилж, найдвартай байдлыг хангах, шинээр гудамж, талбай, объектуудыг телекамерын хяналтад оруулж, нийслэл хотоо бүрэн камерын хяналтын системд оруулах зорилгоор Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлөөс “Аюулгүй хот” төслийг удахгүй	2017	Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газар, ГХУСАЗСЗ

	<p>боловсруулан батлуулж, хэрэгжилтийг үе шаттайгаар зохион байгуулна, үүнд зарцуулах хөрөнгийн асуудлыг шийдвэрлэнэ”¹ гэсний дагуу “Аюулгүй Багануур хот” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллах,</p> <p>- Нэг хороог сонгон авч, “Аюулгүй Баянбүрд”-ийг бодлого болгон хэрэгжүүлэх</p>		
7.	<p>“Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор нийтийн эзэмшлийн гудамж талбай, гэр хорооллыг телекамерын системд хамруулж, гэрэлтүүлгийг сайжруулна” гэж төлөвлөсөн ажлын хүрээнд Улаанбаатар хотын Цагдаагийн газраас 2017 он гарангуут хэрэгжүүлэх “Телекамер”, “Эргүүл” хөтөлбөрийг дүүргийн хэмжээнд үр дүнтэй хэрэгжүүлэх бэлтгэлийг хангах, үүнд шаардлагатай хөрөнгө мөнгийг төсөвлөж, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлэх</p> <p>- Нийслэлээс гаргасан эрүүл, аюулгүй байдлын индексийн үзүүлэлтэд хувь хүний аюулгүй байдлыг хангах чиглэлээрх үзүүлэлтүүд доогуур байгаа тул үүнийг нэмэгдүүлэх ажлыг бодлого болгон хэрэгжүүлэх</p>		
8.	<p>ЦЕГ-ын хэмжээнд туршигдаж буй crime mapping болон Улаанбаатар хотын цагдаагийн газраас хэрэгжүүлэх гэж буй гэмт хэргийн хяналтын цогц системийг Багануур дүүргийн Цагдаагийн хэлтэст нэвтрүүлэх бэлтгэлийг хангаж, мэргэшсэн алба хаагчийг ажиллуулах, холбогдох төсөв хөрөнгийг асуудлыг шийдвэрлүүлэх</p> <p>- Телекамерын системд нэвтрүүлэх ажилтай хамтатган гэмт хэргийг цахим зурагжуулах систем (Crime mapping system)-ийг нэвтрүүлэх</p>	2017 оноос	Багануур дүүргийн ГХУСАЗСЗ, Цагдаагийн хэлтэс
9.	<p>Камержуулах, цахим зурагжуулах хөтөлбөр хэрэгжүүлэх. “Байгууллага, аж ахуйн нэгжийг камержуулах тухай” Дүүргийн Засаг даргын захирамж гаргуулах. Тухайлбал, Хэсгийн байцаагч нар хариуцсан хороонд байрлах хүн ам олноор төвлөрсөн зах, худалдааны төв, банк санхүүгийн болон бусад аж ахуйн нэгж байгууллагын судалгааг гаргаж, түүнээс камер тавигдаагүй аж ахуйн нэгж байгууллагын судалгааг гарган захирамжийг хэрэгжүүлэх чиглэлээр захирамж, албан мэдэгдлийг 2017 оны эхнээс хэрэгжүүлэх, ач холбогдлыг таниулах сурталчлагааг тараан өгч, үр дүнг тооцох, энэ ажлын хүрээнд цаашид камержуулах ажлыг үргэлжлүүлэн хөгжүүлсэнээр иргэдийн өмчийн эсрэг гэмт хэрэг бууруулах</p>	2017	Багануур дүүргийн ЗДТГ, ГХУСАЗСЗ
10.	<p>ГХУСТХ, Цагдаагийн албаны тухай хууль болон бусад хуульд заасан төрийн албан байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг нэгтгэж уялдуулж өгөх, ГХУСТХ-д иргэн байгууллага, аж ахуй нэгжүүд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар хүлээх үүргийг заасан тул үүний дагуу арга хэмжээ авах, шаардлага хүргүүлдэг механизмтэй байх</p>	Тогтмол	Багануур дүүргийн ГХУСАЗСЗ
11.	<p>“Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагаа” хөтөлбөрийг хэрэгжүүлэх, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг иргэд, олон нийтэд сурталчлах, иргэд, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг эрчимжүүлэх ажлын төлөвлөгөөг гарган дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 96 аж ахуйн нэгж,</p>	Тогтмол	Багануур дүүргийн ГХУСАЗСЗ

¹ <http://ulaanbaatar.mn/content/show/18112>

	байгууллагатай түншлэлийн гэрээ байгуулж "Гэмт хэргээс урьчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх үйл ажиллагаанд идэвх санаачлагатай ажилласан иргэд байгууллагын урамшуулах тогтолцоог бий болгох" ажлыг эхлүүлэх		
12.	Гэмт хэргээс урьчилан сэргийлэх ажилд идэвх зүтгэл гаргаж ГХУСТХ-ийн 10.1.3-т тогтоосон иргэний үүргээ биелүүлсэн иргэн, байгууллагыг идэвхжүүлэх зорилготой урамшууллын тогтолцоог илүү тодорхой болгож эрх зүйн зохицуулалт хийх шаардлагатай нь 2015 онд 2 иргэн урамшуулсан үзүүлэлтээр илэрхийлэгдэнэ. Энэ талаар бусад дүүрэгболон гадаадын улс орны туршлагаас судлах. Иймд гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд иргэдээс мэдээлэл авах үйл ажиллагаанд иргэдийн аюулгүй байдлыг хангаж, хамгаалах асуудлыг онцгой анхааран ажиллах механизмыг бүрдүүлэн ажиллах	2017 оноос	Багануур дүүргийн ГХУСАЗСЗ
13.	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн оролцоотойгоор интернэт, мэдээллийн технологийг ашиглах тухай заалтын хувьд ч иргэдийн оролцоог ашиглахдаа мэдээллийн аюулгүй байдлыг нь хангах, тогтмол гэмт хэргийн гомдол, мэдээлэл хүлээн авдаг website ажиллуулж, утсан сүлжээг тогтмолжуулах арга хэмжээ авахдаа иргэдийг урамшуулдаг тогтолцоог тодорхой болгосноор тэдний энэ ажилд оролцох идэвхийг нэмэгдүүлэх	2017 оноос	Багануур дүүргийн ГХУСАЗСЗ
14.	Хил залгаа аймаг, сумдын засаг захиргааны хамтын ажиллагааны хэлбэр, төрлийг өргөжүүлэх	Тогтмол	Багануур дүүргийн ГХУСАЗСЗ
15.	Цаашид хөршийн холбоог сайжруулахдээрх ажиллагаанд гэр хорооллын өрхүүдийг бүлэг болгон хөршийн холбоод нийтэд нь байгуулан, үйл ажиллагааг нь тогтмолжуулж, үр дүнг улирал тутамд тооцож ажиллах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хороодод хөршийн холбоо байгуулах ажлыг эрчимжүүлэх зорилгоор " Хөрш " ажиллагааны төлөвлөгөө гаргаж дүүргийн Засаг даргаар батлуулан эхлүүлэх.	2017 оноос	Багануур дүүргийн ГХУСАЗСЗ
16.	Нийтийн хэв журмын урамшуулалтай эргүүл, олон нийтийн Цагдаагийн орон тоог нэмэгдүүлж, урамшууллын хөлсийг хороодын Засаг дарга, цагдаагийн байгууллагын саналыг үндэслэн шийдвэрлэх ажлын хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт иргэдийн урамшуулалтай эргүүл ажиллуулсан тоон мэдээ байгаа боловч хүн ам харьцангуй өсөж байгаа дүүргийн хувьд хангалтгүй. Иймд цаашид Цагдаагийн албаны тухай хууль, Эрүүгийн хууль болон ГХУСТХ-ийн 12.1.2-т зааснаар 12.3-т дүүргийн ИТХ-аас хэв журмын урамшуулалтай эргүүл, олон нийтийн байцаагчийн тоо болон урамшууллын хэмжээг хангалттай хэмжээнд тогтоож энэ үйл ажиллагааг тогтмолжуулах нь зүйтэй. Эргүүлд аж ахуйн нэгж байгууллагуудын ажилтан албан хаагчдыг татан оролцуулах, урамшуулал олгох, хэрэгжилт, үр дүнг тооцон ажиллах заалтын хувьд сургуулийн орчинд бага насны хүүхдийг хуурч мэхлэн эд зүйлийг нь авах, дээрэмдэх, булаах, айлган сүрдүүлэх, архидан согтуурах, мансуурахаас урьдчилан сэргийлэх зорилгоор "Багш нарын нийтийн эргүүл"-ийг 7 хоногийн баасан гарагуудад 19:00- 22:00 цагийн хооронд зохион	2017	Багануур дүүргийн ЗДТГ

	байгуулах нь хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үр дүнтэй ажил болох тул цаашид энэ ажлын тоо, чанарт анхаарч тогтмолжуулж		
17.	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд нийтийн тээврийн болон таксины жолооч, зочид буудлын ажилтнууд зэрэг бусад хувийн хэвшлүүдийг татан оролцуулж идэвхтэй хамтрах ажлыг зохион байгуулах	2017	Багануур дүүргийн ЗДТГ
18.	Багануур хот нь стратеги бодлогын түвшиний судалгааг хийлгүүлэх шаардлагатай, үүнд аюулгүй байдлыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах	2017	Багануур дүүргийн ЗДТГ
19.	Иргэдээс гэмт хэрэг, зөрчлийн талаарх өгсөн мэдээллийг төлбөртэйгээр авах, үнэлэх тогтолцоог дүүргийн хэмжээнд жишиг байдлаар нэвтрүүлэх, үүнд мөнгө төсөвлөж, зарцуулах		Багануур дүүргийн ГХУСАЗСЗ
20.	Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас мөрдүүлж буй "Эрүүл аюулгүй байдлын индекс" -т хамаарах хувь хүний аюулгүй байдлын үзүүлэлт, улмаар гэмт хэрэг, зөрчлийн хүчин зүйл болдог үзүүлэлтийг сайжруулах ажлыг бодлого, үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлэх	Тогтмол	Багануур дүүргийн ЗДТГ
21.	Багануур дүүргийн гэмт хэргийн статистикийн судалгааг жил бүр сүүлийн 5 жилийн байдлаар хийж, Дүүргийн удирдлагад танилцуулж, сайтаар нийтийн хүртээл болгож байх, Нийслэлийн Статистикийн хэлтсээс хуулийн байгууллагатай нягт хамтран ажиллах	Жил бүр	Багануур дүүргийн ГХУСАЗСЗ, Статистикийн хэлтэс
22.	Төлөвлөлтийн тогтолцоо /planning system/ бүрдүүлэх. Жижиг хотын аюулгүй байдлыг хангах асуудлыг (Small city policing) хотын дэд бүтэц, төлөвлөлт, бүтээн байгуулалтыг хийхэд иргэдийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудлыг заавал давхар авч үзэх, хотын төлөвлөлт, ирээдүйн бодлогод гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх асуудлыг тогтмол авч үздэг байх, шинээр баригдаж байгаа хорооллол, барилга байгууламжид нэмэлт шаардлага тавих	Тогтмол	Багануур дүүргийн ЗДТГ
23.	Багануур дүүргийн хөгжлийн бодлоготой уялдуулан Цагдаагийн хэлтсийг "Цагдаагийн газар" болгон өргөтгөн зохион байгуулах асуудлыг судалж, холбогдох шатны байгууллагад уламжилж шийдвэрлүүлэх, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангалт хийж, орон тоог нэмэгдүүлэх (Засгийн газрын 2011 оны 153 дугаар тогтоолд заасан онцлог нь тус дүүрэгт бүрэн байна)	2017	Багануур дүүргийн ЗДТГ, Цагдаагийн Ерөнхий газар
24.	Албаны, мэргэжлийн, ажлын байрны орчинд сэтгэл зүйн бэлэн байдал, албаны бэлтгэлийг хангах зорилгоор эрх зүй, эдийн засаг, нийгэм соёлын чиглэлээр хууль сахиулагч, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий ажилтнуудад шат дараалсан сургалтыг зохион байгуулах	2017	Багануур дүүргийн ЗДТГ, ГХУСАЗСЗ
25.	"Гэрэлтэй Багануур хөтөлбөр" боловсруулж хэрэгжүүлж, ялангуяа захын гэр хорооллыг гэрэлтүүлэгтэй болгох	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ
26.	Байгууллага, өрх бүрийг хаягжуулах, "Хаягжилт" төсөл хэрэгжүүлэх; Дүүргийн иргэний бүртгэлийн ажилтан, хороодын нийгмийн ажилтнууд хамтран дүүргийн хүн амын болон дүүргийн нутагт оршин суугчид, шилжилт хөдөлгөөний бүртгэл хаягжуулалтын судалгааг нарийвчлан гаргах. Мэдээллийн сан нь цагдаагийн байгууллага болон бусад хууль сахиулах байгууллагатай	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ, Бүртгэлийн хэлтэс, Хороодын Засаг дарга

	харилцан холбоотой хамтран ажилладаг байх. Ялангуяа түр оршин суугчид, орон гэргүй тэнэмэл хүмүүс, архи, мансууруулах бодисонд донтсон хүмүүсийг анхааралдаа авч бүртгэлжүүлэх, хянах - Хороод, бүртгэлийн ажилчдын чадавхийг сайжруулж, албан бус оршин суугч хүн амын бүртгэлийг бодитой гаргаж, судалгаанд хамруулах,		
27.	Орон сууц, байрны хаалгыг коджуулах, ингэснээр орон байрны хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх. Гадаад орны туршлагаас үзвэл барилга байгууламж дахь кодыг сайжруулах нь эд хөрөнгийн өмчлөгч нарт өөрсдийн эд хөрөнгийг хариуцлагатай эзэмшихэд тусалдаг бөгөөд гэмт хэрэг үйлдэх явдлыг багасгаж өгдөг байна. Камержуулсан, кодолсон байранд хуучны байртай харьцуулахад орон байрны хулгайн гэмт хэрэг гарах нь бага байдаг нь олон оронд нотлогдсон байдаг.	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ, Бүртгэлийн хэлтэс, Хороодын Засаг дарга
28.	Согтууруулах ундааны үйлдвэрлэлийн хэмжээг багасгах, экспортыг түлхүү бодлоор дэмжих, Согтууруулах ундааг худалдаалдаг, түгээдэг, үйлчилдэг аж ахуйн нэгж, байгууллагуудыг цөөлөх -дүүргийн архинд донтсон хүнийг сайн дурын болон албадан эмчилгээ үйлчилгээгээр хангах, тусгайлан сургалтаар тэдний бодит амьдралын түүхийг яриулах зэрэг арга хэмжээ авснаар гэмт хэргийн гаралт болон тээврийн ослыг бууруулахад чухал нөлөө үзүүлэх боломжтой. -Залуучуудад зориулсан “архигүй” орчинг бий болгож, үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран олон нийтэд сурталчлах ажлыг цаашид өргөжүүлэн хөгжүүлэх, -Архи, согтууруулах ундааг худалддаг, үйлчилдэг дэлгүүр, цэнгээний газруудад зөвшөөрөл олгохдоо тэгээрийн байршил, хоорондын зайг зохистой байхаар зохицуулах, согтууруулах бүтээгдэхүүнээр үйлчлэх, худалдах хугацааг богиносгож, өдрийг цөөрүүлэх асуудлыг дүүргийн удирдлагын зүгээс шийдвэрлэх	Тухай бүр	Багануур дүүргийн ЗДТГ, Мэргэжлийн хяналтын хэлтэс, Цагдаагийн хэлтэс
29.	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг сурталчилж олон нийтэд сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хороодын Засаг дарга, нийгмийн ажилтан нартай хамтран хорооны иргэдийн дунд хуулийг ухуулан таниулах, сурталчилах ажлыг зохион байгуулж байгаа боловч ямар сургалт нь үр дүнтэй байгаа нь тодорхой бус байгаа тул гэр бүлийн хүчирхийлэлд өртөх эрсдэлд орсон, гэр бүлийн хүчирхийлэлд өртөх магадлалтай хүүхэд, эмэгтэйчүүдийг хамгаалах, тэдний хуулийн мэдлэгийг өргөжүүлэн нэмэгдүүлэх тал дээр илүү анхаарч тэдэнд мэргэжлийн хуульч, сургагч багш нартай хамтран албан бус сургалтыг тогтмолжуулж зохион байгуулах шаардлагатай. Энэ ажил дээр хууль эрх зүйн чиглэлийн төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах тухайлбал, Хууль сахиулахын их сургууль, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн сургагч багш нарыг урьж ажиллуулах зэргээр илүү үр дүнтэй байдлаар ажиллах нь зүйтэй.	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ, Гэр бүл, хөгжлийн хэлтэс
30.	Хүүхэд, залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, өөрийгөө хөгжүүлэхэд зориулсан	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ, Гэр бүл,

	<p>үйлчилгээний хэлбэрүүдийг өргөжүүлж, цахим тоглоомын газар, интернет төвүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж, хамтран ажиллана гэсэн заалтын хүрээнд хийгдсэн ажлын хувьд дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй цахим тоглоом, интернет төвүүдийн мэдээллийн сан бүрдүүлж, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллаж, хууль тогтоомж зөрчсөн газрын үйл ажиллагааг хязгаарлах, интернет тоглоомд донтохоос хүүхэд залуучуудыг сэргийлүүлэх арга хэмжээг цаашид авч хэрэгжүүлэх ажлын хүрээнд дүүргийн ЭМН-тэй хамтран ЕБС-ын зэрэг сургуулийн дунд болон ахлах ангийн сурагчдад интернэт тоглоомонд донтох болон хор уршгийн талаар хамтарсан сургалт зохион явуулсан боловч цаашид бусад ЕБС болон хүүхэд залуучуудыг хамруулах</p>		хөгжлийн хэлтэс
31.	<p>Архи тамхины хяналт болон соёлтой хэрэглээг төлөвшүүлэх үйл ажиллагаанаас гадна мансууруулах бодисын хэрэглээг хянах арга хэмжээ авах, түүний хор хөнөөлийг сурталчлах. Сүүлийн үед хар тамхи, мансууруулах бодисын хэрэглээ нийслэлд ихээхэн газар аваад байгаа бөгөөд 2011 оны НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албанаас (UNODC) гаргадаг тайланд Монгол Улс каннабисын өргөн тархалттай, героин, кокаин, экстазийн тархалттай оронд хамаарах болсон ба 2011 оны судалгаагаар 16000 хэрэглэгч манай улсад байна. Түүнчлэн АНУ-д үйлддэгдэг нийт гэмт хэргийн ихэнх хувь нь ямар нэгэн байдлаар хар тамхи, мансууруулах бодистой уялдан гарч байна. Иймд дүүргийн хэмжээнд хар тамхи мансууруулах бодистой тэмцэх чиглэлээр арга хэмжээ авах шаардлагатай.</p>	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ, Мэргэжлийн хяналтын хэлтэс, Цагдаагийн хэлтэс
32.	<p>Сургууль, цэцэрлэгийн орчинд зам тээврийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангана гэсэн заалт нь ЕБС-ийн хүүхдийг зам тээврийн ослоос сэргийлсэн сурталчилгааны хичээлийг ЗЦТ-тай хамтран сургалт зохион байгуулсан, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, явган зорчигчдын хөдөлгөөнд оролцох сахилга соёлыг дээшлүүлэх, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, хөдөлгөөний ачаалал ихтэй цэг, уулзваруудад Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж ажиллах туслах ажилтанг гэрээгээр ажиллуулах зэрэг ажлуудыг хэрэгжүүлэх, сургууль цэцэрлэгийн орчинд зам тээврийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад зөвхөн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа бус орон нутгийн захиргааны байгууллага бусад ААНБ-ийн хамтын ажиллагааны үр дүн байдаг.АНУ-д "Нөхцөл байдлын урьдчилан сэргийлэх арга" гэж тооцогддог ба эдгээр орчныг аюулгүйжүүлснээр аюулгүй орчин, аюулгүй бүтээгдэхүүн бий болгож гэмт хэргийг бууруулна гэж үздэг.</p>	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ, Гэр бүл, хөгжлийн хэлтэс
33.	<p>Ял эдлүүлж буй механизмыг сайжруулах, тухайлбал цагаар ажил хийлгэх ялыг хотын хөгжилд үр ашигтай байдлаар хэрэгжүүлэх, энэ чиглэлээр Шүүхийн шийдвэр, Нийтийн үйлчилгээний албыг хамтран ажиллуулах (зам арчилгаанд дайчлах, хог цэвэрлэгээ гэх мэт);</p>	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба
34.	<p>Хорих ангид ЕБС-ийн зан байдлын доголдолтой, хэрэг зөрчилд холбогдсон хүүхдүүдийг зочлуулж хорих ангийн бодит байдлыг мэдрүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх (Энэ арга нь АНУ-д анх үүсч, БНСУ, Энэтхэг зэрэг олон улсад</p>	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба

	нэвтэрсэн арга)		
35.	Дүүргийн хэмжээний ЕБС-ийн зарим сурагчдыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар болон цагдаагийн байгууллагатай хамтран хорих ангийн бодит байдлыг мэдрүүлэх хөтөлбөрт хамруулснаар тухайн хүүхдийг ирээдүйн гэмт хэрэгтэн болохоос урьдчилан сэргийлэх ач холбогдолтой. Гэмт хэрэгт холбогдох эрсдэл бүхий бүлгийн болон захиргааны зөрчилд шийтгүүлсэн насанд хүрээгүйчүүдийг энэхүү хөтөлбөрт хамруулж байсан ба тус ажлын хүрээнд 1978 онд "Айсан хүн" нэртэй баримтат киног хүртэл хийж байсан. Өмнөд Каролина мужийн томоохон хорих ангиудад насанд хүрээгүйчүүдийг зочлуулж хорих ангийн бодит байдал, тэрхүү хүнд хэцүү амьдралыг мэдрүүлэх энэхүү хөтөлбөрт нийт 8000 гаруй хүүхэд хамрагдсан байдаг.	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба
36.	Эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэн, төв, их, дээд сургууль, төрийн бус байгууллага, судалгааны байгууллагуудын оролцоог дэмжих, тэдний шинэлэг саналуудыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд ашиглах /Think thank/;	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ, ГХУСАЗСЗ
37.	Хэвлэл, мэдээллийн байгууллага, телевизийн нийгмийн хариуцлага, ухамсрыг дээшлүүлэх, хүүхдийн хүмүүжилд сөргөөр нөлөөлөх мэдээлэл, нэвтрүүлэг түгээхгүй байх, Сургалт, соён гэгээрүүлэх, мэдлэгжүүлэх, хүмүүжлийн чиглэлээр түлхүү явуулах;	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ, ГХУСАЗСЗ
38.	Аюулгүй байдлыг хангах, гэмт явдлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр үүрэн телефоны оператор компаниудтай (Mobicom, Skytel, Unitel, G-Mobile гэх мэт), түүнчлэн хэвлэл, мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах -жишээ нь: Дүүргийн бүс нутагт нэвтрэн ороход аюулгүй байдлаа хангаж явахыг сануулсан мсж ирүүлдэг байх	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ
39.	Хүүхдийн хүмүүжил, ухамсар сэтгэхүйг сайжруулахад үйл ажиллагааг чиглүүлэх; <ul style="list-style-type: none"> • Цэцэрлэг, сургуульд бага насны хүүхдүүдийн хүмүүжилд нь анхаарах; • Боловсролын салбарт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх; • Цэцэрлэг, сургуулийг олноор төлөвлөлттэйгээр тархаан байгуулах; • Боловсролын байгууллагын мэргэжилтнүүдийг нэмэгдүүлэх; 	Тогтмол	Багануур дүүргийн ЗДТГ, Боловсролын хэлтэс
40.	ГХУСАЗСЗ-өөс гаргасан сургуулийн орчимд үүрэг гүйцэтгэх "School police" эргүүлийн ажиллах журмыг ЕБС, цэцэрлэгүүдэд хэрэгжүүлэх	Тогтмол	Багануур дүүргийн ЗДТГ, Боловсролын хэлтэс
41.	<u>Аюулгүй орчин бүхий сургуулиудыг бий болгох.</u> Зам тээврийн хөдөлгөөн төдийгүй сургуулийн барилга байгууламж, талбайн загвар дизайн, засвар үйлчилгээ зэргийг сайжруулахад дүүргийн удирдлагын зүгээс хамтран ажиллах нь зүйтэй. Насанд хүрээгүй хүмүүс гэмт хэрэгт өртөх явдал ихэссэн өнөөгийн нийгэмд сургуулийн орчинг аюулгүйжүүлэх нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэн чухал асуудлын нэг болдог.	Тогтмол	Багануур дүүргийн ЗДТГ, Боловсролын хэлтэс
42.	ЕБС-ийн орчинд гэмт хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлж, ахлах ангийн сурагчдыг зохион байгуулан өсвөрийн цагдаа клуб байгуулан ажиллах	Тогтмол	Багануур дүүргийн ЗДТГ, Боловсролын хэлтэс, сургуулиуд
43.	Иргэдийн бухимдал, стрессийг арилгах зорилгоор Нийгмийн сэтгэлгээг өөрчлөх менежмент хийх зайлгүй	Тогтмол	Багануур дүүргийн ЗДТГ, Гэр бүл,

	шаардлагатай байна. Сэтгэл судлалын төв, төрийн бус байгууллагыг дэмжиж, иргэдийг соён гэгээрүүлэх талаар хамтран ажиллах; <ul style="list-style-type: none"> • Нийгэмд буй бухимдал, стрессийг багасгах шинэ менежмент хийх; • Нийгэм, амьдрал өөрөө системээр гэр бүлд нөлөөлсөнөөс үүдэн хүчирхийлэл бий болж байна. 		хүүхдийн хөгжлийн хэлтэс
44.	НҮБ-ын Хүн амын сангийн 2015 оны тайланд дэлхийн хүн амын 52 хувь нь том хотуудад, 47.6 хувь нь дагуул болон хаяа хотуудад, 0.4 орчим хувь нь алслагдсан сууринд амьдарч байна гэж дүгнэсэн. Иймд томоохон хот, дагуул хотуудад хүн ам төвлөрөх тусам сэтгэл гутрал, уур бухимдал, амьдралын хэрэгцээнээс үүдэлтэй бэрхшээлүүд улам нэмэгддэг тул зөвхөн зөрчил гаргагч төдий бус хохирогч тэр ч бүү хэл хууль сахиулагчид, засаг захиргааны, үйлчилгээний ажилтан нарт сэтгэл зүйн болон буруу зан төлөв, зуршилаас татгалзах чиглэлийн албан болон албан бус сургалтуудыг мэргэжлийн сэтгэл зүйч, сэтгэц оношлогч эмч, шашны байгууллага, бусад олон нийтийн байгууллагуудын мэрэгжилтэн нарыг урьж "тусгай хөтөлбөрт" сургалтыг тогтмол зохион байгуулах	Тогтмол	Багануур дүүргийн ЗДТГ, Гэр бүл, хүүхдийн хөгжлийн хэлтэс
45.	Цагдаагийн байгууллагын хөгжлийн стратеги хөтөлбөр, Багануур дүүргийн хөгжлийн бодлого, чиг хандлагатай уялдуулан "Багануур дүүрэг дэх Цагдаагийн байгууллагын хөгжлийн стратеги" боловсруулж, хэрэгжүүлэх	2017-2028 он	Багануур дүүргийн Цагдаагийн хэлтэс
46.	Багануур дүүрэг нь байгалийн унаган төрхийг хадгалан байгаа бүс нутаг төдийгүй хөдөө аж ахуй, үйлдвэрлэл үйлчилгээ, аялал жуулчлал, зүүн бүсийн автозамын хөдөлгөөний идэвхжилтэй дамжин өнгөрөх уулзвар тул Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор малчид, анчид, байгаль хамгаалагч, олон нийтийн байгууллагатай хамтран ажиллах тусгай "хөтөлбөр" хэрэгжүүлэх	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ, Мэргэжлийн хяналтын хэлтэс, Цагдаагийн хэлтэс
47.	Иргэдээс гаргасан өргөдөл, гомдол, мэдээлэл бүрийг бүртгэлдээ оруулж, бодит нөхцөл байдлыг бодитой илэрхийлэхэд анхаарч ажиллах	2017 оноос	Багануур дүүрэг дэх Цагдаагийн хэлтэс
48.	Дүүргийн хэмжээнд хамгийн ихээр үйлдэгдэж буй гэмт хэргийн төрлийг тодорхойлж, ГХУСТХ-ийн 6.3-т зааснаар тусгай арга хэмжээг хэрэгжүүлэх. Эдгээр гэмт хэрэгт өмчлөх эрхийн эсрэг, хүний амь бие эрүүл мэндийн эсрэг, нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг. Тухайлбал: Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг, хулгайлах, танхайрах, зам тээврийн осол, хар тамхи, гэр бүлийн хүчирхийлэл, бусдын бие махбодид гэмтэл учруулах гэх мэт. Хулгай, Илрүүлэлт, Анчин нэгдсэн арга хэмжээ зохион байгуулж, ажиллах	2017 оноос	Багануур дүүрэг дэх Цагдаагийн хэлтэс
Хоёр. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажлыг сайжруулах чиглэлээр:			
49.	Байцаан шийтгэх ажиллагааны бланк нэгэн хэвийн бус, тогтсон загвар байхгүй байгаа нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нар өөр өөр тогтоол, санал үйлдэж, улмаар ЭБШХ зөрчигдөх үндэс болж байгаа тул Цагдаагийн байгууллагын хэмжээнд нэгдсэн загварыг гаргаж, хэрэгжүүлэх	2017 оноос	ЦЕГ-т зөвлөх, санал хүргүүлэх
50.	Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааны явцад	2017	ЦЕГ-т зөвлөх, санал

	зайлшгүй дагаж мөрдөх дүрэм, журам, гаргаж байгаа хэдий ч тухайн дүрэм, журмыг хэрэгжүүлэх тоног төхөөрөмж, нөхцөл бололцоогоор хангахгүй байгаа нь эрүүгийн хэрэг, гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг шийдвэрлэх ажиллагаанд саад учруулж байгаа тул хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглагдах тоног төхөөрөмжийг шийдвэрлэх;	оноос	хүргүүлэх
51.	Алба хаагчдын үйл ажиллагаанд хэрэглэгдэж байгаа компьютер болон бусад техник хэрэгсэл хуучирсан, бичиг хэрэг болон бусад төрлийн зардал бага байгаа тул техник хэрэгслийг шинэчлэх, бичиг хэрэг болон бусад төрлийн зардлыг нэмэгдүүлэх;	2017 оноос	ЦЕГ-т зөвлөх, санал хүргүүлэх
52.	Улаанбаатар хотын төвийн дүүргүүдэд жижүүрийн мөрдөн байцаагчийн орон тоог баталж өгсөн боловч алсын дүүргүүдэд тухайн орон тоог баталж өгөөгүй нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нарт өдөр тутмын ажил хийхийн хажуугаар жижүүрийн үүрэг гүйцэтгэж, улмаар жижүүрээс буусан өдрөө амарч чадахгүй ажил үүргээ үргэлжлүүлэн гүйцэтгэж байна. Иймээс хойшлуулашгүй ажиллагаа, ялангуяа хэргийн газрын үзлэгт мэргэшсэн жижүүрийн мөрдөн байцаагчийн орон тоог нэмэгдүүлж, батлуулах;	2017 оноос	ЦЕГ-т зөвлөх, санал хүргүүлэх
53.	Сүүлийн жилүүдэд БША-ны зардлыг төрөөс баталж өгөөгүйн улмаас эрүүгийн хэрэгт хөрөнгө мөнгө шаардсан ажиллагаа хийгдэж чадахгүй, гадны мэргэшсэн байгууллагаар шинжилгээ хийлгэх болон бусад төрлийн нотломж бүрдүүлэх ажиллагаа хийлгэхэд хүндрэл ихээхэн тулгарч байгаа тул ЭБША-ны зардлыг шийдвэрлүүлэх;	2017 оноос	ЦЕГ-т зөвлөх, санал хүргүүлэх
54.	Цагдаагийн алба хаагч, түүний дотор хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нар байнгын стресст ордог учир Багануур дүүргийн Цагдаагийн хэлтэст мэргэшсэн сэтгэл зүйчийг ажиллуулах;	2017 оноос	ЦЕГ-т зөвлөх, санал хүргүүлэх
55.	Алба хаагчдын албаны сургалтын чанарыг сайжруулах зорилгоор үе шаттай сургалтыг тогтмол ажлын байранд мэргэшсэн багшаар оруулдаг болох;	2017 оноос	ЦЕГ-т зөвлөх, санал хүргүүлэх
Гурав. Олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр:			
56.	Олон нийтийн аюулгүй байдлын хангах хэсгийн харуулын цэгүүдэд ашиглагдаж байгаа богино долгионы радио станцуудыг шинэчлэх, дахин дамжуулагчаар хангах	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ, ЦЕГ-т зөвлөх, санал хүргүүлэх
57.	Хамгаалалтын объектуудыг иж бүрэн дохиолол, камерын хяналтанд авах	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ, ЦЕГ-т зөвлөх, санал хүргүүлэх
58.	Тусгай хэрэгслээр алба хаагч нэг бүрийн тоогоор хангах, одоогоор нөөцгүй байгааг анхаарч, шийдвэрлэх	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ, ЦЕГ-т зөвлөх, санал хүргүүлэх
Дөрөв. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр:			
59.	Авто машины түгжрэл бий болох учраас хотын замын зохион байгуулалтыг хийж өгөх	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ
60.	Дүүргийн хэмжээнд авто зогсоолыг сайжруулах. Зогсоолуудын зохицуулалт, хяналт, ашиглалт ба нийтийн эзэмшлийн зогсоолын тоног төхөөрөмжийн аюулгүй байдал нь замын хөдөлгөөнд ихээхэн нөлөө үзүүлдэг бөгөөд энэ нь тээврийн хэрэгслүүдийн аюулгүй	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ

	байдалд мөн нөлөөлдөг. Ялангуяа автомашины хулгайн гаралт өндөртэй хороодыг анхааралдаа авч, тэдгээр хороонд авто зогсоолуудыг шинээр бий болгох нь шаардлагатай.		
61.	Дамжин өнгөрдөг болон бүс нутаг дамнан амьдардаг хөдөлгөөний эрчимийг тооцоолох тогтолцоог бий болгох,	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ
62.	Багануур дүүргээс Улаанбаатар хот явах замд байнгын хяналтын постод ажиллах, мөн Хэнтий аймгийн Цэнхэрмандал, Төв аймгийн Мөнгөнморьт, Баяндэлгэр сумдад гарсан зам тээврийн осол, хэргийн дуудлагыг хүлээн авч шийдвэрлэх, тухайн сумдад урьдчилан сэргийлэх чиглэлээр хяналт шалгалт явуулахад хүн, хүч дутмаг зэргээс шалтгаалан тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавихад алба хаагчдын хүрэлцээ хангалтгүйгээс орон нутгийн замд гардаг осол, хэргийн гаралт өдөр бүр нэмэгдэх хандлагтай байна. Улсын хэмжээнд 1 алба хаагчдад 300 тээврийн хэрэгсэл ногдох норматив байхад тус тасгийн хэмжээнд дүүргийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрч байгаа болон дүүрэгт хөдөлгөөнд оролцож байгаа"УБ" серийн улсын дугаартай тээврийн хэрэгслийг оруулахгүйгээр зөвхөн "БРА" серийн улсын дугаартай тээврийн хэргслийн тоо 5850 байна, мөн дүүргийн нутаг дэвсгэрээр хоногт дайран өнгөрч буй тээврийн хэрэгслийн тоо нэг хоног буюу 24 цагийн туршид тооллого хийхэд давхардсан тоогоор 1550-1680 тээврийн хэрэгсэл өнгөрч байна. Иймд 1 алба хаагчид 490 тээврийн хэрэгсэл ноогдож байгаа зэргийг харгалзан Дүүрэгт хүн ам, тээврийн хэрэгслийн тоо эрчимтэй өсөж байгааг харгалзан алба хаагчдын ажлын ачаалалыг бууруулах, орон нутгийн замд тавих хяналтыг сайжруулах, хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ажилд хүн хүчийг ашиглах, алба хаагчдын аюулгүй байдлыг хангах зорилгоор ЗЦТ-ийн алба хаагчийн 4-оос доошгүй орон тоог нэмэгдүүлэх	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ, ЦЕГ-т зөвлөх, санал хүргүүлэх
63.	Дүүргийн болон орон нутгийн замд автомашинаар хөдөлгөөнт эргүүлээр хяналт шалгалт хийх, мал хулгайлах болон байгаль орчны эсрэг гэмт хэргийг илрүүлэх зорилгоор хяналтгүй баталгаат бус авто замуудад хяналт шалгалт хийх, гэмт хэргийг хурдан шуурхай илрүүлэхчиглэлээр хоногт 288 км зам туулахад шаардагдах шатах, тослох материалын лимитийг нэмэгдүүлэх;	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ, ЦЕГ-т зөвлөх, санал хүргүүлэх
64.	Тасгийн хэмжээнд хөдөө орон нутгийн замд хамгаалалт болон арга хэмжээний үед ажиллахад тохиромжтой туулах чадвар сайтай автомашин, зөөврийн хяналтын цэг /чиргүүл/, тээврийн хэрэгсэл албадан зогсоох зараа, тусгай дуут дохиогоор тоноглогдсон мотоцикль, согтуурал шалгагч танадагч багаж, замын нөхцөл байдлын талаар болон жолооч зорчигч нарт мэдээлэл өгөх цахилгаан самбар зэрэг техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах;	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ, ЦЕГ-т зөвлөх, санал хүргүүлэх
65.	Мотоцикльтой холбоотой зам тээврийн осол хэргийг бууруулах үүднээс дүүргийн болон орон нутгийн замд мотоцикльт хөдөлгөөнт эргүүл ажиллуулах шаардлагатай байгаа тул албан ажлын хэрэгцээнд	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ, ЦЕГ-т зөвлөх, санал хүргүүлэх

	зориулж тусгай дуут гэрэл дохио бүхий 2 ширхэг мотоциклоор хангуулах саналыг дүүргийн төр захиргааны байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;		
	Тав. Мэргэжлийн хяналтын байгууллагаас гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах чиглэлээр:		
66.	Дүүргийн хэмжээнд архи, согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй цэгийн тоо дүүргийн хүн амын тоотой харьцуулахад 14 дахин их байна. Иймд тусгай зөвшөөрөлтэй цэгийн тоог бууруулахад холбогдох байгууллагатай хамтрах ажиллах	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ, Мэргэжлийн хяналтын хэлтэс
67.	Архи, согтууруулах ундаагаар үйлчилдэггүй 1, 7, 20-ны өдрүүдэд гар дээрээс архи худалдаалах зөрчил гарч байгаа тул үүнд тавих хяналтыг сайжруулах	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ, Мэргэжлийн хяналтын хэлтэс
68.	Архи, согтууруулах ундаа худалдаалах болон түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй цэгүүдэд хамтран сургалтыг үр дүнтэй зохион байгуулах	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ, Мэргэжлийн хяналтын хэлтэс
69.	Зөвшөөрөгдсөн цэгээс бусад газарт зөвшөөрөлгүй ил задгай худалдааг гар дээрээс худалдах явдал их гарч байгаа тул хяналт шалгалтыг сайжруулах, чангатгах, Эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах,	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ, Мэргэжлийн хяналтын хэлтэс
70.	Хууль бусаар модны тээвэрлэлт, боловсруулалтын байдалд цагдаагийн байгууллагатай хамтран хяналт шалгалтыг сайжруулах,	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ, Мэргэжлийн хяналтын хэлтэс
71.	Хууль бусаар нэн ховор, ховор болон агнуурын амьтан агнаж байгаатай хийх тэмцлийг эрчимжүүлж, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг сайжруулах,	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ, Мэргэжлийн хяналтын хэлтэс
72.	Багануур дүүргийн нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж, байгууллага, хороодын гадна талбай гэрэлтүүлгийг сайжруулахад болзолт уралдаан гарган, хэрэгжүүлэх,	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ, Мэргэжлийн хяналтын хэлтэс
73.	Хэрлэн худалдааны төвийн урьд талбайн явган хүний зам дээрх автомашиныг журманд оруулах	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ, Цагдаагийн хэлтэс
74.	Гамшгаас хамгаалах, газар хөдлөлт, зам гүүр нурах, үер, ган зуд, хөлдөлт, бороо болон цасан ба шороон шуургатай тэмцэх талаар хууль сахиулах албаны үйл ажиллагаа, авто замын бэлэн байдлыг дээшлүүлэх, гамшгийн голомт бүхий газарт орон тооны бус удирдлагын болон мэргэжлийн багийн томилгоот бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэх чадвар, сэтгэл зүйн бэлтгэлийн чадвахийг сайжруулах, аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгоход харилцан ажиллах шуурхай ажиллагааны бэлэн байдлыг хангах зорилготой сургалт зохион байгуулах	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ, Онцгой байдлын хэлтэс
75.	Байгаль орчин, болзошгүй гамшгын үед хууль сахиулах байгууллагуудын оролцоо, хамтын ажиллагааны талаар сургалт явуулах	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ, Онцгой байдлын хэлтэс
76.	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах чиглэлээр олон улс, гадаадын болон үндэсний донор байгууллагаас санхүүжилт авах санаачлига гаргаж, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх	2017 оноос	Бүх байгууллага
77.	Гэмт хэрэг, зөрчлийг мөрдөн шалгаж, эцэслэн шийдвэрлэх, хүний эрхийг баталгаатай хангах болон урьдчилан сэргийлэх ажилд өмгөөллийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэн гүйцэтгэж байгаа иргэд, байгууллагыг оролцуулсан, хамтран ажилласан талаар гаргасан тайлан бүртгэл хангалттай байхгүй байгааг цаашид анхаарч ажиллах шаардлагатай.	2017 оноос	Багануур дүүргийн ЗДТГ, Хуулийн хэлтэс

КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ БА АВТО ЗАМЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

TRANSPORT ACCIDENTS AND TRANSPORT CONDITIONS IMPORTANT ISSUES

Б.Эрдэнэхуяг

*Замын цагдаагийн албаны Хан-Уул дүүрэг дэх
Замын цагдаагийн хэлтсийн зохицуулагч,
ХСИС-ийн магистрант, цагдаагийн ахмад*

Хураангуй: Монгол улсад гарч байгаа зам тээврийн осол, хэргийн тоо жилээс жилд өсөх хандлагатай байгаа хэдий ч осол, хэргийн шалтгаан нөхцлүүдийн нэг болох авто зам түүнээс үүдэн гарсан зам тээврийн ослын тоо нийт гарсан осол, хэргийн маш бага хувийг эзэлж байгаа билээ. Манай орны хувьд авто замын засвар, үйлчилгээ, арчлалт сайнгүй хирнээ авто замын нөхцөл байдлаас үүдэн гарч байгаа зам тээврийн осол, хэргийн тоо баримт бага байгаа нь хангалтгүй гэж үзэж судлахыг зорьж байгаа билээ.

Abstract: The transport accident amount was increasing year by year. But one of the reasons that transport accident quantity is very small percentage of total number of highway or transport accidents. For our country, we try to do a research about transport accident, and a crime amount is not enough because road fixing, service, and road maintenance is not great from the facts of the case.

Түлхүүр үг: Зам тээврийн осол, хэрэг, Замын хөдөлгөөний аюулгүй байдал.

Key words: Transport accidents, cases of transport safety.

ОРШИЛ

Монгол Улсад сүүлийн жилүүдэд импортоор орж ирж байгаа автомашины тоо өдрөөс өдөрт тогтмол өсч байгаатай уялдаа холбоотойгоор нийслэл хот болон хөдөө орон нутгийн замын хөдөлгөөний ачаалал эрс нэмэгдэж хөдөлгөөний нягтрал, түгжрэл саатал, бензин тосны хий шаталт /агаарын бохирдол/, үргүй цаг ашиглалт, зам тээврийн осол, хэрэг жилээс жилд өсөх гэх мэтээр сөрөг үр дагаварууд байсаар байна.

ҮНДСЭН ХЭСЭГ

Зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх, хүний амь нас, эрүүл мэнд, өмч хөрөнгийг хамгаалах нь Хүний эрхийн түгээмэл тунхаглалд заасан "Хүн бүр амьд явах, эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх"², Монгол Улсын Үндсэн хуульд заасан "Иргэн амьд явах эрхтэй, эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрх"³-ийг хангах нэг нөхцөл болно.

Гэтэл дэлхий дахинд зам тээврийн ослын улмаас жилд 1.2 сая гаруй хүн амь насаа алдаж, 50 сая гаруй хүн бэртэж, гэмтэн хөгжлийн бэрхшээлтэй болж байгаагийн зэрэгцээ 5-29 насны хүүхэд, залуучуудын үхлийн үндсэн шалтгаан нь зам тээврийн осол болж байна. Зам тээврийн осол нь зүрхний шигдээс, сэтгэлийн дарамтын дараа хүн амын нас баралтын гурав дахь гол шалтгаан болох төлөвтэй байгаа бөгөөд зам тээврийн ослоор нас барагсдын 90 гаруй хувь нь буурай болон хөгжиж байгаа улс оронд ногдож, жилд нийт 65 тэрбум ам.долларын хохирол учирч байгааг НҮБ-аас онцлон тэмдэглэж, 2010 онд Ерөнхий Ассемблейн хуралдаанаас 2011-2020 оныг "Замын хөдөлгөөний аюулгүй байдлын жилүүд" болгон зарлаж 64/255 дугаар тогтоолыг гаргаж, зам тээврийн ослыг эрс багасгаж, нас баралтыг 50 хувиар бууруулах зорилтыг дэвшүүлсэн.

Мөн 2010 онд Тайланд Улсын Бангкок хотод зохион байгуулагдсан Ази, Номхон далайн нийгэм, эдийн засгийн комиссын Бүс нутгийн замын хөдөлгөөний шинжээч нарын уулзалтаар улс орон бүрт зам тээврийн ослын нас баралтыг бууруулах "Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зөвлөмж"-ийг гаргасан.

² Олон улсын гэрээ хэлэлцээрүүдийн эмхтгэл УБ., 1993

³ Төрийн мэдээлэл, УБ., 1992, №01

Манай улсын хувьд зам тээврийн осол, зөрчлийн тоо жилээс жилд нэмэгдэж, түүнээс шалтгаалах нас баралт өсөх хандлагатай байна⁴.

Хүснэгт №1

д/д	Он	Нийт дуудлага	Зам тээврийн осол	Хэрэг	Нас барсан хүн	Гэмтсэн хүн
1	2013	90721	18397	2143	423	1281
2	2014	107727	31585	2148	503	1460
3	2015	92645	45161	2010	429	1382

Монгол Улс дахь зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлтээс харахад зам тээврийн осол, гэмтэл үүсэхэд нөлөөлж байгаа гол хүчин зүйлд:

- Хурд хэтрүүлэх;
- Согтууруулах ундаа хэрэглэх;
- Гадна хот төлөвлөлтийн оновчтой бус байдал;
- Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг зохицуулж байгаа хууль, дүрэм, журам, стандартын биелэлтийн хангалтгүй байдал;
- Тээврийн хэрэгслийн парк хэт хуучирсан;
- Хөдөлгөөнд оролцогчдын соёл, боловсрол дутмаг байдал;
- Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах байгууллагуудын ажлын уялдаа хангалтгүй зэрэг дутагдлууд хамаарч байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах явдал нь замын хөдөлгөөнийг зохицуулагч, жолоочийн үүрэг мэт алдаатай ойлголт байсан бөгөөд орчин үед замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах нь "Хүн-Тээврийн хэрэгсэл-Зам-Орчин" гэсэн харилцан уялдаа бүхий цогц асуудал гэдгийг эрдэмтэд тогтоогоод байна. Нөгөө талаас замыг шинээр барьж байгуулах, засварлахдаа технологийн шаардлагыг чанд мөрдөж иж бүрнээр /замын инженерийн байгууламж, хөдөлгөөн зохицуулах техник хэрэгсэл гэх мэт/ нь шийдвэрлэж байх шаардлагатай гэж олон улсад үздэг байна. Зам-орчин нь өөрөө замын хөдөлгөөний нэг бүрдэл болдог.

2015 онд замын нөхцлөөс шалтгаалан гарсан зам тээврийн осол улсын хэмжээнд 49 бүртгэгдсэний 14 нь нийслэлд, 35 нь орон нутагт бүртгэгдсэн байна. Энэ шалтгаанд техникийн гэмтэл, гадны гэрэл /замын гэрэл/, зам орчны нөхцөл зэргийг багтаан авч үзэж байгаа боловч авто зам, замын байгууламж хариуцсан байгууллагад техникийн акт тавьж арга хэмжээ тооцсон бүртгэл, мэдээлэл байхгүйгээс замын нөхцлөөс гарсан ослын үзүүлэлт бага бүртгэгдсээр байна.

Замын нөхцөл гэдэгт:

- Хот төлөвлөлт;
- Хот хоорондын зам;
- Унадаг дугуйн зам;
- Хорооллын доторхи зам;
- Явган хүний зам;
- Зогсоолын талбай;
- Замын хяналт, шалгалт;
- Авто замын тэмдэг, тэмдэглэгээ;
- Гэрэлтүүлэг;
- Замын эвдрэл, гэмтэл;
- Тэмдэг, тэмдэглэгээ;
- Эгнээ хоорондын зай;
- Халтиргаа, гулгаа;
- Цаг уураас хамааралтай бусад нөхцөл;
- Бусад нөхцлүүд хамраана.

Зам дээрх онгорхой нүх, овоолсон шороо, зузаан мөстсөн зорчих хэсэг, замын бусад эвдрэл гэмтлийг тойрч гарах жолооч хөдөлгөөний чиглэлээ гэнэт өөрчлөх, зарим үед тойрон гарах үедээ эсрэг урсгалд орсноос үүдэн гарсан зам тээврийн ослыг ослын акт, дүгнэлтэнд тусгадаггүй, ихэнхи тохиолдолд бурууг жолооч, бусад хөдөлгөөнд оролцогчдод хариуцуулж байна. Манай орны авто замын байгууламж, арчлалт төдийлөн сайн биш байхад зам тээврийн осол, хэргийн акт, дүгнэлтийг замын нөхцөлөөс үүдэн гарсан гэж тогтоосон шинжээчийн дүгнэлтийн тоон үзүүлэлт бага байгаа нь үүнтэй холбоотой юм.

⁴ Монгол Улс дахь Зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлт. УБ.,2015, 2016 №4, №5

Замын нөхцлөөс шалтгаалан гарсан Зам тээврийн осол, хэргийн улмаас учирсан хохирлыг замын засвар арчлалт хариуцсан байгууллага, албан тушаалтнаар нөхөн төлүүлж байх, замын засвар арчлалт хариуцсан албадыг шинээр бий болгох, үйл ажиллагааг нь эрс сайжруулах тогтолцоо манай улсад зайлшгүй шаардлагатай байгааг дээрх тоо баримтаас харж болно. Замын хөдөлгөөнд оролцогчдод сайн зам дотроо аюулгүй зам хэрэгтэй байдаг учир замын байгууламж хариуцсан албадад хариуцлага хүлээлгээд ирэхээр зам, замын нөхцөл нь чанарын өндөр түвшинд хүрэх нэг нөхцөл болно.

Тиймээс ч Монгол Улсын Засгийн газар 2012 онд 146 дугаар тогтоолоор **"Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний стратеги" (2012-2020)-ийг баталж, "Аюулгүй зам орчин" хэмээх стратегийн зорилт дэвшүүлэн**

- Авто замын сүлжээний аюулгүй байдлыг нийт хөдөлгөөнд оролцогчид, ялангуяа хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон явган, дугуйгаар зорчигчдод зориулан сайжруулах;
- Хот төлөвлөлтийн хууль тогтоомж, ерөнхий төлөвлөгөөг боловсронгуй болгож, хариуцлагын тогтолцоог бий болгох;
- Хотын блок хоорондын зайг 150 метрээс ихгүй байхаар төлөвлөх;
- Хотын төвийн хөдөлгөөний ачааллыг "хэрэглэгч төлдөг" зарчимд шилжүүлэх замаар багасгах;
- Замын байгууламжийг төлөвлөх, зураг, төсөл зохиох, барих, ашиглах үед орчин үеийн техник технологи, стандартыг хэрэглэж аюулгүй байдлын шаардлагыг заавал хангах;
- Хөдөлгөөний аюулгүй байдлын үнэлгээг жилд 1-ээс доошгүй удаа хийдэг байх;
- Замын сүлжээний төлөвлөлтийг зорчигч болон ачаа тээврийн төлөвлөлттэй нягт уялдуулах гэсэн үйл ажиллагааны чиглэлийг тогтоосон байна.

Уг тогтоолын 2 дугаар хавсралтаар замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний стратеги (2012-2020 он)-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж, түүндээ аюулгүй зам, орчныг бүрдүүлэх, сайжруулах чиглэлээр дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. */Хүснэгт №2-т хавсралтаар харуулав/*

ДҮГНЭЛТ

Иймд хуулиар үүрэг хүлээсэн албан тушаалтан, аж ахуйн нэгж байгууллагуудад хамаарах хуулийн заалтуудын талаар албаны зүгээс дэлгэрэнгүй мэдээлэл өгч тэдний ажил үйлчилгээг зохих түвшинд хүртэл сайжруулах шаардлагатай байна.

Мөн Зам тээврийн осол, хэргийн дуудлага мэдээлэл хүлээн аваад хүрэлцэн очиж үзлэг, хэмжилт хийж байгаа Замын цагдаагийн албаны жижүүрийн бүрэлдэхүүн, техникийн байцаагч нар тухайн зам, орчны байдлыг үзлэгийн тэмдэглэл болон, ослын газрын зурагт тодорхой тэмдэглэснээр Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулнд заасан замын засвар, арчлалт хариуцсан албан тушаалтан, аж ахуйн нэгж байгууллагад холбогдох заалтууд зөрчигдсөн байгаа тохиолдолд учирсан хохирлыг нөхөн төлүүлж, хариуцлага тооцох бүрэн боломжтой гэж үзэж байна.

САНАЛ

Энэ хүрээнд зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг цогцоор хэрэгжүүлэх тэр дундаа замын дэд бүтэц, орчин нөхцөлд тавих хяналт, зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр өөрийн орны өнөөгийн нөхцөл байдалд үндэслэн дэд бүтэц өндөр хөгжсөн орнуудын туршлагыг нэвтрүүлж ажиллах нь зүйтэй. Тухайлбал, ОХУ-д мөрдөж байгаа замын тэмдэг, тэмдэглэл болон замын хучилтад хяналт тавихад баримталдаг норм дүрмийг дараах байдлаар тогтоосон байна.

- Замын дарааллын тэмдэг эвдэрч гэмтсэн байхгүй болсон тохиолдолд 24 цагийн дотор, бусад тэмдгийг 24 цагийн дотор, бусад тэмдгийг 3 хоногийн дотор сэргээн засварлаж байрлуулна.
- Замын нэг хөндлөн огтлолд 3-аас илүүгүй тэмдэг тавих /Үүнд нэмэлт тэмдгийг оруулан тооцохгүй/
- Замын тэмдэг байрлуулах өндрийн хэмжээ суурингийн гадна 1,5-2,2 метр, суурин газар 2,0-4,0 метр, замын зорчих хэсэг, тусгаарлах зурвас дээр 0,6 метрээс багагүй, зорчих хэсгийн дээр бол 5,0-6,0 метр байх
- Тэмдгийн хамгийн ойр ирмэг зорчих хэсгийн захаас 0,5-2,2 метр хүртэл
- 50 метр замд будгаар тавьсан тэмдэглэлийн 50%, термопластаар тавьсан тэмдгийн 25% нь элэгдсэн бол тэмдэглэлийг сэргээнэ.

- Зам дээр тавьсан гэрэл ойлгууртай хэрэгслүүд нь зорчих хэсгийн гадаргуугаас 15 мм-ээс илүүгүй өндөрт байна.
- Замын эвдрэлийн хэмжээ уртаашаа 15 см, өргөнөөрөө 60 см, гүнээрээ 5 см-ээс илүү байхыг хориглоно
- Замын зорчих хэсэг дээрх үзлэгийн болон шүүрт худгийн эвдэрсэн болон алга болсон тагийг 3 цагийн дотор сольж тавих эсвэл хөдөлгөөнд оролцогчдод анхааруулж хашилт хийнэ гэж тогтоожээ.

Мөн үйлчилгээний байгууллагыг замын дагуу байршуулахад эргэлт бүхий хэсэгт бол 1000 метрээс дээш эргэлтийн радиустай байх, 2 түвшиний огтлолцсон шүүрээс 1000 метрээс ойргүй байх, зогсоолын талбайн хэмжээ байгууллагын хүчин чадалд нийцсэн байх, замын гэрэлтүүлгийн хувьд 95 хувиас дээш хувь нь асаж байвал хэвийн гэж үзнэ гэсэн зохицуулалтуудыг хийсэн байна.

Хальтиргаа гулгааны хувьд ОХУ-ын норм дүрэмд 1-р зэргийн зам дээр хальтиргаа гулгаа үүссэн бол 4 цагийн дотор, 2-р зэрэглэлийн замд 5 цаг, бусад замд 6 цагийн дотор хэвийн болгохыг үүрэг болгосон байдаг байна. Энэ мэтчилэн замын хөдөлгөөний хэвийн нөхцлийг хангах, цаашлаад зам тээврийн осол, хэрэг гарахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн норм, дүрмийг тогтоосон нь манай улсын хувьд анхаарч үзвэл зохих зохицуулалт байна.

Монгол улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулинд замын засвар, арчлалт хариуцсан холбогдох албан тушаалтан, аж ахуйн нэгж байгууллага үүргээ биелүүлээгүйгээс зам тээврийн осол, хэрэг гарах шалтгаан нөхцлийг бүрдүүлсэн болон зам тээврийн осол, хэрэг гарсан бол учирсан хохирлыг нөхөн төлүүлж, хариуцлага тооцохоор заасан байгаа хэдий ч үүнийг хэвшүүлэн хэрэгжүүлэх процедур нь хангалтгүй байна

НОМ ЗҮЙ

1. Я.Чулуунбаатар, Хөдөлгөөний аюулгүй байдлын үндэс, УБ 2007
2. А.Энхболд, Замын хөдөлгөөний аюулгүй байдал, УБ 2007
3. Монголын мянганы сорилтын сан- Эрүүл мэндийн төсөл, Зам тээврийн осол хэргийн дүн шинжилгээ, УБ 2010
4. Ц.Эрдэнэчимэг, Монгол улс дахь зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлт эмхэтгэл, УБ 2014
5. Ц.Эрдэнэчимэг, Монгол улс дахь зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлт эмхэтгэл, УБ 2015
6. Ц.Эрдэнэчимэг, Монгол улс дахь зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлт эмхэтгэл, УБ 2016

Хавсралт. Хүснэгт №2

Бүлэг 2. Аюулгүй зам, орчныг сайжруулах чиглэлээр				
13	Олон улсын болон улсын чанартай хатуу хучилттай авто замын тоог 2 дахин нэмэгдүүлж, замын тэмдэг, тэмдэглэл, гэрэлтүүлэг, хашлага, гармыг оновчтой байрлуулах	ЗТБХБЯ	ХЗДХЯ, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар	2012-2016
14	Авто замын байгууламжийг төлөвлөх, зураг төсөл зохиох, түүнийг барих, ашиглах, арчлахад аюулгүй байдлын үнэлгээ заавал хийж, замын аюултай хэсгийг тогтоон засаж сайжруулах	ЗТБХБЯ	ХЗДХЯ, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар	2012-2020
15	Авто замын засвар, арчлалтын менежментийг боловсронгуй болгох, жилд 200 км замд ээлжит засвар хийх	ЗТБХБЯ	ХЗДХЯ, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар	2012-2020
16	Авто замын судалгаа шинжилгээний хүрээлэн байгуулж, гадаад орны дэвшилтэт техник, технологийг судалж нутагшуулах	ЗТБХБЯ	АЗГ	2012-2020
17	Жил тутам авто замын инженер, техникч мэргэжлээр 50-иас доошгүй хүнийг дотоодод бэлтгэх, 250-иас доошгүй мэргэжилтэй ажилчин бэлтгэдэг болох	ЗТБХБЯ	БСШУЯ	2012-2016

18	Замын барилгын ажлын хяналтыг зөвлөх үйлчилгээний бие даасан компаниар гүйцэтгүүлэх	ЗТБХБЯ	СЯ	2012-2016
19	Хот төлөвлөлтийн ерөнхий төлөвлөгөө, холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох	ЗТБХБЯ	ХЗДХЯ	2012-2015
20	Хот төлөвлөхдөө блок хоорондын зайг 150-200 метрээс ихгүй байхаар зохион байгуулах	ЗТБХБЯ	Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар	2012-2015
21	Хотын төвийн хөдөлгөөний ачааллыг "хэрэглэгч төлдөг" зарчимд шилжүүлэх замаар багасгах	ЗТБХБЯ	ХЗДХЯ, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар	2012-2014
22	Томоохон хотуудад явган зорчигчийн аюулгүйн гармын тоог нэмэгдүүлэх, тухайлбал явган зорчигчид зориулсан гарам, хонгил, гүүрэн гарц байгуулж, гэрлэн дохионы горимыг сайжруулах	ЗТБХБЯ	Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар	2012-2020
23	Хөдөлгөөнд оролцож байгаа тээврийн хэрэгслийн даац, хэмжээг олон улсын конвенцийн шаардлагад нийцүүлэх, уурхайн буюу тусгай зориулалтын авто замын стандарт, техникийн нөхцөлийг тогтоон, хэрэгжүүлэх	ЗТБХБЯ	Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар	2012-2013
24	Хөдөлгөөнд оролцогч хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхэд, өндөр настан, явган зорчигч, моторт бус тээврийн хэрэгслээр болон мотоциклоор зорчигчдын аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авто замын хийцэд тусган төлөвлөж, хэрэгжүүлэх	ЗТБХБЯ	Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар	2012-2020
25	Тусгаарлалтыг нэмэгдүүлж, хотын болон хот орчмын бүсэд явган зорчигч, унадаг дугуйгаар зорчигч, мотоциклоор зорчигч нарт зориулсан зам, аюулгүй бүс бий болгох (боломжтой хэсэгт)	ЗТБХБЯ	Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар	2012-2020
26	Хот хоорондын болон хотын тээврийн сүлжээ, үйлчилгээг нэгдсэн байдлаар хөгжүүлэх, тээврийн төрөл хоорондын (авто тээвэр, төмөр зам, агаарын тээвэр) уялдааг хангах, хот хоорондын болон хотын доторхи замын хөдөлгөөнийг тусгаарлах (хот хоорондын тээврийг хотын захгаар тойруулах)	ЗТБХБЯ	Нийслэлийн нийтийн тээврийн газар	2012-2020
27	Хотын хөгжлийг дэмжих, өрсөлдөх чадвар бүхий нийтийн тээврийн тогтолцоог бүрдүүлэх, ингэхдээ их багтаамжийн тээврийн төрлийн системийг бий болгон автобус, микро автобус, такси үйлчилгээг уялдуулах	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар,	Нийслэлийн нийтийн тээврийн газар	2012-2015
28	Замын хөдөлгөөнийг хянах, ялангуяа хотын төв, түгжрэлтэй байрлалуудад автомашины хэрэглээг хянан зохицуулах	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар,	Нийслэлийн нийтийн тээврийн газар, Замын цагдаагийн газар	2012-2015
29	Замын хөдөлгөөний хяналтын тогтолцоог нийт замын урт болон тээврийн хэрэгслийн тоонд зохистойгоор уялдуулах	ЗТБХБЯ	ХЗДХЯ	2012-2020

ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙГ АВЛИГАД ӨРТӨХӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗАРИМ АСУУДАЛ

А.Энх-Амгалан

Хан-Уул дүүрэг дэх Цагдаагийн хоёрдугаар хэлтсийн
эргүүлийн офицер, цагдаагийн ахлах дэслэгч

Товч хураангуй: Нийгмийг эрүүл хөгжүүлэх нэг түлхүүр нь төрийн байгууллагын албан хаагчдын үйл ажиллагаа нь хууль тогтоомжийн хүрээнд байх явдал бөгөөд хуулийн хэрэгжилтийг хэлбэрэлтгүй хангах нэг үндэс нь сонирхлын нөлөөнд автахгүй шударгаар ажиллах, тэрхүү боломжийг бүрдүүлэх нь чухал юм.

Цагдаагийн байгууллагын иргэдэд үзүүлдэг үйлчилгээ нь өөрөө хууль тогтоомж тушаал шийдвэрийг хэрэгжүүлэх, удирдлага болгох, биелүүлэх хүрээнд байдаг ба иргэдийн зарим эрхийг хязгаарлахад хүрдэг, цагдаагийн алба хаагчийн мэдлэг боловсрол, мэргэжлийн үр чадвар муу, цагдаагийн алба хаагчийн үндсэн цалин гэр бүлээ тэжээж амьдрал ахуйгаа аваад явж чадах хэмжээнд байж чадахгүй, иргэдийн сэтгэлгээ ухамсарын түвшин муу, ёс зүйгүй байдал, хууль эрх зүйн мэдлэг дутмаг, эдийн засгийн хямралт байдал, банк санхүү зээлийн хүрээн дэх элдэв зөрчил, гэнэтийн үйл явдлаас үүдэлтэй хэрэгцээ шаардлага гэх мэт объектив, субъектив хүчин зүйлүүдийн хамааралд алба хаагчид авлига авах, өгөх, албан тушаалаа урвуулах зэрэг үйлдэл гаргаж байгаа нь түүний учир шалтгааныг судалж гарах, шийдвэрлэх арга замыг тодорхойлох явдал чухал байгаа юм.

Түлхүүр үг: Цагдаагийн алба хаагч, төрийн бодлого, авлига, нөхцөл, шалтгаан, авч хэрэгжүүлэх ажил.

Аливаа улсын төр барьж буй албан тушаалтан, улс төрийн зүтгэлтнүүд, засаглалыг хариуцагч эрх мэдэл бүхий хүмүүс хээл хахуульд автагдах магадлал их байдаг. Манай орны хувьд засаглалыг хэрэгжүүлэгч болон гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагууд, нийгэм соёлын бүхий л салбарт авлигын тухай асуудал яригдах болсон. Тэр дундаа Хууль сахиулах байгууллагууд авлигад өртөх явдал нь нийгэм түүнийг хүлээн зөвшөөрөхөд илүү амар, хялбар болгож байна.

Авлигатай тэмцэх газар, АНУ-ын Сант Марал сан болон Мерси кор олон улсын байгууллагаас хамтран авлигын талаарх олон нийтийн ойлголт мэдлэгийг тогтоох судалгааны үр дүнг танилцуулсан байна. Судалгааны дүнгээс үзэхэд 2014 оны байдлаар авлига нь Монгол улсад авлигатай тэмцэхэд саад болж буй хүчин зүйлсийн хамгийн түгээмэл нь "хууль сахиулах байгууллагуудын хүрээнд авлига газар авсан явдал" гэж үзжээ. Тодруулбал Шүүх болон Хууль сахиулах байгууллагуудын шудрага харьцаанд итгэх иргэдийн итгэл маш доогуур байна гэв.⁵

Хууль хяналтын байгууллагын алба хаагч нар авлигад өртсөнөөр иргэдийн халдашгүй байх, хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх, шударга шүүхээр шүүлгэх, хохирлоо нөхөн төлүүлэх эрхийн баталгаа алдагдаж, хуулийн хамгаалалтгүй болох, аливаа асуудлыг зөвхөн хөрөнгө мөнгө, танил талаараа зохицуулахад хүргэдэг. Энэ нь иргэдийн хууль хяналтын байгууллагад итгэх итгэлийг сулруулж, эрхээ хамгаалуулах боломжийг хааж байдаг юм.

Өнөө үед төрийн бодлогын чухал асуудал болон яригдаж буй авлига, хээл хахууль өгөх, авах, зуучлах гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцлийг судлах нь авлигатай тэмцэх арга замыг боловсронгуй болгох бөгөөд Хууль сахиулах байгууллагууд тэр дунд нийгмийн өргөн харилцааны тодорхой хэсэгт буюу хуулиар хамгаалагдсан харилцааг зохицуулдаг Цагдаагийн алба, алба хаагчийн авлигад өртөх шалтгаан, нөхцлийг судлан шийдвэрлэх арга замыг тодорхойлсноор алба хаагчдыг авлигаас урьдчилан сэргийлээд зогсохгүй, төр, нийгмийн ёс зүй, хууль тогтоомж, тушаал, шийдвэрүүдийг хэлбэрэлтгүй үйлчлэх нөхцлийг хангахад хөшүүрэг нь болох юм. Иймд Төрийн байгууллагууд, Хууль сахиулах байгууллагуудыг авлигагүйгээр манлайлах анхны байгууллага нь Цагдаагийн алба байна.

Б.Баярсайханы Монгол хэлний тайлбар толь бичигт авлига нь аливаа ажил үйлсийг бүтээхийн тулд албан тушаалтанд өгсөн хахууль, хууль бусаар бусдаас авсан эд хөрөнгө, ашиг хонжоо гэсэн бол хууль зүйн нэр томъёог авч үзвэл Авлигын эсрэг хуулийн 3-р зүйлд авлига гэж албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглаж бусдад давуу байдал олгосныхоо төлөө өөрт нь болон бусдад буй болох эдийн болон эдийн бус ашигт байдал гэж тодорхойлсон байна. "Авлига,

хээл⁶ хахуулийн гэмт хэрэг хоёр нь агуулгын хувьд ялгаатай ойлголт юм. Авлига нь нийгмийн шударга ёс, хууль тогтоомжийг тойрон гарч, албан тушаалтнаар хууль бус үйлдлийг хийлгэх зорилгод шууд үйлчилдэг.

Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах хэлтсийн 2012 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайланд иргэд, байгууллагаас ирүүлсэн гомдол мэдээллийн агуулга, холбогдох байгууллага, салбраар нь авч үзвэл нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаанд хамаарах 52 гомдол мэдээллийн 43-засаг даргын үйл ажиллагаанд, 9- ЗДТГ-ын үйл ажиллагаанд, хууль хяналтын байгууллагын үйл ажиллагаанд хамаарах 23 гомдол мэдээллийн **4-цагдаа**, 4-шүүх, 7-ШШГБ, 3- мэргэжлийн хяналт, 3-гааль, 2-хил хамгаалах байгууллагын үйл ажиллагаанд, боловсрол, эрүүл мэнд төрийн үйлчилгээний салбарт хамаарах 29 гомдол мэдээллийн 21 -боловсрол, 5-эмнэлэг, 2-улсын бүртгэлийн алба, 1-даатгал, газар ашигт малтмалын салбарт хамаарах 9, яамдын үйл ажиллагаатай холбоотой 7, УИХ-ыг гишүүдтэй холбоотой 3, төрийн болон орон нутгийн өмчит улсын үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд хамаарах 11. аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд хамаарах /хувийн хэвшил/ 19 бусад 30 тус тус эзэлсэн байна⁷.

Үүнээс үзэхэд цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой гомдол мэдээлэл багагүй хувийг эзэллэж байгаа нь авлига биднээс ангид байхгүй юм. Мөн алба хаагчдаас зөрчил дутагдал заагдаж сахилгын шийтгэл ногдуулж, эрүүгийн хэрэг үүсгэн шалгагдаж, шийтгэх тогтоолоор⁸ шийтгүүлж байсан тохиолдол ч байх юм. Тиймээс юунаас болоод яагаад шийтгүүлэх болов? гэдэг асуултанд хариулт хайх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл хогийн зэрлэг ургамалыг ишээр нь тасдаад байвал дараа жил нь улам олон болж үндэс нь бүдүүрэх учраас түүнийг үндсээр нь сугалж хаях арга техникийг боловруулах хэрэгтэй юм.

Доктор, профессор Л.Батжав, Б.Цэвээн нарын үзэж байгаагаар авлига, ашиг сонирхлын зөрчил гаргаж буй нөхцлийг судлахад:

1. Удирдах албан тушаалтаны харьцааны соёл ааш ариншингийн байдал багагүй нөлөө үзүүлдэг.
2. УИХ-аас батлан мөрдүүлж байгаа хуулиудыг хэрэгжүүлэхтэй холбогдуулж яам, агентлагын сайд, дарга нарын тушаалаар баталсан олон мянган дүрэм журам, заавар, аргачлал, хүнд суртлын уурхай болж ашиг сонирхолын зөрчил. авлига газар авахад ихээхэн нөлөө үзүүлдэг
3. Ажилтнуудаа авлига, ашиг сонирхолын зөрчилд орохоос урьдчилан сэргийлэх талаар удирдах албан тушаалтан хайнга хандсанаас ийм зүй бус үйлдэл гарах үүд хаалга нээгдэх тал бий
4. Хэн нэгэн нэр хүнд бүхий хүний буруу үйл ажиллагаа зуршлын нөлөөнд автах явдал нь ашиг сонирхолын зөрчил авлигын нөхцөл болдог бол ашиг сонирхолын зөрчил авлигын шалтгааныг эдийн засгийн харилцаанаас эхлэлтэй нийгэм, улс төрийн харилцаанаас хамааралтай, нийгмийн ес суртахуунаас үүдэлтэй гэж ангилан авч үзжээ.

Авлига, ашиг сонирхолын зөрчлийн гол шалтгаан нийгмийн ёс суртахуунаас үүдэлтэй шалтгаан юм. Ашиг сонирхолын зөрчлийн тоо хэмжээ, чанарын үзүүлэлт, түүний нийгэмд учруулж байгаа хор аюулын байдал нь төрийн захиргааны байгууллагын удирдах ажилтан, албан хаагч болон жирийн иргэдийн ёс суртахуун, хүний мөсийг илэрхийлэх чухал хэмжүүр болно. Тиймээс авлига, ашиг сонирхолын зөрчлийн нийгмийн ёс суртахууны байдал, үнэлэмжээс хайх хэрэгтэй⁹.

АТГ-аас 2013 онд явуулсан авлигын индексийн судалгааны шинжээчдийн болон олон нийтийн төсөөллийн судалгаанд оролцогч шинжээч иргэд төрийн албан хаагч бизнес эрхлэгчдээс монгол улсад авлига үүсэж буй шалтгаан нөхцлийг асуухад дараах шалтгаануудыг гол шалтгаан гэж нэрлэсэн байна.

Шинжээч, иргэд, төрийн албан хаагч, бизнес эрхлэгчдийн үзсэнээр улс төрийн нөлөө их, ашиг сонирхолын зөрчил үүсэх магадлал өндөр, төрийн албан хаагчдын цалин орлого бага, эрх зүйн зохицуулалт, хуулийн хэрэгжилт сул байгаа нь монгол улсад авлига үүсэх гол шалтгаан гэж дүгнэж болохоор байна. Түүнчлэн шинжээч, төрийн албан хаагч, бизнес эрхлэгчдийн үзэж байгаагаар хүмүүсийн сэтгэлгээ, ухамсарын түвшин муу, ёс зүйгүй байдал нь авлига үүсэх бас нэг гол нөхцөл болохыг харууллаа. Авлига үүсэхэд хамгийн ихээр нөлөөлж буй гол шалтгааныг шинжээчид хариуцлага тооцдоггүй хөндлөнгийн хяналт сул гэж дүгнэсэн байхад иргэд төрийн

⁶хээл - бусдад зусдаглаж хахууль болгон өгөх эд юм, хахууль идэх буюу хээл авах, хээл зутгах буюу бусдад өгөх зүйл

хээл - дэлхий нийтэд bribe буюу хээл хахуулийн тухай асуудал нь агуулах үзэгдлийнхээ үйл явцын хувьд асар өргөн болоод хамрах орон зай нь нийгмийн бүх л салбар түвшинг эзэлдэг.

⁷www.Iaac.mn

⁸ Албан тушаалын гэмт хэргийн шүүхийн шийдвэрийн эмэхтгэл №2. т.118-119, 2010

⁹ Батжав Л., Цэвээн Б., Ашиг сонирхлын зөрчил, УБ., 2009, т.56

албан хаагчид ажилгүйдэл болон ядуурал, бизнес эрхлэгчид төрийн үйлчилгээний хүртээмж муу байгаа нь авлига үүсэх шалтгаан болж байна гэж үзсэн байна.¹⁰

Тэгвэл цагдаагийн алба хаагчын авлигад өртөх нөхцлийг авч үзье:

- Цагдаагийн алба хаагчийн мэдлэг боловсрол, мэргэжлийн ур чадвар их нөлөөтэй
- Цагдаагийн алба хаагчийн үндсэн цалин гэр бүлээ тэжээж амьдрал ахуйгаа аваад явж чадах хэмжээнд байж чадахгүй
- Цагдаагийн байгууллагын иргэдэд үзүүлдэг үйлчилгээ нь өөрөө хууль тогтоомж тушаал шийдвэрийг хэрэгжүүлэх, удирдлага болгох, биелүүлэх хүрээнд байдаг ба иргэдийн зарим эрхийг хязгаарлахад хүрдэг
- Иргэдийн сэтгэлгээ ухамсарын түвшин муу, ёс зүйгүй байдал, хууль эрх зүйн мэдлэг дутмаг
- Цагдаагийн байгууллагын хуулийг хэрэгжүүлэх үеийн процессын ажиллагаа нь цаг хугацаа их зарцуулдаг, шат дамжлага их байдаг
- Монгол улсын хүн амын цөөн байдал нь гол нөхцөл болж өгдөг. Нэг нутаг усны хүмүүс, танилын танил, найзын найз гэх зэргээр ямар нэгэн байдлаар ашиг сонирхлын зөрчилтэй болоход хүрдэг.

Цагдаагийн алба хаагчийн авлигын шалтгааныг авч үзвэл:

- Эдийн засгийн хямралт байдал, банк санхүү зээлийн хүрэн дэх элдэв зөрчил, гэнэтийн үйл явдлаас үүдэлтэй хэрэгцээ шаардлага
- Нийгмийн харилцаанаас үүдэлтэй. Цагдаагийн алба хаагчийн хөдөлмөр эрхлэлт, ажиллах нөхцөл бололцоо, ажлын байран дахь дарамт шахалт, ажлын хэт их ачаалал, орон сууцны нөхцөл, амь зуулгын хэрэгсэл, эрүүл мэнд, боловсролын байдал зэрэг өргөн хүрээтэй асуудлууд байна
- Цагдаагийн алба хаагчийн ёс суртахуун, мэдлэг боловсрол, хувь хүний төлөвшил, албандаа хандах хандлага, ухамсарын түвшин, зарчимч байдал алдагдах болсон нь гол шалтгаан болж байна.

ДҮГНЭЛТ, САНАЛ

Дээрх шалтгаан, нөхцлөөс үзэхэд цагдаагийн алба хаагч авлигад өртөж буй нь эдийн засаг, нийгмийн асуудалтай холбоотой боловч ёс суртахуун, зарчимч байдал ихээхэн ач холбогдолтой. Нийт Цагдаагийн албаны бие бүрэлдэхүүнд сайн муу нийлж сав дүүргэдэгтэй адил бусдыхаа нэр төрийг өөрийн хийсэн үйлдлээрээ гутаадаг нэгэн байхад шудрага хөдөлмөрөөрөө олсон хэдэн төгрөгөө амьдрал ахуйдаа хүргэх гэж хичээж яваа нь олон байгаа.

Өнөө үед шудрага ёс оршин тогтнож бүхнийг дийлдэггүй цаг ирснийг нийгэм өөрөө харуулж байна. Нэгэнт бий болсон нийгмийн энэхүү гаж үзэгдлийг хэрхэн бууруулах талаар ямар арга хэмжээ авах нь төрийн ухаалаг бодлогоос гадна төрийн алба, хууль хяналтын байгууллагын хяналт маш чухал юм.

Иймээс цагдаагийн байгууллагын хүрэн дэх авлигыг бууруулахад дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

1. Цагдаагийн албаны чадавхыг сайжруулах
2. Ур чадвар үндэслэн томилгоо хийх
3. Байгууллагын ил тод байдлыг нэмэгдүүлэх
4. Албан тушаалтныг чөлөөлөх, өөрчлөх, халахдаа шудрага ил тод байдлыг бий болгох
5. Тогтвортой ажиллах баталгааг сайжруулах
6. Алба хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх, нийгмийн баталгааг сайжруулах
7. Албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх механизмыг боловсронгуй болгож хэрэгжүүлэх
8. Эрүүгийн хуульд заасан хээл хахууль өгөх, авах, зуучлах гэмт хэргийн хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох¹¹
9. Техник технологийн дэвшлийг ашиглах
10. Авлигын эсрэг үйл ажиллагааг олон нийтэд сурталчилах, авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагаандаа иргэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх

¹⁰ www.Iaac.mn

¹¹ Эрүүгийн хуульд хээл хахууль өгөх, авах, зуучлах үйлдлийг гэмт хэрэг байхаар заасныг хээл хахууль авсан, зуучилсан тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр зааж, хээл хахууль өгөх үйлдлийг сайн дураар хэргээ илчилсэн тохиолдолд эрүүгийн хариуцлагаас чөлөөлж, тухайн шийдвэрлүүлэхээр хахуулдсан асуудлыг хуулийн хүрээнд тодорхой хөнгөлөлттэйгээр шийдэх хүртэл урамшуулах хэм хэмжээг тусгах, хэрэв сайн дураар илчлээгүй бол хариуцлага хүлээдэг тогтолцоог судалж нэвтрүүлэх

11. Алба хаагчийн ёс зүй, харьцааны соёл, хариуцлагыг нэмэгдүүлэх
12. Авлигын эсрэг хууль, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхолын зөрчилөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хуулийн хэрэгжилт хяналтыг сайжруулах шаардлагатай юм.

НОМ ЗҮЙ

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Монгол Улсын Эрүүгийн хууль
3. Авлигын эсрэг хууль
4. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль
5. Редактор Баатар Я., Авилгал бол мөнхийн үзэгдэл биш, УБ, 2002
6. Зориг сан, Авилгал түүний ойлголт, тэмцэх арга зам семинарын эмэхтгэл, УБ, 2001
7. Редактор Ганхуяг Б., Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт мониторингийн судалгаа, УБ, 2004
8. Ихзаяа П., Жанцан С., Мөнхдорж Б., Гэмт хэргийн статистик, УБ., 2007
9. Батжав Л., Хээл хахуулийн гэмт хэрэгт хүлээлгэж байсан эрүүгийн хариуцлагын түүхэн хөгжил, УБ, 2000
10. Батжав Л., Хээл хахуулийн гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн үндсэн шинж, УБ, 2003
11. Батжав Л., Албан тушаалын гэмт хэргийг зүйлчлэхэд анхаарах асуудал, УБ, 2000
12. Батжав Л., Цэвээн Б., Ашиг сонирхлын зөрчил, УБ, 2009
13. Авилгын эсрэг сан ТББ, Хээл хахууль, авилга, ашиг сонирхлын зөрчил, УБ, 2012
14. Батжав Л., Дангаасүрэн Б., Авилга, авилгын зөрчил, гэмт хэргийн эрүүгийн эрх зүй керминологийн асуудал, УБ, 2007
15. Vip76.mn/content/25463
16. www.Iaac.mn

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЖОЛООЧ БЭЛТГЭХ КУРСЫН СУРГАЛТЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИНД ХИЙХ ДҮН ШИНЖИЛГЭЭ

VEHICLE DRIVER TRAINING COURSE IN THE LEGAL ENVIRONMENT ANALYSIS

Б.Энхболд

Замын цагдаагийн албаны Урьдчилан сэргийлэх олон нийттэй харилцах хэлтсийн мэргэжилтэн, цагдаагийн ахлах дэслэгч


Товч агуулга: Монгол Улсын дэд бүтцийн хөгжил хийгээд иргэдийн амьжиргааны түвшингээс хамаарч сүүлийн хориод жил тээврийн хэрэгслийн тоо огцом өссөнтэй уялдан олон сайн хийгээд сөрөг үзүүлэлт нийгмийг бүхэлд цочроох хүртэл хэмжээнд очиж байна. Энэ байдлаас үзэхэд монгол улсад 18-34 насны, эрэгтэй шинэ жолооч буюу 5 жил хүртэл түүнээс доош жил жолоо барьсан хүмүүс зам тээврийн осолд ихээр холбогдож байна. Энэ насны хүмүүс замын хөдөлгөөнд ихээр оролцдог ч нөгөө талаас тэдгээр нь шинэ жолооч, дадлага туршлага ур чадвар муутай, хурд хэтрүүлэх дуртай, замын хөдөлгөөний дүрэм мэддэггүй мэдсэн ч биелүүлдэггүй хэнэггүй байдал нь зам тээврийн осолд холбогдох хүчин зүйл нь болж байна. Иймд шинэ жолооч нарыг дадлагажуулж туршлагажуулахын тулд жолооны сургалтын одоо мөрдөгдөж байгаа сургалтын журамд өөрчлөлт оруулж сургалтын эрх зүйн орчинг боловсронгуй болгон чанаржуулж олон улсад мөрдөгдөж байгаа сургалтын хөтөлбөртэй харьцуулалт хийж сургалтын шинэлэг арга барилыг хэрэгжүүлэх нь нэн шаардлагатай байгаа нь харагдаж байна.

ОРШИЛ

Монголчуудын өмнөх нийгмийн үед “жолооч”¹² гэдэг бол тусгайлсан урт хугацаагаар суралцдаг “мэргэжил” байсан бол эдүгээ бүхий л хүмүүсийн үндсэн хэрэглээний нэг болжээ. Иймдээ ч Монголын хүн амын 3/1 ээс илүү хувь нь жолооч болсон явдал нь Замын хөдөлгөөний аюулгүй байдал¹³-д олон эрсдлийг дагуулж байна. Нийгмийн массыг хамарсан өргөн хэрэгцээг хангах нь зах зээлийн эдийн засаг хөгжсөн өнөө үед мөнгөний их урсгалыг араасаа дагуулж байна.

Өнөөгийн байдлаар улсын хэмжээнд алба ёсны эрхтэй 394 жолооч бэлтгэх курс үйл ажиллагаа эрхлэн явуулж шинээр жолооч бэлтгэж байна. Үүнээс дунжаар жилд 60000-80000 мянган иргэн шинээр жолооч болж байгаа бөгөөд одоогоор 1,131,000¹⁴ хүн шинээр жолооч болж жолоодох эрхийн үнэмлэх авсан байна.

Монгол улсад жолоодох эрх бүхий 2014 оны байдлаар 977366 жолооч байсан бол 2016 оны байдлаар 1,129,000 хүн шинээр жолоочийн бүртгэлд орсон байна. Хүйсийн байдал эрэгтэй 66%, эмэгтэй 34%, хүйсийн харьцаагаар авч үзвэл 89.8% хувь нь эрэгтэй жолооч хэрэгт холбогдож, Автомашин жолоодох эрх бүхий 200 жолооч дунджаар амь насаа алдсан байна¹⁵.



¹² “Жолооч”- тээврийн хэрэгслийг жолоодож яваа хүн. Жолоодлогын дадлага хийлгэж яваа багш, замаар ердийн хөсөг унаж, хөтөлж яваа хүнийг жолоочид хамааруулж ойлгоно.

¹³ Замын хөдөлгөөний аюулгүй байдал нь: “Хүн-Тээврийн хэрэгсэл-Зам- Орчин” гэсэн өөр хоорондоо харилцан уялдаа холбоо, шүтэлцээ бүхий элементүүдийн аюулгүй байдлын цогц гэж тодорхойлжээ.

¹⁴ Цагдаагийн ерөнхий газрын Лицензийн төвөөс 2016 онд гаргасан судалгаа

¹⁵ Монгол Улс дахь зам тээврийн осол, зөрчлийн статистик. Ц.Эрдэнэчимэг УБ., 2016т. 20:

№	Жолоочийн хугацаа	Хувь
1	0-5	40.3
2	6-10	27.7
3	11-15	29.5
4	16-20	4.4
5	25 ба түүнээс дээш	0.5

Тээврийн хэрэгслийн жолооч дүрэм журмаа биелүүлээд, замын хөдөлгөөнд сахилгатай, соёлтой оролцохыг зорчигчдод үлгэрлэх нь аюулгүй байдлыг хангах нөхцлийг бүрдүүлдэг юм.

Сүүлийн жилүүдийн зам тээврийн ослын статистик үзүүлэлтүүдээс дүгнэлт хийхэд бүртгэгдэж буй зам тээврийн ослын дийлэнх нь хувь нь жолоочийн буруутай үйлдлээс гарч, хохирлын тоон үзүүлэлтээс явган зорчигч, тээврийн хэрэгслээр зорчигч ихээхэн гэмтсэн нь жолоочийн буруугаас хүмүүс ихээхэн хохирол амсч байгаа учраас хор уршгийг нь харж хариуцлага тооцдог механизм манай улсад нэн тэргүүнд хэрэгтэй байгаа юм. Явган зорчигч, тээврийн хэрэгслээр зорчигчийн амь нас, эрүүл мэнд ихээхэн хохирч байгаан тун харамсалтай явдал юм. Иймд бид жолооч бэлтгэх сургалтыг чанаржуулах нь нэн шаардлагатай болоод байна.

Сэдвийн агуулгын хүрээнд тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх курсын сургалт, уг сургалттай холбогдсон эрх зүйн орчинд дүн шинжилгээ хийснээ толилуулж байна

ҮНДСЭН ХЭСЭГ

Жолооч-автомашин-зам-орчин гэсэн системд жолооч хамгийн онцгой байр эзэлдэг.

-Өөрөө суралцах үйл явцдаа дадлага олж авах / харьцангуй аажмаар дадлага хуримтлуулах/, суралцах хугацаанд / арай хурдан мэдсэн, чадвараа ашигтайгаар хуримтлуулах/,

-Өөрийн үйл ажиллагаанд дүгнэлт хийх, чадварыг хуримтлуулах туршлагыг ашиглах,

-Ой тогтоомж- санах чадвартай зөвхөн мэдээллийг сэргээн авахад биш харин дадлага дүйг олж авах,

-Өнгөрсөн мэдээллийг сэргээн бодох чадвартай дадлага болох,

-Ухамсартайгаар үйл ажиллагаагаа удирдах, ослоос болон хнүд нөхцлөөс гарах чадварыг эзэмших,

-Урд гаргасан алдаагаа давтахгүй, түүнээс сургамж авах, жолоодох ур чадварыг чадамгай эзэмших,


-Жолооч- автомашин-зам-орчинд дасан зохицох, аюул гарч болох нөхцлүүдийг урьдчилан анхаарах мэдэрч, сэтгэдэг, сонор сэрэмжтэй байх,

-Ядрах, өвдөх, нас ахисны шинжүүд болон согтууруулах ундаа хэрэглэх өөрийгөө эмчлэх зэргээс аль болох татгалзаж явах зэрэг нь ЗТО-оос урьдчилан сэргийлж чадах нөхцлүүдийг бүрдүүлнэ.

Замын хөдөлгөөнд оролцогч хэн бүхэнд замын хөдөлгөөнд зөв оролцох дадлыг тухайн замын хөдөлгөөнд оролцогчдын дадал хэвшил болгох асуудал нэн чухал байгаа юм. Замын хөдөлгөөнд оролцогч хүн бүхэн дүрмээ биелүүлдэг, биелүүлэх ёстой гэсэн сэтгэл зүйтэй байх юм бол зам тээврийн ослоос урьдчилан сэргийлж, амь насаа алдах, бусдын амь насыг хохироох, эрүүл мэндээрээ хохирох асуудал буурах магадлалтай юм.

Мөн жолооч болсон жилээр гаргасан үзүүлэлтийг бүлэглэн авч үзвэл 0-5 жил автомашин жолоодсон жолооч 38.2 хувь, 6-10 жил автомашин жолоодсон жолооч 29.2 хувь, 11-15 жил жолоодсон жолооч 21.9 хувь буюу дийлэнх хувийг шинэ жолооч эзэлж байгаа нь шинэ жолооч зам тээврийн осолд холбогдох нь их байгааг харуулж байна.

Зам тээврийн осол үйлдсэн хүмүүсийн жолооч болсон жилээр гаргасан үзүүлэлт



Түүнчлэн жолооч болоод удах тусам замын хөдөлгөөнд оролцохдоо үр чадвар нь дээшилж зам тээврийн осол, зөрчилд холбогдох нь багасч байгаа нь жолоодох үр чадвар нь замын хөдөлгөөнд зөв оролцох, зам тээврийн осол, зөрчилд холбогдох эрсдлийг бууруулах өндөр магадлалтай юм.

Манай улс зам тээврийн ослоор нас баралтаараа эхний 25 орны нэг болсон нь туйлын харамсалтай тоо мэдээ юм. Энэ бүх зам тээврийн ослын ихэнх хувийг жолоочийн буруутай үйлдэл гэсэн тодорхойлолт гарч байгаа нь манай улсын жолооч нарын ухамсарт үйлдлээс хамааралтай байна.

Дээрхи судалгаанаас үзэхэд зөв зөрчилд холбогдож байгаа тээврийн хэрэгслийн жолооч нарын дийлэнх хувийг шинэ жолооч нар эзэлж байгаа нь тэдний замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг дутуу, хөдөлгөөнд оролцох байдал нь тааруу, зам тээврийн ослоос гарах үр дагаврын талаарх мэдлэг муугийн шинж билээ.

Өнөөгийн манайд мөрдөгдөж байгаа журмаар сургалтын хөтөлбөр нь:

Онол ба Дадлага гэсэн хоёр хэсгээс бүрдсэн сургалтын системтэй.

Онол хэсэгт / Замын хөдөлгөөний дүрэм, эрх зүйн мэдлэг/гэсэн 2 хөтөлбөртэй.

Дадлага хэсэгт (Талбайн дадлага,дром/ хотын жолоо) гэсэн 2 сургалтын хөтөлбөртэй байна.

Монгол улсад 1929 онд 20 автомашин замын хөдөлгөөнд оролцож байсан бол 86 жилийн дараа буюу 2015 онд 720278 автомашин болон өсчээ.МУ нутаг дэвсгэрт хөдөлгөөнд оролцож буй автомашины 439129 буюу 60,9 хувь тээврийн хэрэгслийн 466677 буюу 59,1 хувь нь Улаанбаатар хотод бүртгэлтэй байна¹⁶.

Монгол улсад автомашины тоо жил ирэх тусам нэмэгдсэн нь 2015 онд **720278** хүрч насанд хүрсэн 3 хүн бүрт 1 автомашин ноогдож байна¹⁷.

“Зам тээврийн осол” –н зам дээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүдэн хүний амь бие, эрүүл мэнд хохирох, тээврийн хэрэгсэл болон замын байгууламж эвдэрч гэмтэх, ачаа болон бусад эд материалын хохирол учрах явдал¹⁸-ыг хэлнэ.

ЗТО гарсан шалтгааныг ангилан үзвэл:

-Жолоочийн буруутай үйлдлээс

- Явган зорчигчийн буруутай үйлдлээс
- Замын нөхцөлөөс
- Техникийн гэмтлээс гарсан гэсэн 4 зүйлд ангилж байна.
- Зам тээврийн осол гарсан шалтгаан¹⁹


¹⁶ Авто тээврийн газрын Зам тээврийн хяналт,бүртгэлийн газраас гаргасан үзүүлэлтээс авав.

¹⁷ Монгол Улс дахь зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлт.Ц.Эрдэнэчимэг. УБ.,2016т.6

¹⁸ Монгол Улсын замын хөдөлгөөний дүрэм.1,4 заалтаас


¹⁹ Монгол Улс дахь зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлт.Ц.Эрдэнэчимэг. УБ.,2016т.15,2015т.15,2014т.16

№	Улсын хэмжээнд бүртгэж шалгасан зам тээврийн осол	2013он		2014он		2015он	
		18367 зөрчил		31585 зөрчил		45161 зөрчил	
		Зөрчил	Хувь	Зөрчил	Хувь	Зөрчил	Хувь
1	Жолоочийн буруу	17848	97.2	30110	95.3	43570	96.5
2	Явган зорчигчийн буруу	475	2.6	1444	4.6	1542	3.4
3	Замын нөхцлөөс гарсан	44	0.2	31	0.1	49	0.1



Бүртгэгдсэн зам тээврийн ослын жолоочийн буруутай үйлдэл буюу жолоочийн хууль, дүрэм, зөрчсөн, сахилгагүй, хариуцлагагүй үйл ажиллагаа, тэдний шууд буруутай үйлдэл байна. Жолоочийн буруутай үйлдлийн статистик мэдээ²⁰.

Жолоочийн буруутай үйлдэл



Зам тээврийн осол гэмтлийн гол эрсдэлтэй / шалтгаан / хүчин зүйлүүд нь:

- Согтуугаар автомашин жолоодох
- Хамгаалалтын бүс, малгай хэрэглэхгүй байх

²⁰ Монгол Улс дахь зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлт.Ц.Эрдэнэчимэг. УБ.,2016т.16,2015т.16,2014т.17

- Хурд хэтрүүлэх
- Замын дэд бүтэц хангалтгүй байх.

ЗТО хэргээс урьдчилан сэргийлэх, гарсан осол гэмтэл түүний үр дагаврыг бууруулах тодорхой үйл ажиллагаануудыг хэрэгжүүлж үр нөлөөг нь тооцох нь чухал болоод байна.

Анхаарал болгоомжгүй замын хөдөлгөөнд оролцох нь автомашин жолоодон замын хөдөлгөөнд оролцож буй жолооч нь гар утсаар ярих, нүүрээ будах /эмэгтэйчүүд/, тамхи асаах, хүүхэдтэйгээ зууралдах зэргээр анхаарал сарнихад жолоочийн хөдөлгөөн удаашрах, гэрэл дохио зөрчих, эгнээ байр эзлэхдээ бусдыг анхаарахгүй байх, хажуу хоорондын зайг барихгүй зэрэг нь жолоочийн үр чадварт нөлөөлдөг байна. Ялангуяа шинэ жолооч нарт ихээхэн тохиолддог гар утсаар ярьж хөдөлгөөнд оролцох үед жолооч нь чихэвч ашиглаж сураагүйгээс нэг гараараа жолооны хүрдийг эргүүлснээр осол гарах нөхцлийг бүрдүүлдэг. Энэ байдлаас авч үзвэл жолоочийн үр чадвар хангалтгүй, туршлага багатай жолооч нар замын хөдөлгөөнд ихээр оролцож байгаатай холбоотой гэж үзэж болно.

Хамгаалалтын бүс, малгай хэрэглэхгүй байх нь аюулгүйн бүсийг 25 хүртэл насны эрэгтэйчүүд бусад насны бүлгийнхнээс бага хэрэглэдэг байна. Аюулгүй бүс нь гэмтэл бэртэл авах эрсдэлийг 40-50 хувь, нас баралтыг 40-60 хувь тус тус бууруулдаг. Мотоциклын малгай нь толгойн гэмтэх эрсдэл болон гэмтлийн зэргийг 70 хувь бууруулдаг байна²¹.

Хурд хэтрүүлэх нь олонхи улс оронд зам тээврийн осол гарах үндсэн хүчин зүйл болдог нь ялангуяа шинэ, залуу жолооч нартай холбоотой байна. Хурдыг 1км /цаг- аар бууруулахад зам тээврийн осол 4-5 хувь буурдаг гэж олон улсад үздэг байна. Осол гарах үед автомашины хурд 30 км/ цаг түүнээс бага хурдтай байхад осолд өртсөн явган зорчигч /бусад оролцогчид /-ын авсан гэмтэл нь үхэлд хүргэх эрсдэлд хүргэдэггүй²². Өөрөөр хэлбэл хурд багатай явах тусам хохирол бага учирна.

Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох нь шинэ залуу жолоочийн согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ зам тээврийн осол гаргах магадлал нь 30 ба түүнээс дээш насныхнаас 5 дахин их²³ байдаг байна.

Орон нутгийн замд нийт ослын талаас илүү хувийг эзэлж байгаа шалтгаан нь хяналт шалгалт тавих боломж дутмаг байгаатай холбон үзэж болох талтай ч жолооч нар хяналтгүй газар сахилга батгүй, замын хөдөлгөөний дүрэм журам биелүүлэхгүй байгаатай холбоотой юм.

Энэ бүгдээс харахад это ихэнх нь жолоочийн буруутай үйлдэл байгаан жолооч замын хөдөлгөөний дүрэм биелүүлээгүй жолоочийн буруугаас гарсан ослын улмаас хотод явган зорчигч, орон нутагт тээврийн хэрэгслээр зорчигчийн амь нас, эрүүл мэнд хохирсоор байна.

2014 онд гэмт хэрэгт холбогдсон 18-34 насны хүмүүс 62.3% эзэлж, эрэгтэй жолооч 90.1% -г эмэгтэй жолооч харьцангуй бага 9.9% эзэлж байна²⁴. Үүнээс

2015 онд гэмт хэрэгт холбогдсон жолоочийн хүйсийн ерөнхий харьцаанаас эрэгтэй жолооч 89,8 хувийг үлдсэн 10,2 хувийг эмэгтэй жолооч эзэлсэн²⁵ харьцангуй бага үзүүлэлтэй гарсан байна.

Гэмт хэрэгт холбогдсон жолооч нарын нийгмийн байдлыг авч үзвэл²⁶:

²¹ Монгол Улс дахь зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлт.Ц.Эрдэнэчимэг. УБ.,2016т.16


²² Монгол Улс дахь зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлт.Ц.Эрдэнэчимэг. УБ.,2016т.17

²³ Монгол Улс дахь зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлт.Ц.Эрдэнэчимэг. УБ.,2015т.25

²⁴ Монгол Улс дахь зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлт.Ц.Эрдэнэчимэг. УБ.,2015т.24

²⁵ Монгол Улс дахь зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлт.Ц.Эрдэнэчимэг. УБ.,2015т.24

²⁶ Монгол Улс дахь зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлт.Ц.Эрдэнэчимэг. УБ.,2016т.21,2015т.26,2014т.24



	Ажил хөдөлмөр эрхэлдэггүй	Хувиараа хөдөлмөр эрхэлдэг	Хувийн хэвшлийн ажилтан	Ажилчин, малчин	Төрийн албан хаагч	Төрийн бус байгууллагын ажилтан
■ 2013он	1298	3.2	308	126	129	60
■ 2014он	779	520	310	161	130	61
■ 2015он	914	418	320	128	129	45

Боловсролын хувьд гэмт хэрэгт холбогдсон жолооч нарын талаас илүү буюу 57,2 хувь нь бүрэн дунд боловсролтой байна. Гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийн 409 нь буюу 20,0% хувь нь согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож явсан, 27 буюу 1,4 хувь нь урьд нь ял шийтгэгдэж байсан гэсэн тоон үзүүлэлт гарчээ.²⁷

ДҮГНЭЛТ

Монгол Улсад гарч байгаа зам тээврийн ослын дийлэнх хувийг жолоочийн буруутай үйлдэл гэсэн статистик дүн мэдээ эзэлж байдаг. Зам тээврийн ослын шалтгаан нөхцлийг үзэхэд ихэнх зам тээврийн осолд жолоочийн ухамсарт үйлдэл бие биенээ үл хүндэтгэх, соёлтой боловсон, хөдөлгөөний дэг журамгүй зам хөдөлгөөний дүрмээ биелүүлээгүй байдлаас үүсэлтэй байна. Манай улсад зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх түгжирлийг бууруулах чиглэлээр шинээр төсөл төлөвлөгөө журам батлуулан ажилласан ч тодорхой үр дүнд хүрдэггүй. Энэ бүхнээс үзэхэд бид одоогоор хичнээн их урьдчилан сэргийлэх ажил хийж хэрэгжүүлсэн ч зам тээврийн осол зөрчлийн тоо буурахгүй байгаан жолооч нары буруутай үйлдлээс гэж үзэж болхоор байна. Иймд нэгэнт бид энэ байдлаас гархын тулд жолоочийн сургалтын орчинд өөрчлөлт оруулж сургалтын шинэлэг хөтөлбөр боловсруулж төгсгөвөл зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх маш том алхам болох юм. Гадаад орнуудын тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх сургалтын туршлагаас олж авсан зүйлээ өөрийн орондоо хэрэгжүүлж харьцуулсан судалгаа хийж дүгнэлт өгч ажиллах нь өнөө үед хамгийн түрүүнд хийх ажлуудыг нэг юм. Судалгаанаас үзэхэд манай улсад шинээр төгсөж жолооч болсон жолооч нарын дийлэнх хувийг шинээр жолооч болж хөдөлгөөнд оролцож зам тээврийн осолд холбогдох болсон шалтгаан нь үүнтэй холбоотой.

САНАЛ

Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх сургалттай холбогдсон эрх зүйн орчны дүн шинжилгээ

“Хүний амь” гэдэг юугаар ч нөхөж баршгүй үнэт зүйлийг Зам тээврийн ослоос бид авран хамгаалахад юуны өмнө уг шалтгаанд нь системтэйгээр өөрчлөлт хийх явдал юм. Үүнд:

Нэгт. Жолооч бэлтгэх сургалтын эрх зүйн орчинд зохих хууль, дүрэм, журамд өөрчлөлт оруулах. Ингэснээр жолооч бэлтгэх дамжааны эрх зүйн баталгаа хангагдана.

Хоёрт. Жолооч бэлтгэх сургалтын хөтөлбөрийг өргөтгөх, шинэчлэх, Замын цагдаа болон бусад холбогдох байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах.

Гуравт. Сургалтын хөтөлбөрийг шинжлэх ухааны үндэстэй боловсруулж байгаа судлаачид хийгээд мэргэжлийн хамт олны сургалтын хөтөлбөрөөр сургагч багш бэлтгэх. Сургагч

²⁷ Монгол Улс дахь зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлт. Ц.Эрдэнэчимэг. УБ., 2016т.34

багш нарын үйл ажиллагааг тогтмол, системтэйгээр хөгжүүлэн шинэчилж нэгдсэн графиктайгаар жолооны курсын багш нарт сурталчлах, танилцуулах хичээл оруулах гэх мэт нь эцсийн үр дүн нь Монгол хүний алтан амийг зам тээврийн ослоос хамгаалах, аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх үйлсэд чухал ач холбогдолтой юм. Энэ нь эдүгээ цагийн замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах нэг чухал үндэслэл болно гэж үзэж байна.

Одоогоор манайд мөрдөгдөж байгаа Хөдөлмөрийн сайд, Боловсрол соёл шинжлэх ухааны сайд нарын 2015 онд баталсан "Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх журам"*-д өөрчлөлт хийж шинэчлэн найруулах цаг нь болсон гэж үзэж байна. Учир нь:

Журмын хөтөлбөрт байгаа Онол хэсэгт:

- Замын хөдөлгөөний дүрэм
- Эрх зүйн сургалт

-Сэтгэл зүй, харилцааны сургалт/ ЗТО холбогдсон жолооч ямар сэтгэл зүйтэй байж асуудалд хандах, ЗТО холбогдсон жолооч шооконд ордог энэ байдалд зэрэгт бэлтгэгдэх, мөн цагдаа зохицуулагч нартай яаж харьцах ямар байдлаар асуудалд хандах зэрэг хэрэгтэй сургалтын хөтөлбөр юм.

- Эмнэлгийн анхан шатны тусламж сургалт/ ЗТО холбогдсон жолооч зорчигч хүнд гэмтсэн үед анхны тусламж үзүүлж чаддаггүй байдлаас болж нас барах,гэмтлийн зэрэг нь хүндрэх зэрэг асуудал тулгардаг энэ байдалд жолооч зорчигч эсвэл зөрж өнгөрч буй тээврийн хэрэгслийн жолооч нар анхны тусламж үзүүлж сургах нь маш хэрэгтэй байна.

Дадлага хэсэгт:

- Талбайн дадлага/дром/
- Хотын жолоо

-Бодит сургалт буюу/ модуль/ ЗТО ын бодит дүрсжүүлсэн зураглал бүхий бичлэг, ЗТО ын судалгаа шинжилгээ статистик мэдээ мэдээллийг бодитоор хүргэж өгөх нь нэн чухал асуудал болоод байна.

Эдгээр хэсгүүдээр шинээр хөтөлбөр боловсруулж оруулбал замын хөдөлгөөний аюулгүй байдал хийгээд зам тээврийн гэмт хэрэг осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх бас нэгэн том алхам болох юм.

Өнөөдөр манайд хэрэгжиж байгаа журмын дагуу Цагдаагийн ерөнхий газрын лицензийн төвд жилд дунджаар 8000 мянган жолооч жолоочийн эрх сэргээх шалгалтанд орж бодит модуль сургалтанд хамрагдан эрхээ сэргээлгэж байна. Жилд дунджаар 40 мянган жолооч жолоодох эрхээ хасуулж байгаагаас 98% нь согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчил бүртгэлтэй байгаан шууд жолоочийн буруутай үйлдэлтэй холбоотой байна.

Олон улсад хэрэгждэг зарим дүрэм журмаас үзвэл Европын холбооны зарим улсуудад жолоодох эрхийн сургалтанд хамруулахдаа иргэнийг сэтгэц мэдрэлийн байдлыг тогтоолгох зорилгоор сургалтанд хамруулж бсараас 1 жилийн хугацаанд уг хүний мөн чанар ёс суртахууны төлөв байдлыг тогтоон удаа дараагийн судалгаа хийгдсэний үндсэн дээр жолооч бэлтгэх сургалтанд хамрагдах шалгалтын тест авж байж тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх сургалтанд хамруулдаг байна.

НОМ ЗҮЙ

1.Ц.Эрдэнэчимэг, Монгол улс дахь зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлт эмхтгэл, УБ 2013

2.Ц.Эрдэнэчимэг, Монгол улс дахь зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлт эмхтгэл, УБ 2014

3.Ц.Эрдэнэчимэг, Монгол улс дахь зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлт эмхтгэл, УБ 2015

4.Д.Дүгэрээ,Ш.Бямбаа, Б.Батмөнх, Б.Баярсайхан, Замын хөдөлгөөний осолгүйн байдал,автотээврийн экологи,УБ 2008

5. Б.Энхболд, Монгол улсын замын хөдөлгөөний өнөөгийн байдал, УБ 2006

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙ ДЭХ ХУУЛЬ ЗҮЙН ФАКТ, ТҮҮНИЙ МӨН ЧАНАР, АНГИЛАЛ, ТӨРӨЛ

Г.Гантөмөр

*Отгонтэнгэр их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, хууль зүйн доктор /Ph.D./,
профессор*

Г.Лхагвамаа

*ХСИС-ийн Хууль Сахиулахын Удирдлагын Академийн аюулгүй байдлын удирдлага,
стратегийн профессорын багийн дэд профессор, хууль зүйн доктор /Ph.D./*

ЭЭЗүйн харилцааны чухал элемент болох хууль зүйн фактын ойлголт, мөн чанар, шинж, ангилал, төрлийг эрх зүйн онолын үндсэн дээр ЭЭЗүйн шинжлэх ухааны үүднээс судалж түүний бусад эрх зүйн хууль зүйн фактаас ялгагдах онцлог, чиг үүрэг, ЭЭЗүйн зохицуулалтын механизмд эзлэх байр суурь, эрүүгийн харилцааны агуулга, бусад элементүүдтэй хэрхэн холбогдох, нөлөөлөх байдлыг тодорхойлж судалсан болно.

Түлхүүр үгс: Legal fact-хууль зүйн факт, legal relationship-эрх зүйн харилцаа, эрүүгийн эрх зүйн харилцаа, эрүүгийн эрх харилцааны хууль факт, хууль зүйн event үйл явдал, эрх зүйн зан үйл, action-үйлдэл

Оршил. Эрүүгийн эрх зүй /цаашид ЭЭЗүй гэх/ нь эрх зүйн тогтолцоонд чухал үүрэгтэй, бие даасан эрх зүйн салбар болох нь түүний эрх зүйн зохицуулалтын механизмын онцлог, ЭЭЗүйгээр хамгаалагдаж, зохицуулагдаж байгаа нийгмийн харилцаа буюу хамгаалах болон зохицуулах зүйл, зохицуулалтын арга зэрэгтэй холбоотой юм. Үүнд ЭЭЗүйн харилцааны хууль зүйн факт ч нэгэн адил хамаарна.

Монгол улсад ЭЭЗүйн чиглэлээр гарсан бүтээлүүдэд ЭЭЗүйн зохицуулах зүйл буюу зохицуулах харилцааны талаар тодорхой хэмжээнд авч үзсэн²⁸ боловч хууль зүйн фактын тухай асуудлыг тусгайлан судлаагүй, зөвхөн эрүүгийн эрх зүйн харилцаа үүсэх, өөрчлөгдөх, дуусгавар болох хууль зүйн фактыг нэрлэх явдлаар хязгаарлажээ²⁹.

Иймээс ЭЭЗүйн харилцааны хууль зүйн фактын тухай асуудлыг онолын өндөр түвшинд гүнзгийрүүлэн судлах, ЭЭЗүйн зохицуулалтын механизмд түүний эзлэх байр суурь, ЭЭЗүйн харилцаа, түүний агуулга, бусад элементүүдэд үзүүлэх нөлөө, ЭЭЗүй дэх хууль фактын мөн чанар, онцлог, ангилал, төрлийг тодорхойлох шаардлага манай ЭЭЗүйн шинжлэх ухаанд зүй ёсоор тавигдаж байгаа, энэ чиглэлийн судалгаа үгүйлэгдэж байгааг хэлэх хэрэгтэй.

Үндсэн хэсэг.

Эрүүгийн эрх зүй дэх хууль зүйн фактын ойлголт . ЭЭЗүйн харилцааны хууль зүйн фактын тухай асуудал нь эрх зүйн ерөнхий онолоос үүдэлтэй, эрх зүйн харилцааны талаарх онолын сургаал, үзэл баримтлалд тулгуурладаг, бие даасан өөр онолын сургаалыг бий болгодоггүй³⁰.

Факт гэдэг нь латин хэлний **"factum"** буюу **"хийсэн, үйлдсэн"** гэсэн үгнээс гаралтай бөгөөд хамгийн ерөнхий утгаар тодорхойлбол байгаль, нийгмийн юмс үзэгдлийн үүсэх, оршин тогтнох, өөрчлөгдөн хувьсах, дуусгавар болох зүй тогтлын бодит илэрхийлэл, үндсэн нөхцөл, үр дагавар болсон, хүний хүсэл зориг

оос үл хамаарах эсвэл хамаарах, амьдралд бодитой оршин байдаг объектив шинжтэй үйл явдал, үйлдэл мөн³¹.

Академич С.Нарангэрэл уг ойлголтыг монгол хэлэнд **"хууль зүйн үйл баримт"** хэмээн томъёолж тодорхой эрх зүйн харилцааг үүсгэх, өөрчлөх дуусгавар болгох үндэслэл болсон, хуульд заасан нөхцөл байдал гэж тайлбарлажээ³². Эрх зүйн бусад бүтээлүүдэд **"хууль зүйн факт"** гэж томъёолж уг ойлголтыг тодорхойлсон байдаг.

²⁸ Г.Совд. БНМАУ-ын ЭЭЗүйн курс. Ерөнхий анги. УБ., 1974 он. 5- 7 дахь тал, С.Нарангэрэл. Монгол улсын ЭЭЗүй. Ерөнхий анги. УБ., 1998 он. 4-9 дэх тал, С.Жанцан. Монгол улсын Эрүүгийн эрх зүйн онол. I боть. Гэмт хэргийн сургаал. УБ., 2009 он. 9-12 дахь тал,

²⁹ Б.Ганболд. Эрүүгийн эрх зүйд нэвтрэхүй. УБ., 2012 он. 84-85 дахь тал

³⁰ Иймээс эрх зүйн онол дахь хууль зүйн фактын тухай онолын асуудлыг тулгуурлан судалж буй асуудлыг тодорхойлох, ингэхдээ түүний ЭЭЗүй дэх илрэх онцлогийг жишээ болгон авч үзсэн болно.

³¹ С.С.Алексеев. Общая теория права в 2 томах. Том 1. М. 1982 г. стр 163

³² С.Нарангэрэл. Эрх зүйн эх толь бичиг. Анхны хэвлэл. УБ., 2007 он. 555 дахь тал

Эрх зүйн онолд **"хууль зүйн факт"** гэдэг нь эрх зүйн хэм хэмжээнд заасан, эрх зүйн харилцаа үүсэх, өөрчлөгдөх, дуусгавар болох эрх зүйн үр дагаврыг бий болгож байгаа, амьдралын тодорхой нөхцөл байдал, үйл явдал, үйлдлийг хэлнэ³³.

Хууль зүйн факт нь эрх харилцааны анхдагч үндэс, түүний агуулгын чухал элемент мөн. Хууль зүйн факт нь эрх зүйн харилцааг анх үүсгэн /амь оруулж/ бодит шинж чанартай болгож, түүний шинж чанар, агуулгыг өөрчлөн хувьсгаж, эрх зүйн харилцаанд оролцогчдын субъектив эрх, үүргийг үүсгэн, эрх зүйн харилцааг тодорхой чиглэл, зорилгод чиглүүлж, эрх зүйн хэм хэмжээнд заасан үр дагаварт хүргэж байдаг, хууль зүйн онцгой учир холбогдол бүхий ухагдхуун билээ.

Хууль зүйн фактын эрх зүйн харилцаанд гүйцэтгэх үүрэг, ач холбогдлыг ОХУ-ын нэрт эрдэмтэн Р.О.Халфина "...Хууль зүйн фактаас л тухайн салбар эрх зүйн зохицуулалтын онцлог, тухайн эрх зүйн харилцаа хэзээ үүсэх, тухайн эрх зүйн хэм хэмжээ амьдралд хэрхэн хэрэгжих нөхцөл, үйл явц, үр дүн хамаардаг..."³⁴ гэж оновчтой тэмдэглэсэн байдаг. Энэ дүгнэлт ЭЭЗүйн хууль фактад ч нэгэн адил хамаарна.

ЭЭЗүйд хууль зүйн факт нь ЭЭЗүйн харилцааг үүсгэж, өөрчилж, дуусгавар болгодог, эрх зүйн шинжтэй үр дагавар бүхий, Эрүүгийн хуульд заасан тодорхой үйл явдал, зан үйл /үйлдэл/ юм.

Эрүүгийн эрх зүй дэх хууль зүйн фактын мөн чанар нь ЭЭЗүйн чиг үүрэг, ЭЭЗүйн харилцааны мөн чанар, төрөл, хамгаалах болон зохицуулах зүйл, зохицуулалтын аргын онцлогтой салшгүй холбоотой, тэдгээрээр дамжин илэрнэ.

1.ЭЭЗүйн хууль факт нь юуны өмнө ЭЭЗүйн чиг үүрэгтэй шууд холбогдоно. ЭЭЗүйн дотоод буюу хууль зүйн чиг үүрэг нь хамгаалах болон зохицуулах гэсэн үндсэн чиглэлээр хэрэгждэг³⁵.

ЭЭЗүйн хамгаалах чиг үүрэг нь нийгмийн хамгийн чухал харилцаа, үнэт зүйлс болох Монгол улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон хувийн өмч, байгаль орчин, үндэсний баялаг, нийгмийн эрх зүйн бусад журмыг гэмт халдагаас хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх эрх зүйн үйлчлэл бөгөөд Эрүүгийн хуульд нийгэмд аюултай зан үйлийг хориглох, нийгмийн ашиг сонирхолд нийцсэн зан үйлийг биелүүлэхийг урьдаас үүрэг болгон хуульчлах, зөрчсөн тохиолдолд хүлээлгэх эрүүгийн хариуцлага, ял хүлээлгэхээр заналхийлэх, сүрдүүлэх замаар нийгмийн гишүүдийн зан үйлд нөлөөлөх явдлаар хэрэгжинэ.

ЭЭЗүйн хоёр дахь чиг үүрэг нь зохицуулах чиг үүрэг бөгөөд Эрүүгийн хуулийн хориглолтыг зөрчиж гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хуульд заасан хариуцлага /албадлага/ хүлээлгэхтэй холбоотой үүсч буй харилцаанд нөлөөлөх эрх зүйн үйлчлэл, арга хэрэгсэлийг тодорхойлох явдал мөн.

Ийнхүү ЭЭЗүй нь дээрх хоёр чиг үүргийн аль алиныг хэрэгжүүлдэг онцлог эрх зүйн болохоор түүний хууль зүйн фактуудын онцлог илэрнэ.

2. ЭЭЗүйн хууль зүйн факт нь ЭЭЗүйн хамгаалах, зохицуулах зүйл буюу ЭЭЗүйн харилцааны агуулга, төрлөөс хамаарна.

Манай улсын ЭЭЗүйн шинжлэх ухаанд ЭЭЗүйн харилцааны агуулга, төрлийн талаар эрдэмтэд, судлаачид үндсэндээ ижил байр суурийг баримталж байгаа нь судалгааны явцад ажиглагдаж байна. Академич С.Нарангэрэл ЭЭЗүйн харилцааг агуулгаар нь:

а. Гэмт хэрэгтэй үйлдэгдсэнтэй холбоотой үүсч буй ЭЭЗүйн хамгаалах харилцаа,

б. Эрүүгийн эрх зүйн хэмжээнд ял хэрэглэхээр заналхийлэх замаар тодорхой этгээдийг тогтоон барихтай холбоотой харилцаа,

в. Онцгой харилцаа буюу гэмт хэргийн нийгмийн хор аюулыг үгүйсгэх нөхцөл байдлын үед бусдад гэм хор учруулах эрхийг иргэдэд олгосон эрхийг хэрэгжүүлэх үед үүсч буй харилцаа гэж гурван төрөлд ангилж авч үзсэн³⁶ бол шинжлэх ухааны доктор, профессор С.Жанцан үүнтэй төстэй ангилал хийсэн ба хоердахь харилцааг урьдчилан сэргийлэх харилцаа гэж тодорхойлсон байдаг³⁷.

Харин судлаач Б.Ганболд ЭЭЗүйн харилцааг а/ ЭЭЗүйн хамгаалах харилцаа, б/ ЭЭЗүйн хориглолтын харилцаа, в/ ЭЭЗүйн урамшуулсан хэм хэмжээний хэрэгжих харилцаа гэж 3 төрөлд ангилаад, гуравдахь төрөлд иргэдээс гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, таслан

³³ Ч.Нямсүрэн. Эрх зүй, төрийн ерөнхий онол. Нэмж засварласан дөрөвдэх хэвлэл. УБ., 2004 он. 257 дахь тал, Д.Баярсайхан. Эрх зүйн онол. III хэвлэл. УБ., 2010 он. 170 дахь тал, Н.Гантулга. Төр, эрх зүйн ерөнхий онол /Үзүүлэнт схем/. УБ., 1998 он. 107 дахь тал, М.Ариунаа. Төр, эрх зүйн онол. УБ., 2005 он. 141 дэх тал

³⁴ Р.О.Халфина. Общее учение о правоотношении. М.1974 г. стр 286

³⁵ Эрх зүйн хамгаалах болон зохицуулах чиг үүргийн талаар Ч.Нямсүрэн. Эрх зүй, төрийн ерөнхий онол. УБ., 2004 он. номын 98-109 талаас дэлгэрүүлж үзнэ үү

³⁶ С.Нарангэрэл. Монгол улсын ЭЭЗүй. Ерөнхий анги. УБ., 1998 он. 4-6 дахь тал

³⁷ С.Жанцан. Монгол улсын Эрүүгийн эрх зүйн онол. Тэргүүн дэвтэр. Гэмт хэргийн сургаал. УБ., 2009 он. 8-9 дэх тал,

зогсооход оролцох үүргийг урамшуулах, гэмт хэргээс өөрийгөө болон бусдыг хамгаалах эрхийг олгож байгаа харилцааг хамааруулсан, нь Академич С.Нарангэрэл багшийнхтай ижил байна³⁸.

Харин бид ЭЭЗүйн харилцааг агуулгаар нь түүний чиг үүрэгтэй холбоотойгоор а/ ЭЭЗүйн хамгаалах харилцаа, б/ ЭЭЗүйн зохицуулах харилцаа гэж хоёр ангилсан ангиллыг дэмжиж байна.³⁹ Эрх зүйн харилцааны ийм ангилал, төрлийг эрх зүйн онолын бүтээлүүдэд ч хийсэн байдаг.⁴⁰

Дээрх дурьдсан манай эрдэмтэн, судлаачдын ЭЭЗүйн харилцааны гуравдах төрөлд хамааруулж байгаа харилцаа нь бидний үзэж байгаагаар бие даасан ЭЭЗүйн харилцаа болохгүй, гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдалд үйлдэл хийж бусдад гэм хор учруулсан нь гуравдагч ЭЭЗүйн харилцааг үүсгэхгүй, ийм нөхцөл байдал байсан эсэхийг ЭЭЗүйн зохицуулах харилцааны хүрээнд тогтоож шийдвэрлэдэг.

ЭЭЗүйн хамгаалах чиг үүргийн хүрээнд төр, иргэн хоёрын хооронд үүссэн харилцааг эрүүгийн эрх зүйн хамгаалах харилцаа гэх ба уг харилцаа эрүүгийн хууль батлагдсанаар үүсэх бөгөөд нийгмийн зарим тогтворгүй гишүүдийг нийгэмд аюултай үйлдэл хийхийг эрүүгийн хариуцлага, ялаар заналхийлэх замаар урьдчилан сэргийлэх зорилгоос үүдэлтэй.

ЭЭЗүйн хууль зүйн фактууд нь ЭЭЗүйн хамгаалах болон зохицуулах харилцааны хувьд өөр байдаг.

ЭЭЗүйн хамгаалах харилцаа үүсэх хууль зүйн факт нь эрүүгийн хууль батлагдах /эрүүгийн хуулийг шинээр батлан мөрдөж эхлэх, эсвэл нийгэмд аюултай үйлдлийг гэмт хэрэг тооцож, эрүүгийн хуульд шинээр хуульчлах/, өөрчлөгдөх хууль зүйн факт нь эрүүгийн хуульд өөрчлөлт орох /тодорхой нийгэмд аюултай үйлдлийг гэмт хэрэгт тооцсон эрүүгийн хуулийн тодорхой зүйлд нэмэлт өөрчлөлт орох/, харин дуусгавар болох хууль зүйн факт нь эрүүгийн хууль хүчингүй болох /эрүүгийн хуулийн хүчин чадал дуусгавар болох, гэмт хэрэг нийгэмд аюултай үйлдлийг гэмт хэрэгт тооцохоо болих, Эрүүгийн хуулиас хасах/ явдал юм.

ЭЭЗүйн зохицуулах харилцаа үүсэх хууль зүйн факт нь тодорхой этгээд эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдэх, өөрчлөгдөх хууль зүйн факт нь ял тэнсэгдсэн этгээд хянан харгалзах хугацаанд шинээр гэмт хэрэг үйлдэх гэх мэт, дуусгавар болох хууль зүйн факт нь ялгүй болох, ялгүйд тооцогдох, ялтай байдлыг хүчингүй болгох, ялтан нас барах г.м болно.

ЭЭЗүйн хамгаалах харилцааны хууль зүйн фактын нэг онцлог нь бүгд хууль зүйн үйл явдал байдаг өөрөөр хэлбэл хүний хүчин зүйлээс үл хамаарах нийгмийн шинжтэй үйл явдал буюу хууль тогтоох үйл ажиллагааны хүрээнд гаргасан эрх зүйн акт юм.

ЭЭЗүйн зохицуулах чиг үүргийн хүрээнд үүсч буй харилцааны хууль зүйн факт нь ЭЭЗүйн хамгаалах харилцааны хууль фактаас тооны хувьд харьцангуй олон, зөвхөн хууль зүйн үйл явдал төдийгүй хууль зүйн үр дагавар бүхий үйл явц, хууль зүйн байдал байдаг, хүний хүсэл зоригоос хамаарах болон хамаарахгүй /байгалийн биологийн г.м/ үйл явдал, үйл явц байдаг зэрэг онцлогтой.

3. ЭЭЗүйн харилцааны хууль зүйн факт нь ЭЭЗүйн зохицуулалтын аргатай холбогдоно. Хууль бүтээх ажиллагааны хүрээнд ЭЭЗүйн хууль зүйн факт, түүний ангилал, төрөл нь ЭЭЗүйн зохицуулалтын аргаас хамаарч байдаг.

Эрх зүйн зохицуулалтын арга нь салбар эрх зүйг тодорхойлох гол шинж, түүнийг бусад салбар эрх зүйгээс ялгах шалгуур болохын зэрэгцээ тухайн салбар эрх зүйн чиг үүрэг, зохицуулах зүйл зэрэг бусад ухагдхуунтай харилцан хамааралтай.

Эрх зүйн ерөнхий онолд салбар эрх зүйгээр тодорхой нийгмийн харилцааг зохицуулах явцад тухайн харилцаанд оролцогчдын зан үйлд нөлөөлж буй эрх зүйн нөлөөлөл, энэ хүрээнд хэрэглэж буй хууль зүйн арга хэрэгслийг *эрх зүйн зохицуулалтын арга* гэнэ.

ЭЭЗүйн зохицуулалтын арга нь ЭЭЗүйн хамгаалах болон зохицуулах харилцааны хувьд өөрийн онцлогтой байдаг нь тухайн харилцааг зохицуулах төрийн /нийтийн/ ашиг сонирхол, хэрэгцээ шаардлага, тэдгээр харилцааны мөн чанар, энэ зорилгоор төрөөс хэрэглэж буй эрх зүйн арга хэрэгсэл, тэдгээрийг хэрхэн хуульчилсан байдал, хэрэглэж буй арга хэлбэр зэрэг олон зүйлээс шалтгаалдаг онцлогтой.

ЭЭЗүйн хамгаалах харилцааны зохицуулалтын арга нь хүчин төгөлдөр үйлчилж буй 2002 оны Эрүүгийн хуулийн 1-р зүйлийн 1.2-д зааснаар хүн, төр, нийгэмд аюултай ямар үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцох, түүнийг үйлдсэн гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээг тогтоох явдал билээ.

³⁸ Б.Ганболд. Эрүүгийн эрх зүйд нэвтрэхүй. УБ., 2012 он. 79-82 дахь тал

³⁹ Курс уголовного права в 5 томах. Общая часть. Том 1. Учение о преступлении. /Под ред. Н.Ф.Кузнецовой и И.М.Тяжковой/ М.изд Зерцало. 1999. стр 3, В.Д.Филимонов. Охрани-тельная функция уголовного права. СПб. 2003 г. стр 80-81

⁴⁰ Ч.Нямсүрэн. Эрх зүйн ерөнхий онол /үндсэн ойлголт, тулгамдсан асуудал/. УБ., 2010 он. 307 дахь тал

Харин ЭЭЗүйн зохицуулах харилцааны хувьд зохицуулалтын арга нь ЭХ-ийн Ерөнхий болгон Тусгай ангид заасан хууль зүйн арга хэрэгслийн тусламжтайгаар хэрэгжинэ. Жишээ нь ЭХ-ийн Ерөнхий ангийн 47-р зүйлийн 47.3-ийн "...торгох ялаас ноцтойгоор зайлсхийвэл уг ялын хэмжээнээс хамааруулан шүүх торгох ялыг гурван жил хүртэл хугацаагаар хорих ялаар солих..." тухай заалт, ЭХ-ийн Тусгай ангийн 79, 112, 185-р зүйлүүдэд зааснаар үйлдсэн хэргээ сайн дураар илчлэн ирсэн тохиолдолд эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх тухай хэм хэмжээнүүдийг дурьдаж болно. Эдгээр зохицуулалтын арга нь бүгд тодорхой хууль зүйн фактуудтай холбогдон хуульчлагдсан, тэдгээр хууль зүйн фактын үндсэн дээр хэрэгжих боломжтой юм.

4. Хууль зүйн факт нь тодорхой эрх зүйн харилцаанд оролцогчдын субъектив эрх үүрэг үүсэх нөхцөл, эрх үүргийн агуулга, хэмжээ, хязгаарыг тогтоож өгдөг.

ЭЭЗүйн хамгаалах харилцааны хууль зүйн факт болох эрүүгийн хууль батлагдах, эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулж тодорхой нийгэмд аюултай үйлдлийг шинээр гэмт хэрэгт тооцох /криминализаци хийх/ нь иргэдээс өөрийн зан үйлийг эрүүгийн хуульд нийцүүлэх, сахиж мөрдөх, гэмт хэрэг үйлдэхгүй байх, өөрийгөө болон бусдыг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх үүргийг бий болгодог бол хууль тогтоогчид эрүүгийн хуулийг хэрэгжүүлэх, хуулийг дагаж мөрдүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтэнд хяналт тавих эрх, үүргийг бий болгодог.

ЭЭЗүйн зохицуулах харилцааны үүсэх хууль зүйн факт буюу гэмт хэрэг үйлдэгдсэнээр гэмт хэрэг үйлдсэн этгээдэд үйлдсэн хэргийнхээ төлөө эрүүгийн хуульд заасан ял, эрүүгийн хариуцлагын арга хэмжээг эдлэх, хүлээх үүрэг бий болж байхад, энэ харилцааны нөгөө оролцогч төрд уг этгээдэд эрүүгийн хариуцлагыг төрийн албадлагын хэрэглэн хүлээлгэх эрх үүсэх жишээтэй. Мөн ЭЭЗүйн зохицуулах харилцааны дуусгавар болох хууль зүйн фактын нэг болох гэмт хэрэг үйлдэхээс сайн дураараа татгалзсан тохиолдолд татгалзсан этгээдэд эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдөх эрх үүсч байхад төр, хуулийн байгууллага сайн дураар татгалзсан эсэхийг хуульд заасан шалгуураар тогтоож, ЭХ-ийн Ерөнхий ангийн 33-р зүйлд заасны дагуу тухайн этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үүрэг хүлээнэ.

Эрүүгийн эрх зүй дэх хууль зүйн фактын шинж. Аливаа факт /үйл явдал, зан үйл/ нь хууль зүйн факт болохын хувьд эрх зүйн ерөнхий онолын шинжлэх ухаанаас тодорхойлсон дараахь шинжийн агуулсан байх ёстой⁴¹. Энэ шинжүүд нь ЭЭЗүйн харилцааны хууль фактад ч нэгэн адил илэрнэ.

1. *Тодорхой, бодитой оршиж буй нөхцөл байдал байх,*

Тодорхой байна гэдэгт ерөнхий буюу нийтлэг шинжтэй, үргэлжлэн явагддаг үйл ажиллагаа, процесс бус, харьцангуй бие даасан шинжтэй, амьдралын тодорхой нэг эсвэл нийлмэл нөхцөл, үйл явдал, үйлдэл байхыг ойлгоно.

Бодитой байх гэдэг нь хүний санаа бодолд хийсвэр /санаа бодол, төсөөлөл/ байдлаар оршдоггүй, объектив шинжтэй, амьдралд тодорхой цаг хугацаа, орон зайд үйлдэгдсэн, илэрсэн, хэрэгжсэн үйл явдал, үйлдэл байна гэсэн үг юм.

Үйл явдал нь тодорхой орон зай, цаг хугацаанд өөрөө тодорхой хүчин зүйлийн улмаас бий болдог бол, үйлдэл нь эрх зүйн харилцаанд оролцогчдын зан үйл, үйлдлээр илэрч хууль зүйн учир холбогдол, үр дагаврыг бий болгодог.

2. *Эрх зүйн хамгаалах ба зохицуулах зүйл болох нийгмийн харилцааны шинж чанар, агуулгын талаар тодорхой мэдээллийг тээгч, өөртөө агуулсан байх,*

Тухайн факт нь нийгмийн агуулгагүй, эрх зүйн хувьд учир холбогдолгүй, хүн, төр, нийгмийн эрх ашиг сонирхолд хамаарахгүй, тэдгээрийг хөндөөгүй, тэдгээртэй холбогдон бий болоогүй, тэдгээрт нөлөөлөх шинжгүй бол хууль зүйн факт болохгүй, өөрөөр хэлбэл хууль зүйн фактаас тодорхой эрх харилцааны мөн чанар, агуулга, бүтэц, бусад эрх зүйгээс ялгагдах онцлог зэрэг мэдээллүүдийг хууль зүйн фактаас харж болно.

3. *Материаллаг ертөнцийн тодорхой үзэгдэл, эерэг, сөрөг эрх зүйн үйл явдал, үйлдэл нь эрх зүйн хэм хэмжээнд илэрхийлэгдсэн байх,* өөрөөр хэлбэл эрх зүйн хэмжээний гипотезид шууд ба шууд бусаар тусгагдан хуульчлагдсан байх ёстой.

4. *Хууль тогтоомжид заасан эрх зүйн үр дагаврыг бий болгох, хүргэх шинжтэй байх,*

Эрх зүйн шинжлэх ухаанд хууль зүйн факт гэдэг ойлголтод аливаа нийгмийн факт буюу үйл явдал, үйлдлийг бус, гагцхүү эрх зүйн үр дагавар бүхий үйл явдал, зан байдал /үйлдлийг/ хамааруулна. Учир нь хууль тогтоогч тодорхой эрх зүйн харилцааг зохицуулахын тулд тодорхой үйл явдал, зан үйлд эрх зүйн ач холбогдол өгч, эрх зүйн хэм хэмжээнд хуульчилсанаар тухайн харилцаа үүсэх, өөрчлөгдөх, дуусгавар болох эрх зүйн үр дагавар бий болдог.

⁴¹ Ч.Нямсүрэн. Эрх зүйн ерөнхий онол /Үндсэн ойлголт, тулгамдсан асуудал/. УБ., 2010 он. 317-318 дахь тал, В.Б.Исаков. Юридические факты в российском праве. М.изд Юстицинформ. 1998 г. 3-4 дэх тал

Эрх зүйн үр дагаврыг бий болгох гэдэг нь тодорхой үйл явдал, үйлдэл нь хувь хүн, хүмүүсийн хамтлаг /нэгдэл/, төрийн хооронд хууль зүйн хувьд харилцан хамаарал /харилцааг/ бий болгох, субъектив эрх, үүргийг үүсгэх, тухайн харилцааны агуулга, оролцогчдын хүлээх эрх, үүрэг, эрх зүйн байдал өөрчлөгдөх, улмаар уг харилцаа дуусгавар болох зэрэг хууль тогтоомжид заасан эрх зүйн ач холбогдол бүхий өөрчлөлт, үр дагавар бий болгох явдал билээ.

5. *Бодит байдалд тодорхой эрх зүйд нийцсэн, нийцээгүй үйл явдал бий болсон, эсвэл тийм үйлдэл хийгдээгүй болохыг илэрхийлэх,*

Хууль зүйн фактууд нь нийгмийн харилцааны хүрээнд эрх зүйн үр дагавар бүхий үйл явдал бодитойгоор бий болсон, эсвэл хуульд заасан хориглосон зөвшөөрсөн, эрх олгосон, үүрэг болгосон, урамшуулсан зан үйл хийгдсэн, эсвэл хийгдээгүй болохыг хууль зүйн хувьд амьдралд, хууль хэрэглэх үйл ажиллагааны практикт баталгаажуулж өгдөг.

6. *Хууль зүйн факт нь түүнийг баримтжуулах, нотолж тогтоох боломжтой байх,*

Хууль зөрчсөн эсвэл хууль зүйн дагуу хийгдсэн, эрх зүйн үр дагавар бүхий үйл явдал, үйлдэл нь бодитой, тодорхой шинж чанартай нөхцөл байдал болохын хувьд түүнийг хууль хэрэглэх үйл ажиллагааны хүрээнд хууль зүйн арга хэрэгслээр /нотлох баримт, эрх зүйн баримт бичиг г.м/ баримтжуулах боломжтой байх, түүнийг хуульд заасны журмын дагуу нотолж тогтоосон тохиолдолд албан ёсны болж эрх зүйн үр дагавар үүсгэх чадамжтай болно.

Хууль зүйн фактыг тодорхойлж буй дээрх шинжүүдийг нэгтгэн дүгнэвэл хууль зүйн факт нь 1-рт: материаллаг шинжтэй 2-рт: эрх зүйн шинж чанартай үзэгдэл, ухагдхуун болох нь харагдана.

Бидний авч үзсэн 1-2, 5-6 дахь шинж нь хууль зүйн фактын материаллаг шинжид хамаарах, 3-4 дэх шинж нь түүний эрх шинж чанарыг тодорхойлж байгааг харж болно.

Хууль зүйн фактын дээрх шинж чанар, онцлогийг ОХУ-ын эрдэмтэн Н.Г.Александров "...аливаа үйл явдал, үйлдэл нь түүнд хууль тогтоогч эрх зүйн ач холбогдол өгч, тодорхой эрх зүйн үр дагаврыг бий болгохоор заасан тохиолдолд л хууль зүйн факт болно. Иймээс хууль зүйн факт нь нилээн өвөрмөц мөн чанар, зүй тогтол бүхий үзэгдэл, ойлголт болохын хувьд материаллаг болон эрх зүйн шинжийн нийлбэр байдаг..."⁴² гэсэн дүгнэлтийг хийсэнтэй санал нэгдэж байна.

Эрүүгийн эрх зүйн хууль зүйн фактын чиг үүрэг. Хууль зүйн факт нь зохиомлоор, санаандгүй бий болсон зүйл бус, тодорхой хууль цаазын учир холбогдол, зорилго, чиг үүрэг бүхий харьцангуй бие даасан эрх зүйн үзэгдэл, ойлголт мөн.

Хууль зүйн фактын чиг үүрэг гэдэг нь эрх зүйн зохицуулалтын механизмд түүний гүйцэтгэх үүрэг, үзүүлэх нөлөө, түүний өмнө тавигдаж буй зорилго чиглэлийг хэлнэ.

Хууль зүйн фактын эрх зүйн харилцаа, түүний агуулга, элементүүдтэй хэрхэн уялдаж буй байдлаас хамаарч үндсэн болон нэмэлт чиг үүрэг гэж ангилсан ангиллыг эрх зүйн онолын зарим бүтээлүүдэд хийжээ⁴³.

Хууль зүйн фактын *үндсэн чиг үүрэг* нь аливаа эрх зүйн харилцааны үүсэх, өөрчлөгдөх, дуусгавар болох нөхцлийг тодорхойлох замаар уг эрх зүйн харилцааны хэрэгжих хэм хязгаар, нөхцөл, журмыг тогтооход оршино.

Харин *нэмэлт чиг үүрэг* нь 1-рт: эрх зүйн зохицуулалтын хүрээнд хууль хэрэглэх явцад хууль зөрчихөөс урьдчилан сэргийлэх, хууль ёсыг хангах баталгаа болох //Жишээ нь гэмт хэргийн бүрэлдэхүүнийг агуулаагүй хэрэг үйлдэгдсэн нь ЭБШАжиллагаа явуулж болохгүй нөхцөл байдал болохоор ЭБШХ-ийн 24-р зүйлд заасан нь ЭБШАжиллагааны явцад хууль ёсыг хангах баталгаа болж байна/, 2-рт: эрх зүйн харилцааг өөрчлөхгүй боловч түүний хүрээнд хэрэглэх эрх зүйн нөлөөлийн арга, албадлаын арга хэмжээний төрөл, хэмжээг тодорхой тохиолдолд өөрчлөх, түүнд нөлөөлөх /гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадвартай байсан боловч шүүх хэргийг шийдвэрлэх үед сэтгэцийн өвчтэй болсон, сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан, эсхүл өөр бусад хүнд өвчний улмаас сэтгэцийн хувьд өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын шинж чанарыг ухамсарлах буюу үйл ажиллагаагаа удирдан жолоодох чадваргүй болсон этгээдэд ял оногдуулахгүй. Ийм этгээдэд энэ хуульд заасан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж, эдгэрсний нь дараа ял оногдуулах эсэхийг шүүх шийдвэрлэх /ЭХ-ийн 22-р зүйлийн 22.2/, ялтан торгох ялаас ноцтойгоор зайлсхийвэл торгуулийн хэмжээнээс хамаарч шүүх торгох ялыг гурван жил хугацааны хорих ялаар сольж болох /ЭХ-ийн 47-р зүйлийн 47.3//, 3-рт: эрх зүйн харилцаанд оролцогчдын зан үйлд нөлөөлөх, эрх зүйд нийцсэн эерэг зан үйлийг урамшуулах //Ял тэнсэгдсэн этгээд хянан харгалзах хугацаанд захиргааны зөрчил гаргавал ял тэнсэнийг хүчингүй болгох эсэхийг цагдаагийн байгууллагын саналыг үндэслэн шүүх шийдвэрлэх /ЭХ-ийн 61-р зүйлийн 61.5/, үйлдсэн хэргээ сайн дураар илчлэн ирсэн этгээдэд оногдуулах ял хөнгөрүүлэх /ЭХ-ийн 55-р

⁴² Н.Г.Александров. Правоотношения в советском обществе. М.Госюридиздат.1955 г. стр 163

⁴³ В.Б.Исаков. Юридические факты в российском праве. М. Изд. Юрлитинформ.1998 г. стр 24

зүйлийн 55.1.9/, гэмт хэрэг үйлдэхээс сайн дураар татагалзсан этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх /ЭХ-ийн 33-р зүйл/ зэрэг байдлаар хэрэгжинэ.

Эрүүгийн эрх зүйн хууль фактын ангилал, төрөл. Эрх зүйн онолд хууль зүйн фактын ангилал, төрөл харьцангуй боломжийн түвшинд судлагдсан, энэ талаар манай эрдэмтэд, судлаачдын дунд үзэл баримтлалын хувьд зөрөөгүй, нэгдсэн ойлголт тогтсон нь харагдаж байна⁴⁴.

Эрх зүйн онолд хууль зүйн фактыг хэд хэдэн үндэслэлээр ангилсан нь бий. Үүнд:

1. Хууль зүйн фактыг эрх зүйн харилцаанд үзүүлэх нөлөө, үүсгэж буй эрх зүйн үр дагавраар нь а/. Эрх зүйн харилцааг үүсгэх, б/. эрх зүйн харилцааг өөрчлөх, в/. эрх зүйн харилцааг дуусгавар болгох хууль зүйн фактууд гэж ангилна.

ЭЭЗүйн харилцаа үүсэх хууль зүйн факт нь ЭЭЗүйн хамгаалах харилцааны хувьд эрүүгийн хуулийг шинээр батлах, эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, ЭЭЗүйн зохицуулах харилцааны хувьд гэмт хэрэг үйлдэгдэх явдал юм.

ЭЭЗүйн харилцааг өөрчлөх хууль зүйн фактууд нь тооны хувьд харьцангуй олон юм. Ийм фактуудад давтан гэмт хэрэг үйлдэх /ЭХ-ийн 18-р зүйлийн 18.1/, хэд хэдэн гэмт хэрэг үйлдэх /ЭХ-ийн 19-р зүйлийн 19.1/, Арван найман насанд хүрэхийн өмнө анх удаа хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэг үйлдвэл ял оногдуулахгүй хүмүүжлийн шинж чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх /ЭХ-ийн 21-р зүйлийн 21.3/, гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадвартай байсан боловч шүүх хэргийг шийдвэрлэх үед сэтгэцийн өвчтэй болох, сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан, эсхүл өөр бусад хүнд өвчнөөр өвчлөх /ЭХ-ийн 22-р зүйлийн 22.3/, шүүх эмнэлгийн шинж чанартай албадлагын арга хэмжээний төрлийг өөрчлөх шаардлагатай гэж үзэх /ЭХ-ийн 66-р зүйлийн 66.2, 66.3, 66.6/, гэмт хэрэг үйлдсэний дараа буюу ял эдэлж байх үедээ сэтгэцийн өвчтэй болсон, сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан, эсхүл өөр бусад хүнд өвчний улмаас сэтгэцийн хувьд өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын шинж чанарыг ухамсарлах буюу үйл ажиллагаагаа удирдан жолоодох чадваргүй болсон этгээд /өвчтөн/ эмнэлгийн шинж чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэсний дараа эдгэрэх /ЭХ-ийн 67-р зүйлийн 67.1/, онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдох /ЭХ-ийн 24-р зүйл/, ял тэнсэгдсэн этгээд хянан харгалзах хугацаанд шинээр гэмт хэрэг үйлдээгүй, өөрийн засарч хүмүүжсэнээ харуулах, ял тэнсэгдсэн этгээд захиргааны зөрчил үйлдэх, уг хугацаанд шинээр гэмт хэрэг үйлдэх /ЭХ-ийн 61-р зүйлийн 61.2, 61.3, 61.5/, ял хойшлуулсан насанд хүрээгүй этгээд ял хойшлуулсан хугацаанд шүүхээс хүлээлгэсэн үүргийг биелүүлж засарч хүмүүжсэнээ харуулах, захиргааны шийтгэл хүлээх, шинээр гэмт хэрэг үйлдэх /ЭХ-ийн 62-р зүйлийн 62.3, 62.4, 62.5/, жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх хүүхэдтэй эх буюу ганц бие эцэг ял хойшлуулсан хугацаанд хүүхдээ асарч хүмүүжүүлэхээс татгалзах, шинээр гэмт хэрэг үйлдэх /ЭХ-ийн 63-р зүйлийн 63.2, 63.3/, торгох ял шийтгүүлсэн ялтан торгох ялаас санаатайгаар зайлсхийх /ЭХ-ийн 47-р зүйлийн 47.3/, Албадан ажил хийлгэх ял эдлэхээс зайлсхийх /ЭХ-ийн 50-р зүйлийн 50.3/, хохирлоо нөхөн төлж, гэмт хорыг арилган, хохирогчтой эвлэрэх /ЭХ-ийн 55-ийн 1-р зүйл/, ялтан шүүхээс оногдуулсан ялынхаа зохих хэсгийг биеэр эдэлсэн, хохирлоо нөхөн төлсөн, гэмт хорыг арилган өөрийн засарч хүмүүжсэнээ харуулсан байх /ЭХ-ийн 74-р зүйл/ зэргийг нэрлэж болно.

ЭЭЗүйн харилцааг дуусгавар болгох хууль зүйн фактуудад шүүх эмнэлгийн шинж чанартай албадлагын арга хэмжээг цаашид хэрэглэх шаардлагагүй гэж үзэх, зогсоох, /ЭХ-ийн 66-р зүйлийн 66.7/, гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн этгээд ялгүй болох, ялгүйд тооцох, ялтай байдлыг арилгах /ЭХ-ийн 78-р зүйлийн 78.2, 78.3/, өршөөл үзүүлэх /ЭХ-ийн 77-р зүйлийн 77.1/, уучлал үзүүлэх /ЭХ-ийн 77-р зүйлийн 77.2/, Үйлдсэн хэргээ илчлэн ирэх /ЭХ-ийн 70-р зүйл/, хохирлоо нөхөн төлөх, гэмт хорыг арилгах, хохирогчтой эвлэрэх /ЭХ-ийн 71-р зүйл/, эрүүгийн хариуцлагад татаж болох хугацаа өнгөрөх /ЭХ-ийн 72-р зүйл/, шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлж болох хугацаа өнгөрөх /ЭХ-ийн 76-р зүйл/, түүнчлэн ЭХ-ийн Тусгай ангид заасан нөхцлүүд - хэргээ сайн дураар илчлэн ирэх, гэмт хэргийн зүйлийг сайн дураар хуулийн байгууллагад өгөх /ЭХ-ийн 79, 112, 177, 185, 270-р зүйлүүд/ тус тус хамаарна.

2. Хууль зүйн фактыг түүнийг хүсэл зоригийн шинжээр нь хууль зүйн үйл явдал, эрх зүйн зан үйл /зан байдал/ гэж ангилдаг.

Хууль зүйн үйл явдал гэдэг нь хүний хүсэл зоригоос үл хамаарах, байгалийн, нийгмийн хууль, зүй тогтол, хувьсал өөрчлөл, жам ёсны дагуу явагддаг, эрх зүйн үр дагавар бүхий байгаль, нийгмийн үзэгдэл, үйл явц /учрал, тохиолдол/ юм. Гэмт хэрэг үйлдсэн этгээд эсвэл ялтан нас барах, сэтгэл мэдрэлийн болон бусад хүнд өвчнөөр өвчлөх, эрүүгийн хариуцлагад татаж болох хугацаа

⁴⁴ Ч.Нямсүрэн. Эрх зүй, төрийн ерөнхий онол. Нэмж засварласан дөрөвдэх хэвлэл. УБ., 2004 он. 259-262 дахь тал, Д.Баярсайхан. Эрх зүйн онол. III хэвлэл. УБ., 2010 он. 172-173 дахь тал, Н.Гантулга. Төр, эрх зүйн ерөнхий онол /Үзүүлэнт схем/. УБ., 1998 он. 108 дахь тал М.Ариунаа. Төр, эрх зүйн онол. УБ., 2005 он. 141-143 дахь тал,

өнгөрөх, шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлж болох хугацаа өнгөрөх, ялгүй болох хугацаа өнгөрөх зэрэг нь энэ төрлийн хууль зүйн үйл явдал болно.

Эрх зүйн зан үйл /зан байдал/ нь хүний хүсэл зоригоос хамаардаг, хүний ухамсарласан үйл ажиллагаагаар дамжин хэрэгждэг, хууль зүйн үр дагавар бүхий үйлдлүүд байдаг онцлогтой бөгөөд энэ шинжээрээ хууль зүйн үйл явдлаас ялгагдана.

Бидний Эрүүгийн хуульд хийсэн судалгаагаар ЭЭЗүйд 40 гаруй хууль зүйн фактууд байдгийн дийлэнх нь эрх зүйн үйлдлүүд байгаа нь анхаарал татаж байна.

Эрх зүйн зан үйлийг дотор нь мөн тодорхой шалгуураар төрлүүлэд ангилж болно.

а/. Эрх зүйн зан үйлийг илрэх гадаад хэлбэр, шинжээр нь эрх зүйн үйлдэл, эрх зүйн эс үйлдэл ангилах ба *эрх зүйн үйлдэл* нь хүний бие эрхтний идэвхтэй зан байдал, үйлдлээр гадаад байдлаар хэлбэршсэн зүйн үйл мөн. Жишээ нь ял хойшлуулсан насанд хүрээгүй этгээд ял хойшлуулсан хугацаанд шинээр гэмт хэрэг үйлдэх /ЭХ-ийн 62-р зүйлийн 62.5/.

Эрх зүйн эс үйлдэл гэдэг нь тодорхой этгээд хуулиар биелүүлэх ёстой зан үйлийг биелүүлээгүй, хүлээлгэсэн үүргийг биелүүлээгүй, биелүүлэхээс татгалзсан, зайлсхийсэн, эрх зүйн үр дагавар бүхий, хүний идэвхгүй зан үйлийг хэлнэ. Жишээ нь Торгох ял шийтгүүлсэн ялтан торгох ялаас санаатайгаар зайлсхийх /ЭХ-ийн 47-р зүйлийн 47.3/.

б/. Эрх зүйн онолд эрх зүйн зан үйлийг эрх зүйн хэм хэмжээний шаардлагад хэрхэн нийцэж байгаа байдал, хууль зүйн шинжээр нь эрх зүйд нийцсэн /хууль ёсны дагуу, эерэг/ үйлдэл, эс үйлдэхүй, эрх зүйд нийцээгүй /хууль бус, сөрөг/ үйлдэл, эс үйлдэхүй гэж ангилах ангилал нэгэнт тогтжээ.

Ял тэнсэгдсэн этгээд хянан харгалзах хугацаанд шүүхээс хүлээлгэсэн итгэлийг дааж шинээр гэмт хэрэг үйлдээгүй байх, өөрийн засарч хүмүүжсэнээ харуулах нь /ЭХ-ийн 61-р зүйлийн 62.4/ эрх зүйд нийцсэн үйлдэл, эс үйлдэхүйн, албадан ажил хийлгэх ял шийтгүүлсэн этгээд уг ялыг эдлэхээс зайлсхийх /ЭХ-ийн 50-р зүйлийн 50.3/ нь эрх зүйд нийцээгүй эс үйлдэхүйн жишээ юм.

в/. Эрх зүйд нийцсэн үйлдлийг илрэх хэлбэрээр нь хууль зүйн үйлдэл, хууль зүйн акт /баримт/ гэсэн 2 төрөлд хувааж болно.

Хууль зүйн акт гэдэг нь эрх зүйн үр дагаварт хүргэсэн эрх зүйн тодорхой асуудлыг шийдвэрлэж гаргасан тогтоосон журмын дагуу үйлдсэн шийдэл буюу эрх зүйн хэм хэмжээний болон эрх зүйн хэм хэмжээг хэрэглэсэн актуудыг хэлнэ. ЭЭЗүйн тухайд энэ төрлийн хууль зүйн фактад Эрүүгийн хууль батлагдах, эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хууль батлагдах, Өршөөл үзүүлэх тухай хууль батлагдах, Уучлал үзүүлэх тухай Ерөнхийлөгчийн зарлиг гарах зэрэг багтана.

3.Хууль зүйн фактыг бүтэц, бүрэлдэхүүний шинжээр нь энгийн хууль зүйн факт, нийлмэл хууль зүйн факт ангилах нь ЭЭЗүйд ч өөрийн илрэлээ олсон байдаг. Нэг л нөхцөл байдал эрх зүйн харилцааг үүсгэх, өөрчлөх, дуусгавар болгох үндэс болж эрх зүйн үр дагаварт хүргэж байхыг *энгийн хууль зүйн факт* гэнэ. Жишээ нь жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх хүүхэдтэй эх буюу ганц бие эцэг ял хойшлуулсан хугацаанд хүүхдээ асарч хүмүүжүүлэхээс зайлсхийх нь ял хойшлуулсан шийдвэрийг хүчингүй болгож хорих ялыг биечлэн эдлүүлэх нөхцөл факт болно. /ЭХ-ийн 63-р зүйлийн 63.2/

Нийлмэл хууль зүйн факт гэдэг нь хуульд заасан хоёр буюу түүнээс дээш хэд хэдэн үндэслэл, нөхцөл байж сая эрх зүйн үр дагавар үүсгэхээр байх, тодорхой эрх зүйн асуудлыг шийдвэрлэх нөхцөл болох явдал юм. Эрүүгийн хуулийн зарим хэм хэмжээнд хуульчилсан эрх зүйн тодорхой асуудлыг шийдвэрлэхэд нэг бус, бидний дээр ангилсан өөр өөр ангилал, төрөлд хамаарах хэд хэдэн нөхцөл байдал нэгэн зэрэг байхыг шаарддаг. Жишээ нь: ЭХ-ийн 74-р зүйлд зааснаар хорих газраас ялтныг хугацааны өмнө тэнсэн суллахад тухайн хоригдол шүүхээс оногдуулсан ялынхаа зохих хувийг биеэр эдэлсэн байх /хууль зүйн байдал/, үйлдсэн хэргийнхээ хохирлыг нөхөн төлсөн, гэмт хорыг арилгасан байх /хууль зүйн үйлдэл/, өөрийн засарч хүмүүжсэнээ өөрийн зан байдлаараа харуулсан байх /хууль зүйн үйлдэл/, түүний ял эдэлж байгаа хорих анги ялтныг хугацааны өмнө тэнсэн суллах саналыг шүүхэд гаргасан байх /хууль зүйн акт/ гэсэн 4 нөхцөл байдал /факт/ хангагдсан байх ёстой.

4. ЭЭЗүй дэх хууль зүйн фактуудыг Эрүүгийн хуульд хуульчлагдсан байдлаар нь Эрүүгийн хуулийн Ерөнхий ангид заасан хууль зүйн фактууд, Эрүүгийн Тусгай ангид заасан нөхцөл байдал гэж ангилж болно.

5. Мөн ЭЭЗүй дэх хууль зүйн фактуудыг а/ ЭЭЗүйн харилцаанд бүхэлд хамаарах нийтлэг нөхцөл байдлууд /гэмт хэрэг үйлдэх, ялгүй болох, ялгүйд тооцондох/ б/ ЭЭЗүйн тодорхой институтын хүрээнд хамаарах хууль зүйн фактууд /Жишээ нь Эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх институтын хувьд хэргийн хөөн хэлэлцэх хугацаа өнгөрөх, шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлж болохгүй хугацаа өнгөрөх, ялтан ял эдэлхэд саад болох хүнд өвчнөөр өвчлөх, ялтан уучлал үзүүлэх хүсэлт гаргах, уучлал үзүүлсэн Ерөнхийлөгчийн зарлиг гарах г.м/

Дүгнэлт

1.ЭЭЗүйн хууль зүйн фактын тухай асуудал нь эрүүгийн эрх зүйн харилцаа, эрүүгийн хариуцлагын асуудалтай адил ЭЭЗүйн онолын судлагдхуун боловч манай ЭЭЗүйн шинжлэх харьцангуй бага судлагджээ.

2. ЭЭЗүйн хууль зүйн фактын тухай асуудлыг ЭЭЗүйн харилцааны асуудлын хүрээнд харьцангуй бие даасан байдлаар, гэхдээ ЭЭЗүйн харилцааны түүний бусад элементүүдтэй төдийгүй, ЭЭЗүйн бусад институудтэй салшгүй холбоотойгоор иж бүрнээр судлах шаардлагатай байна.

3.ЭЭЗүйн хууль фактыг салбар эрх зүйн хууль зүйн фактын хувьд эрх зүйн ерөнхий онол дахь эрх зүйн харилцааны болон хууль зүйн фактын тухай сургаал, үзэл баримтлалд суурилах ба түүний үндсэн дээр түүний мөн чанар, онцлогийг тодорхойлж, судлах, таньж мэдэх боломжтой.

4. ЭЭЗүйн хууль зүйн факт нь хууль бүтээх ажиллагааны хүрээнд ЭЭЗүйн харилцаа үүсэх, түүний агуулга, шинж чанарыг өөрчлөх, улмаар уг харилцаа дуусгавар болох Эрүүгийн хуульд заасан нөхцөл байдал, хууль хэрэглэх ажиллагааны түвшинд эрүүгийн хуулийг зөв хэрэглэх шалгуур, нөхцөл болсон эрх зүйн үр дагавар бүхий, амьдралын тодорхой үйл явдал, зан үйл, эрх зүйн байдал мөн.

5. ЭЭЗүйн хууль зүйн факт нь амьдралд өдөр тутам, урсгалаар бий болдог ердийн нөхцөл байдал бус, өөрийн гэсэн хууль зүйн шинж, мөн чанар, эрх зүйн үр дагавар, учир холбогдол бүхий нөхцөл байдал, нарийн төвөгтэй ухагдхуун юм.

6. ЭЭЗүйн хууль зүйн факт нь Эрүүгийн харилцааг үүсгэх, өөрчлөх, дуусгавар болгох үндсэн чиг үүргээс гадна эрүүгийн хуулийг хэрэглэх ажиллагааны хууль зүйн үндэс болох, ЭЭЗүйн харилцааг тодорхой зорилго, чиглэлтэй болгох, ЭЭЗүйн харилцаанд оролцогчдын зан үйлд нөлөөлөх зэрэг нэмэгдэл чиг үүрэгтэй эрх зүйн үзэгдэл болохыг тэмдэглэж байна.

Санал

1. Манай улсын ЭЭЗүйн шинжлэх ухаанд хууль фактын тухай асуудлыг зөвхөн сурах бичгийн гарын авагын түвшинд бус, шинжлэх ухааны өндөр түвшинд магистр, докторын судалгааны ажлын хэмжээнд үл суурьтай, иж бүрнээр судлах, судалгааны бүтээл гаргах замаар эрх зүйн энэ үзэгдлийн талаарх онолын сэтгэлгээг цаашид хөгжүүлэх,

2. Хууль факт, түүний дотор ЭЭЗүйн хууль зүйн фактыг эрх зүйн ерөнхий онолд эрх зүйн харилцааны агуулга, бүтцийн элемент, эрх зүйн хэм хэмжээний гипотезын хүрээнд судлах уламжлалт хандлагаас хальж эрх зүйн хэмжээ, ЭЭЗүйн хэм хэмжээг хэрэглэх түвшинд хууль фактыг тогтоох, нотлох үйл ажиллагаа болох талаас практик асуудлыг судлах шаардлагатай байна.

**ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДСЭН ЭТГЭЭДИЙГ БАРИВЧЛАХ, СААТУУЛАХ ҮЕД
ГЭМ ХОР УЧРУУЛАХ ҮЙЛДЛИЙГ ГАДААДЫН ЗАРИМ ОРНУУДЫН ЭРҮҮГИЙН
ХУУЛЬД ХУУЛЬЧИЛСАН БАЙДАЛ**

*Галбатын Гантөмөр
Отгонтэнгэр их сургуулийн Хууль зүйн сургуулийн
Нийтийн эрх зүйн тэнхмийн багш, хууль зүйн доктор /Ph.D/, профессор*

*Лувсангийн Бат-Очир
ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Мөрдөх ажиллагааны тэнхмийн багш,
докторант, цагдаагийн ахмад*

Товч агуулга. Гэмт хэргийн нийгмийн хораюулыг үгүйсгэхнөхцөл байдлын нэг төрөл болох гэмт этгээдийг баривчлах, саатуулах үед гэм хор учруулах үйлдлийг гадаадын зарим орнуудын эрүүгийн хуульд хэрхэн хуульчилсан байдлыг судалж Монгол улсын эрүүгийн хууль тогтоомжийг боловсронгуй болгоход чиглэсэн санал, зөвлөмжийг гаргасан болно.

Abstract. This article deals with the provisions of a number of international criminal codes determining the permissible damage that can be inflicted on the criminal during detainment, thus creating the theoretical framework for the improvement of the corresponding provisions of the Criminal code of the Mongolia .

Түлхүүр үгс. Гэмт хэргийн нийгмийн хор аюулыг үгүйсгэх нөхцөл байдлууд, гэмт этгээдийг баривчлах, саатуулах үед гэм хор учруулах, Монгол улсын эрүүгийн хууль, гадаад орнуудын эрүүгийн хууль, аргагүй хамгаалалт, гарцаагүй байдал.

Оршил. Сүүлийн жилүүдэд Монгол улсын эрх зүйн шинжлэх ухаанд харьцуулсан судлал ихээхэн хөгжиж, аливаа эрх зүйн бүтээл туурвил, судалгаа шинжилгээний ажлын салшгүй нэгэн хэсэг, судлах зүйл болоод байгаа билээ.

Эрх зүйн харьцуулсан судлалыг хөгжүүлэх нь даяарчлагдаж буй өнөөгийн нөхцөлд үндэсний хууль тогтоомжийг олон улсын жишиг, стандартад нийцүүлэх, боловсронгуй болгох, орчин үеийн эрх зүйн шинжлэх ухааны хөгжил, ололт амжилтыг эх орондоо нутагшуулах, хууль, эрх зүйн талаар хөрш улс орнууд төдийгүй бүс нутгийн хэмжээнд болон дэлхий хамтын нийгэмлэгтэй ойртон нягтрах, ижил эрх зүйн орон зайд хамтран ажиллах нөхцөл болно.

Энэ нь ЭЭЗүйн шинжлэх ухаанд ч нэгэн адил хамаарах бөгөөд энэ үүднээс гэмт хэргийн нийгмийн хор аюулыг үгүйсгэх нэг нөхцөл байдал болох гэмт этгээдийг баривчлах, саатуулах үед гэм хор учруулах үйлдлийг гадаад орнуудын эрүүгийн хуульд хэрхэн хуульчилсан байдлыг үндэсний эрх зүйн зохицуулалтай харьцуулан судалсан судалгааны үр дүнг танилцуулж байна.

Үндсэн хэсэг.

Бидэнд биетээр байгаа гадаадын 30 гаруй улсын эрүүгийн хуулийн хэмжээнд гэмт этгээдийг баривчлах, саатуулах үед гэмт хор учруулах институтыг судалсан бөгөөд судалгааны үр дүн дараахь байдалтайгаар гарч байна.

Судалгаанд хамрагдсан ихэнх орнуудын хувьд гэмт этгээдийг баривчлах, саатуулах үед гэм хор учруулах үйлдлийг гэмт хэргийг үгүйсгэх бие даасан нөхцөл байдал болгон Эрүүгийн хуульдаа тусгайлан хуульчилаагүй, аргагүй хамгаалалт, гарцаагүй байдал, хууль биелүүлэх, тушаал, захирамж биелүүлэх институтын хүрээнд авч үздэг байна. Ийм орнуудад Австрали, Австри, Аргентин, Бельги, Герман, Голланд, Дани, Швейцарь, Франц, Турк, Израль, Испани, Польш, БНХАУ, БНСУ, Япон, Тайланд хамаарна. Тэдний төлөөлөл болгон дараахь орнуудын эрүүгийн хууль дахь зохицуулалтыг авч үзье.

ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн 1-р хэсгийн 4-р бүлгийн 32-р зүйлд "...Аргагүй хамгаалалт хийх хэрэгцээ, шаардлагын улмаас тодорхой нөхцөл байдалд үйлдэл хийсэн бол гэмт хэрэгт тооцохгүй. Аргагүй хамгаалалт нь өөрт болон бусад хүнд халдсан бодитой, хууль бус довтолгооныг няцаах зорилгоор хийсэн хамгаалалт мөн....", 34-р зүйлд "...Өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэнд, эрх чөлөө, нэр төр, алдар хүнд, өмчлөх эрх болон бусад эрх зүйн үнэт зүйлийг тэдгээрт бодитой, нэгэнт тулгарсан аюулаас хамгаалах, түүнийг зайлуулахын тулд хууль ёсны үйлдэл хийсэн бөгөөд зөрчигдсэн эрх ашиг, учруулсан хор уршиг нь хамгаалж буй эрх ашиг

сонирхол, түүнд учирч болох байсан хор уршгаас бага бол гэмт хэрэгт тооцохгүй..."⁴⁵ заасан ба дээрх хоёр ойлголтын хүрээнд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах саатуулах үедээ гэм хор учруулах үйлдлийг авч үзжээ.

Франц улсын Эрүүгийн хуулийн *"Нийтлэг үндэслэл"* гэсэн 1-р дэвтрийн *"Эрүүгийн хариуцлага хүлээлгэж болохгүй байдал"* гэсэн 2 бүлгийн 122.4-р зүйлд хууль биелүүлэх, 122.5-р зүйлд аргагүй хамгаалалтын ойлголт, нөхцлийг хуульчилжээ. 122.4-д "...Хуульд заасан болон тушаал, захирамжаар үүрэг болгосон үйлдлийг хийх явцдаа гэм хор учруулсан үйлийг гэмт хэрэг тооцохгүй, харин илт хууль бус тушаал, захирамжийг мэдсээр байж биелүүлсэн нь энэ зүйлд хамаарахгүй...", 122.5-д "...өөрт нь болон бусдад халдсан хууль бус үйлдэл, халдлагын эсрэг хууль ёсны хамгаалалтын нөхцөл байдалд үйлдэл хийсэн ба уг үйлдэл нь түүнд тавигдах хэр хэмжээнд хийгдсэн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй. Хууль ёсны хамгаалалтын байдалд үйлдэл хийсэн гэдэгт өөрийн болон бусдын орон байранд хүч хэрэглэх, хаалга, хамгаалалт бэхэлгээг эвдэх, шөнөөр нэвтрэх, эсвэл хуурч мэхлэх замаар нэвтэрсэн, хууль бус үйлдэл, хүч хэрэглэсэн болон хулгай, дээрмийн халдлагаас өөрийгөө болон бусдыг хамгаалах зорилгоор хийсэн үйлдлийг ойлгоно..."⁴⁶ гэж зааснаас үзэхэд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах, саатуулах үед гэм хор учруулах үйлдлийг хууль хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хамааруулсан харагдаж байна.

Австралийн холбооны улсын 2005 оны Эрүүгийн хуулийн *"Эрүүгийн хариуцлагын зарчим"* гэсэн 2 бүлгийн *"Эрүүгийн хариуцлагыг үгүйсгэх нөхцөл байдал"* гэсэн 2.3 хэсгийн 10-р зүйлийн 10.3-т ".. гэнэтийн болон онцгой аюултай нөхцөл байдлын үед түүнийг таслан зогсоох, зайлуулах, хамгаалах зорилгоор хор уршиг учруулсан нь эрүүгийн хариуцлагыг үгүйсгэнэ..."⁴⁷, 10.4-т "...өөрийгөө болон бусдын амь нас эрүүл мэндийг хамгаалах, өөрийн болон бусдын эрх чөлөөг хязгаарласан болон хязгаарлах гэсэн үйлдлийн эсрэг хийсэн, өөрийн эд хөрөнгийг бусдын зүгээс хууль бусаар авах, устгах, гэмтээхээс хамгаалах, дээрх зорилгоор орон байранд хууль бусаар нэвтрэх үед хамгаалах, өөрийн эдлэн газар, эд хөрөнгийг хамгаалах, орон байр, эдлэн газраас гэмт этгээдийг албадан гаргах зорилгоор хийсэн бол өөрийгөө хамгаалсан гэж үзнэ..."⁴⁸ гэж түүнийг гарцаагүй байдал, аргагүй хамгаалалтад хамааруулсан нь илт байна.

Голланд улсын Эрүүгийн хуулийн *"Эрүүгийн хариуцлага хүлээлгэж болохгүй нөхцөл байдлууд"* гэсэн 3-р хэсгийн 42-р зүйлд "...хэрэв хувь хүн хуулийн заалтыг биелүүлэхдээ хууль зөрчсөн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй...", 43-р зүйлд "...эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас өгсөн хууль ёсны тушаал, зааврыг биелүүлэхдээ хууль зөрчсөн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй..."⁴⁹ гэж заасан бол **Турк** улсын Эрүүгийн хуулийн *"Эрүүгийн хуулийн зарчим"* гэсэн 1-р дэвтрийн *"Эрүүгийн хариуцлагыг үгүйсгэх болон түүнийг хөнгөрүүлэх нөхцөл байдал"* 4-р хэсгийн 49-р зүйлийн 1 дэх заалтад "... хууль хэрэгжүүлэх болон дээд шатны эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас өгсөн тушаалыг биелүүлэх нь тодорхой этгээдийн хувьд албан тушаалын үүрэг байсан бөгөөд түүнийг тогтоосон хэр хэмжээнд биелүүлсэн бол гэмт хэрэг болохгүй..."⁵⁰ гэж уг институтыг хууль биелүүлэх, даргын тушаал захирамж биелүүлэхтэй адилтган үзэхээр хуульчилсан байна.

Манай урд хөрш **БНХАУ**-ын Эрүүгийн хуулийн 20-р зүйлд "... Улс орон, олон нийтийн ашиг тус, тус хүнээ буюу бусдын биеийн, эд хөрөнгийн ба бусад эрхийг яг явагдаж байгаа хууль бус халдлагаас халдлагад учруулахгүйн тулд, хууль бус халдлагыг хориглон зогсоохын тулд авсан үйл ажиллагаа нь хууль бусаар халдагсад хохирол учруулсан байвал зүй ёсны хамгаалалтанд тооцогдох болохоор эрүүгийн хариуцлага хүлээхгүй.

Зүй ёсны хамгаалалт нь зохих хэмжээнээс илтэд хэтрээд хүнд их хохирол учруулсан байвал эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Гэвч хөнгөрүүлэн шийтгэх буюу шийтгэлээс хэлтрүүлэх ёстой. Явагдаж байгаа хэрцгийлэх, хүн алах, булаан тонох, мэхлэх, уулгалах жич, хүний биеийн амар түвшинд хүнд ноцтой хор хохирол учруулсан нь бусдад хүчирхийллийн ялт ажиллагаанд хамгаалах ажиллагаа ба хууль бус халдагсдыг шархдуулсан, үхүүлсэн буюу бусад үр уршиг гаргасан байвал хамгаалалт хэтэрсэнд үл тооцогдох болохоор эрүүгийн хариуцлага хүлээхгүй...", 21-р зүйлд "...Улс орон, олон нийтийн ашиг тус, тус хүнээ буюу бусдын биеийн, эд хөрөнгийн ба бусад эрхийг ял гарч байгаа аюул түгшүүрт учруулахгүйн тулд арга бусаар аюулаас зайлуулах бачим үйл ажиллагаа аваад хохирол учруулсан байвал эрүүгийн хариуцлага хүлээхгүй.

⁴⁵Уголовный кодекс ФРГ. МГУ.Изд. Зерцало. М. 2001 г. с 19

⁴⁶Уголовный кодекс Франции. СПб. Изд. Юридический центр Пресс. 2002 г. с.80-81

⁴⁷Уголовный кодекс Австралии. СПб. Изд. Юридический центр Пресс. 2002 г. с.75

⁴⁸Уголовный кодекс Австралии. СПб. Изд. Юридический центр Пресс. 2002 г. с.76

⁴⁹Уголовный кодекс Голландии.СПб. Изд. Юридический центр Пресс. 2001 г. с.174

⁵⁰Уголовный кодекс Турции. .СПб. Изд. Юридический центр Пресс. 2003 г. с.60

Аюулаас зайлуулах бачим ажиллагаа нь зохих хэмжээнээс хэтрээд байж болзошгүй хэмжээнээс илүү хохирол учруулсан байвал эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Гэвч хөнгөрүүлэн шийтгэх буюу шийтгэлээс хэлтрүүлэх ёстой...”⁵¹ гэж зааснаас харахад аргагүй хамгаалалт, гарцаагүй байдлын ойлголт, хэр хэмжээ, түүнийг хэтрүүлсэн тохиолдолд хүлээлгэх хариуцлага, оногдуулах ялын тухай зааснаас бус, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах саатуулах үед гэм хор учруулах талаар тусгайлсан зохицуулалт байхгүй байна. Гэмт этгээд ямар төрлийн объектод халдсанаас хамаарч аргагүй хамгаалалт, гарцаагүй байдлын үед хэр хэмжээ хэтрүүлсэн эсэхийг тогтоох талаар заасан нь хүний эрхийг дээдэлсэн дэвшилттэй зохицуулалт болжээ.

Япон улсын Эрүүгийн хуулийн 7-р бүлгийн 35-р зүйл / хууль болон албаны үүргээ биелүүлэх/, 36-р зүйл /хууль ёсны хамгаалалт/, 37-р зүйл /гарцаагүй байдал/, **БНСУ**-ын Эрүүгийн хуулийн 2-р бүлгийн 20-р зүйл /зөвтгөж болох үйлдэл/, 21-р зүйл /Өөрийгөө хамгаалах/, 23-р зүйл /гарцаагүй байдал/ зүйлүүдэд⁵² дээрх улсуудтай ижил зохицуулалтыг хуульчилжээ. .

Судалгааны үр дүнд харьцангуй цөөхөн орны эрүүгийн хуульд гэмт этгээдийг баривчлах, саатуулах үед гэм хор учруулах үйлдлийг гэмт хэргийн нийгмийн хор аюулыг үгүйсгэх бие даасан нөхцөл байдалд тооцож тусгайлан бие даасан зүйлд хуульчилжээ. Ийм ЭЭЗүйн зохицуулалттай орнууд нь ОХУ, хуучнаар ЗХУ-ын бүрэлдэхүүнд багтаж байсан, одоогийн ТТУХН-ийн гишүүн орнууд /Украйн, Беларусь, Казакстан, Киргыз, Молдав, Узбекистан, Туркменистан, Тажикстан, Азербайджан, Армени/, болон Норвеги, Сан-Марино, Аргентин, АНУ-ын зарим муж улсууд /Техас, Нью-Йорк г.м/ , Монгол, Болгар зэрэг улсууд юм.

ОХУ-ын Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн 38-р зүйлд бидний судалж буй институтыг гэмт хэргийн нийгмийн хор аюулыг үгүйсгэх бие даасан нөхцөл байдал болгон хуульчилсан ба уг зүйлийн 1-д "...Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах, төрийн байгууллагад хүргэх, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилгоор уг этгээдэд гэм хор учруулсан бөгөөд түүнийг тухайн нөхцөлд өөр арга хэрэгслээр зогсоох боломжгүй байсан, энэ ажиллагаанд тавигдах хэр хэмжээнд нь хийсэн бол гэмт хэрэгт тооцохгүй..." , 2 дахь хэсэгт "...Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах саатуулах явцад хэр хэмжээг илтэд хэтрүүлсэн гэдэгт тухайн этгээдийн үйлдсэн хэргийн нийгмийн хор аюулыг шинж чанар, хэр хэмжээ, баривчлах, саатуулах үйл ажиллагаа хэрэгжүүлэх үеийн нөхцөл байдлыг харгалзахгүйгээр уг этгээдэд онцын шаардлагагүйгээр, үүссэн нөхцөл байдалд тохироогүй, илүү хүнд гэм хор учруулсаныг ойлгоно. Энэ нөхцөлд хор үршгийг санаатайгаар учруулсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ..."⁵³ гэж хуульчилсан байна. Киргыз улсын Эрүүгийн хуульд үүнтэй ижил хэм хэмжээ бий⁵⁴.

Болгар улсын Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн "Гэмт хэрэг" гэсэн 2-р бүлгийн 12.А зүйлийн 1 дэх хэсэгт "...Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг төрийн байгууллагад хүргэх, дахин гэмт хэрэг үйлдэхийг таслан зогсоох зорилгоор баривчлах, саатуулахдаа гэм хор учруулах учруулсан нь тухайн нөхцөлд өөр арга хэрэгслээр баривчлах, саатуулах боломжгүй байсан, уг үйл ажиллагаанд тавигдах хэр хэмжээнээс хэтрээгүй бол гэмт хэрэгт тооцохгүй..."⁵⁵ гэж заасан нь гэмт этгээдийг баривчлах саатуулах үед гэм хор учруулах ажиллагааны ойлголт, мөн чанар, үр дагаврыг бүрэн гаргасан тодорхойлолт болсон гэж үзэж байна. Харин уг зүйлийн 2 дахь хэсэгт гэмт этгээдийг баривчлах саатуулах үед гэм хор учруулахад тавигдах хэр хэмжээг тодорхойлсон заалт нь ОХУ-ын Эрүүгийн хуулийнхтай үндсэндээ төстэй юм.

Хүлээн зөвшөөрч авч хэрэглэж болохуйц шинэлэг зохицуулалт **Узбекистан** улсын Эрүүгийн хуульд байгааг дурьдалгүй өнгөрч боломгүй. Тус улсын Эрүүгийн хуулийн 39-р зүйлийн 3 дахь хэсэгт "...Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах, саатуулах явцад гэм хор учруулахдаа хэр хэмжээг хэтрүүлсэн эсэхийг тогтоохдоо гэмт этгээдийн баривчлах саатуулах үеийн зан байдал, үзүүлсэн эсрэгүүцэл, үйлдлийн шинж чанар, тоо, хүчний харьцаа, саатуулж буй этгээдийн хийсэн үйлдэл, сэтгэл зүйн байдал болон бусад нөхцөл байдлыг харгалзана..."⁵⁶ гэж заасан нь онолын хувьд шинэлэг бус ч, тухайн хэм хэмжээг амьдралд хэрэглэх, уг үйлдлийг практикт нотолж тогтооход ач холбогдолтой заалт болжээ.

Казакстан улсын Эрүүгийн хуулийн 33-р зүйлийн 1, 2 дахь эсэгт ОХУ-ын Эрүүгийн хуулийн хэм хэмжээтэй ижил зохицуулалт байгаа бол уг зүйлийн 3 дахь хэсэгт гэмт этгээдийг баривчлах, саатуулах эрх бүхий этгээдийг хуульчилсан нь онцлог, судалгааны хувьд анхаарал

⁵¹БНХАУ-ын Эрүүгийн ба эрүүгийн заргын тухай хууль /Монгол хэлэнд буулгасан Б.Батзориг, Э.Зууннасан. УБ. 2006 он. 13-14 дэх тал

⁵²Уголовный кодекс Японии. СПб. Изд. Юридический центр Пресс. 2002 г. с.50-51, Уголовный кодекс Корея. СПб. Изд. Юридический центр Пресс. 2004 г. с. 49-50 үзнэ үү

⁵³Уголовный кодекс Российской Федерации. М.изд. Проспект.2014 год. с 34

⁵⁴Уголовный кодекс Кыргызской Республики. Бишкек. изд Раритет.1999 г. с 12

⁵⁵Уголовный кодекс Республики Болгария. СПб. Изд Юридический центр Пресс.2001 г. с 33

⁵⁶Уголовный кодекс Республики Узбекистан.СПб. изд Юридический центр Пресс.2001 г. с 79

татаж байна. Уг хэсэгт гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах, саатуулах үйл ажиллагаа явуулах эрхийг хууль сахиулах байгууллагын ажилтнууд, гэмт хэргийн хохирогч, бусад иргэн эдлэх талаар заажээ⁵⁷. Ийм заалт Беларусь улсын Эрүүгийн хуулийн 35-р зүйлд бас байдаг⁵⁸.

Харин **Молдов** улсын Эрүүгийн хуулийн 37-р зүйл нь нэг хэсэгтэй бөгөөд судалж буй институтын зөвхөн ойлголтыг хуульчилсан⁵⁹ нь манай улсын Эрүүгийн хуулийн 41-р зүйлтэй ижил байна.

Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах, саатуулах үед гэм хор учруулах үйлийг бие даасан хэм хэмжээнд хуульчилсан орнуудын дотор Норвеги, Сан-Сарино, АНУ-ын зарим муж улсуудын Эрүүгийн хуулиуд онцгой байр суурь эзэлнэ.

Норвеги улсын Эрүүгийн хууль тогтоомж нь 1902 онд батлагдсан Эрүүгийн нийтлэг /ерөнхий/ хууль болон Тусгай Эрүүгийн /Цэргийн эрүүгийн хууль/ хуулиас бүрддэг⁶⁰.

Норвеги улсын Эрүүгийн ерөнхий хуулийн *"Эрүүгийн хариуцлага хүлээлгэх нөхцөл"* гэсэн 3-р бүлгийн 47, 48-р дэд бүлэгт хууль ёсны хамгаалалт, гарцаагүй байдал, гэмт этгээдийг баривчлах, саатуулах асуудлыг хуульчилсан байдаг. Тухайлбал: 48-р дэд бүлгийн 1 дэхь хэсэгт "...Өөрийгөө хамгаалах зорилгоор хийсэн үйлдлийн төлөө хэн ч хариуцлага хүлээхгүй..." 2 дахь хэсэгт "...Гэмт этгээдийн хууль бус халдлага, довтлогооноос урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилгоор хийгдсэн, хууль бус халдлагын шинж чанар, түүний улмаас учирч болох байсан хор уршиг, халдан довтлогч этгээдийн гэм буруу зэрэгт нийцсэн, түүнээс илт хэтрээгүй, эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн шинжийг хэлбэр төдий агуулсан үйлдлийг өөрийгөө хамгаалсан үйлдэл гэж үзнэ..." гэж аргагүй хамгаалалтын ойлголт, түүний хэр хэмжээг тодорхойлсон бол 3 дахь хэсэгт "...Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах, урьдчилан хорих газар болон хорих ангиас ялтныг оргохоос сэргийлэх зорилгоор хийсэн үйлдэл нь түүнд тавигдах хэр хэмжээ, зорилгоос хэтрээгүй, байж болох зохистой хэмжээнд хийсэн бол хууль бус халдлагыг таслан зогсоосон гэж үзэж гэмт хэрэгт тооцохгүй..."⁶¹ байхаар гэмт этгээдийг баривчлах үйл ажиллагааг хуульчилжээ.

Ингэхдээ зөвхөн гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах, саатуулах бус, хорих газар хоригдож буй ялтан, урьдчилан хорих төвд саатуулагдагдаж буй сэжигтний оргох үйлдлийг таслан зогсоох зорилгоор уг үйлдлийг хийсэн байхаар заасан нь манай улсын Эрүүгийн хуулийн 41-р зүйлтэй үндсэндээ ижил төстэй.

Судалж буй асуудал нь **Сан –Марино** улсын Эрүүгийн хуульд их өвөрмөц байдлаар хуульчилагдсан болохыг *"Зөвтгөж болох нөхцөл байдал"* гэсэн 4-р бүлгийн 43-р зүйлээс харж болно. Уг зүйлд "...Албан тушаалтан өөрийн албан тушаалын үүргээ биелүүлэх, хэрэгжүүлэх явцад хууль ёсны үйл ажиллагааг нь эсрэгүүцсэн, саад учруулсан тохиолдолд биеийн хүч хэрэглэсэн бол ял оногдуулахгүй. Энэ нөхцөлд зөвхөн хуульд шууд заасан тохиолдолд зэвсэг хэрэглэж болно..." гэж хууль ёсны дагуу хүч хэрэглэх үйлдлийг заасан байна.

Тус улс эрүүгийн хуулийн 45-р зүйлд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах саатуулах үед гэм хор учруулахдаа түүнд тавигдах хэр хэмээг хэтрүүлсэн тохиолдолд хүлээлгэх асуудлыг өвөрмөц байдлаар шийдвэрлэжээ. Уг зүйлд "...энэ хуулийн 41, 42, 43-р зүйлүүдэд заасан үйлдлийг хийхдээ тэдгээрт хуулиар болон төрийн захиргааны байгууллагаас тавигдсан хэр хэмжээ, шалгуурыг санаатай бус байдлаар хэтрүүлж хор уршиг учруулсан бол болгоомжгүй гэмт хэрэг үйлдсэнд тооцож ял онооно..."⁶² гэж заасан нь манай улсын эрүүгийн хуульд хэрэгжүүлж болох хэм хэмжээ байж болох юм.

Англи улс орчин үед төрөлжүүлж нэгтгэсэн Эрүүгийн хуульгүй цөөхөн орны нэг бөгөөд ЭЭЗүйн эх сурвалжид парламентаас баталсан хууль /статуты/, шүүхийн прецедент /жишиг/ хамаардаг. Хэдий гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдлыг ЭЭЗүйн онол, шүүхийн практикт тулгуурлан авч үздэг хэдий ч 1967 онд батлагдсан *"ЭЭЗүйн тухай"* хуулийн 3-р зүйлд "...Аливаа хүн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоохын тулд гэмт хэрэгтэн, болон сэжигтнийг баривчлах, баривчлахад туслахын тулд бололцоотой хэмжээнд хүч хэрэглэж болно..." гэмт хэрэгтнийг баривчлах саатуулах үйл ажиллганы эрх зүйн үндсийг хуульчилж өгчээ.

Бидний судалгаанд хамрагдсан улсуудаас судалж буй гэмт этгээдийг баривчлах, саатуулах үед гэм хор учруулах үйлдлийг бусад орноос илүү нарийвчлан, дэлгэрэнгүй хуульчилсан орон бол АНУ юм. Энэ нь тус улсад хүний эрхийг дээд зэргээр дээдэлдэг, иргэд галт зэвсгийг чөлөөтэй эзэмшдэг, галт зэвсэг ашиглан үйлдэгддэг гэмт хэргийн тоо харьцангуй их, хүний эрхийг хууль сахиулах

⁵⁷Уголовный кодекс Республики Казакстан.СПб.Изд.Юридический центр Пресс.2001 г. с 54-55

⁵⁸Уголовный кодекс Республики Беларусь.СПб.Изд.Юридический центр Пресс.2001 г. с 109

⁵⁹Уголовный кодекс Республики Молдова. г.Кишинев. 2002 г. с 10

⁶⁰Уголовное законодательство Норвегии.СПб.Изд.Юридический центр Пресс.2003 г. с 13

⁶¹Уголовное законодательство Норвегии. СПб.Изд.Юридический центр Пресс.2003 г. с 74

⁶²Уголовный кодекс Республики Сан-Марино. СПб.Изд.Юридический центр Пресс.2002 г. с 54-55

байгууллагын хууль бус үйлдлээс хамгаалах, хууль сахиулах байгуул-лагын ажилтны эрхийг хангах зэрэг зайлшгүй шаардлагаас үүдэлтэй.

АНУ-ын Эрүүгийн хууль тогтоомжийн тогтолцоо нь Холбооны эрүүгийн загвар хууль, муж улсуудын эрүүгийн хууль, холбооны хэмжээнд үйлчилдэг бусад хуулиас бүрддэг. АНУ-ын Холбооны эрүүгийн загвар хууль нь жинхэнэ биет хуулийн шинж чанаргүй, зөвхөн шинжлэх ухааны зөвлөмжийн шинж чанартай эрх зүйн акт учраас Нью-Йорк, Техас муж улсуудын Эрүүгийн хуулийг төлөөлүүлэн судаллаа.

1909 оны Нью-Йорк муж улсын Эрүүгийн хуулийн 35.30-р зүйлд "...Хэрэв нийгмийн хэв журам сахиулж буй цагдаагийн ажилтан болон бусад албан тушаалтан гэмт этгээдийг баривчлах явцад хүч хэрэглэсэн нь баривчлах үеийн нөхцөл байдалд нийцсэн, зайлшгүй шаардлагатай байсан бол хууль ёсны гэж үзнэ..."⁶³ гэж тодорхойлолт өгсөний зэрэгцээ баривчлах ажиллагаанд тавигдах шаардлага, хэр хэмжээ үүсэх үр дагаврыг нарийвчлан тусгажээ.

Техас муж улсын Эрүүгийн хуулийн *"Эрүүгийн хариуцлагын нийтлэг зарчим"* гэсэн 2-р хэсгийн *"Эрүүгийн хариуцлагыг үгүйсгэх, зөвтгөх нөхцөл байдал"* гэсэн 4-р бүлгийн 9.51-р зүйлд гэмт этгээдийг баривчлах болон нэгжих явцад эсрэгүүцсэн тохиолдолд хүч хэрэглэх, 9.52-р зүйлд саатуулагдсан этгээд оргон зайлахыг таслан зогсоох, 9.53-р зүйлд хорих газар аюулгүй байдлыг сахиулах асуудлыг хуульчилжээ. 9.51-р зүйлд "...Хууль сахиулах байгууллагын ажилтан эсвэл бусад этгээд хууль сахиулах ажилтны даалгавраар баривчлах, нэгжих ажиллагааг явуулах, эсвэл баривчилсаны дараа оргон зугтахыг таслан зогсоох зорилгоор бусдад хүч хэрэглэсэн бөгөөд ийнхүү хүч хэрэглэсэн нь тухайн нөхцөлд зайлшгүй байсан, баривчлах, нэгжих ажиллагаа явуулахад тавигддаг шаардлагад нийцсэн бол хууль ёсны гэж үзнэ..." гэж заасан байна.

Харин 9.52-р зүйлд урьдчилан хоригдсон /саатуулагдсан/ этгээдийг оргон зайлахыг таслан зогсоох зорилгоор хүч хэрэглэх үйлдлийг зөвхөн оргон зайлсан этгээдийг баривчлах, урьдчилан хорих арга хэмжээг цаашид хэрэгжүүлэхэд чиглэгдсэн байх, оргон зайлах үеийн нөхцөл байдалд нийцсэн байх, онцгой тохиолдолд амь насыг хохирохоос бусад хор уршгийг учруулсан байх гэсэн шинжүүдээр тодорхойлсон бол 9.53-р зүйлд "...Хорих байгууллагын албан хаагч, албан тушаалтан уг байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах, өөрийн болон бусад хорих байгууллагын ажилтан, бусад ялтнуудын аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор ялтанд хүч хэрэглэсэн, гэм хор учруулсан нь тухайн нөхцөлд зайлшгүй, тухайн ялтны зан байдалд нийцсэн бол хууль ёсны үйлдэл болно..."⁶⁴ гэж заасан байна.

Техас муж улсын Эрүүгийн хуульд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах саатуулах ажиллагааг хуульчлахдаа түүний хамрах хүрээг зөвхөн гэмт хэрэг үйлдсэн этгээд төдийгүй урьдчилан хоригдож буй этгээд, хорих ял эдэлж ялтан байхаар заасны зэрэгцээ үйл ажиллагаа нь зөвхөн цагдаагийн байгууллагын хүрээнд бус урьдчилан хорих төв, хорих ангид хэрэгжихээр заасан, хэрэгжүүлэх субъектыг цагдаагийн ажилтан, баривчлах, нэгжих ажиллагаанд орлцож буй иргэн, урьдчилан хорих байрны ажилтан, хорих ангийн ажилтан байхаар илүү тодорхой, ойлгомжтой байдлаар хуульчилсан нь сайшаалтай.

Дүгнэлт.

1. Гэмт этгээдийг баривчлах, саатуулах явцад гэмт хор учруулсан үйлдлийг ихэнх улс орнууд гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдлын бие даасан төрөл болгон эрүүгийн хуульдаа хуульчилаагүй, манай улсын 1986 оны шинэчилэн найруулсан Эрүүгийн хуулийн зохицуулалттай ижил байдлаар аргагүй хамгаалалттай, эсвэл гарцаагүй байдал, хууль биелүүлэх, мэргэжлийн үүргээ биелүүлэх үйлдэлтэй адилтган авч үзсэн байна.

2. Манай улс гэмт этгээдийг баривчлах, саатуулах явцад гэмт хор учруулсан үйлдлийг гэмт хэргийн нийгмийн хор аюулыг үгүйсгэх нөхцөл байдлын бие даасан төрөл болгон эрүүгийн хуульдаа тусгайлан заасан цөөн орнуудын нэг юм.

3. Хууль тогтоогч Эрүүгийн хуулийн 40, 42, 43-р зүйлүүдэд гэмт хэргийн нийгмийн хор аюулыг үгүйсгэх бусад нөхцөл байдлуудыг хуульчлахдаа тэдгээрийн ойлголт, шалгуур, хэр хэмжээ, үр дагаврын талаар тодорхой хэмжээнд хуульчилсан атлаа 41-р зүйлд гэмт этгээдийг баривчлах, саатуулах үед гэм хор учруулах институтыг зөвхөн түүний ойлголтыг хуульчилах явдлаар хязгаарлажээ.

4. АНУ, Сан-Марино, Норвеги, Узбекистан зэрэг орнуудын эрүүгийн хуульд судалж буй институтын ойлголт, хууль зүйн шинж, хамрах хүрээ, хэрэгжүүлэх субъект, шалгуур, хэр хэмжээ, үүсэх эрх зүйн үр дагавар, хүлээлгэх хариуцлагын /ялын/ хэмжээ зэргийг илүү тодорхой нарийвчлан хуульчилсан нь дээрх орнуудын эрүүгийн хууль тогтоомжийн шинжлэх ухааны үндэс,

⁶³Уголовное право зарубежных стран.Сборник законодательных актов.Под ред.И.П.Козочкина М. изд. Зерцало. 1999 г. с.114-115

⁶⁴Уголовный кодекс Штата Техас. СПб.изд.Юридический центр Пресс.2006 г. с.110-115

хөгжлийн түвшинг илэрхийлээд зогсохгүй, эрүүгийн хууль хэрэглэх үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой юм.

5. Манай улсын хувьд гэмт этгээдийг баривчлах, саатуулах үед гэм хор учруулах институтыг дээрх орнуудын жишигт ойртуулан хуульчлах нь түүний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох төдийгүй, хүний эрхийг хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох ажиллагаанд оролцох иргэдийн оролцоог хангах, ийм ажиллагааг хэрэгжүүлсэн төрийн албан хаагч, хууль сахиулах байгууллагын ажилтан, иргэний эрх ашгийг хамгаалах, эрх зүйн баталгааг бий болгоход чухал нөлөө үзүүлэх учиртай.

Санал

Судалгааны үр дүнд хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн 41-р зүйл, 2017 оны 7-р сарын 1-нээс хүчин төгөлдөр үйлчлэх 2015 оны Шинэчилэн найруулсан эрүүгийн хуулийн 4.2 –р зүйлийг дараахь байдлаар өөрчлөн найруулах зүйтэй гэж үзэж байна.

.....р зүйл. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах, саатуулах үед гэм хор учруулах

1. Гэмт хэрэг үйлдсэн этгээд болон мөрдөн шалгах ажиллагаанаас оргосон сэжигтэн, яллагдагч, хорих ангиас оргосон ялтныг төрийн байгууллагад хүргэх, шинээр гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилгоор баривчлах, саатуулахдаа гэм хор учруулсан бөгөөд уг үйлдэл нь энэ хуульд заасан хэр хэмжээнээс илт хэтрээгүй бол гэмт хэрэгт тооцохгүй.

2. Баривчлах, саатуулах үеийн нөхцөл байдалд илт нийцээгүй үйлдэл хийсэн, зайлшгүй хор уршиг учруулах нөхцөл байдал бүрдээгүй байхад хор уршиг учруулсаныг баривчлах, саатуулахдаа хэр хэмжээг илт хэтрүүлсэн гэж үзнэ.

3. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах, саатуулах явцад гэм хор учруулахдаа хэр хэмжээг илт хэтрүүлсэн эсэхийг тогтоохдоо гэмт этгээдийн баривчлах, саатуулах үеийн зан байдал, үзүүлсэн эсрэгүүцэл, үйлдлийн шинж чанар, учруулж болох байсан хор уршиг, баривчилах, саатуулах зорилгоор хийсэн үйлдлийн шинж чанар, учруулсан хор уршиг, баривчилах, саатуулах үйлдлийг хийсэн этгээдийн сэтгэл зүйн байдал, хэрэглэсэн зэвсэг, хүчний харьцаа болон бусад нөхцөл байдлыг харгалзана.

4. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах, саатуулах үед санаатайгаар хэр хэмжээг илт хэтрүүлж хор уршиг учруулсан бол эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээнэ.

ПРЕВЫШЕНИЕ ПРЕДЕЛОВ НЕОБХОДИМОЙ ОБОРОНЫ В РАЗЪЯСНЕНИЯХ ПЛЕНУМОВ ВЕРХОВНОГО СУДА СССР И РОССИЙСКОЙ ФЕДЕРАЦИЙ

Одним из условий правомерности необходимой обороны является требование о том, чтобы не были превышены ее пределы. Понятие превышения пределов необходимой обороны раскрывается в части 2 статьи 37 УК РФ – под таким превышением понимаются умышленные действия, явно не соответствующие характеру и опасности посягательства.

Таким образом, можно выделить как минимум два признака превышения пределов необходимой обороны:

- 1) под таким превышением понимаются лишь умышленные действия;
- 2) данные действия должны явно не соответствовать характеру и опасности посягательства.

Следует заметить, что законодательное определение превышения пределов необходимой обороны является оценочной категорией. Определение пределов правомерности оборонительных действий, без сомнения, остается весьма дискуссионным вопросом как в науке уголовного права, так и в правоприменительной деятельности.

В течение длительного времени вопросы, возникавшие в ходе применения положений статьи 37 Уголовного кодекса Российской Федерации, разрешались с учетом разъяснений, данных Пленумом Верховного суда СССР в постановлении от 16 августа 1984 года № 14 «О применении судами законодательства, обеспечивающего право на необходимую оборону от общественно опасных посягательств». В настоящее время данное постановление утратило силу в связи с принятием постановления Пленума Верховного суда Российской Федерации от 27 сентября 2012 г. № 19 «О применении судами законодательства о необходимой обороне и причинении вреда при задержании лица, совершившего преступление». Необходимость принятия нового постановления во многом была обусловлена вопросами, требующими более конкретного решения при оценке правомерности оборонительных действий.

Разъяснения, данные в вышеуказанных постановлениях, коснулись и проблемы установления пределов необходимой обороны.

Содержание первого из вышеуказанных признаков превышения пределов необходимой обороны представляется довольно простым и заключается в требовании установления вины оборонявшегося в форме умысла к оборонительным действиям и наступившим в результате этого последствиям.

Пленум Верховного суда СССР по этому поводу указывал, что «причинение посягающему при отражении общественно опасного посягательства вреда по неосторожности не может влечь уголовной ответственности»⁶⁵. Аналогичное разъяснение дает и Пленум Верховного суда РФ: «ответственность за превышение пределов необходимой обороны наступает только в случае, когда по делу будет установлено, что оборонявшийся осознавал, что причиняет вред, который не был необходим для предотвращения или пресечения конкретного общественно опасного посягательства»⁶⁶.

Второй признак имеет более сложное содержание, и для правильного его толкования следует, во-первых, определиться с понятием явности, а, во-вторых, выяснить, в каких случаях оборонительные действия будут явно не соответствовать характеру и опасности посягательства.

В русском языке термин «явный» определяется как «совершенно очевидный»⁶⁷, а также «что всякому ясно, видно, ощутительно, понятно, не подлежит сомнению или спору»⁶⁸. В связи с

⁶⁵ п. 7 постановления Пленума Верховного Суда СССР от 16 августа 1984 года № 14 «О применении судами законодательства, обеспечивающего право на необходимую оборону от общественно опасных посягательств» // Справочно-правовая система «КонсультантПлюс».

⁶⁶ п. 11 Постановления Пленума Верховного суда Российской Федерации от 27 сентября 2012 г. № 19 «О применении судами законодательства о необходимой обороне и причинении вреда при задержании лица, совершившего преступление» // Справочно-правовая система «КонсультантПлюс».

⁶⁷ Ожегов С.И. Словарь русского языка / под ред. Н.Ю. Шведовой. - М., 1986. С. 793.

⁶⁸ Даль В.И. Толковый словарь живого великорусского языка: в 4 т. М., 1994. Т. 4. С. 672.

этим К.И. Попов отмечал, что «явное, то есть очевидное, бесспорное, резкое, значительное, не подлежащее сомнению, не требующее дополнительного толкования несоответствие защиты характеру и степени общественной опасности посягательства означает причинение нападающему чрезмерного, совершенно ненужного, не вызываемого обстановкой тяжкого вреда»⁶⁹.

Пленум Верховного суда СССР по этому поводу указал, что «по смыслу закона превышением пределов необходимой обороны признается лишь явное, очевидное несоответствие защиты характеру и опасности посягательства», когда посягающему без необходимости умышленно причиняется тяжкий вред здоровью или смерть»⁷⁰.

Пленум Верховного суда РФ разъяснил данный вопрос несколько более конкретно: «уголовная ответственность за причинение вреда наступает для оборонявшегося лишь в случае превышения пределов необходимой обороны, то есть когда по делу будет установлено, что оборонявшийся прибегнул к защите от посягательства, указанного в части 2 статьи 37 УК РФ, такими способами и средствами, применение которых явно не вызывалось характером и опасностью посягательства, и без необходимости умышленно причинил посягавшему тяжкий вред здоровью или смерть»⁷¹.

Такая формулировка представляется более удачной, поскольку конкретизирует, что подлежит оценке и сравнению правоприменителем при установлении пределов правомерности оборонительных действий для конкретной ситуации. Однако простое сравнение способов и средств, а также орудий посягательства и защиты представляется явно недостаточным, поэтому в обоих постановлениях уделяется внимание тем обстоятельствам, на которые должен обратить внимание суд при решении вопроса о правомерности действий, совершенных в состоянии необходимой обороны.

Так, Пленум Верховного Суда СССР в своем постановлении от 16 августа 1984 года № 14 указывал, что «решая вопрос о наличии или отсутствии признаков превышения пределов необходимой обороны, суды должны учитывать не только соответствие или несоответствие средств защиты и нападения, но и характер опасности, угрожавшей оборонявшемуся, его силы и возможности по отражению посягательства, а также все иные обстоятельства, которые могли повлиять на реальное соотношение сил посягавшего и защищавшегося (количество посягавших и оборонявшихся, их возраст, физическое развитие, наличие оружия, место и время посягательства и т.д.)»⁷².

Пленум Верховного суда Российской Федерации в своем постановлении от 27 сентября 2012 г. № 19 отметил, что «разрешая вопрос о наличии или отсутствии признаков превышения пределов необходимой обороны, суды должны учитывать:

объект посягательства;

избранный посягавшим лицом способ достижения результата, тяжесть последствий, которые могли наступить в случае доведения посягательства до конца, наличие необходимости причинения смерти посягающему лицу или тяжкого вреда его здоровью для предотвращения или пресечения посягательства;

место и время посягательства, предшествовавшие посягательству события, неожиданность посягательства, число лиц, посягавших и оборонявшихся, наличие оружия или иных предметов, использованных в качестве оружия;

возможность оборонявшегося лица отразить посягательство (его возраст и пол, физическое и психическое состояние и т.п.);

иные обстоятельства, которые могли повлиять на реальное соотношение сил посягавшего и оборонявшегося лиц.

Признав в действиях подсудимого признаки превышения пределов необходимой обороны, суд не может ограничиться общей формулировкой и должен обосновать в приговоре свой вывод со

⁶⁹ Попов К.И. Ответственность за превышение пределов необходимой обороны и некоторые институты Общей части уголовного права. Дис. ... канд. юрид. наук. М., 2001. С. 25.

⁷⁰ п. 7 постановления Пленума Верховного Суда СССР от 16 августа 1984 года № 14 «О применении судами законодательства, обеспечивающего право на необходимую оборону от общественно опасных посягательств» // Справочно-правовая система «КонсультантПлюс».

⁷¹ п. 11 Постановления Пленума Верховного суда Российской Федерации от 27 сентября 2012 г. № 19 «О применении судами законодательства о необходимой обороне и причинении вреда при задержании лица, совершившего преступление» // Справочно-правовая система «КонсультантПлюс».

⁷² п. 8 постановления Пленума Верховного Суда СССР от 16 августа 1984 года № 14 «О применении судами законодательства, обеспечивающего право на необходимую оборону от общественно опасных посягательств» // Справочно-правовая система «КонсультантПлюс».

ссылкой на конкретные установленные по делу обстоятельства, свидетельствующие о явном несоответствии защиты характеру и опасности посягательства»⁷³.

Нетрудно заметить, что новое постановление более подробно перечисляет обстоятельства и условия, подлежащие оценке правоприменителем при решении вопроса о правомерности оборонительных действий. Представляется, что это должно способствовать снижению вероятности привлечения оборонявшегося лица к уголовной ответственности вследствие неправильного определения пределов правомерности его действий.

Таким образом, внимание теоретиков и правоприменителей к вопросам определения пределов необходимой обороны не случайно. От правильности их определения зависит, будет ли лицо привлечено к уголовной ответственности за свои оборонительные действия. Без сомнения, принятие нового постановления Пленума Верховного суда РФ является своевременным, актуальным и практически значимым. Следует отметить, что многие из положений утратившего силу постановления Пленума Верховного суда СССР нашли свое отражение в действующем. Это говорит о том, что эти положения выдержали проверку временем (временной интервал между данными постановлениями составил 28 лет), а отдельные изменения их формулировок вызваны необходимостью дальнейшей конкретизации.

Тем не менее, следует признать, что вопросы правомерности необходимой обороны по-прежнему остаются открытыми, поскольку каждая ситуация посягательства строго индивидуальна, и поэтому представляется невозможным создать универсальный алгоритм определения пределов необходимой обороны, который был бы одинаково применим ко всем без исключения случаям причинения вреда при данном обстоятельстве, исключая преступность деяния.

⁷³ п. 13 Постановления Пленума Верховного суда Российской Федерации от 27 сентября 2012 г. № 19 «О применении судами законодательства о необходимой обороне и причинении вреда при задержании лица, совершившего преступление» // Справочно-правовая система «КонсультантПлюс».

2015 ОНЫ ЭРҮҮГИЙН ХУУЛЬ /ШИНЭЧЛЭН НАЙРУУЛГА/ ДАХЬ ӨСВӨР НАСНЫ ХҮНД ЯЛ ОНОГДУУЛАХ АСУУДАЛ

Г.Ганчимэг

*Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албаны ахлах
мэргэжилтэн, ХСИС-ийн магистрант*

Хураангуй: Энэ сэдвийн хүрээнд улсын хэмжээнд өсвөр насны хүн /насанд хүрээгүй этгээд/-ий гэмт хэрэгт холбогдсон байдал, өсвөр насны хүн гэмт хэргийн холбогдогч болсон байдал, түүний шалтгаан нөхцөл болон өсвөр насны хүнийг гэмт хэргээс хэрхэн урьдчилан сэргийлэх зэрэг асуудлуудыг тусгахыг зорилоо.

Өсвөр насны хүнд оногдуулах ял нь түүний нас, биед тохирсон, эрүүл мэнд, ёс суртахуун, сэтгэцийн онцлогийг харгалзсан, нийгэмд өөрийн байр суурийг олоход туслах, боловсрол эзэмшүүлэх, үйлдсэн гэмт хэргийнх нь хор уршгийг ухамсарлуулах, гэмт хэрэг үйлдэхэд хүргэсэн орчин, хүмүүсийн нөлөөнөөс тусгаарлах, шаардлагатай тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг хорьж хүмүүжүүлэхэд чиглэсэн байна.

Өсвөр насны хүнд гэмт хэрэг үйлдэхэд юу нөлөөлж байгаа талаар ажиглахад эцэг эхийн хайр халамж дутах, амьдралын түвшин доогуур байх, ядуурал ажиглалт, гуйланчлал, тэнүүчлэл, бусад хүмүүсийн муу нөлөө, гэр бүлийн хүчирхийлэл, насанд хүрсэн болон арай ахмад насны хүүхдүүдийн зүгээс гэмт хэрэг үйлдэх эсвэл гуйлга гуйхыг шаардан дарамтлах, сониуч, гэнэн зан, согтуурал, мансуурал, хэвлэл мэдээллийн хэрэгслийн сөрөг нөлөөлөл, бусдын нөлөөнд амархан автдаг байдал, багш сурган хүмүүжүүлэгч, эцэг эхийн таагүй харьцаа, сургууль завсардалт зэрэг олон төрлийн нийгмийн сөрөг үзэгдэл нь энэ төрлийн гэмт хэргийн үндсэн шалтгаан нөхцөл болж байна.

Түлхүүр үг: Хүүхэд, гэмт хэрэг, шалтгаан нөхцөл /child, crime, circumstances of/

ОРШИЛ

Хүүхдийн эрхийн тухай конвенцид “18 нас хүрээгүй хүн бүрийг хүүхэд гэнэ”, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд “Хүүхдийн эрхийг төрсөн цагаас нь эхлэн 18 насанд хүртэл хамгаалахад энэ хууль үйлчилнэ” гэж тодорхойлсон байдаг.

Монгол Улсын хүн амын 40 гаруй хувийг 18 нас хүрээгүй өсвөр үеийнхэн эзэлж байна. Сүүлийн жилүүдэд нийгмийн хөгжлийн сөрөг үр дагаварыг даган гэмт хэргийн төрөл шинж чанар, хөдөлгөөнд ихээхэн өөрчлөлт гарч, гэмт хэрэг үйлдэж буй насанд хүрээгүй хүний тоо жилээс жилд өсч, хүүхэд гэмт хэргийн золиос болох явдал нэмэгдсээр байна.

“Шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль дахь өсвөр насны хүнд ял оногдуулах асуудал ба статистик” гэсэн энэ сэдвийн хүрээнд улсын хэмжээнд сүүлийн 2 жилд өсвөр насны хүн /насанд хүрээгүй этгээд/-ий гэмт хэрэгт холбогдсон байдал, өсвөр насны хүн гэмт хэргийн холбогдогч болсон байдал, түүний шалтгаан нөхцөл болон өсвөр насны хүнийг гэмт хэргээс хэрхэн урьдчилан сэргийлэх зэрэг асуудлуудыг тусгахыг зорилоо.

Иймд миний бие дээрх сэдвийг сонгон авч, тус сэдвийн онолын хүрээнд өчүүхэн өгүүллийг бичихийг оролдлоо. Өгүүлэл гэдэг бол орон зай, цаг хугацааны өргөн хүрээнд сонгож авсан баримтад гүнзгий дүн шинжилгээ хийж, түүний учир шалтгааныг гаргах замаар үнэлэлт өгч, дүгнэлт хийдэг шинжлэлт бичлэгийн төрөл юм.

Өгүүлэл нь нийтлэлийн төрөл зүйлийн дотроос сэдвийн хамрах хүрээ хамгийн өргөн, мэдээллийн багтаамж сайтай, танин мэдэхүйн ач холбогдол өндөр төрөл зүйл бөгөөд гол зорилго нь нийгмийн амьдралын баримт, үйл явдлыг шинжлэн судлах, нэгтгэн дүгнэхэд оршдог. Иймээс өгүүллийг бичихдээ статистик судалгаа хийх, түүний талаар мэдээлэл цуглуулах, дүгнэх нь хамгийн чухал юм. Түүнчлэн өсвөр насны хүн гэдэг нь бидний нэрлэж заншсан насанд хүрээгүй этгээд гэж ойлгож болно. Судлаачийн зүгээс тус сэдвийн хүрээнд өсвөр нас хүн болон түүнд оногдуулах ялын талаар ойлголт өгөх, эцэст нь судласан сэдвийн талаар өөрийн дүгнэлтийг танилцуулах болно.

Өсвөр насны хүн /насанд хүрээгүй этгээд/ гэмт хэргийн субъект болох нь:

Монгол Улсын хууль тогтоох эрх мэдлийн байгууллага болох Улсын Их Хурлаас шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийг 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан бөгөөд 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн даган мөрдөхөөр болсон билээ.

Хараахан хүчин төгөлдөр болж үйлчилж эхлээгүй байгаа хэдий ч хууль сахиулагч байгууллагууд нь дээрхи хуулийг даган мөрдөж, сахин биелүүлэх нь дамжиггүй юм.

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн наймдугаар бүлэгт Өсвөр насны хүнд хэрхэн ял оногдуулах талаар хуульчлан тогтоосон байна. Тухайлбал:

- Өсвөр насны хүнд ял оногдуулах үндэслэл /8.1 дүгээр зүйл/
- Өсвөр насны хүнд оногдуулах ялын төрөл /8.2 дугаар зүйл/
- Нийтэд тустай ажил хийлгэх /8.3 дугаар зүйл/
- Зорчих эрхийг хязгаарлах /8.4 дүгээр зүйл/
- Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих /8.5 дугаар зүйл/
- Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ /8.6 дугаар зүйл/ гэх мэт.

Хүний нас нь өргөн утгаараа хувь хүний онцлогийг тодорхойлох нэг гол шинж болохын хувьд өөртөө биологи, физиологи, сэтгэл судлал, нийгэм, эрх зүйн учир холбогдолтой олон хүчин зүйлийг багтаасан төрөх үеэс эхлэлтэй амьдрах, амьдарсан хугацаа юм. Хүний ухамсарт үйл ажиллагааны онцлог, сэтгэцийн түвшинг тодорхойлогч хүчин зүйл бол түүний нас юм.

Учир нь хүний нас ахиж, физиологийн хөгжлийн тодорхой өндөрлөгт хүрэх тусам хувь хүний оюун ухаан, сэтгэх үйл явцын цар хүрээ улам сайжирч, энэ хэрээр амьдрал үйл ажиллагааны туршлага баяжин төлөвшиж, өөрийн үйл ажиллагааны мөн чанар, утга учир, гарах үр дагаварыг ухамсарлан ойлгох, тайлбарлах, түүнчлэн үйл ажиллагаагаа удирдан залах, захиран хариуцах чадвар улам нэмэгддэг зүй тогтолтой.

0-14 хүртэлх насны хүүхдийг бага насны хүүхэд гэх ба бага насны хүүхэд нь өөрийн үйлдсэн гэмт хэргийн нийгмийн хор аюул, учир холбогдлыг бүрэн ухаарах чадваргүй, үйлдсэн хэргийн хариуцлага, үр дагаварыг мэдэх боломжгүй, оюун ухааны хөгжил гүйцээгүй байх тул бага насны хүүхдийг хариуцлага хүлээх чадваргүй гэж үздэг.

14-18 хүртэлх насны хүүхдийг насанд хүрээгүй гэж үзэх ба тэд хэдийгээр өөрийн үйлдлийн учир холбогдлыг ухаарах боловч бүрэн ухаарах чадваргүй, өөрийгөө удирдан жолоодох, үйлдлээ хянах, үр дагаварыг ойлгох чадвар насанд хүрсэн хүнтэй харьцуулахад харьцангуй сул тул тэдний үйлдсэн хэргийг тусгайлан авч үздэг.

Монгол Улсад 18 насанд хүрсэн этгээдийг өөрийн үйлдлээр өөртөө эрх олж авах, үүрэг бий болгох чадвартай болсон буюу эрх зүйн бүрэн чадамжтай гэж үздэг бөгөөд иргэн 18 нас хүрснээр өөрийн үйлдлийн учир холбогдлыг бүрэн ухамсарлаж, түүнээс гарах үр дагаварыг өөрөө хариуцахад оюуны болон сэтгэхүйн хөгжил нь хангалттай төлөвшсөн байдаг байна.

Хэдийгээр 18 насанд хүрч байж насанд хүрсэнд тооцогдох боловч 16 насанд хүрэхэд нь бие хүн болж төлөвшсөн гэж үзэж, иргэний үнэмлэх олгодог тул гэмт хэрэг үйлдэхдээ 16 насанд хүрсэн байвал хариуцлага хүлээх чадвартай болсон гэж үзнэ.

Иймд гэмт хэрэг үйлдэх үедээ 16 насанд хүрсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр 2002 оны Эрүүгийн хууль болон 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад тус тус хуульчлан тогтоосон байдаг.

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд тухайн этгээдийн санаатай гэм буруугаар үйлдэгддэг, хуульд тусгайлан заасан хүнд, онц хүнд /арван хоёр/ гэмт хэрэгт 14 насанд хүрсэн өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр хуульчилсан байна. Тухайлбал,

Гэмт хэрэг үйлдэх үедээ арван дөрвөн насанд хүрсэн ба арван найман насанд хүрээгүй байсан хүнд хуулийн 8 дугаар бүлэгт заасан үндэслэл, журмын дагуу ял оногдуулна.

Өсвөр насны хүнд оногдуулах ял нь түүний нас, биед тохирсон, эрүүл мэнд, ёс суртахуун, сэтгэцийн онцлогийг харгалзсан, нийгэмд өөрийн байр суурийг олоход туслах, боловсрол эзэмшүүлэх, үйлдсэн гэмт хэргийнх нь хор уршгийг ухамсарлуулах, гэмт хэрэг үйлдэхэд хүргэсэн орчин, хүмүүсийн нөлөөнөөс тусгаарлах, шаардлагатай тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг хорьж хүмүүжүүлэхэд чиглэсэн байна. Мөн шүүх гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүний хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг харгалзан энэ бүлэгт заасан журмын дагуу ял оногдуулж, оногдуулсан ял дээр нэмж, эсхүл ял оногдуулахгүйгээр хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж болохоор хуульчилсан.

Гэмт явдал, гэмт хэрэг, түүний ерөнхий ойлголт:

Гэмт хэрэг гэдэг нь нийгэмд аюултай, эрүүгийн хуульд заасан, гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүй юм. Гэмт явдал бол түүхэн явцад өөрчлөгдөж ирсэн нийгэм эрх зүйн үзэгдэл юм.

Нийгмийн хөгжлийн үе шат бүрт гэмт явдал нь өөрчлөгдөж, эрүүгийн эрх зүйн шинж чанартай тодорхой цаг үеийн дотор тухайн улсад гарч байгаа гэмт хэргүүдийн нийлбэр цогц юм.

Гэмт явдлын шалтгааныг түүний түгээмэл шинж байдлаар нь онолын үүднээс авч үзэхдээ нийгмийн объектив, субъектив шалтгаан, гэмт явдлын ерөнхий болон тодорхой төрлийн гэмт хэргийн шалтгаан, тодорхой бүлэг гэмт явдлын шалтгаан /насанд хүрээгүй хүмүүсээс үйлдэж буй гэмт явдал гэх мэт/ шууд буюу тойруу шалтгаан, гэмт хэрэгтэн бие хүнд хамаарагдах шалтгаан гэх мэт ангилж үздэг.

Гэмт явдлын шалтгаан нөхцөл, нөлөөлж байгаа хүчин зүйл олон байдгийн дотор нэг гол асуудал бол гэмт хэрэг үйлдэж байгаа этгээдийн /гэмт хэрэгтэн/ зан төлөвийн байдал юм.

Гэмт хэрэгтэн бие хүн гэдэг нь хуулиар хориглосон, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нийгэмд аюултай үйлдэл үйлдсэн бие хүн юм.

Гэмт явдал нь тухайн этгээдийн сэтгэхүйд ёс суртахууны доголдол давамгайлсан нийгэмд харш дадал хэвшил тогтсон, тэдгээр нь бие хүнд ёс суртахууны харш зан үйл бүрэлдэн тогтох тааламжгүй нөхцлөөс шалтгаалан гэмт хэрэг үйлддэг. Тиймээс бие хүний нийгэмд төлөвших ёс суртахуун, төлөвшил юу юунаас чухал болох нь тодорхой. Өсвөр насны хүмүүс гэмт хэрэгт өртөх явдал бага биш бөгөөд зарим төрлийн ноцтой гэмт хэрэг үйлдэх явдал ч өсөх хандлагатай байгааг олон талын судалгаа харуулж байна. Тухайлбал, 2016 оны 01-10 дугаар сарын байдлаар өсвөр насны хүн гэмт хэрэгт холбогдсон байдлыг үзвэл:

2015 онд гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүн 335 байсан ба 2016 оны 10 дугаар сарын байдлаар гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүн 222 байна.

Насанд хүрсэн хүн нь хүүхэд насандаа сэтгэл санаандаа тусгаж авсан зүйлээ хожим нь өөрийн зан төлөвт буулгаж байдаг гэдгийг эрдэмтэн судлаачид тогтоосон байдаг. Иймээс гэр бүлийн гишүүн - хүний төлөвшил чухал юм.

Гэр бүл бол өсвөр насны хүний /хүүхдийн / амьдралын гол орчин юм. Тиймээс өсвөр насны хүн сэтгэцийн болон ёс суртахууны хүмүүжлээ тэнд олдог.

Сүүлийн үеийн судалгаагаар насанд хүрээгүй гэмт хэрэгтний тоо нэмэгдэж, эрүүгийн гэмт хэргийн субъект болох 14 наснаасаа өмнө эрх зүйн зөрчил гаргаж, хулгай, дээрмийн гэмт хэрэгт зонхилон холбогдох болсон. Мөн сэтгэл зүйн хувьд гажигтай өсвөр насны хүний гэмт хэрэгтний тоо нэмэгдэж байна. Тухайлбал:

1. Ёс суртахуун, зан төлөвийн доголдолтой, тэр байдал нь амьдрал, үйл хөдлөл дээр нь илэрч байдаг /харааж зүхэх, бусдыг доромжлох гэх мэт/

2. Мөрийтэй тоглоом тоглох, согтууруулах ундаа, тамхи хэрэглэх, зан заншлыг үл тоомсорлох,

3. Сургалт хүмүүжлийн байгууллага, гэрээсээ зугтах,

4. Хүчирхийлсэн үйлдэл хийх, өс хонзон авах, хорон муу санаа гаргах,

5. Бэлгийн харьцаанд эрт орох, бэлгийн замбараагүй амьдралд дасах,

6. Эцэг эх, гэр бүлийн бусад гишүүнд заналхийлэх, тэдэнтэй хэрэлдэх,

7. Сахилга, сурлага сайтай хүүхдүүдэд дайсагнах хандлага гаргах,

8. Муу зүйлийг тусган авах, сурахдаа түргэн бөгөөд туршиж үзэх, хэрэгжүүлэх гэх мэт.

Өсвөр насны хүний гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, өнөөгийн байдал, цаашдын хандлага:

Өсвөр насны хүн гэмт хэргийн байдал:

Улсын хэмжээнд 2015 онд нийт 24857 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсанаас өсвөр насны хүн 419 байсан байна.

Мөн 2015 онд 335, 2016 оны эхний 10 сарын байдлаар 222 өсвөр насны хүн гэмт хэрэгт холбогдсон бөгөөд сүүлийн 2 жилийн тоон үзүүлэлтийг харахад 113 /33.7%/-аар буурсан байгаа хэдий ч гэмт хэрэгт холбогдсоор байгаа нь харамсалтай хэрэг юм. Үүнээс үзэхэд гэмт хэргийн тоо буурч байгаа мэт боловч гэмт хэрэгт холбогдсон өсвөр насны хүний тоо ихсэх хандлагатай байж болох юм. Энэ нь гэмт хэргийг хүүхдүүд бүлэглэж үйлдэж, нэг хэрэгт олон хүүхдүүд холбогдох хандлага ихсэж байгааг илэрхийлж байна. Өөрөөр хэлбэл тухайн гэмт хэргийн нийгэмд учруулж буй хор аюул ихсэж байгааг харуулж байна.

Өсвөр насны хүнд гэмт хэрэг үйлдэхэд юу нөлөөлж байгаа талаар авч үзье. Нийтлэг байдлаар ажиглахад эцэг эхийн хайр халамж дутах, амьдралын түвшин доогуур байх, ядуурал ажилгүйдэл, гуйланчлал, тэнүүчлэл, бусад хүмүүсийн муу нөлөө /жишээ нь: хохирогч өөрийн гэрийн тооноор өсвөр насны хүнийг оруулж эд зүйлээ авхуулсны дараа хүүхэд тэр айлын гэрийн тооноор орж эд зүйлсийг хулгайлсан гэмт хэрэг гарсан тохиолдол байдаг/, гэр бүлийн хүчирхийлэл, насанд хүрсэн болон арай ахмад насны хүүхдүүдийн зүгээс гэмт хэрэг үйлдэх эсвэл гуйлга гуйхыг шаардан дарамтлах, сониуч, гэнэн зан, согтуурал, мансуурал, хэвлэл мэдээллийн хэрэгслийн сөрөг нөлөөлөл, бусдын нөлөөнд амархан автдаг байдал, багш сурган хүмүүжүүлэгч, эцэг эхийн таагүй харьцаа, сургууль завсардалт зэрэг олон төрлийн нийгмийн сөрөг үзэгдэл нь энэ төрлийн гэмт хэргийн үндсэн шалтгаан нөхцөл болж байна.

Өсвөр насны хүн гэмт хэргийн өсөлтийн шалтгаан нөхцөлийг юуны өмнө дотоод буюу субъектив хүчин зүйл, гадаад буюу объектив хүчин зүйл гэж салгаж үзэх боломжтой юм.

Объектив хүчин зүйлд: ядуурал ажилгүйдэл, сургууль завсардалт, эцэг эхийн хайр халамж дутах, гэр бүлийн хүчирхийлэл, эцэг эх, сурган хүмүүжүүлэгчийн таагүй харьцаа, найз нөхдийн сөрөг нөлөө зэрэг хамаардаг.

Субъектив хүчин зүйлд: сэтгэл зүйн ерөнхий шинж, төлөвшлийн үе, сониуч, гэнэн зан, өөрийгөө хэт үнэлэх хандлага, бусдын нөлөөнд амархан автдаг байдал, сахилга хүмүүжилгүй байдал гэх мэт хамаардаг байна.

Өсвөр насны хүний гэмт хэргийн шалтгаан нөхцлийн субъектив хүчин зүйл гэдэг нь тухайн өсвөр насны хүний өөрийн сэтгэл зүйн байдал, зан төлөв оюун ухааны гүйцэт хөгжөөгүй байдал зэрэг өөрийн хөгжилтэй холбоотой хүчин зүйлүүд ордог.

Өсвөр насны хүн сэтгэл зүйн байдал буюу ялангуяа түүний темперамент нь тэдгээрийн үйлдэж буй гэмт хэргийн шалтгаан нөхцлийн анхдагч алхам мөн. Темперамент бол хүний зан төлвийн төрөлхийн үндэс бөгөөд хүний амьдрал ахуй нөхцөл, хүмүүжлийн эрчимтэй хамаатай байдаг.

Өсвөр насны хүний үйлдэж байгаа гэмт хэргийн ихэнхи нь оюун санаанд нь нийгэмд харш үзэл бодол хэвшил болон тогтсоноос шалтгаалдаггүй, харин тухайн цаг үеийн нөхцөл байдал, болж буй үзэгдлийг зөв үнэлж, түүнтэй холбогдуулж өөрийнхөө явуулж буй үйл ажиллагааны нийгмийн хор уршгийг богино хугацаанд бүрэн гүйцэд ойлгож үнэлэх дадлага туршлага, чадвар дутсантай холбоотой байдаг. Ингэж амьдралд байр сууриа олох гэж тэмтчиж явахдаа эрх зүйн зөрчил гаргаж, гэмт хэрэг үйлдэх зэргээр ёс суртахууны эвдрэл гажуудалд ордог.

Нөгөө талаас өсвөр насны хүний өсөн хүмүүжихэд хайр халамжаар дутаахгүй өсгөх нь дээрх үйлдлээс сэргийлэх боловч бие даах чадваргүй болгож, сэтгэлийн тэнхээгүй, арчаагүй, сул дорой байдалд оруулдаг. Ийм өсвөр насны хүн хамт олны дотор өөрийнхөө байр суурийг мэдрэх үедээ сэтгэл санаагаар унах явдал ажиглагддаг. Энэ нь эргээд гэмт хэрэг үйлдэхэд нь тодорхой нөлөө үзүүлдэг. Мөн насанд хүрээгүйчүүдийн үе тэнгийнхэн насанд хүрсэн хүмүүсийн арга мэхэнд амархан автан гэмт хэрэг үйлдэж байгаа нь тэдэнд өөрийн гэсэн амьдрал, үйл ажиллагааны чиглэл, зорилго, итгэл, үзэл бодол хараахан төлөвшөөгүй хөнгөн хийсвэр, итгэмтгий цагаан цайлган сэтгэлтэй зэрэг онцлогтой холбоотой юм.

ДҮГНЭЛТ

Өсвөр насны хүнийг "гэмт хэрэгтэн" хэмээн цоллох нь тэднийг зохисгүй байдлаар бие авч явах байдалд улам түлхдэг. Өсвөр насны хүний биеэ авч явах байдалд хийсэн судалгаагаар гэмт хэрэгтэн хэмээн нэрлүүлж, шоронд хоригдож байсан өсвөр насны хүмүүс нийгэмд өсөрхөх, элдэв гаж авир гаргах, цаашид дахин гэмт хэрэг үйлдэх магадлал илүүтэй болохыг харуулсан байдаг.

Өсвөр насны хүний гэмт хэргийн тоог бууруулахад өсвөр насны хүний гэмт хэрэг хийж буй шалтгааныг олж, түүнд анхаарлаа хандуулах нь чухал гэж олон улс орнууд үздэг. Сүүлийн жилүүдийн судалгаанаас харахад өсвөр насны хүний үйлдсэн гэмт хэргийн тоо их байх тул манай улс ч мөн адил өсвөр насны хүмүүст гэмт хэрэгт холбогдох байдал их байгаад анхаарах нь зүйтэй юм.

Өсвөр насны хүний гэмт хэрэг нийгэм эдийн засгийн олон хүчин зүйлстэй холбоотой байдаг тул дан ганц цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, амьдралаас тасархай хууль, хууль эрх зүйн хөтөлбөрөөр гэмт хэргээс урьчилан сэргийлж чадахгүй бөгөөд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудлыг улс орны нийтлэг хөгжлийн төлөвлөгөөнд тусгах хэрэгтэй.

Өсвөр насны хүний гэмт хэргийн тоог бууруулахад авч хэрэгжүүлэх гол бодлого нь өсвөр насны хүнд эрүүл өсч торних, боловсрол, мэдлэг, зөв хүмүүжил олгох нөхцлийг бүрдүүлэх, байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх боловсрол олгох, өсвөр насны хүнд чиглэсэн танин мэдэхүйн ажлыг зохион байгуулах, эцэг эхчүүдийн хариуцлагыг дээшлүүлэх, ядуурал ажилгүйдлыг бууруулах, сургууль завсардах, гудамжинд гарах болсон шалтгааныг олж үүнд анхаарлаа хандуулах явдал юм.

САНАЛ

Өсвөр насны хүнийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд дараах ажлыг төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран хэрэгжүүлэх боломжтой.

- Өсвөр насны хүнийг засан хүмүүжүүлэх байгууллагад байлгах явдлыг хамгийн эцсийн арга хэмжээ болгож хамгийн богино хугацааг өгөх
- Өөрийнхөө гэрт цаашид амьдрах боломжгүй болсон ба орон гэргүй өсвөр насны хүмүүсийг амьдрах орон байраар хангах тусгай арга хэмжээг бий болгох
- Хичээлээ тасладаг, сургууль завсардсан хүүхэд, залууст тусгайлан туслалцаа үзүүлэх, албан бус боловсрол, мэргэжлийн сургалтанд хамруулах

- Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь гэмт хэргийн тухай мэдээлэл хийхдээ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүний шалтгаан нөхцөл, хор холбогдлыг өсвөр насны хүмүүс, олон түмэнд таниулах, сэрэмжлүүлэхийг гол зорилго болгох
- Хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүчирхийлэл, аллага хядлаг, садар самуун, гэмт хэрэг үйлдэхийг өөгшүүлэн сурталчилсан, гэмт хэрэг үйлдэх аргыг нарийвчлан харуулсан нийтлэл, нэвтрүүлэг хийхгүй байх
- Гэмт хэрэгт холбогдсон, засан хүмүүжүүлэх газарт байгаа болон тэндээс гарсан өсвөр насны хүний хувьд тэднийг нийгэмшүүлэх нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх нь чухал юм.
- Өсвөр насны хүнийг өсөж хөгжих хамгийн таатай орчин нь гэр бүл гэдгийг анхаарч хүүхдийг гэр бүлээс нь аль болохоор тусгаарлалгүйгээр асуудлыг шийдвэрлэх, хамт байлгах бүл боломжийг нь бүрдүүлэн, нийгмийн ажлын үйлчилгээг үзүүлэх зэрэг үйл ажиллагаа байж болох юм.

НОМ ЗҮЙ:

1. Монгол Улсын Эрүүгийн хууль, УБ., 2002
2. Монгол Улсын Эрүүгийн хууль, УБ., 2015
3. Н.Жанцан, "Криминологи", УБ., 2000 о
4. Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс. "Хүний эрх" онол, арга зүйн сэтгүүл, УБ., 2013
5. <http://www.nso.mn/>
6. <http://www.police.gov.mn/>

КРИМИНАЛИСТИКИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

С.ГАНБОЛД

ШШҮХ-ийн Тусгай шинжилгээний хэлтсийн дарга, биологийн
ухааны доктор (Ph.D), цагдаагийн хошууч

Ж.ОЮУНАА

Тус хэлтсийн биологийн лабораторийн ахлах шинжээч,
цагдаагийн ахлах дэслэгч

Ш.ПҮРЭВДУЛАМ

Тус хэлтсийн ДНХ-н лабораторийн ахлах шинжээч,
цагдаагийн ахлагч

ДНХ-ИЙН МЭДЭЭЛИЙН САН, ТҮҮНИЙГ ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНД ХЭРЭГЛЭХ НЬ

Түлхүүр үг: ДНХ-ийн мэдээллийн сан, гэмт хэрэг, аутосом хромосом, Y-хромосом, генотип, гаплотип

ОРШИЛ: Дэлхийн өндөр хөгжилтэй орнуудын шүүхийн шинжилгээний байгууллага, Олон улсын эрүүгийн цагдаагийн газар болох Интерполын байгууллагууд хүний геном дахь удамшлын зарим маркеруудыг /аутосом хромосомын 16, Y-хромосомын 12, 17 локус/ хэрэглэн гэмт хэргийг илрүүлэх молекул-генетикийн арга технологийг нэвтрүүлээд даруй 20 гаруй жил болж байна [9].

Зарим нэгэн онц ноцтой гэмт хэрэгт олон хүнийг сэжиглэн шалгах шаардлага гарсан үед тухайн гэмт хэргийн эзэн холбогдогчийг үнэн зөвөөр ялган танихын тулд ДНХ-ийн шинжилгээг хийх шаардлага гардаг. Ялангуяа бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэргийг бүлэглэн үйлдсэн тохиолдолд тухайн хохирогчоос дээжлэн авсан биологийн материалд олон этгээдийн үрийн шингэн холилдсон байдлаар лабораторийн шинжилгээнд ирэх нь түгээмэл бөгөөд эзэн холбогдогчийг үнэн зөв, богино хугацаанд тогтооход ДНХ-ийн шинжилгээ чухал үүргийг гүйцэтгэдэг.

ДНХ-ийн шинжилгээг зөвхөн гэмт хэргийн шинжтэй тохиолдолд хэрэглэхээс гадна осол аваар, байгалийн гамшиг, гал түймрийн улмаас хэн болох нь танигдахгүй болсон цогцос хэнийх болохыг тогтоох, сураггүй алга болсон хүн мөн эсэхийг хамгийн өндөр магадлалтай, найдвартай тогтоох үндсэн арга технологи болоод байна.

Гэмт хэрэг, зөрчил үйлдэгдсэн газраас олж илрүүлсэн биологийн ул мөрд ДНХ-ийн шинжилгээ хийж гарган авсан үр дүнг тухайн хэрэгт сэжиглэгдсэн хүнийхтэй адилтган харьцуулж цаашид сэжигтэнг хэрхэхийг шийдвэрлэхэд ДНХ-ийн шинжилгээ онцгой чухал ач холбогдолтой юм. Өөрөөр хэлбэл сэжигтэн тухайн хэргийн эзэн холбогдогч мөн бол түүнийг хөдөлгөөнгүй нотлох, биш бол хүний эрх чөлөөг үндэслэлгүйгээр хохироох асуудлыг таслан зогсооход шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг.

Хэрэг учралын газраас "Хураан дээжлэн авсан" хүний эд эрхтэн, түүний зөөлөн болон шингэн үлдэц гадны янз бүрийн хүчин зүйлийн үйлчлэлээр амархан муудах, эсийн бөөмийн ДНХ-ийн бүтэц эвдэрч гэмтэх, устаж алга болох магадлал маш өндөр байдаг. Ийм учраас дээрх материалд ДНХ-ийн шинжилгээ хийж 16 локусаар генотипийг тогтоож, улмаар "Генетик мэдээллийн сан"-д бүртгэн авах нь чухал байдаг.

Энэхүү эзэн нь тодорхойгүй биологийн материалын ДНХ-ийн мэдээлэл нь сэжигтнийхтэй тохирохгүй бол яг ийм мэдээлэлтэй өөр хүнийг урьд нь байршуулсан ба ирээдүйд байршуулах "Генетик мэдээллийн сан"-д хайх замаар гэмт хэрэгтэнг эрэн сурвалжлах ажлыг цааш нь үргэлжлүүлэх ёстой.

Эдгээр нөхцөл байдлаас манай улсын хэмжээнд гэмт хэргийг илрүүлэхэд "Хүний удамшлын мэдээллийн сан" бүрдүүлж ашиглах хэрэгцээ шаардлага урган гарч байгаа ба хүчний байгууллагын өмнө тулгамдаж байгаа чухал асуудлын нэгд зүй ёсоор орж байна. Хүнийг хилс хэрэгт гүтгэхгүй байх, гэмт хэрэг үйлдсэн хүнд ял завшуулахгүй байх, мөрдөн байцаагчийн тогтоолоор тавьсан асуултанд шинжлэх ухааны үндэслэлтэй нотлох баримтыг гарган өгөх асуудал бол туйлын хариуцлагатай хийх ёстой ажил юм [1, 2, 3]. Нөгөө талаас энэ хүн хэрэг хийсэн нь үнэн гэдгийг гагцхүү шинжлэх ухааны бодит үнэнд тулгуурлан гаргасан шинжээчийн дүгнэлтэд үндэслэж тухайн хүний хувь заяаг шийддэг тохиолдол ч олонтаа байдаг.

Иймд ДНХ-ийн шинжилгээний технологи нь үнэнийг дэнслэхэд чухал ач холбогдолтой үйл ажиллагаа, нөгөө талаас шинжлэх ухааны инновацийг ард иргэдэд хүргэж байгаа үйлчилгээний шинэ хэлбэр гэж ойлгож болно.

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО: Бид гэмт хэргийг илрүүлэхэд хүний геномын ДНХ-ийн олон хэлбэршлийг Монголын шүүхийн шинжилгээний практикт хэрэглэх, нэвтрүүлэх, генетик мэдээллийн сан бий болгон хэрэглэх туршилт судалгааны ажил хийх зорилго тавив.

Судалгааны ажлын зорилт:

1. Гэмт хэргийн эзэн холбогдогчдыг тогтооход сүүлийн үед дэлхийн өндөр хөгжилтэй орнуудад эрчимтэй хөгжүүлж байгаа “ДНХ-ийн мэдээллийн сан”-г өөрийн орны шүүхийн шинжилгээнд нэвтрүүлэх шинжлэх ухааны үндэслэлийг боловсруулах

2. Иргэний болон гэмт хэргийн хохирогч, холбогдогч, сэжигтэн, ял эдэлж буй ялтан, иргэний хэргийн нэхэмжлэгч, хариуцагч нарт Аутосом болон Y-хромосомын микросателлит локусын генотип болон гаплотипыг тодорхойлж гарган авсан ДНХ-ийн шинжилгээний үр дүнгээр генетик мэдээллийн төрөлжсөн сан бий болгох (электрон хэлбэрээр)

СУДАЛГААНЫ ОБЪЕКТ:

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн ДНХ-ийн лабораторид иргэний болон гэмт хэрэг, зөрчлийн улмаас шинжлүүлэхээр ирсэн нэхэмжлэгч, хариуцагч, хохирогч, сэжигтэн, холбогдогч, ялтан болон гэмт хэргийн газарт хийсэн мөрдөн байцаагч, шинжээчдийн бэхжүүлж авсан биологийн гаралтай эд мөрийн баримтыг шинжилгээ, судалгааны объект болгон авав.

СУДАЛГААНЫ АРГА, ЗҮЙ:

Шинжилгээнд ирсэн хүн болон эд мөрийн баримт болох биологийн сорьцоос Promega фирмийн “Wizard Genomic DNA Purification иж бүрдэл” [20], QIAamp DNA micro иж бүрдэл [19], Chelex-100 [3, 4], E-Prep [8], “AccuPrep Genomic DNA Extration [7] иж бүрдэл, Differex. System [18] болон уламжлалт фенол-хлорформын [3, 4] аргаар эсийн ДНХ-ийг ялган үнэлж, сорьцины аутосом хромосомын микросателлит локусын генотипийг AmpFISTR® Identifier™ [5], PowerPlex®16 System [10], PowerPlex®16 HS System [11] иж бүрдэл, Y-хромосомын микросателлит локусын гаплотипийг “AmpFISTR®Y-filer” [6], “PowerPlex® Y System [17] иж бүрдлүүд хэрэглэн тус тус тодорхойлов.

Ген олшруулалтыг Applied Biosystems фирмийн “2720 Thermal Cycler”, “GeneAmp® 9700 PCR System”, Bioneer фирмийн “Mygene32 thermal block” зэрэг машинд явуулав.

Микросателлит локусын аллелийг GeneScan™ 500 LIZ, Internal lane Standard 600 зэрэг Size Standart хэрэглэн “ABI PRISM 310, 3130 Genetic Analyser” –т капилляр электрофорез гүйлгэсний дараа “GeneMapper™ ID Software Version 3.1” програм ашиглан дээжний генотип, гаплотипийг тодорхойлов.

СУДАЛГААНЫ ҮР ДҮН, ХЭЛЦЭМЖ:

Гадаадын улс орнуудад ДНХ-ийн шинжилгээ, ДНХ-ийн мэдээллийн санг гэмт хэргийг шийдвэрлэх, гэмт хэргийг бууруулах, гэм буруугүйг цагаатгах, хөрөнгө, зардал хэмнэх зэрэг 4 үндсэн чиглэлд ашиглаж байна.

DNA-resource веб хуудсанд мэдээлснээр 2011 оны байдлаар дэлхийн 56 улс орон ДНХ-ийн мэдээллийн сантай байгааг дурдсан байна [21]. Эдгээр улс орнуудын зарим нь эхлэлийн шатандаа байхад АНУ, ИБУИНВУ зэрэг орнууд 18 жил үйл ажиллагаа явуулсан ихээхэн туршлагатай болсон байдаг. АНУ-ын Холбооны мөрдөх товчоо “Combined DNA Index System” (CODIS) үндэсний хэмжээний ДНХ-ийн мэдээллийн сан бий болгосноор давтан гэмт хэрэгтэнг таньж тогтоох, эзэн холбогдогч нь тодорхойгүй хүчингийн хэргийг илрүүлэх нэн чухал боломжийг нээж өгснийг тэмдэглэжээ.

2012 оны байдлаар 44 орны 40 сая гаруй гэмт хэрэгтний ДНХ-ийн мэдээлэл тухайн улс ДНХ-ийн мэдээллийн үндэсний санд бүртгэгдсэн байна /хүснэгт 1/.

Хүснэгт 1.

№	Улс орнууд	ДНХ-ийн мэдээллийн санд бүртгэгдсэн хүний тоо
Нэг саяас дээш		
1	БНХАУ	12,000,000
2	АНУ	10,423,000
3	Англи	4,859,903
4	Франц	1,214,511
100,000 –аас дээш		
5	Герман	746,912
6	Канад	223,735
7	Авсрали	200,000

8	Изриал	170,000
9	Австри	129,901
10	Шинэ Зеланд	124,000
11	Голланд	121,272
12	Шве цари	114,364
13	Испани	112,106
14	Финлянд	112,036
	50,000 аас дээш	
15	Швед	99,443
16	Япон	80,000
17	Дани	77,500
18	Унгар	75,809
19	Тайвань	60,000
	50,000 аас доош	
20	ОХУ	50,000
21	Йордан	40,000
22	Сингапура	40,000
23	Белурусь	35,000
24	Чили	35000
25	Латви	32,402
26	БНСУ	32,295
27	Хонг-Конг	30,000
28	Хорват	29,500
29	Эстони	29,274
30	Польш	28,071
31	Норвеги	23,809
32	АБН Эмират улс	23,000
33	Кувейт	20,000
34	Бельги	18,012
35	Панама	15,000
36	Словаки	8,216
37	Португаль	6,000
38	Румын	5,820
39	Исланд	5,000
40	Словани	3,750
41	Сургус	3,000
42	Македони	2,449
43	Barbados	2,000
44	Монгол улс	3200 гаруй /2014 оны 03-р сарын 29-ны байдлаар, олон улсын статистикд албан ёсоор бүртгэгдээгүй тоо /

Олон улсын Эрүүгийн цагдаагийн байгууллага болох Интерпол нь гишүүн орнууддаа генийн мэдээллийн сантай болгох бодлого барьж ажилладаг бөгөөд 2000 онд генийн мэдээллийн сантай улс 5% байсан бол 2010 онд 30% болж нэмэгдсэн ба 2015 онд 60 хувь болтол өсгөхөөр төлөвлөж байгаага мэдээлсэн байна.

Энэтхэг, Индонеза, Пакистан, Нигери, Мексика, Вьетнам, Турк, Тайланд, Пакистан, ӨАБНУ, Укриан, Коломби, Кени, Аргентин, Перу, Саудын Араб, Алжир, Марокко, Шри Ланк, Чехославак, Ирланд зэрэг улс орнууд ДНХ-ийн мэдээллийн сангийн тухай хууль батлахыг идэвхтэй дэмжиж байгаа бөгөөд Итали, Малайз, Урагвай зэрэг улсууд хуулиа батлан хэрэгжүүлээд явж байна [22].

Өмнөд Америкийн ихэнх улсад ДНХ-ийн мэдээллийн санг бий болгоход төрөөс дэмжихээ илэрхийлж, энэ талаар мэргэжилтэнг сургахад анхаарч эхэлсэн байна. Венесуэль улс ДНХ-ийн шинжилгээ нэвтрүүлэхийг эрмэлзэж, хэрэгжүүлэх шатандаа явж байхад Парагвай улс ДНХ-ийн шинжилгээг хөгжүүлэхийн тулд АНУ-ын засгийн газартай хамтарч ажиллаж байгаа бол Коломби улс ДНХ-ийн шинжилгээг хийж байгаа боловч, ДНХ-ийн мэдээллийн сангийн эрх зүйн орчин байхгүйгээс ялтны мэдээллийн санг бий болгож чадаагүйгээ мэдээлсэн байна.

Чили улс үндэсний ДНХ мэдээллийн санг хөгжүүлэхээр санаачлага гаргаж, 2009 оноос ДНХ-ийн мэдээллийн сангийн хууль хэрэгжүүлж эхэлсэн анхны улс бөгөөд одоогоор 35000 гэмт хэрэгтэн, 57000 гэмт хэргийн холбогдолтой сорьц хадгалагддаг байна.

БНХАУ “ДНХ-ийн мэдээллийн үндэсний сан” Хятад дахь хүний наймааг таслан зогсоход маш чухал үүрэг гүйцэтгэж байна гэж үзэж байгаа ба 2009 оны 4-р сараас хойш 39000 хүн худалдсан хэргийн тохиолдлыг шийдвэрлэсэн байна. Орон гэргүй, асрах хүнгүй хүүхэд, тэдний эцэг эхээс дээж авч ДНХ-ийн шинжилгээ хийж харьцуулсны үр дүнд 1400 хүүхдийг эцэг, эхэд нь буцааж олж өгсөн байна.

ДНХ-ийн шинжилгээний үр дүнд ДНХ-ийн мэдээллийн үндэсний сан бүрдсэнээр Хятадад хүүхэд худалдаалах гэмт хэрэг ихээхэн буурсныг Хятадын нийгмийн аюулгүйн албаны яамны Хүн худалдаалахын эсрэг тэмцэх албаны захирал Чен Шигу мэдэгдсэн байна.

Гэмт хэргийг илрүүлэхэд “ДНХ-ийн мэдээллийн сан”-гийн ач холбогдолтой бөгөөд бид орчин үед гадаадын улс орнууд гэмт хэрэг илрүүлэхэд ДНХ-ийн шинжилгээг хэрхэн ашиглаж байгаа болон “Үндэсний ДНХ-ийн мэдээллийн сан”-гийн үйл ажиллагааг зохицуулах хууль эрх зүйн орчин, өнөөдрийн хүрсэн түвшингийн талаар товч дурдъя.

Өнөөдөр манай улсад “Генетик мэдээллийн нэгдсэн сан”-г бий болгох эрх зүйн орчинг бий болгох зорилгоор 2012 онд ХЗДХ сайдын 16 тоот тушаалаар “Генетик мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, ашиглах журам” батлуулан ажиллаж байна.

Гэвч энэ асуудлыг сайдын тушаалаар зохицуулахад учир дутагдалтай, боловсон хүчний орон тоо хангалттай биш, хөрөнгө санхүүгийн хувьд хүрэлцээгүй, шинжилгээ хийх шаардлагатай хүн, сорьцын тоо байнга нэмэгдэж байгаа зэрэг тулгамдсан асуудал байсаар байна.

Бид Монгол улсад ДНХ-ийн шинжилгээний өнөөгийн хүрсэн түвшин, гадаад улс орнуудад нөхцөл байдлыг судлан үзэж манайд “Генийн мэдээллийн сан” бий болгох шаардлагатай байгаа шинжлэх ухааны үндэслэлийг гарган тавьж Монгол улсын генийн бүртгэлийн тухай хуулийн төсөл боловсруулан хууль санаачлах эрх бүхий субъектэд хүргүүлээд байна.

Бусад орны ДНХ-ийн мэдээллийн сан бүрдүүлж байгаа туршлага, хуулийн агуулгыг судалж үзэхэд тухайн улс, үндэстний нийгмийн тогтолцоо, ёс заншил, шашин шүтлэг, улс орны хөгжлийн түвшин, хууль эрх зүйн орчин зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан өөрийн улс улсын онцлог байдалд тохируулсан заалтуудыг оруулсан байдаг. Тухайлбал: Панама улс хуулиараа хүчингийн хэрэгт холбогдогсод, галт зэвсэг эзэмшигч ба хүчний байгууллагын ажилчдын ДНХ-ийн мэдээллийг, гэмт хэрэгт холбогдсон хүн бүрийн ДНХ мэдээллийг, ОХУ хуулиар хүчингийн хэрэгт холбогдогсдыг, ялтан, хоригдлуудыг хамруулж байхад Кувейт улс одоогоор цөөн тооны гэмт хэрэгтнээс, мөн Кувейтын иргэншилтэй гэдгээ нотолж чадаагүй хүмүүсийг /тусгайлан баталсан хууль байхгүй/, Литва улс гэмт хэргийн бүх сэжигтэн, бүх төрлийн гэмт хэрэг, зөрчил гаргагчдыг, Урагвай улс 2011 онд ДНХ-ийн мэдээллийн сангийн хуулиа баталж улмаар хууль зөрчиж саатуулагдсан хүнд тайлбарласны үндсэн дээр ДНХ-ийн шинжилгээнд дээж авах, БХЯ, ДЯЯ-ны ажилтны зөвшөөрөл, шүүхийн захирамжаар хувь хүнээс, хэргийн газраас бол шууд ДНХ-ийн шинжилгээнд сорьц авч ДНХ-ийн мэдээллийн санг бүрдүүлэн ашигладаг байна.

Бүлэг 2. Бид судалгааны хүрээнд ДНХ-ийн лабораторид иргэний болон гэмт хэрэг, зөрчлийн улмаас шинжлүүлэхээр ирсэн нэхэмжлэгч, хариуцагч, хохирогч, сэжигтэн, холбогдогч, ялтан болон гэмт хэргийн газарт хийсэн мөрдөн байцаагч, шинжээчдийн хураан авсан биологийн гаралтай эд мөрийн баримтад ДНХ-ийн шинжилгээ хийж гарсан үр дүнг төрөлжүүлсэн байдлаар “ДНХ-ийн мэдээллийн сан” болгон хадгалж байна.

Шүүхийн шинжилгээнд хэрэглэж байгаа аутосом болон Y-хромосомын генетик маркерын тоо жил ирэх тутам нэмэгдэж байгаа бөгөөд сүүлийн 3 жилийн мэдээллээс харахад PowerPlex® Fusion System, PowerPlex® Y23 System, PowerPlex® 21 System, Investigator Argus X-12 kit зэрэг шинэ маркер бүхий оношилгооны иж бүрдлүүдийг гаргасаар байна [12, 13, 14, 15, 16]. Эдгээр иж бүрдлийг үйлдвэрлэгчээс нь худалдан авах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэж чадсан нөхцөлд тус хүрээлэнгийн ДНХ-ийн лабораторид энэ технологийг нэвтрүүлж, шинжилгээ судалгааны ажлын өдөр тутмын практикт нэвтрүүлэх техник тоног төхөөрөмжийн болон мэргэжлийн боловсон хүчний чадавх байгаа гэж бид үзэж байна.

Өнөөдрийн байдлаар шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн ДНХ-ийн лабораторид олон улсад хэрэглэгдэж байгаа аутосом болон Y-хромосомын генетик маркеруудыг тодорхойлдог “AmpFISTR® Identifier”, “PowerPlex®16 System”, “PowerPlex®16HS System”, “AmpFISTR® Y-filer®”, “PowerPlex®Y System” иж бүрдлийг хэрэглэн ДНХ-ийн шинжилгээ, судалгааг өргөн хүрээтэй явуулж байна.

Одоогийн байдлаар ШШҮХ-ийн ДНХ-ийн лабораторид 2009 оноос хойш хийсэн 3200 гаруй ДНХ-ийн шинжилгээний үр дүн “ДНХ-ийн мэдээллийн сан” хэлбэрээр хадгалагдаж байна.

Эдгээр санг бид “Эзэн холбогдогч нь тогтоогдоогүй биологийн үл мөрийн мэдээллийн сан”, “Иргэний хэргийн мэдээллийн сан” “Гэмт хэргийн хохирогч, холбогдогч, сэжигтэн, эд мөрийн баримт дахь биологийн гаралтай үл мөрийн сан” гэж 3 үндсэн хэсэгт хувааж ангилаад байна.

Иргэний хэрэгт холбоотой ДНХ-ийн шинжилгээ хийсэн 1552 сорьцийн 831-ийг Appliedbiosystems фирмд үйлдвэрлэсэн “AmpFISTR® Identifiler” иж бүрдэл, 721-ийг Promega фирмд үйлдвэрлэсэн “PowerPlex®16 System”, “PowerPlex®16HS System” иж бүрдэл хэрэглэн үр дүнг гарган авав.

Гэмт хэрэгт холбоотой хохирогч, холбогдогч, сэжигтэн, эд мөрийн баримт дахь биологийн гаралтай үл мөрийн 1556 сорьцийн 1042-ийг “AmpFISTR® Identifiler” иж бүрдэл, 514-ийг “PowerPlex®16 System”, “PowerPlex®16HS System” иж бүрдэл тус тус хэрэглэн аутосом хромосомын микросателлит локусын генотипийг тодорхойлж гарган авсан ДНХ-ийн шинжилгээний үр дүнгээр генетик мэдээллийн төрөлжсөн санд электрон хэлбэрээр оруулан хадгалсан болно.

Монгол улсад ял эдэлж байгаа 138 ялтны сорьцонд аутосом хромосомын микросателлит локусын генотипийг “AmpFISTR® Identifiler” иж бүрдэл хэрэглэн тодорхойлж, ДНХ-ийн шинжилгээний үр дүнг генетик мэдээллийн төрөлжсөн санд электрон хэлбэрээр оруулан хадгалав

Цаашид улсын хэмжээнд ял эдэлж буй бүх ялтны дээжид ДНХ-ийн шинжилгээ хийж үр дүнг санд оруулахын зэрэгцээ, шинээр ял эдлүүлэхээр шүүхийн шийдвэр гарсан ялтны дээжийг ч санд оруулах ажлыг зохион байгуулах хэрэгтэй юм.

Өнөөдрийн байдлаар шүүхийн шинжилгээний практикт ДНХ-ийн шинжилгээний арга технологи нэвтэрснээр иргэний, гэмт хэргийн холбоотой, ялтны нийт 3246 хүний ДНХ-ийн мэдээлэл санд бүртгэгдсэн байна.

2012-2013 онд гэмт хэрэгт холбоотой хохирогч, холбогдогч, сэжигтэн, эд мөрийн баримт дахь биологийн гаралтай үл мөрийн 172 сорьцонд PowerPlex®Y System , AmpFISTR® Yfiler® иж бүрдэл хэрэглэн 12, 17 локусаар Y-хромосомын микросателлит локусын гаплотипийг тодорхойлж гарган авсан ДНХ-ийн шинжилгээний үр дүнг генетик мэдээллийн төрөлжсөн санд электрон хэлбэрээр оруулан хадгалсан болно.

ДҮГНЭЛТ

- Монгол улсын хэмжээнд үйлдэгдсэн онц ноцтой гэмт хэргийн эзэн холбогдогч, эрсдэл бүхий хүмүүсийн /ял эдэлж буй ялтан, ял шийтгэл эдлээд, суллагдсан иргэн/ генийн мэдээллийн сан бүрдүүлэх, энэ санг ашиглан гэмт хэрэг үйлдэгчийг богино хугацаанд илрүүлэх эрх зүйн орчинг шинэчлэх шаардлагатай байна.

- Хэргийн газраас олдсон биологийн гаралтай эд мөрийн баримт, улсын хэмжээнд илрээгүй зарим гэмт хэрэгт холбоотой биологийн эд мөрийн баримт, хүчингийн хэрэгт холбоотой эд мөрийн баримт, хэн болох нь танигдахгүй болсон цогцосны үлдэц зэрэгт ДНХ-ийн шинжилгээ хийсэн үр дүнг ДНХ-ийн мэдээллийн сан хэлбэрээр хадгалж, хайлтын программ хангамж суурилуулж байнга ашиглах ажлыг зохион байгуулах хэрэгтэй байна.

ЗӨВЛӨМЖ

Шүүх-ДНХ-ийн шинжилгээний орчин үеийн дэвшилтэт технологийг Монголын шүүхийн шинжилгээний практикт нэвтрүүлэн ажиллаж байгаа ололт амжилт, олон улсын жишигт хүрсэн арга технологийг цаашид улам өргөжүүлэн практикт хэрэглээ болгон олон чиглэлээр өргөн хүрээтэй ажиллах хэрэгцээ шаардлага байна, Дараах хэд хэдэн чиглэлээр ажиллавал илүү үр дүнд хүрэх, арга зам байгааг бодлого боловсруулах субъектууд анхааралдаа авч ажиллахыг санал, зөвлөмж болгож байна.

- 2009 оноос хойш тус лабораторид хийгдсэн 3200 гаруй хүний ДНХ-ийн шинжилгээний үр дүнг “Генетик мэдээллийн сан”-д оруулж байгаа боловч “Сан”-д хайлт хийх програм хангамж байхгүйн улмаас Генетик мэдээллийн санг жинхэнэ утгаар нь ашиглаж чадахгүй байна. Иймд олон улс орнуудад өргөнөөр хэрэглэгдэж байгаа Combined DNA Index System /CODIS/ програм хангамжийг нэн богино хугацаанд нэвтрүүлэх асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй байна.
- “Генетик мэдээллийн сан бий болгох” тухай хуулийн шинжлэх ухааны үндэслэл, хэрэгцээ шаардлагыг боловсруулсан учраас хууль санаачлах субъектэд хүргүүлж батлуулах талаар ажил зохион байгуулах
- ДНХ-ийн шинжилгээний оношлуур, шинжилгээний зарим хэрэглэгдэхүүний хангамжийг нэмэгдүүлэх, боломжит нөөцтэй байлгах, хүн амьтны мтДНХ-ийн шинжилгээний чиглэлээр 2-оос доошгүй мэргэжилтэнг гадаад улс оронд сургаж, мэргэшүүлэхэд хөрөнгийн эх үүсгэврийг шийдвэрлэх
- Тус хүрээлэнгийн ДНХ-ийн лабораторид 3-4 шинжээчийн орон тоог нэмж шинэ арга технологийг өөрийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх туршилт судалгааны багийг бий болгох,

ДНХ-ийн судалгааны ажлыг бие даасан төвийн статустай болгон ажиллуулах зэрэг зөвлөмжийг санал болгож байна.

НОМ ЗҮЙ

1. Ганболд С., "Гэмт хэргийг илрүүлэхэд "Генетик мэдээллийн сан"-г бий болгож, ашиглах асуудалд, "Хууль дээдлэх ёс" сэтгүүл, 2009, № 1, х.68—70.
2. Ганболд., С. "Шүүх биологийн шинжилгээнд хэрэглэгдэх 17 STR локусын аллелийн тархалтаар Монгол хүний генийн сан бий болгох нь" сэдэвт ШУТСангийн ажлын тайлан, УБ., 200700039, х 81.
3. Ганболд С., Пүрэвдулам Ш., Баярлхагва Д., "ДНХ-ийн олон хэлбэршлийг шүүхийн шинжилгээнд хэрэглэхүй"- УБ-2013 он, х 168.
4. Пименов М.Г, Культин А.Ю, Кондрашов С.А, "Научные и практические аспекты кримналистического ДНК-Анализа" Москва., 2001 г. Щербинская типография.стр 3.
5. AmpFISTR Identifier PCR Amplification Kit – User’s Manual -2001, Applied Biosystems.
6. AmpFISTR Y-filer PCR Amplification Kit – User’s Manual -2001, Applied Biosystems.
7. "AccuPrep Genomic DNA Extration kit" - (www.bioneer.com)-2008
8. Application of Novel DNA extraction method for Forensic Evidence Samples, 2008.
9. John M.Butler., "Fundamentals of Forensic DNA typing" – Elsevier academic press, 2009, p.500.
10. PowerPlex 16 System – Part # TMD012, (www.promega.com) - 2002.
11. PowerPlex 16HS System – Part # TMD022, (www.promega.com) - 2012.
12. PowerPlex 18 System – Part # BR 231, (www.promega.com) - 2012.
13. PowerPlex 21 System – Part # BR 236, (www.promega.com) - 2012.
14. PowerPlex Y23 System – Part# TMD035, (www.promega.com) - 2012.
15. PowerPlex Y23 System – Part# BR238, (www.promega.com) - 2012.
16. PowerPlex Fusion System – Part# BR243, (www.promega.com) - 2013.
17. Technical Manual, Part#TMD018., PowerPlex^{RY} System 2003-www.promega.com.
18. Technical Manual, Part#TMD020., Differex. System, 2006-www.promega.com.
19. "QIAamp DNA micro Handbook" - 2003, - (www.qiagen.com)
20. "Wizard Genomic DNA Purification Kit"- Instructoins for use of products A 1125, Technical Manual, -2005, Part # TM050.
21. www.dnaresource.com

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ХААГЧИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ ЗАРИМ АСУУДАЛ

Л.НЯМДАВАА

*Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга, цагдаагийн дэд
хурандаа, хууль зүйн магистр*

Түүхэн уламжлал

"Түүхээ мэдэхгүй хүн ойд төөрсөн сармагчин лугаа адил" гэсэн сургамжит үг байдаг. Цагдаагийн байгууллага нь үүсэн байгуулагдсан түүхэн цаг үеэсээ эхлэн хууль ёсыг сахин бэхжүүлэх, төр, иргэдийн ашиг сонирхлыг хамгаалах, нийтийн хэв журмыг бэхжүүлэх, өмч хамгаалах, гэмт хэрэг, зөрчлөөс сэргийлэх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлж ирсэн бөгөөд нийгмийн хөгжлийн түүхэн цаг үеүдэд нийгмийн байгуулал, нам, төрийн бодлоготой уялдан харилцан адилгүй зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж иржээ. Цагдаагийн байгууллагаас дээрх зорилтуудыг хэрэгжүүлэхэд үе үеийн цагдаагийн алба хаагчид онцгой үүрэг хүлээж ирсэн байна.

Эзэн Чингис хааны үед хэв журмаа сахиулахдаа хааны ордыг хамгаалах өдрийн манаа эргүүлд 70, шөнийн манаанд 80 хэвтүүл байж, 150 цэрэг бүхий хишигтэн ажиллуулж байснаас гадна дайн тулаанд манлайлагч 1000 баатартай байжээ. Монголын нэгдсэн их төрийн эзэн хаан болмогц Чингис хаан шинээр зарлиг гаргаж 1000 хорчин нэмж, хэвтүүл цэрэг 1000, торгууд 7000, баатар цэрэг 1000-тайгаа нийт түмэн хишигтэнтэй болж, хэв журмаа сахиулах болжээ.

Түүнчлэн "Хүн бүрийн ажил эрх тэгш, баян ядуу ба эрхэм, доордсоос ялгаж үл болно", "Өтгөсийг хүндэлж ядуучуудыг тэтгэнэ", "Үл харгис, үнэнч шударга цэгц журамтай, эрдэм гүн, билиг хурц хүмүүсийг эрх биш сайшаан хүндлэнэ", "Зусар харгис элбэрэл журамгүй этгээдийг жигшинэ", "Эцэг эх, дүү багачууд, ахас ихэсээ үл хүндлэгсэд, гэргий нь эрийнхээ зарлигийг үл дагагсад буюу харьяат нь захирагчаа үл хүндэлбэл хүндээр шийтгэнэ" гэсэн хэм хэмжээнүүдийг тогтоож байсан нийгмийн хэв журам сахиулж, хэрэг, зөрчилтэй тэмцэх ажилд гол хүч хэрэгсэл болгож байжээ.

Чингисийн залгамжлагч Хубилай хаан ширээнд суусныхаа дараа 1364 оноос хууль дүрмийг шинээр зохиож эхэлжээ. Энэ үеэс Хубилай болон түүнийг хаадуудын гаргаж байсан цуврал олон хууль дүрмийг эмхэтгэн 1320 онд "Их Юань Улсын нэвтэрхий хууль" гэж нэрлэгдсэн нэгдмэл хуулийг гаргаж мөрдүүлсэн.

Энэ үед хэв журам сахиулах, хэрэг зөрчилтэй тэмцэх ажил явуулж буй ноёд, түшмэд, цэргүүдийг аюулгүй байдлыг хангах чиглэлээр тусгайлсан заалт байхгүй боловч уналганы морь, хоол хүнс, зэр зэвсэг олгодог байсан байна. Тухайлбал: "Зэвсэглэл нь нум сүм байв."⁷⁴

Их хаадын үеийн нийгмийн хэв журам сахиулах, хэрэг зөрчилтэй тэмцэл үйл ажиллагаа эзэн Чингис хааны тогтоосон дэг журам, "Их засаг" хуулийн дагуу өөрсдийн гаргасан зарлиг хуулиар зохицуулагдаж тусгайлсан аппаратгүй, цэрэг, шүүх, засаг ноёдын нэгэн үүрэг болж хэрэгжиж байжээ.

Юань гүрний үед заргач түшмэл шүүгч шийдэм эргүүлэн ёс дэглэм ба эмх замбарааг хамаардаг гэж түүхэнд тэмдэглэжээ. 1286 онд хулгай дээрмийг барих нум сумны тоог тогтоож, 1288 онд хулгай дээрэм барихад хэрэглэдэг сумыг монгол уйгар, хотон дарга нар хураан хадгалдаг байсан талаар сурвалж бичгүүдэд тодорхойлон ирсэн байна.

1865 онд Богд хааны хэрэг шийтгэх газраас Их Хүрээнд цагдаагийн алба байгуулсан нь "Арван тавны цагдаа" гэж нэршжээ.⁷⁵

Арван тавны цагдаа нарыг аймгууд хариуцан ажиллуулж байгаад нилээд хожим Автономит засгийн үед (олноо өргөгдсөний долдугаар онд) Хүрээний цагдаа нарыг нэгтгэн удирдах хороо байгуулж байсан.

Арван тавны цагдаа 1916 онд баталсан дүрэмтэй байсан бөгөөд 1921 оны хувьсгалын дараа цагдан сэргийлэхийн дүрмийг баталсан байна.

1921 онд Ардын хувьсгалтай хамт байгуулагдсан төрийн анхны байгууллагын нэг нь Цагдаагийн байгууллага юм. Ардын засгийн газрын 1921 оны 7 дугаар сарын 19-ний өдрийн 06 дугаар хурлаар Цэргийн яамны харьяанд "Сэргийлэх цэрэг" байгуулж, олон нийтийн хэв журам сахиулах, цэргийн албан хаагчдын сахилгын зарим асуудлыг хариуцсан ёс журмын эргүүл хийх үүргийг ногдуулжээ.

⁷⁴ А.Думбурай. Монгол төрийн цагдаагийн уламжлал, түүхэн хөгжил. УБ., 1997. х.3

⁷⁵ Б.Пүрэв. Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хуулийн тайлбар. УБ., 1997. х.3

1921 оны 3 дугаар сарын 24-нд Монгол Ардын намын Төв хороо, Түр Засгийн газрын хавсарсан 11 дүгээр хурлаар Түр Засгийн Газрын тухай хэлэлцээд Цэргийн яамны цэрэг элсүүлэх, татах хэлтсийн дотор ард түмний амь бие, эд хөрөнгө, хувьсгалт дэг журмыг хамгаалах үүрэгтэй "Сэргийлэх салаа" байгуулжээ. Партизан цэрэг Хиагт хотод байх үед сэргийлэх цэрэг идэвхитэй ажиллаж байсан.

Цагдан сэргийлэх дүрмүүдийг 1923, 1926, 1928, 1934, 1936, 1942, 1955, 1963, 1985 онуудад тус тус баталсан байна.

Тус дүрмүүдэд алба хаагч нар нь дүрэмт хувцас, техник хэрэгсэл, буу зэвсэгтэй байх болон түүний хэрэглэх талаар тусгаж өгсөн нь цагдаагийн алба хаагчийн үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангахтай холбоотой заалтууд тусгаж өгсөн байна. Тухайлбал: БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1955 оны 129 дүгээр тогтоолоор баталсан БНМАУ-ын Дотоод явдлын яамны харьяа улсын цагдан сэргийлэх дүрэм"-ийн 16 дугаар зүйлд "Улсын цагдан сэргийлэхийг зэвсэг, хувцас, эд хэрэглэгдэхүүн, шинжлэх ухаан техникийн хэрэгсэл, тээврийн ба холбооны хэрэгсэл зэрэг бусад эд хогшлоор хангах явдлыг ДЯЯ-наас төвлөрсөн журмаар гүйцэтгэнэ. Морь ба албаны нохойн тоо, тээврийн хэрэгсэл, мөн зэвсэг, техник болон бусад эд хогшлын жагсаалтыг ДЯЯ-ны сайдаас тогтооно."⁷⁶ гэж тусгажээ.

Мөн БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1963 оны 449 дүгээр тогтоолоор баталсан БНМАУ-ын Цагдан сэргийлэх байгууллагын дүрэм"-ийн 15 дугаар зүйлд "*Цагдан сэргийлэх байгууллагын ажилтан нарын албан үүргээ гүйцэтгэж байгаа үед нь бусдаас бүлэглэх буюу буу зэвсэг, бусад хэрэглэлийг ашиглах, илтээр халдан довтолж, амь насанд аюул учруулахад хүрвэл.*"⁷⁷ зэвсэг хэрэглэж болохоор тусгаж өгсөн байна.

Цагдаагийн багууллага, алба хаагчийн эрх зүйн өнөөгийн зохицуулалт

1992 онд Монгол Улсын Үндсэн хуулийг баталж, "Монгол Улсын Үндсэн хуулийг дагаж мөрдөх ажлыг зохион байгуулах тухай" Улсын Бага Хурлын 1992 оны 14 дүгээр тогтоол гарснаар төрийн байгууллагын шинэтгэлийн үйл явц албан ёсоор эхэлсэн билээ.

Төрийн байгууллагын шинэтгэлийн хүрээнд Улсын Их Хурал 1993 оны 12 дугаар сарын 2-ны өдөр "Монгол Улсын цагдаагийн байгууллагын тухай хууль"-ийг батлан гаргасан бөгөөд уг хуулиар цагдаагийн байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлж, иргэд цагдаагийн алба хаахтай холбогдсон харилцааг зохицуулж эхэлсэн.

Улсын Их Хурал 1998 онд эрх зүйн бодлогын цаашдын чиг хандлагыг тодорхойлсон "Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр"-ийг баталсан бөгөөд уг хөтөлбөрт "Гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахиулах ажлын үр дүнг сайжруулах, цагдаагийн байгууллагын зохион байгуулалт, бүтцийг боловсронгуй болгох, боловсон хүчний хангалтыг сайжруулах, техник хэрэгслээр хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх"-ээр заажээ.

Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт "*Төрийн бүх шатны албан хаагчдын үүргийг тодорхой болгож, үүргийн биелэлтийг үндэслэн хариуцлага тооцдог болох, цагдаагийн хэв журам сахиулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийг орон нутгийн эрх мэдлийн түвшинд зохион байгуулах*"-аар тусгасан нь "Цагдаагийн албаны тухай хууль"-ийн төслийг боловсруулан батлах хууль зүйн үндэслэл болсон байна. Цагдаагийн албаны тухай хуулийг Монгол Улсын Их Хурал 2013 оны 07 дугаар сарын 05-ны өдөр 9 бүлэг 42 зүйлтэйгээр батлаж, хууль 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

Монгол Улсын цагдаагийн байгууллагын тухай хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж, эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн он жилүүдэд цагдаагийн байгууллага бүтэц, зохион байгуулалт, хүч хэрэгслийн хувьд бэхжиж, гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах чадавх дээшилсэн хэдий ч үйл ажиллагааг нь цаашид эрчимжүүлэх, үйлчилгээг чанартай, ил тод, хүртээмжтэй болгох шаардлага байна хэмээн үзэж Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2009 оны 156 дугаар тушаалаар 2009-2021 он хүртэл хэрэгжүүлэх "Цагдаагийн байгууллагын хөгжлийн стратеги хөтөлбөр"-ийг баталжээ.

"Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого"⁷⁸-той уялдуулан боловсруулсан уг хөтөлбөрт "Монгол Улсын иргэдэд цагдаагийн байгууллагын ажил үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй хүргэх, тэдний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулах замаар цагдаа олон нийтийн хамтын ажиллагааг сайжруулах"-аар цагдаагийн байгууллага стратегийн зорилгоо тодорхойлж, үйл

⁷⁶ Т.Хүрэлбаатар, Д.Чулуунбат. Монголын Цагдаагийн байгууллагын түүхийн зарим баримт бичгүүд. УБ., 2011. х.66

⁷⁷ Мөн тэнд. х.74

⁷⁸ Монгол Улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар тогтоолоор баталсан.

ажиллагаагаа төлөвлөсөн бөгөөд 2015 онд хийсэн мониторингийн үнэлгээгээр хөтөлбөр 95.4 хувийн биелэлттэйгээр хэрэгжсэн байдаг⁷⁹.

Хууль зүйн салбарын шинэтгэлийн хүрээнд Хууль зүйн сайдын 2012 оны А/83 дугаар тушаалаар 2012-2016 онд хэрэгжих "Цагдаагийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр"-ийг баталж, цагдаагийн төв байгууллагын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн загварыг тодорхойлжээ.

Гэвч цагдаагийн байгууллагын хүрээнд хөгжлийн төлөвлөлтийг урт хугацаанд, судалгаанд суурилуулж, даацтай хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага байгаа нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны өнөөгийн байдал, үүсээд буй эрүүгийн ба хэв журмын нөхцөл байдал, гэмт хэрэг, зөрчлийн гаралт, илрүүлэлтийн динамик болон бусад үзүүлэлтээс тод харагдсаар байна.

Цагдаагийн байгууллагад үйл ажиллагааны шинэчлэлийг цогц байдлаар, далайцтай хийх нь хуулиар хүлээсэн үүргээ баталгаатай биелүүлэх үндсэн нөхцөл болно хэмээн үзэж үүнийг урт хугацааны хөгжлийн стратеги хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар л цагдаагийн ажлыг мэргэжлийн түвшинд хүргэж, ард иргэдийн итгэлийг эргэн олж авах ба цагдаагийн байгууллагын чадавхийг дээшлүүлэхэд Засгийн газар, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бодлогын дэмжлэг, шинэ менежмент, бүх талын хамтын ажиллагаанд суурилсан цагдаагийн байгууллагын идэвхтэй үйл ажиллагаа онцгой үүрэгтэй болохыг мэргэжилтнүүд онцолж байна.

Улсын Их Хурлын 2015 оны "Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" 105 дугаар тогтоол гарч цагдаагийн байгууллагын хөгжлийн стратеги хөтөлбөрийг "Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль", "Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого", "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030"-тай уялдуулан шинэчлэх шаардлага бий болсон.

Цагдаагийн байгууллагын хөгжлийн бодлогыг тодорхойлоход улс орны гэмт хэрэг, зөрчлийн байдал, шалтгаан нөхцөл, чиг хандлага шууд хамааралтай. Сүүлийн 10 жилийн статистик мэдээгээр жилд дунджаар 22 мянга гаруй гэмт хэрэг бүртгэгдэж, 1257 хүн нас барж, 8851 хүн гэмтэж, зам тээврийн хэрэг, ослын улмаас 550 иргэний амь нас хохирч, 100.000 хүн тутамд 1191 гэмт хэрэг ногдож байгаа нь гэмт хэргийн гаралтын түвшин өндөр байгааг илэрхийлж байна. Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 65 хувь нь Улаанбаатар хотод үйлдэгджээ.

Гэмт хэргийн төлөв байдалд хийсэн дүн шинжилгээгээр жилд дунджаар 1034 гэмт хэрэг буюу 4.8 хувиар нэмэгдэж байгаа нь 2020 онд 18.6 хувь, 2024 онд 33.5 хувь, 2028 онд 48.4 хувиар тус тус өсөх төсөөлөл байна.

Дэлхийн даяарчлал, бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжил, өөрчлөлтөөс хамааран терроризм, хар тамхи, мансууруулах бодисын хууль бус эргэлт, хүн худалдаалах, хүрээлэн буй орчин, эдийн засаг, цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг өсөх хандлагатай байна.

Цагдаагийн байгууллага нь хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд техник, технологийн хувьд хоцрогдсон, үйл ажиллагааны арга тактик шинэчлэгдээгүй, техник, алба хаагчийн ажлын ачаалал их, төсөв хөрөнгийн хүрэлцээ дутмаг зэргээс шаардлагын түвшинд хүрч ажиллаж чадахгүй байгаа болно.

Цагдаагийн байгууллагад хийгдсэн шинэчлэлийн үр нөлөөг гүнзгийрүүлж, ард иргэдийн аюулгүй, амар тайван амьдралын баталгааг хангахын тулд мэргэшсэн, чадварлаг, харилцааны өндөр соёлтой хүний нөөцөөр бэхжүүлэх, өндөр технологийг нэвтрүүлэх, орчин үеийн техник хэрэгслээр хангах, шуурхай, найдвартай ажиллах таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх, алба хаагчдын эдийн засаг, нийгмийн баталгааг сайжруулах, олон нийт-цагдаагийн хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэсэн эрх зүйн зохицуулалт, судалгаанд суурилсан, шинжлэх ухааны үндэслэлтэй бодлого төлөвлөлтийг урт хугацаанд хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна.

Цагдаагийн алба хаагчийн эрх зүйн хамгааллын хэрэгжилт

Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.4 дэх заалтад "албан үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан хүчирхийлэх, заналхийлэх, доромжлох, гүтгэх болон бусад хууль бус үйлдэл, үйл ажиллагаанаас төрийн албан хаагч, түүний гэр бүлийн гишүүн хамгаалуулах эрхтэй. Энэ эрхийг тухайн төрийн албан хаагчийн ажиллаж байгаа төрийн байгууллага хангана." гэжээ.

Цагдаагийн байгууллагын 2014, 2015 оны эрсдлийн үнэлгээний тайланд цагдаагийн алба хаагч албан үүрэг гүйцэтгэж байхдаа гүтгүүлэх, доромжлуулах, хүчирхийлэл, заналхийлэлд өртөх

⁷⁹ "Цагдаагийн байгууллагын хөгжлийн стратеги хөтөлбөр" (2009) бүрэн хэрэгжсэн, зарим төлөвлөсөн ажил, арга хэмжээ нь "Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр" (2014)-т тусгагдсан тул Хууль зүйн сайдын 2016 оны 02 сарын 23-ны өдрийн А/54 тоот тушаалаар хүчингүй болгосон.

эрсдэл "5" буюу өндөр үнэлгээтэй гарч цагдаагийн байгууллага дахь эрсдэл бүхий ажлын байрны жагсаалтыг НХХЯ-нд хүргүүлсэн байна.

Дээрх судалгаа, үндэслэлд тулгуурлан хууль тогтоомжийн хүрээнд тодорхой арга хэмжээний хэрэгжилтийг цагдаагийн алба хаагчид хүлээж байна.

- *Цагдаагийн алба хаагчийн эрх зүйн мэдлэг гэмт хэрэг, зөрчлийн улмаас хохирох, хууль ёсны эрх ашиг, сонирхлоо хамгаалуулахад нөлөөлж буй нь:*

Цагдаагийн алба хаагч гэмт хэрэг, захиргааны зөрчлийн улмаас хохирох явдлаас урьдчилан сэргийлэх, тэдний эрх ашгийг хамгаалах эрх зүйн зохицуулалтын хэрэгжилт хангалтгүй дүгнэгдсэн.

Судалгаанд оролцогчдоос 828 буюу 33% нь албан үүргээ гүйцэтгэж байхдаа гэмт хэрэг, зөрчлийн улмаас хохирч байсан бол энэ талаараа эрх бүхий байгууллагад хандаагүй, шийдвэрлүүлээгүй буюу хууль ёсны эрх ашгаа хамгаалуулаагүй гэж 1950 буюу 78 хувь нь хариулжээ.

Цагдаагийн алба хаагчийг гэмт хэрэг, зөрчлийн хохирогч болох эрсдлийг бууруулах нэн шаардлагатай арга хэмжээнд "хууль, эрх зүйн хамгааллыг боловсронгуй болгох" нь зүйтэй гэсэн хариултыг судалгаанд оролцогчдын 57.0 хувь нь сонгосон зэрэг үр дүнгээс үзэхэд алба хаагчид ажил үүргээ гүйцэтгэж байхдаа хохирсон тохиолдолд хаана, хэнд хандах, нэхэмжлэх зэрэг эрх зүйн мэдлэг дутмаг байдал дүгнэгдлээ.

Тухайлбал, санал асуулгад алба хаагчид гэмт хэрэг, зөрчлийн эрсдлийн түвшингээ тодорхойлохдоо гэмтэл учруулахыг гэмт хэрэг, алба хаагчийн биед гэмтэл учруулахгүйгээр хүч хэрэглэх явдлыг зөрчилд хамааруулж ойлгох нийтлэг сэтгэлгээ төлөвшсөн байна.

Эрх зүйн зохицуулалтыг сайжруулах үндэслэл, хэрэгцээ, шаардлага

Улсын Их Хурлаас 2013 оны 07 дугаар сарын 05-ны өдөр "Цагдаагийн албаны тухай хууль"-ийг баталж, улмаар 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж эхэлсэн. Уг хуулийг дагаж мөрдөх явцад практикт тулгарсан хүндрэл бэрхшээлийг арилгах, бодлогын өөрчлөлтийн улмаас зарим зохицуулалтыг өөрчлөн найруулах зайлшгүй шаардлага гарсан.

Цагдаагийн алба хаагчийн албан үүргээ биелүүлэх хууль зүйн нөхцөл баталгаатай холбоотой нийтлэг асуудлыг Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд тусгасан боловч уг хуулийг батлах боломжгүй болж, Засгийн газраас 2014 онд татан авсан.

Цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдлыг тусгай хуулиар зохицуулах бодлогод зарчмын өөрчлөлт гарсан тул цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдалтай холбоотой зохицуулалтыг Цагдаагийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгасан.

Иймээс л Цагдаагийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг одоогийн үүсээд буй нөхцөл байдал, цагдаагийн алба хаагчийн албан үүргээ биелүүлэх хууль зүйн баталгааны эрх зүйн орчинг сайжруулах үүднээс боловсруулж, хууль тогтоох байгууллагад өргөн мэдүүлж, хэлэлцүүлгийн шатанд байгаа.


Цагдаагийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөл⁸⁰-д цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа буюу алба хаагчийн өдөр тутам хэрэгжүүлдэг бусдад шаардлага тавих, иргэн, хуулийн этгээдийн баримт бичиг шалгах, согтуурсан, мансуурсан хүнтэй хэрхэн харьцах, орон байр, бусад газарт нэвтрэн орох, гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох, биечилсэн судалгаа, эрэн сурвалжлах ажиллагаа, үзлэг хийх зэрэг үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг тодорхой тусгасан.

Түүнчлэн биеийн хүч, тусгай хэрэгсэл, техник, галт зэвсэг хэрэглэх үндэслэл, журам, авч хэрэгжүүлэх арга хэмжээ, цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдал, улс төр, хууль зүй, нийгэм, эдийн засгийн баталгаа, хөдөлмөрийн хуульд заасан хэм хэмжээнээс ажлын онцлогийг харгалзан дэвшилт бүхий эрх зүйн зохицуулалтыг оруулсан.

Цагдаагийн албаны тухай хуулийн шинэ төсөл батлагдвал Засгийн газар цагдаагийн алба хаагчийн хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх үүргийг хүлээх болно.

Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/, Зөрчлийн тухай хуулиудын хэрэгжих хугацааг 2017 оны 07 дугаар сарын 01-ны өдөр хүртэл хойшлуулсан боловч эдгээр хуулиудыг хэрэгжүүлэхэд

Албан үүргээ гүйцэтгэж байхдаа гэмт хэрэг, захиргааны зөрчлийн хохирогч болж байсан эсэх



⁸⁰ Төрийн мэдээлэл. 2013. №29

цагдаагийн байгууллага, алба хаагчид зайлшгүй судлах, бэлтгэл ажлыг хангах шаардлагатай байна. Тухайлбал:

- Эрүүгийн хуулийн нэр томъёо, ойлголтыг тайлбарлахад Монгол Улсын хууль, нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан тодорхойлолт, хэм хэмжээг баримтлахаар заасан⁸¹. Иймд алба хаагчид Эрүүгийн хуулийг зөв ойлгож хэрэглэхийн тулд олон улсын гэрээ, конвенцийн талаарх мэдлэгээ дээшлүүлэх шаардлагатай тулгарч байна.

- Эрүүгийн хуульд "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх" нь тус хуулийн үндсэн зорилт байхаар тусгажээ⁸². Энэ нь цагдаагийн байгууллагын хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын /ялангуяа гүйцэтгэх ажил/ арга тактикийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлд төвлөрүүлэх, цагдаагийн мөрдөгчийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлагыг бий болгож байна.

- Хүч хэрэглэх буюу хүч хэрэглэх заналхийлэлд автаж бусдын албадлага, эрхшээлд орсны улмаас хийсэн үйлдлийг гэмт хэрэгт тооцохгүй байхаар заажээ. Энэ тохиолдолд бусдыг албадлага, эрхшээлдээ оруулсан хүнийг гэмт хэргийн гүйцэтгэгч гэж үзэхээр хуульчилсан нь цагдаагийн мөрдөгчөөс гэмт хэргийн шалтгаан, нөхцлийг тогтооход онцгой анхаарал хандуулах шаардлагатай болж байна.

- Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршиг, нөхөн төлөх хохирлын хэмжээг зөвхөн шүүх тогтоохоор заасан⁸³ тул хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд хохирлыг тогтоох, нотлох, хуульд заасан бүхий л арга хэмжээг авах хэрэгцээ шаардлагыг илэрхийлж байна.

- Давтан, удаа дараа үйлдсэн гэмт хэрэг нэг бүрт нь ял оногдуулж⁸⁴ тэдгээрийг нэмж нийт ялыг тогтоохоор болсон нь мөрдөн байцаалтын явцад эрүүгийн хэргийг нэгтгэхгүйгээр эсхүл тусгаарлан хэргийг шийдвэрлэх боломжтой болсон байна.

- Зөрчлийн тухай хуулиар хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан болон мөрдөгдөж буй 220 гаруй хуулиар зохицуулагдаж байсан нийт 601 зөрчлийн бүрэлдэхүүн, тэдгээрт хүлээлгэх хариуцлагыг хуульчилжээ.

Цаашид зөрчил, гэмт хэргийн ялгааг тодорхой болгож тэдгээрт хүлээлгэх хариуцлагыг ялгамжтай тогтоох шаардлага урган гарч, хууль зүйн шинэчлэлийн бодлогын хүрээнд энэхүү хуулийг батлах хэрэгцээ шаардлагыг хууль тогтоогч тодорхойлжээ.

Хуульд тодорхойлогдсон зөрчлийн 601 бүрэлдэхүүний 83 буюу 13.8 хувь нь хор уршиг шаардах материаллаг бүрэлдэхүүнтэй байхаар хуульчлагдсан нь зөрчил үйлдэгч этгээдүүдийн субъектив хүчин зүйл, хохирол учруулах нөхцөл байдлыг бий болгох үйлдэл, эс үйлдэхгүйг шууд тодорхойлох байдлаар, тухайлбал эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, эм найруулах шаардлага, нөхцлийг зөрчсөн бол... гэх мэт хуульчилсан.

- Зөрчилд ногдуулах хариуцлагын төрөл торгох, эрх хасах 2 хэлбэртэй байх бөгөөд энэ нь цагдаагийн алба хаагчдын үйл ажиллагаа, сэтгэлгээнд зайлшгүй нөлөөлөх хүчин зүйл мөн.

- Торгуулийг зөрчил гаргагчийн хөрөнгө, орлогоос нь тодорхой хугацаанд төлүүлэх, төлөгдөөгүй тохиолдолд хэмжээг нь нэмэгдүүлэн тооцох, нийтэд тустай ажил хийлгэж үр дүнгээр нь торгуулийг төлүүлэх зэрэг шийдлүүдийг хуульчилжээ.

Энэ нь алба хаагчид зөрчил гаргагчийг шалгахдаа гаргасан зөрчлийн шинж байдал, зөрчигчийн сэдэл зорилго, хувийн болон нийгмийн байдал зэрэг олон зүйлүүдийг тогтоож, торгуулийг нөхөн төлүүлэхийн тулд тодорхой хугацаанд хяналтандаа байлгах зайлшгүй шаардлагатай болж байна.

Хууль хэрэгжиж эхлэхээс өмнө орлого, эд зүйлийг хураах, зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгслийг хураах, хохирол, нөхөн төлбөр гаргуулах, нийтэд тустай ажил хийлгэх зэрэг албадан эмчлэхээс бусад албадлагын арга хэмжээг зохицуулсан хэм хэмжээг боловсруулан гаргах шаардлагатай.

Дээрх Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/, Зөрчлийн хуулийг хэрэгжүүлэхэд процессын хууль болох Хууль сахиулах ажиллагааны тухай, Зөрчил хянан шийдвэрлэх тухай хуулиудыг зайлшгүй Монгол Улсын Их хурлаар батлуулж хамт хэрэглэх практик хэрэгцээ, шаардлага байна.

Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнийг шинээр баталсантай холбогдуулан Тахарын албаны тухай хуулийг 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрөөс хүчингүй болгосон.

⁸¹ Мөн хуулийн 1.2 дугаар зүйлийн 4.

⁸² Эрүүгийн хуулийн 1.1 дүгээр зүйлийн 1.

⁸³ Мөн хуулийн 1.4 дүгээр зүйлийн 3

⁸⁴ Мөн хуулийн 6.8 дугаар зүйлийн 1

Тахарын албаны тухай хууль хүчингүй болсноор цагдаагийн байгууллага хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтаас оргосон сэжигтэн, яллагдагчийг эрэн сурвалжлах, баривчлах, яллагдагчийг шүүхэд хуяглан хүргэх, шүүх, шүүгч, гэрч, хохирогч болон тэдгээрийн хамаарал бүхий этгээдийн аюулгүй байдалд халдлага, хор аюул учруулахаас урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлэхээр болсон ба энэ талаарх нарийвчилсан эрх зүйн зохицуулалт байхгүй байна.

Дүгнэлт

Цагдаагийн албан хаагчийн нийгмийн хамгааллыг тогтоосон хууль тогтоомжуудыг судлан үзэхэд, арга хэмжээний төрлүүдийг тогтоосон эрх зүйн зохицуулалт уламжлагдах шинжтэй харин түүнийг олгох журам, үндэслэл, хэмжээ зэрэг нь тухайн түүхэн цаг үеийнхээ нийгэм, эдийн засаг, улс төрийн амьдралын бодит хүчин зүйлүүдтэй холбоотойгоор шинэчлэгдсэн өөрчлөгдөж ирсэн.

Тухайн цаг үеийн цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагааг зохицуулж ирсэн хууль, дүрмүүдэд алба хаагчийн нийгмийн баталгааг зохицуулж ирсэн заалтууд тодорхой хэмжээгээр байсан боловч дээрхи бүгд баталгаанууд нь бүгд төр, засгийн бодлого, санхүүгийн боломж, нөхцөлөөс ихээхэн хамааралтай зохицуулагдаж байжээ гэж үзэж болохоор байна.

Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг хууль санаачлагчаас буцаан татаж авсантай холбогдуулан цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдалтай холбоотой харилцааг тусдаа хуулиар зохицуулах боломжгүй болсон тул алба хаагчийн эрх зүйн байдал, баталгаа, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэх өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой асуудлыг зохицуулах шаадлагын улмаас Цагдаагийн албаны хуулийг шинэчлэн найруулж, батлуулах зүй ёсны шаардлага бий болжээ.

Ингэснээр цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт тодорхой болж, алба хаагчдын хууль ёсны ажиллагаа баталгаажиж, албандаа итгэх итгэл, хандлага сайжрана гэж үзэж байна.

---oOo---

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ АРГА ЗАМ

Ц.БААСАНХОРОЛ

Улаанбаатар хотын цагдаагийн газрын Төлөвлөлт,
зохион байгуулалтын хэлтсийн
ахлах мэргэжилтэн, ХСИС-ийн магистрант

Хураангуй: Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай” хуулийг баталж, хөгжлийн бодлогын баримт бичгийг төлөвлөх, боловсруулах, батлах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагнах, мэдээлэх, удирдлагыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг эрх зүйн зохицуулалтад оруулсан. Дээрх хууль батлагдсантай холбогдуулан, цагдаагийн байгууллагын хөгжлийн стратеги хөтөлбөрийг шинэчлэх шаардлага тулгарсан.

Түүнчлэн, Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 79 дүгээр тогтоолоор “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр”, Хууль зүйн сайдын 2014 оны А/223 дугаар тушаалаар “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г тус тус баталсан боловч, хөрөнгө оруулалтын асуудлыг орхигдуулснаар хэрэгжилт хангалтгүй байна. Иймд цагдаагийн байгууллагын хэмжээнд стратегийн удирдлагын өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийх, тулгамдаж буй асуудлууд, шийдвэрлэх арга замыг оновчтой тодорхойлон, хөгжлийг хэтээр баримжаалан, түүнд чиглүүлэн удирдах үйл ажиллагаа шаардагдаж байна.

Түлхүүр үг: Хөгжлийн стратеги хөтөлбөр, хөгжлийн хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөө

Нэг. Оршил

Өмнөх тогтолцооны үед дайны дараа бий болсон гадаад, дотоод шинэ нөхцөл байдалд тулгуурлан энх цагийн бүтээн байгуулалтыг хэтийн төлөвлөгөөний үндсэн дээр хөгжүүлэх зорилгоор МАХН-ын Төв хорооны улс төрийн товчооноос 1946 оны 9 дүгээр сард “БНМАУ-ын ардын аж ахуйн ба соёл, боловсролыг хөгжүүлэх анхдугаар таван жилийн төлөвлөгөө зохиох тухай” шийдвэр гарч, улсын төлөвлөгөөний комисс уг төлөвлөгөөний төслийг боловсруулсан.

Анхны таван жилийн төлөвлөгөөний улс ардын аж ахуйд өмчит жижиг таваарын аж ахуй, улсын ба хоршооллын өмч дээр суурилагдсан социалист аж ахуй хоёр зэрэгцэн оршиж байсан нийгэм, эдийн засгийн нөхцөлд улс ардын аж ахуй, соёлыг хэтийн төлөвлөгөөний үндсэн дээр хөгжүүлнэ гэсэн анхны оролдлого туршлага болсон.

Улс орны хөгжлийн явц, онцлогтой холбоотойгоор Цагдаагийн байгууллага улам бэхжин төрийн захиргааны байгууллагын нэгдмэл дэд тогтолцоог бүрдүүлсэн байна. Цагдаагийн байгууллагын албад, алба хаагчдын хөдөлмөр зохион байгуулалтад өөрчлөлт гарч, албадыг төрөлжүүлэн мэргэшүүлж, үүрэг зорилгыг нь тодорхой болгож, дотоод үйл ажиллагаагаа албан тушаалын заавар, ажил үүргийн хуваариар зохицуулж ирсэн байна.

Монгол Улсын Үндсэн хууль 1992 онд батлагдаж, “Монгол Улсын Үндсэн хуулийг дагаж мөрдөх ажлыг зохион байгуулах тухай” Улсын Бага Хурлын 1992 оны 14 дүгээр тогтоол гарснаар төрийн байгууллагын шинэтгэлийн үйл явц албан ёсоор эхэлсэн.

Төрийн байгууллагын шинэтгэлийн хүрээнд Улсын Их Хурлаас 1993 онд “Цагдаагийн байгууллагын тухай хууль”-ийг батлан гаргасан бөгөөд уг хуулиар цагдаагийн байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлж, цагдаагийн алба хаахтай холбогдсон харилцаа зохицуулагдаж эхэлсэн.

Цагдаагийн ерөнхий газар 1996 онд “Ойрын дөрвөн жилд хийх ажлын төлөвлөгөө, дараагийн дөрвөн жилд хийх ажлын бодомж”-ийг гаргаж, төв, орон нутгийн газар, хэлтсээр хэлэлцүүлсэн нь хөгжлийн бодлого, чиглэлээ дунд хугацаагаар төлөвлөх, 1998 онд “Цагдаагийн байгууллагын хэтийн төлөвлөгөө” бодлогын баримт бичгийг боловсруулсан нь хөгжлийн стратегийг урт хугацаагаар төлөвлөн хэрэгжүүлэх анхны оролдлого болсон байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2009 оны 156 дугаар тушаалаар цагдаагийн байгууллагын үйлчилгээг чанартай, ил тод, хүртээмжтэй болгох шаардлага байна хэмээн үзэж, Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого”-той уялдуулан, 2009-2021 он хүртэл хэрэгжүүлэх “Цагдаагийн байгууллагын хөгжлийн стратеги хөтөлбөр”-ийг баталсан бөгөөд 2015 онд хийсэн мониторингийн үнэлгээгээр хөтөлбөр 95.4 хувийн биелэлтэйгээр хэрэгжсэн байдаг.

Хууль зүйн салбарын шинэтгэлийн хүрээнд Хууль зүйн сайдын 2012 оны А/83 дугаар тушаалаар 2012-2016 онд хэрэгжих “Цагдаагийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-ийг баталж, цагдаагийн төв байгууллагын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн загварыг тодорхойлсон.

Улсын Их Хурлаас 2013 онд баталсан “Цагдаагийн албаны тухай” хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2. дахь хэсэгт “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөрийг ...” Засгийн газар батална гэж заасны дагуу 2014-2019 онд хэрэгжих “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр”-ийг Засгийн газрын 2014 оны 79 дүгээр тогтоолоор, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Хууль зүйн сайдын 2014 оны А/223 дугаар тушаалаар тус тус баталсныг мөрдөн ажиллаж байна.

Монгол Улсын Их Хурал 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай” хуулийг баталж, хөгжлийн бодлогын баримт бичгийг төлөвлөх, боловсруулах, батлах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагнах, мэдээлэх удирдлагыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг эрх зүйн зохицуулалтад оруулсан.

“Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль”-ийн 7.1.4. дэх хэсэгт “...агентлагийн хэтийн болон дунд хугацааны стратегийн төлөвлөгөө, үндсэн чиглэл, төсвийн төслийг хуульд заасан нөхцөл, үндэслэлээр хугацаанд нь боловсруулж, төсвийн ерөнхийлөн захирагчид оруулах” тухай заасан.

Дээрх Монгол Улсын хуулиуд нь “Цагдаагийн байгууллагын хөгжлийн стратеги хөтөлбөр”-ийг боловсруулах эрх зүйн үндсийг бүрдүүлж байгаа тул “Цагдаагийн байгууллагын хөгжлийн стратеги хөтөлбөр”-ийг боловсруулан хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага нь дараах нөхцөл байдал, хүчин зүйлүүдээр тодорхойлогдож байна.

Хоёр. Үндсэн хэсэг

2.1. Хөгжлийн хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж буй байдал

Цагдаагийн байгууллага төлөвлөлтийг хэрхэн хэрэгжүүлж, дэвшүүлсэн зорилго, зорилтод хүрэх вэ гэдгийг тодорхойлж үзэхийн тулд төлөвлөлт гэсэн үгийн тодорхойлолтоос эхэлье.

Я.Цэвэлийн “Монгол хэлний товч тайлбар толь”-д “Төлөвлөгөө” гэдэг үгийг үйл ажлыг үүсгэхийн өмнө тэр ажлыг хэрхэн ямар арга, журамтайгаар гүйцэтгэх тухай тоймлон боловсруулж, ирэх жил хийх ажлаа одоогоос эхлэн нарийн төлөвлөх нь чухал. Нэгэнт нягталж боловсруулсан төлөвлөгөөг заавал биелүүлэх хэрэгтэй гэж тайлбарласан.

Эрдэмтэн судлаачид онолын хувьд “Төлөвлөгөө” гэдгийг тодорхой цаг хугацаанд тодорхой зорилго, зорилтод хүрэхийн тул үйл ажиллагааны ирээдүйн чиглэлийг харуулсан баримт бичиг. Төлөвлөлт гэж “Зорилгод хүрэхийн тулд зорилго, зорилтуудаа тодорхойлох, стратеги боловсруулах, үүрэг, даалгавар, ажлын хуваарийн загвар гаргах үйл явцыг хэлнэ. Төлөвлөлт нь хүрэх зорилго, зорилтуудыг тодорхойлох, тэдгээрт хүрэхийн тул стратеги боловсруулах, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох, биелүүлэх, чиглүүлэх, зохих дараалалтай бүх үе шатыг хянах үйл явц гэх зэргээр тодорхойлсон байна.

Цагдаагийн байгууллагын хэмжээнд төлөвлөлтийн үйл ажиллагааг ямар эрх зүйн баримт бичигт тусгасныг авч үзвэл: Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Цагдаагийн байгууллагын ажлыг төлөвлөх, тайлагнах журам” /код 108/-ын 108.2.1-д Цагдаагийн төв байгууллага нь жилийн ажлаа төлөвлөж, төлөвлөгөө гаргах ба түүнийг цагдаагийн бүх шатны нэгж, үйл ажиллагаандаа мөрдөж хэрэгжүүлнэ.

108.2.8-д Жилийн төлөвлөгөө нь Цагдаагийн байгууллагын стратегийн зорилт /хүрэх үр дүн/ тус бүрийн хүрээнд уг зорилтоо хүрэх гол зорилтууд /бүтээгдэхүүний анги/, тэдгээрийг хэрэгжүүлэхийн тулд тухайн дэвшүүлэн тавьж буй зорилтууд /тухайн жилийн зорилт буюу нийлүүлэх бүтээгдэхүүний тоо, хэмжээ/, тухайн бүтээгдэхүүнд тавигдах чанарын шаардлага /тэдгээрийн чанарын үзүүлэлт/, бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх хугацаа гэсэн нягт уялдаа бүхий үзүүлэлтүүдээс бүрддэг учир эдгээр үзүүлэлтүүдийн харилцан шүтэлцээг сайтар тооцон уг төлөвлөгөөнд тусган боловсруулсан байвал зохино гэж заасан байна.⁸⁵

Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Төсвийн шууд захирагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэжлийн түвшинг үнэлж дүгнэх журам”-ын зорилгыг “Монгол Улсын төрийн албаны хэмжээнд төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн шууд захирагчтай энэ журмын дагуу гэрээ байгуулж, үйл ажиллагааны үр дүн, мэргэжлийн түвшинг үнэлэхэд нэгдсэн стандарт тогтоон мөрдүүлэх, гэрээнд тусгагдсан хөтөлбөр, арга хэмжээг хуваарилагдсан төсвийн хүрээнд хэрэгжүүлэх үндсэн дээр байгууллагын үйл ажиллагааны зорилго,

⁸⁵ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам “Цагдаагийн байгууллагын ажлыг төлөвлөх, тайлагнах” /код 108/

зорилтуудыг хангахад чиглүүлэн, төсвийн шууд захирагч үйл ажиллагаагаа оновчтой төлөвлөж хэрэгжүүлэхэд оршино” гэж тодорхойлжээ.⁸⁶

Уг журмын 3.1-т Байгууллагын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө нь энэхүү гэрээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг байна. Байгууллагын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнд тусгагдах арга хэмжээ нь байгууллагын үйл ажиллагааны стратегийн зорилтуудыг хангахад чиглэгдсэн дараах эх үүсвэрээс бүрдэнэ.

3.1.1. хууль тогтоомж, төр засгийн удирдах дээд байгууллагын бусад шийдвэрээр үүрэг болгосон ажил, үйлчилгээ болон салбарын дунд хугацааны хөгжлийн хөтөлбөрт тухайн жил хэрэгжүүлэхээр заасан арга хэмжээ,

3.1.2. өмнөх оны гэрээнээс биелэгдээгүй үлдсэн, цаашид үргэлжлүүлэх шаардлагатай арга хэмжээ,

3.1.3. байгууллагын үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөнд тухайн жилд хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээ,

3.1.4. энэхүү журмын 3.1.1, 3.1.2, 3.1.3-т зааснаас гадна, тодорхой шаардлагын үүднээс тухайн жилд нэмж гүйцэтгэх арга хэмжээ.

3.2. “Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2. дахь хэсэгт заасны дагуу байгууллагын төсвийн жилд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ, тэдгээрийн төсөв, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, хэрэгжилтийг хариуцах тухайн байгууллагын зохион байгуулалтын бүтцийн нэгж /алба хаагч/-ийг заана гэжээ.

Цагдаагийн ерөнхий газрын 2012-2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, түүний биелэлт, хэрэгжилтийн байдалд түүвэр хийж үзвэл. Хүснэгт 1.

Нийт төлөвлөсөн арга хэмжээ		2012 он	2013 он	2014 он	2015 он
Үүнээс	Хэрэгжүүлсэн	126	121	113	121
	Хэрэгжүүлэх боломжгүй хасагдсан	5	2	6	
	Биелэлтийн үнэлгээ хувиар	97.0	98.7	92.0	97.4
	Шийдвэр гарсан эсэх	ЦЕГ-ын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэгдсэн	Шийдвэр гараагүй.	Шийдвэр гараагүй.	Шийдвэр гараагүй.

Төлөвлөгөөнд тусгагдсан ажил, арга хэмжээний давхцлыг 2012, 2013, 2014, 2015 оны байдлаар авч үзэхэд жилд дунджаар 120 ажил, арга хэмжээ төлөвлөгдсөн байна. Үүнээс:

- 2 удаа давхацсан 39 ажил, арга хэмжээ,
- 3 удаа давхацсан 24 ажил, арга хэмжээ,
- 4 удаа давхацсан 32 ажил арга хэмжээ байна.

Шинж чанарын хувьд:

- Тогтмол шинжтэй 42 ажил, арга хэмжээ,
- Үргэлжилсэн шинжтэй 4 ажил, арга хэмжээ,
- Давхацсан шинжтэй 49 ажил, арга хэмжээ байна.

Цагдаагийн алба хаагч нь байгууллагын стратеги хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрхэн хэрэгжүүлж байна вэ гэдэг асуудал гарч ирнэ

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын 108.2-т “Цагдаагийн алба, нэгжийн дарга болон сум хороонд байгаа тасгийн дарга нар өдөр тутмын ажлын тэмдэглэлтэй байна. Цагдаагийн ерөнхий газрын ахлах мэргэжилтэн, мөрдөн байцаагч нар календарчилсан төлөвлөгөөтэй, өдөр тутмын ажлын тэмдэглэлтэй байна.

Цагдаа буюу ахлагч бүрэлдэхүүний алба хаагч авсан үүрэг даалгавар, өдөр тутмын ажлын тэмдэглэл, эргүүл, жижүүрт гардаг алба хаагч ээлжтэй байх хугацаандаа хийсэн ажлын тэмдэглэл тус тус хөтөлнө.”⁸⁷

⁸⁶ Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Төсвийн шууд захирагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэжлийн түвшинг үнэлж дүгнэх журам”

⁸⁷ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам “Цагдаагийн байгууллагын ажлыг төлөвлөх, тайлагнах” /код 108/

Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж, дүгнэх журам"-ын 3.1.1-т "Байгууллагын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө" болон "Нэгжийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө"-нд тухайн төрийн жинхэнэ албан хаагч хэрэгжүүлэхээр тусгагдсан ажил, үйлчилгээ;

3.3.2. Гэрээ нь байгууллага (нэгж)-ын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн ажил, үйлчилгээ болон дотоод ажил, үйлчилгээ гэсэн хэсгээс бүрдэх бөгөөд байгууллага (нэгж)-ын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн ажил, үйлчилгээ нь тухайн нэгжид хамаарах стратегийн зорилтуудаар ангилагдсан байна гэж тус тус заасан.⁸⁸

Цагдаагийн байгууллагын удирдах ажилтан, офицер, ахлагч бүрэлдэхүүнтэй байгуулж буй төрийн алба хаагчийн үр дүнгийн гэрээнд байгууллагын зорилтыг хангах ажлыг тусган хэрэгжүүлж байна уу. Энэ бас л нэг бодох асуудал.

Дотоод аудитын ажлаар дүүрэг дэх цагдаагийн хэлтсүүдэд ажиллаж хэсгийн байцаагч, хэв журмын офицер, хороон цагдаа нартай ярилцлага хийх үеэр та ажлаа төлөвлөдөг үү. Төлөвлөгөөгөө байгууллагынхаа үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулсан уу. Төлөвлөсөн ажлаа хэрэгжүүлж чаддаг уу гэсэн асуулга тавихад ажлаа 7 хоногоор төлөвлөдөг гэхээс өөр хариулт өгч чадахгүй байна.

Та үндсэн ажил болон ар гэртээ хийх ажлаа календарчилсан байдлаар төлөвлөж үзсэн үү. Энэ төлөвлөгөөндөө байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөтэй холбоотой хэрэгжүүлэх заалт болон өөрийн хувийн асуудал тухайлбал хүүхдийн сургуульд эргүүлээр ажиллах, бие давхар эхнэр, өндөр настай аав, ээжээ эмнэлэгт үзүүлэх, түлээ нүүрсээ авах зэрэг асуудлыг тусгасан уу гэж асуухад бас л хариулж чадахгүй байна. Уулзсан 30 орчим алба хаагчдаас хүүхдийнхээ сурч буй сургууль дээр очиж эргүүлээр ажилласан гэж 1 алба хаагч л хариулсан.

Цагдаагийн байгууллагын жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд "...гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг дээшлүүлнэ. Олон нийт иргэдтэй хамтарч ажиллана" гэсэн агуулга бүхий заалт тусгагддаг. Энэ заалтыг хэрэгжүүлэх ажлыг цагдаагийн алба хаагчид ажлаа төлөвлөгөөндөө хэрхэн тусгадаг бол гэсэн асуулт байна.

Аригү медиа (2014) судалгааны тайлан "... Цагдаагийн алба хаагч бүр өдөр тутам, санаатай санамсаргүй аль ч байдлаар иргэдэд богино хугацааны мэдээлэл, харилцааны стратегийг түгээгч эд эс болж байдаг" тухай дурьдсан байна. Өөрөөр хэлбэл ихэнх иргэд цагдаагийн байгууллагыг гэмт хэргийн тухай мэдээлэл түгээгч гэж дүгнэсэн бол алба хаагчийг олон нийтийн газар, гэр бүл, хувь хүний түвшинд мэдээлэл хүргэх, дамжуулагч мөн гэдгийг тодорхойлсон байна.

Та өөрийн амьдарч буй хорооны хэсгийн байцаагч, хэсгийн төлөөлөгч өө таних уу, иргэн хүний хувьд очиж уулзаж байсан уу. Хорооны иргэн хүний хувьд өөрийн чадах зүйлээр зөвлөж, тусалж, хамтарч ажилласан уу. Та хорооны хэсгийн байцаагчийнхаа тайлангийн хуралд сууж байсан уу. Танай хорооны хэсгийн байцаагч танай гэрээр ирж өөрийгөө танилцуулж, хамтарч ажиллах санал тавьсан уу гэсэн асуулгыг алба хаагчдаас асуухад юу асуучихав гэсэн байдалтай хараад "Үгүй" гэсэн хариулт өгдөг. Энэ асуултыг танд үлдээе тунгааж нэг үзээрэй.

Хэсгийн байцаагч нараас танай хороонд цагдаагийн байгууллагад ажилладаг хэдэн иргэн байна. Тэдний гэр орноор орж, хамтарч ажиллах санал тавьсан уу. Тайлангийн хуралд ямар хүмүүс ирж оролцдог. Бусад хүнийг оролцуулах талаар ямар арга хэмжээ авч байсан бэ. Энэ талаар төлөвлөгөөндөө тусгаж үзсэн үүгэхэд тодорхой хариулт өгч чадахгүй байна.

Бид ажлын ачаалал ихтэй ажилладаг гэх боловч үндсэн төлөвлөсөн ажлын дээр нэмэгдэл ачаалал үүсгэж байна гэдгийг баримтжуулж чаддаггүй. Энэ нь ажлаа зөв төлөвлөж чадахгүй байгаатай холбоотой. Өнөөдөр бидний төлөвлөсөн ажил шат шатандаа амьгүй цаас болж хувирсан. Цагдаагийн төв байгууллагаас нэгж, алба хаагч хүртлээ эргээд нөгөө урсгалаараа баахан цаас бичиж шидэлцдэг. Түүнийгээ үнэлдэг. Нэг хэргийн талаар дээд газарт танилцуулга бичих гэхээр асууж, лавласаар мөрдөн байцаагчаас, урьдчилан сэргийлэх ажлын талаар хэсгийн байцаагчаас тодруулах жишээтэй. Дунд нь ахлах байцаагч, тасаг, хэлтсийн дарга гээд алба хаагчид байдаг. Тэд яах ёстой вэ хянах үүрэгтэй.

Байгууллага нь зорилго, зорилтондоо хүрч амжилттай ажиллах нэг гол нөхцөл нь үр ашигтай хяналт байдаг бөгөөд зорилгодоо хүрэх явдлыг баталгаажуулах хэрэгсэл болдог. Хяналтын мөн чанар нь байгууллагын үйл ажиллагаанд учирч байгаа бэрхшээлтэй асуудлыг нээн илрүүлж, улмаар тухайн асуудлыг засч залруулан байгууллагын үйл ажиллагааг хямралаас гаргахад оршино.

⁸⁸ Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Төсвийн шууд захирагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам"

Хяналтын үүрэг нь түүнийг зайлшгүй бий болгодог дараах хүчин зүйлүүдээс хамааралтай.

Үүнд:

- Гадаад орчны өөрчлөлтийн хурд,
 - Нэгж хэсгүүдийн ажлын уялдаа холбоог бий болгох,
 - Ажлын байрны зүгээс ажилтанд тавигдах мэдлэг, үр чадварын шаардлага,
 - Байгууллагын үйл ажиллагааны эцсийн үр дүнгийн талаарх мэдээлэл
- Хяналтын процесс нь дараах үндсэн үүргүүдийг гүйцэтгэдэг. Үүнд:
- Тодорхойгүй байдлыг тодорхой болгох,
 - Алдаа дутагдлыг илрүүлэх,
 - Нөхцөл боломжийг тогтоох
 - Хүнд нөхцөл байдлыг удирдах
 - Эрх мэдлийг бусдад шилжүүлэх гэжээ.

Иргэд цагдаагийн байгууллагаас юу хүсэн хүлээж байна вэ? VISION GROUP-ийн “Улаанбаатар хотын цагдаагийн үйл ажиллагааны талаар олон нийтийн сэтгэгдлийг судлах” /2015/ судалгаанаас харахад: Цагдаагийн байгууллагаас

- Иргэдийг түргэн шуурхай хүлээн авч, асуудлыг хурдан шуурхай шийддэг байх,

-Хуулийн хүрээнд аливаа зүйлийг үнэн зөв шийддэг, гэмт хэрэг, зөрчлийг шуурхай үнэн илрүүлэх,

-Гудамж, нийтийн талбай, байр, гэр хорооллыг камержуулах хяналтыг сайжруулах,

- Хөдөлгөөнт эргүүлийг дүүрэг, хороодод хүртээмжтэй болгох,

- Алба хаагчид нь өндөр чадавхитай байх;

Цагдаагийн алба хаагчдаас:

- Хорооны иргэдтэй сайн хамтран ажиллах

- Олон нийтэд нэг бүрчлэн хүрч үйлчлэх

-Айлуудаа судалсан байх, ард иргэдийнхээ дунд орж ажиллаж, сонсож чаддаг байх,

-Ард иргэдтэй уулзаж тэдний санал бодлыг зохих шатны хүмүүст хүргэх,

-Хүмүүсийн гомдлыг хурдан хугацаанд хуулийн хүрээнд шийдэж өгөх,

- Иргэдэд ажил үүргийнхээ онцлог, чиглэлийг илүү ойлгуулж, танилцуулахыг хүссэн байна.⁸⁹

ДҮГНЭЛТ, САНАЛ

Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа, гэмт хэрэг, зөрчлийн гаралтын өнөөгийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээгээр цагдаагийн байгууллагад хөгжлийн төлөвлөлтийг урт хугацаанд даацтай хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага тавигдаж байна.

Хөгжлийн стратеги хөтөлбөр нь үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцүүлэн цагдаагийн байгууллагыг дэлхий нийтийн чиг хандлага, шинжлэх ухаан, технологийн хөгжил дэвшилд ойртуулан жинхэнэ утгаар нь орчин үеийн мэргэжлийн байгууллага болгон цогц байдлаар өөрчлөн зохион байгуулахад чиглэгдсэн стратегийн түвшний бодлогын тулгуур баримт бичиг мөн.

2016 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/54 дүгээр тушаалаар Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хөгжлийн стратеги боловсруулж, шинэчлэн батлуулах тухай үүргийг хэрэгжүүлэх зорилгоор Цагдаагийн ерөнхий газрын даргын 2016 оны А/25, Хууль сахиулахын их сургуулийн захирлын А/27 дугаар тушаалаар “Цагдаагийн байгууллагын хөгжлийн стратеги хөтөлбөр” боловсруулах ажлын хэсэг байгуулан, хамтран ажиллаж, төслийг Хууль зүйн яаманд хүргүүлсэн.

Түүний зорилго нь цагдаагийн байгууллагын хөгжлийн үзэл баримтлал, стратегийг тодорхойлох, ирээдүйг төсөөлөх, үүний үндсэн дээр бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, хүний нөөцийг мэргэшүүлэх, сургаж дадлагажуулах, удирдах албан тушаалтны манлайлах үр чадварыг дээшлүүлэх, технологийн шинэчлэл хийх, эрх зүйн орчныг сайжруулах, байгууллагын соёл, үнэт зүйлийг төлөвшүүлэх, улмаар үйл ажиллагааг эрчимжүүлэх, чадавхыг сайжруулах, үр ашгийг дээшлүүлэх замаар цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг баталгаатай, шуурхай, ил тод, хүртээмжтэй байлгахад оршиж байна.

Энэ зорилтыг бид хэрхэн хэрэгжүүлэх вэ. Хуучин арга, хэв маягаараа явах уу. эсвэл өөр гарц олох ёстой юу. Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг хангахад ямар хүндрэл гардаг вэ гэсэн асуулгад дараах тайлбарыг өгдөг. Үүнд:

⁸⁹ Вишн групп “Улаанбаатар хотын цагдаагийн үйл ажиллагааны талаар олон нийтийн сэтгэгдлийг судлах” судалгааны ажлын тайлан 2015 он

-Судалгаа, шинжилгээнд суурилагдаагүй, мэдээллийн хомс байдлаас шалтгаалан хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажил, арга хэмжээний төсөв, санхүүгийн зардлыг тооцох боломжгүй байдаг.

-Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах санал болон төсвийн төсөөлөл нь хоорондоо уялдаж чаддаггүй. Цаг хугацааны хувьд ч нийлэмжтэй биш.

-Тодорхой зарим арга хэмжээний санхүүгийн зардлыг төсөвт тусгуулахаар санал хүргүүлдэг боловч төсөв батлагдах үед хасагддаг. Батлагдсан төсөв нь танагддаг хүндрэл гарсаар байна.

-Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөлт, хүний нөөцийн бодлого, санхүү, төсвийн хүндрэлтэй байдлаас шалтгаалж алба хаагчдын албандаа хандах хандлагад ахиц гарахгүй байна.

-Хүрэх түвшин, шалгуур үзүүлэлт тодорхой бус зохион байгуулсан ажил, арга хэмжээгээ зорилтод тохируулан биелэлтийг гаргаж байгаа тул төлөвлөсөн ажлын үр дүн тодорхой харагдахгүй байна.

-Үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр тооцож, санал зөвлөмж ирүүлдэг боловч энэ нь үйл ажиллагаанд нөлөөлөхүйц хэмжээнд хүрч чадахгүй байна гэдэг.

Иймд Цагдаагийн байгууллагын ирээдүйн хөгжлийн чиг хандлагыг зөв тодорхойлж, хөгжлийг дэмжихэд чиглэсэн төлөвлөлтийг тасралтгүй хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтаар хангагдсан байх зарчмын хүрээнд гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах бодлого, стратегийг боловсруулж, хэрэгжүүлэх.

Цагдаагийн байгууллагын хөгжлийн стратегийг төлөвлөх, зохион байгуулах, мэргэжлийн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий стратегийн нэгжийг ажиллуулж, мэргэшсэн алба хаагчаар бэхжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ:

Нэг. Хууль тогтоомж

1. Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хууль. 1993 он
2. Монгол Улсын Цагдаагийн албаны тухай хууль. 2013 он
3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль. 1997 он
4. Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль. 2004 он
5. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль. 2015 он

Хоёр. Бусад материал

1. Цагдаагийн байгууллагын хөгжлийн стратеги хөтөлбөр 2009-2021 он
2. "Цагдаагийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр 2012-2016 он
3. Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр 2014-2019 он
4. Цагдаагийн ерөнхий газрын 2012-2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөө
5. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны "Цагдаагийн байгууллагын ажлыг төлөвлөх, тайлагнах журам" /код 108/
6. Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Төсвийн шууд захирагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэжлийн түвшинг үнэлж дүгнэх журам"
7. Вишн групп "Улаанбаатар хотын цагдаагийн үйл ажиллагааны талаар олон нийтийн сэтгэгдлийг судлах" судалгааны ажлын тайлан 2015 он

ТӨР, ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

ПРЕДЕЛЫ НЕЗАВИСИМОСТИ СУДЕЙ

Б.Улзийсайхан
Директор Института Билиг
Гуманитарного Университета

В статье анализируются процесс, результаты и дальнейшие перспективы правовой реформы Монголии на основе периодов 1990-2002, 2002-2010 и после 2010 года. На основе конкретного исследования делаются выводы относительно независимости суда и судей как гаранта осуществления судебной власти, имеющие научно-исследовательское значение.

I. Принцип независимости судей

Базовые международные правовые нормы, гарантирующие права человека, закрепленные в статье 8 Всеобщей декларации прав человека "Каждый человек имеет право на эффективное восстановление в правах компетентными национальными судами в случаях нарушения его основных прав, предоставленных ему конституцией или законом" и статье 10 "... для определения его прав и обязанностей и для установления обоснованности предъявленного ему уголовного обвинения, имеет право, на основе полного равенства, на то, чтобы его дело было рассмотрено гласно и с соблюдением всех требований справедливости независимым и беспристрастным судом"^[90] являются одним из краеугольных камней судебной власти, выраженным в принципе независимой деятельности суда, независимости судей и подчинения их только закону.

На основе определения в полной степени взаимосвязанных конституционных принципов "самостоятельности суда, независимости суда и судей и подчинения их только закону" устанавливаются основы правовых и политико-экономических гарантий, механизмы их функционирования и организация их обеспечения, а также формируется их правовая среда^[91]. Единственным императивом деятельности судьи является закон, согласно которому судья "подчиняется только закону"^[92].

Принцип "подчинения судьи только закону, закрепленный в Конституции, является, *во-первых*, руководством неукосного соблюдения закона судьей при решении споров в процессе осуществления судебной власти; *во-вторых*, основанием для исключения постороннего воздействия всех возможных компетентных субъектов, а также влияния, принуждения и интересов на судей при осуществлении ими правосудия, правовых гарантий от возможных противоправных действий, неисполнения требований закона и основанием для независимости судей^[93].

Наши исследователи отмечают значение принципа независимости судей в должностных инструкциях судей, отраженного в следующих определениях и точках зрения.

Доктор, профессор Б.Чимид отмечал, что "судебная власть осуществляется самостоятельно в полной степени только на основе закона о независимой судебной власти судей или судебных инстанций. Это – судьи, наделенные Конституцией особым статусом государственных служащих"^[94]

Академик С. Нарангэрэл дал следующий определение: "Судья является государственным служащим, наделенным судебной властью защищать от любого посягательства граждан и общественные интересы посредством отправления правосудия и правом применять меры

⁹⁰ Права человека . (Сборник международных договоров и соглашений). ООН. УБ., 1993. С.3-4. // Хүний эрх. (Олон улсын гэрээ хэлэлцээрүүдийн эмхтгэл. НҮБ. УБ., 1993. 3-4 дэх тал.

⁹¹ Чимид Б. Концепция Конституции: Права человека и компетенция суда (Тетрадь II). УБ., 2004. С.127 // Чимид Б. Үндсэн хуулийн үзэл баримтлал: Хүний эрх, шүүх эрх мэдэл (II дэвтэр). УБ., 2004. 127 дахь тал

⁹² Амарсанаа Ж. и др. Реформа судебной власти Монголии (Обзор за последние 20 лет). УБ., 2010. С.24 //Амарсанаа Ж., ба бусад. Монгол Улсын шүүх эрх мэдлийн шинэтгэл (Сүүлийн 20 жилийн тойм). УБ., 2010. 24 дэх тал.

⁹³ Бямбаа Л. Правовые основания Конституции о независимости суда и судей. Верховенство закона. 2006. №3. С.16. // Бямбаа Л. Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын тухай Үндсэн хуулийн эрх зүйн үндэслэл. Хууль дээдлэх ёс. 2006. №3. 16 дахь тал.

⁹⁴ Чимид Б. Знания о Конституции. УБ., 2008. С.308 // Чимид Б. Үндсэн хуулийн мэдлэг. УБ., 2008. 308 дахь тал.

государственного принуждения к лицам, нарушившим правопорядок”^[95]. Судья — это лицо, наделенное полномочиями осуществлять правосудие. Поскольку судья является лицом, наделенным в законном порядке полномочиями осуществлять правосудие и исполняющее свои обязанности на профессиональной основе ^[96] и назначается исполнять правосудие согласно установленным законом процедуре, то основанием начала действия принципа независимости судьи согласно части 16.1 статьи 16 Закона Монголии о правовом статусе судьи (2012) является принесение присяги государственного служащего: “Я, вступая в должность судьи, торжественно присягаю народу объективно и вне зависимости от других осуществлять правосудие в соответствии только с Конституцией и другими законами Монголии, защищать конституционное устройство Монголии, права и свободу человека, справедливость и верховенство закона, соблюдать морально-этических принципов поведения судьи...” Дается следующий юридический комментарий независимости судьи: Судья осуществляет деятельность вне любого воздействия (профессиональная и личная независимость) и выносит решения в рамках закона (руководствуется только законом)^[97].

Доктор Г.Совд сделал вывод, что независимость суда и судей обеспечивает конституционный статус суда и судей^[98].

Судья является государственным служащим особой категории, отвечающим требованиям Конституции и другим законам, назначаемым Президентом Монголии согласно установленной законом процедуре и наделенным особыми правами по судебному производству^[99]. При этом назначение на должность судьи Президентом не следует понимать с точки зрения тоталитарного мышления “подчиняться тому, кто назначил”, поскольку конкурсный отбор кандидатов в должность судей и признание их полномочий компетентными органами является гарантией невмешательства другой стороны, а новизна концепции Конституции заключается в назначении судей на основе принципа невмешательства во избежание воздействия политических сил^[100].

Согласно части 49.2 статьи 49 Конституции “Президент, Премьер-министр, член Правительства и член Верховного Государственного Хурала, должностные лица государственной, партийной, общественной или любой другой организации и иных учреждений, отдельные граждане не могут вмешиваться в деятельность судьи, исполняющего свои обязанности”. Это является важной гарантией независимости судьи, исходя из его должностного положения, с одной стороны, и отсутствия постороннего воздействия, с другой^[101].

Подчинение судьи букве закона означает правильное применение и толкование Конституции, соответствующих ей официально опубликованных законов и международных договоров Монголии на основе правовой теории и правового сознания^[102].

Деятельность суда и судей, судебное разбирательство независимо от воли политиков и крупного бизнеса является основной характеристикой независимости и самостоятельности суда^[103].

Принцип независимости судей рассматривается в международных правовых документах следующим образом:

В “Основных принципах, касающихся независимости судебных органов”, утвержденных ООН (1985) в статье 11 части “Условия службы и срок полномочий” говорится следующее: “Срок полномочий судей, их независимость, безопасность, соответствующее вознаграждение, условия

⁹⁵ Нарангэрэл С. Правовые системы Монголии и мира. УБ., 2001. С.143 // Нарангэрэл С. Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо. УБ., 2001. 143 дахь тал

⁹⁶ Толковый словарь государственного права. УБ., 2003. С.193 // Солонго Д. Төрийн эрх зүйн тайлбар толь. УБ., 2003. 193 дахь тал

⁹⁷ Эрдэнэцогт Н. Юридический комментарий к статьям 47,48 и 49 Конституции Монголии. Фонд Ханнс-Зейдела. Страницы государственного права. Размышления /Эргэцүүлэл/. 2012. №40. С.806

// Эрдэнэцогт Н. Монгол Улсын Үндсэн хуулийн 47,48, 49 дүгээр зүйлийн онолын тайлбар.//Ханнс-Зейделийн сан. Төр эрх зүйн хуудас. Эргэцүүлэл. 2012. №40. 806 дахь тал.

⁹⁸ Совд Г. К вопросу об обеспечении независимости независимости суда и судей. В Монголын төр, эрх зүй. УБ., 1997. №2. С.1 //

Совд Г. Шүүх, шүүгчдийн хараат бус байдлыг хангах асуудалд. Монголын төр, эрх зүй. УБ., 1997. №2. 1 дэх тал

⁹⁹ Нармандах Б. Конституционное право Монголии. УБ., 2002. С.222 //

Нармандах Б. Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүй. УБ., 2002. 222 дахь тал

¹⁰⁰ Реформа судебной власти Монголии (Обзор за последние 20 лет). УБ., 2010. С.24

//Монгол Улсын шүүх эрх мэдлийн шинэтгэл (Сүүлийн 20 жилийн тойм). УБ., 2010. 24 дэх тал

¹⁰¹ Чимид Б. Концепция Конституции: Права человека и компетенция суда (Тетрадь II). УБ., 2004. С.128

¹⁰² Чимид Б. Знания о Конституции. УБ., 2008. С. 310

//Чимид Б. Үндсэн хуулийн мэдлэг. УБ., 2008. 310 дахь тал.

¹⁰³ Алтансүх Ж. Независимость судебной власти. Верховенство закона.УБ., 2016. №1(56). С.72 //

Алтансүх Ж. Шүүх эрх мэдлийн хараат бус байдал.// Хууль дээдлэх ёс. УБ., 2016. №1(56). 72 дахь тал

службы, пенсия и возраст выхода на пенсию должны надлежащим образом гарантироваться законом^[104]”.

В статье 40 “Независимость судей” Римского статута Международного уголовного суда указывается, что “1. Судьи независимы при выполнении своих функций, 2. Судьи не занимаются никакой деятельностью, которая может препятствовать выполнению ими своих судебных функций или может заставить усомниться в их независимости”.

В обобщенных и утвержденных на встрече международного круглого стола 81 председателя судов “Бангалорских принципах поведения судей” отражены следующие принципы: 1) Независимость - судья должен отстаивать и претворять в жизнь принцип независимости судебных органов в его индивидуальном и институциональном аспектах; 2) Объективность - объективность судьи является обязательным условием надлежащего исполнения им своих обязанностей; 3) Честность и неподкупность - честность и неподкупность являются необходимыми условиями надлежащего исполнения судьей своих обязанностей; 4) Соблюдение этических норм- соблюдение этических норм, демонстрация соблюдения этических норм являются неотъемлемой частью деятельности судей; 5) Равенство - обеспечение равного обращения для всех сторон судебного заседания имеет первостепенное значение для надлежащего исполнения судьей своих обязанностей; 6) Компетентность и старательность - компетентность и старательность являются необходимыми условиями исполнения судьей своих обязанностей.

В преамбуле Софийской декларации о независимости и подотчетности судебной системы (2013) Суда Европейского Сообщества указывается, что “Судья несет высокую ответственность при вынесении решения на основе уважения прав, обязанностей и свободы индивидуальных лиц и юридических лиц. Вследствие этого независимость судьи является правовой гарантией судебного решения согласно закону без любого незаконного постороннего воздействия^[105]”.

Вышеприведенные принципы, признанные Конституцией и международным правом, закреплены в нашем материальном и процессуальном праве следующим образом:

№	Закон	Дата утверждения	Закрепление принципа независимости судей
1	Закон о суде	07.03.2012	<p>Статья 6. Независимость суда 6.3.Запрещается воздействовать на ход судебного разбирательства при исполнении полномочий председателями судов всех инстанций, посягать на независимость судьи, давая рекомендации и указания в связи с данной деятельностью, назначая судей на конкретные дела и рассмотрение исков.</p> <p>Статья 28. Экономические гарантии суда 28.1.Число судей судов всех инстанций должно быть достаточным для обеспечения независимости суда и судей, осуществления правосудия.</p> <p>Статья 29.Гарантии организации судопроизводства 29.3.Для независимого судопроизводства суд и судьи должны быть обеспечены постоянным и передвижным помещением, залом для приема граждан и судебных заседаний, транспортом, связью, информационными и специальными техническими средствами, мебелью, оборудованием и охраной, их стандарты и условия определяет Генеральный судебный совет.</p>
2	О судебной администрации	22.05.2012	<p>Статья 5. Функции Генерального судебного совета 5.1.1.организация работы по обеспечению независимости судей и автономности суда; 5.1.3.Отбор судей из юристов; 5.1.4.защита прав судей и их законных интересов;</p> <p>Статья 9. Защита прав и законных интересов судей 9.1.2.В случае возникновения условий отрицательно</p>

¹⁰⁴ Права человека: права человека в сфере судебной власти. ООН. УБ., 1996. С.179-184 // Хүний эрх: Шүүх эрх мэдлийн салбар дахь хүний эрх. НҮБ. УБ.,1996. 179-184 дэх тал.

4. Боржигон, Мөнгөндалай Гаргуулан тайлбарласан гадаад явдлын төрийг засах яамны хууль зүйлийн бичиг (34-р дэвтэр) нэмж зохиосон нь: Монголчууд хязгаар гарсныг байцаахыг алдахуй нь (М) Бээжин. Үндэстэний хэвлэлийн хороо. 2006 он.
5. Боржигон, Мөнгөндалай Гаргуулан тайлбарласан гадаад явдлын төрийг засах яамны хууль зүйлийн бичиг (35-р дэвтэр) нэмж зохиосон нь (Иргэн Монгол эм, охиныг гэргий болгон авах нь) (М) Бээжин. Үндэстэний хэвлэлийн хороо. 2006 он.
6. Боржигон, Мөнгөндалай Гаргуулан тайлбарласан гадаад явдлын төрийг засах яамны хууль зүйлийн бичиг (41-р дэвтэр) (мэхлэн авч худалдах, мэхлэн авч худалдан авах нь) залруулан зассан нь (Дотоод газрын хүнийг мэхлэн авч явж худалдах нь) Бээжин. Үндэстэний хэвлэлийн хороо. 2006 он.
7. 田利姝 : 清朝民族立法特点之研究(J) : 贵州民族研究, 2003, №4
8. 徐晓光 : 清朝民族立法原初探 (J) : 民族研究, 1992, №1
9. 刘广安 : 中国古代民族自治研究 : 北京 : 中央民族大学出版桂, 2009

МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ХУУЛИЙН 499 ДҮГЭЭР ЗҮЙЛИЙН ЗҮЙЛЧЛЭЛ, ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Э.ЧУЛУУНЦЭЦЭГ

Монгол Улсын Боловсролын их сургуулийн
Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургуулийн
Нийгмийн ухааны тэнхимийн
эрх зүйн багш, магистр

Хураангуй: Монгол Улсын Иргэний хуулийн тавин хоёрдугаар бүлгийн Гэм хор учруулснаас үүсэх үүргийн эрх зүйн зохицуулалт дахь 499 дүгээр зүйлийг ойлгож хэрэглэх зарим асуудалд онолын тайлбар хийх хэрэгцээ шаардлага байгаа нь хуулийн зүйлчлэл, хэрэглээнээс анзаарагддаг. Учир нь тус зохицуулалтын зарим хэсгийн хоёрдмол утга, зөрчил, хийдлээс үйдээд шүүхийн шийдвэр шударга, бодитой байх, хууль зүйн хариуцлага хүлээлгэх онолын зарчимд харшилж болохуйц тохиолдол практикт түгээмэл байна. Иймээс энэхүү өгүүллийн хүрээнд тухайн зохицуулалтын зарим асуудалд онолын тайлбар өгөх, практик хэрэглээнд дүн шинжилгээ хийхийг эрмэлзлээ.

Түлхүүр үгс: Хууль, гэм хор, өмчлөл, эзэмшил, хууль зүйн хариуцлага, шалтгаант холбоо

Манай Улсын хувьд эрх зүйн тогтолцооны онцлог, хэв маягаас хамаарч шүүх болон хууль хяналтын байгууллагын эрх зүйн хэрэглээний практикт "мэргэжлийн хамтлагийн ёсчилсон онолын суурь мэдлэг" хандахгүйгээр позитив эрх зүйн хэм хэмжээг түйлчлэн үзэх хандлага байгаа нь аливаа шийдвэр, үйл ажиллагаа шударга, бодитой байх зарчим, "хүний эрхийг хамгаалах" гэх эрх зүйн гол зорилгыг бүдгэрүүлэх нөхцөл байдал бий болгох тохиолдол гардаг. Үүний нэг тод жишээ нь манай иргэний хуулийн 499 дүгээр зүйлийн зүйлчлэлийн асуудал гэж судлаачийн зүгээс үзэж байна.

Иргэний хуулийн 499 дүгээр зүйлийн 499.1-д зааснаар "Зорчигч болон ачаа тээвэрлэх зориулалт бүхий тээврийн хэрэгслийг ашиглах явцад бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан буюу эд юмс нь эвдэрч, устаж, гэмтсэн бол тухайн тээврийн хэрэгслийг эзэмшигч учирсан гэм хорыг нөхөн төлөх үүрэгтэй"¹⁴⁴ гэж зохицуулжээ. Энэ зохицуулалтыг хэрэглэх явцад тээврийн хэрэгслийг ашиглах явцад учирсан гэм хорыг "**тухайн тээврийн хэрэгслийг эзэмшигч**" хариуцан арилгах үүрэгтэй гэсэн хаалтад байгаа хэсэг болон иргэний хууль дахь эзэмшил, эзэмшигчтэй холбоотой зарим зохицуулалт төөрөлдөлд оруулж, тодорхой бус байдал бий болгодог.

Иймээс нэгдүгээрт, эзэмшил, эзэмшигч гэх нэр томъёонд онолын тайлбар хийх шаардлагатай юм. Латин хэлнээ "роззеззю", Оросоор "владение" буюу "**ЭЗЭМШИЛ**" гэх ойлголт нь эртний Ромын эрх зүйгээс улбаатай. Иргэний эрх зүйн гол ухагдахуун байж, өнөөг хүртэл онол, арга зүйн түвшинд судлагдан ирсэн. Тухайлбал,

- Субъектив эзэмшлийн онол. Энэ онолыг К.Ф.Савиньи үндэслэсэн бөгөөд эзэмшил гэдэг нь хүсэл зоригийн дагуу эд хөрөнгөд бодит ноёрхлоо тогтоох явдал гэсэн үзэл санаанд тулгуурладаг
- Объектив эзэмшлийн онол. Энэ онолыг Р.Иеринг үндэслэсэн. Гол үзэл баримтлал нь субъект тодорхой эд хөрөнгөд өөрийн бодит ноёрхлоо хэрэгжүүлэхийг эзэмшил үүссэн гэж ойлгох юм.
- Иргэний энх тайвны онол. Энэ нь харьцангуй сүүлийн үеийн онол бөгөөд энэ онол нь нийтийн амгалан тайван байдлын төлөө хамгаалагддаг гэж тайлбарладаг.¹⁴⁵

Дээрх эзэмшлийн сонгодог онолуудаас эх газрын эрх зүйн тогтолцоотой улс орнуудын хувьд субъектив болон объектив онолын үзэл баримтлал түлхүү хөгжиж ирсэн байдаг. Жишээ нь ХБНГУ-ын иргэний хуульд дахь эзэмшлийн талаарх үзэл баримтлал нь тухайн эд зүйл, эрхийг бодит байдлаар эрхшээлдээ оруулах замаар үүсэх¹⁴⁶ээр тусгасан нь объектив эзэмшлийн онолын үзэл баримтлал болох эд хөрөнгөд бодит ноёрхлоо хэрэгжүүлснээр эзэмшил үүсэх чиг хандлага давамгайлдаг.

Монгол хэлний тайлбар тольд "Эзэмшил бол "Эзэмших үйлийн нэр, эзэмдэн эдэлж байгаа юм"¹⁴⁷ гэж тайлбарласан нь үгийн утгын хувьд объектив эзэмшлийн онолын үзэл баримтлалтай нийцжээ.

¹⁴⁴ <http://legalinfo.mn/law/details/299?lawid=299>

¹⁴⁵ Галов В.В. "Владение как элемент вещного права" Ростов-на-Дону, Донской юр-кий инс., 2000

¹⁴⁶ Германы иргэний хуулийн 854 дүгээр зүйлээс,

¹⁴⁷ https://mongoltoli.mn/search.php?ug_id=135790&opt=1&word=

Манай Иргэний хуульд эзэмшил гэх ойлголтыг албан ёсоор тодорхойлоогүй боловч иргэний хуулийн 89 дүгээр зүйлийн 89.1-д "Хүсэл зоригийн дагуу эрх, эд юмсыг хууль ёсоор мэдэлдээ авах замаар эзэмшил үүснэ"¹⁴⁸ гэж заажээ. Энэ заалтад дахь "хууль ёсоор" гэх томъёолол нь хуулийн хэрэглээнд төөрөгдөл үүсгэж, мөн онолын зарчимд харш гэж судлаачид үздэг. Учир нь эзэмшил болон эзэмших эрх хоёр нь онолын хувьд ялгаа заагтай ойлголт, эрх бол хуулийн дагуу үүсэх нь гарцаагүй, харин эзэмшил бол хууль бусаар ч үүсэх боломжтой юм. Эзэмшил дэх хамгийн гол асуудал бол бодит хараа хяналт, эршээлдээ оруулсан байдал чухалд тооцогдох юм. Тус хуулийн тайлбарт "Эзэмшил гэдгийг аливаа этгээдийн эд юмсыг бодитойгоор эрх мэдэлдээ байлгахыг ойлгоно. Эзэмшлийг өмчлөлөөс хатуу зааглан ялгах хэрэгтэй. Эзэмшлийн өмчлөлөөс ялгаатай нь тухайн эд юмст байх хууль ёсны харьяалал бус, харин бодит харьяалад үндэслэдэг явдал"¹⁴⁹ гэж тайлбарласан байгааг анзаарч үзэх хэрэгтэй.

Хоёрдугаарт, Монгол Улсын иргэний хуульд заасан эзэмшигчийн ангилал нь хуулийг ойлгох хэрэглэх ажиллагаад төөрөгдөл үүсгэж болох талтай юм. Учир нь иргэний хуулийн 89 дүгээр зүйлийн 89.3-д "Өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлын дагуу хууль буюу хэлцлийн үндсэн дээр тодорхой хугацаагаар эд хөрөнгийг эзэмших эрх олж авсан буюу үүрэг хүлээсэн этгээд нь шууд эзэмшигч, эрх буюу үүргээ шилжүүлсэн этгээд нь шууд бус эзэмшигч байна"¹⁵⁰ гэж зааснаас үзвэл эзэмшигч хэмээх субъектийг эрх зүйн байдлынх нь хувьд:

- Шууд эзэмшигч
- Шууд бус эзэмшигч гэж ангилжээ.

Хуулийн энэ ангилал нь "эд юмсыг эрх мэдэлдээ олж авах харилцаанд биечлэн оролцох ёстой гэсэн зарчимтай харшилж"¹⁵¹, мөн иргэний хуулийн хэрэглээнд эрх зүйн онолын суурь зарчим зөрчигдөх тохиолдол практикт түгээмэл гаргахад хүргэсэн гэж дүгнэж болно. Жишээ болгон хэд хэдэн шүүхийн шийдвэрийг авьч үзье.

Шийтгэх тогтоол 1. Говь сүмбэр аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 4 сарын 27-ны өдрийн 28 дугаар шийтгэх тогтоол¹⁵²-оос иргэний хуулийн 499 дүгээр зүйлийг хэрэглэн, хэрэг маргаан хянан шийдвэрлэсэн хэсгийг онцлон үзэх болно.

Хэргийн талаар товч өгүүлбэл: Реналт экспресс маркийн авто машины өмчлөгч Б нь автомашин жолоодох эрх бүхий А, Т нарт машинаа шилжүүлж өгсөн байдаг. Тэд 2015 оны 09 дүгээр сарын 27-ны өглөө тус аймгийн Баянтал сумын нутаг дэвсгэрт байрлах Улаанбаатараас Чойр чиглэлийн хатуу хучилттай засмал зам дээр Ренаулт экспресс маркийн тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцож яваад Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт заасан "Жолооч хөдөлгөөний эрчим, тээврийн хэрэгслийн онцлог байдал, тээж яваа ачаа, замын болон цаг агаарын нөхцөл, хөдөлгөөний дагуу үзэгдэлтийг харгалзан тээврийн хэрэгслийг хурдыг энэ дүрэмд тогтоосон хязгаараас хэтрүүлэхгүйгээр сонгож явна", мөн дүрмийн 9.2 дахь хэсэгт заасан "Жолооч хөдөлгөөнд аюул, саад би болохыг мэдсэн үед тээврийн хэрэгслийн хурдыг хасаж, зайлшгүй тохиолдолд зогсоох арга хэмжээ авна" гэсэн заалуудыг зөрчиж иргэн Э-гийн жолоодож явсан Норд Бенз маркийн автомашиныг хөдөлгөөнд оролцож байхад нь мөргөсний улмаас зорчигч Д-д бие махбодид хүнд гэмтэл, иргэний нэхэмжлэгч Ж-д 3.900.000 төгрөгийн, Б-д 8.355.000 төгрөгийн хохирол тус тус учруулсан гэмт хэрэгт холбогдож тухайн хэргийг шүүх шийдвэрлэжээ.

Тус шүүхээс тухайн үед автомашин жолоодож явсан А,Т-г гэм буруутайд тооцож, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 215 дугаар зүйлийн 215.2 дахь хэсэгт зааснаар тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 1 /нэг/ жилийн хугацаагаар хасч, 3 /гурав/ сар 01 /нэг/ хоногийн хугацаагаар баривчлах ялаар шийтгэсүгэй хэмээн шийдвэрлэж ял оногдуулсан байдаг.

Харин гэм буруутайд тооцсон А-ийн унаж явсан **автомашинны өмчлөгч Б-г** иргэний хариуцагчаар татаж "Иргэний хуулийн 499 дүгээр зүйлийн 499.1, 499.4 дэх хэсэгт заасныг баримтлан иргэний хариуцагч Б нь 4.280.400 /дөрвөн сая хоёр зуун наян мянга дөрвөн зуу/ төгрөгийг гаргуулан иргэний нэхэмжлэгч Ж-д олгохоор шийдвэрлэжээ.

Автомашинны өмчлөгч Б тээврийн хэрэгслийг гэрээний үндсэн дээр өөрийн болоод А,Т нарийн хүсэл зоригийн дагуу шилжүүлж өгсөн байдаг.

¹⁴⁸ <http://legalinfo.mn/law/details/299?lawid=299>

¹⁴⁹ Монгол Улсын иргэний хуулийн тайлбар, Уб.,2010 он, хуудас 155, 156

¹⁵⁰ <http://legalinfo.mn/law/details/299?lawid=299>

¹⁵¹ Монгол Улсын иргэний хуулийн тайлбар, Уб.,2010 он, хуудас 155, 156

¹⁵² <http://shine.shuukh.mn/eruanhan/5089/view>

Шийтгэх тогтоол 2. Төв аймгийн сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2016.06.06-ний өдрийн 176 дугаартай шийтгэх тогтоол¹⁵³-оос иргэний хуулийн 499 дүгээр зүйлийг хэрэглэн хэрэг маргаан шийдвэрлэсэн байдлыг онцлон үзэх болно.

Хэргийн талаар товч өгүүлбэл: Шүүгдэгч Д нь 2016 оны 2 дугаар сар 26-ны өдөр Төв аймгийн Борнуур сумын нутагт Салхитын ар гэх газар байрлах “Урьхан цогцолбор” гэсэн бичиглэлтэй самбараас баруун тийш 2 километрт асфальтан замд иргэн О-гийн эзэмшлийн Тоёото королла маркийн ... улсын дугаартай тээврийн хэрэгсэл жолоодон замын хөдөлгөөнд оролцож явахдаа Замын хөдөлгөөний дүрмийн 9 дүгээр бүлгийн 9.1-дэх хэсэгт “Жолооч хөдөлгөөний эрчим, тээврийн хэрэгслийн онцлог байдал, тээж яваа ачаа, замын болон цаг агаарын нөхцөл, хөдөлгөөний дагуу үзэгдэлтийг харгалзан тээврийн хэрэгслийн хурдыг энэ дүрэмд тогтоосон хязгаараас хэтрүүлэхгүйгээр сонгож явна. 9.2. Жолооч хөдөлгөөнд аюул, саад бий болохыг мэдсэн үед тээврийн хэрэгслийн хурдыг хасаж, зайлшгүй тохиолдолд зогсоох арга хэмжээ авна.” гэж заасныг зөрчиж Ч.Эрдэнэбатын жолоодож явсан иргэн Г-ийн эзэмшлийн Тоёото хайландер маркийн улсын дугаартай тээврийн хэрэгсэлтэй мөргөлдөж иргэн Г-ийн биед хүндэвтэр зэргийн гэмтэл, түүний авто машинд 12 103 000 / Арван хоёр сая нэг зуун гурван мянган / төгрөгний нийт 13 083 000 /арван гурван сая наян гурван мянган / төгрөгний хохирол учруулсан тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчсөн гэмт хэрэгт холбогджээ.

Тус хэргийг шүүх: Шүүгдэгчийг үйлдэлд гэм буруутайд тооцож, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 215 дугаар зүйлийн 215.1-д зааснаар тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах ял хэрэглэхгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 6 /зургаа/ дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний буюу 1 154 000 /нэг сая нэг зуун тавин дөрвөн мянга/ төгрөгөөр торгож шийтгэсүгэй.

Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 505 дугаар зүйлийн 505.1, 510 дугаар зүйлийн 510.1, 499 дүгээр зүйлийн 499.1 дэх хэсэгт тус тус зааснаар хохирогч Г-д 6 350 000 төгрөг төлсөнг дурьдаж, шүүгдэгч Д, иргэний хариуцагч буюу **автомашинны өмчлөгч** О нараас хувь тэнцүүлэн 4 375 685 төгрөгийг тус тус гаргуулж хохирогч Г-д олгосугай гэж шийдвэрлэжээ.

Шийтгэх тогтоол 3. Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 05 сарын 14-ний өдрийн 506 дугаарт шийтгэх тогтоол¹⁵⁴-оос гэмт хэргийн улмаас учирсан хохирол төлүүлэхтэй холбоотой хэгийг шийлвэрлэсэн байдлыг онцолсон болно.

Хэргийн талаар товч өгүүлбэл: Шүүгдэгч А нь /яллах дүгнэлтэнд тэмдэглэсэнээр/ нь 2016 оны 02 сарын 16-ны өдөр Баянзүрх дүүргийн 15 дугаар хорооны нутаг 10 дугаар байрны зүүн талын замд Nissan cube маркийн улсын дугаартай тээврийн хэрэгслийг жолоодож явахдаа Монгол улсын замын хөдөлгөөний дүрмийн 7.17 “Бусдын хөдөлгөөнд саад учруулахааргүй газарт, аюулгүй байдал хангасан нөхцөлд ухрах үйлдэл хийхийг зөвшөөрнө. Шаардлагатай тохиолдолд ухрах үйлдлийг бусдын тусламжтайгаар гүйцэтгэх бөгөөд жолооч аюулгүй байдлыг хангах үүргээс чөлөөлөгдөхгүй” гэсэн заалтыг зөрчсөний улмаас хохирогч Ш-ыг мөргөж амь насыг нь хохироон тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж зөрчсөн гэмт хэрэгт холбогджээ.

Мөрдөн байцаалтын явцад Nissan cube маркийн улсын дугаартай тээврийн хэрэгсэл нь Иргэн М-ийн эзэмшлийнх болохыг тогтоосон бөгөөд түүнийг иргэний харуцагчаар тогтоож байцаахад “уг авто машиныг ББСБ-д барьцаанд тавьж зээл аваад, зээлээ төлж дуусаны дараа 2014 онд А-д машинаа зарсан” гэж мэдүүлэх боловч бичиг баримтыг нь шилжүүлээгүй байна. Иймд уг тээврийн хэрэгслийн эзэмшигч нь иргэний хариуцагч Ц.Мөнхсайхан гэж үзсэн байна.

Тус хэргийг шүүх шийдвэрлэхдээ “шүүгдэгч А-г гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 215 дугаар зүйлийн 215.3 дахь хэсэгт зааснаар Х.Анхбатыг тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 4 жилийн хугацаагаар хасч, 4 жилийн хугацаагаар хорих ялаар шийтгээд, Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 499 дүгээр зүйлийн 499.1, 508 дугаар зүйлийн 508.1 дэх хэсэгт зааснаар иргэний хариуцагч буюу автомашинны өмчлөгч М-с 5.773.083 төгрөг гаргуулж, иргэний хариуцагч нь шүүгдэгчээс гэм хорын зардлыг иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх журмын дагуу тус тус нэхэмжлэх эрхтэйг тайлбарлажээ.

Ийм байдлаар иргэний хуулийн 499 дүгээр зүйлийг ойлгож хэрэглэх тохиолдол цөөнгүй байгаа нь практик тогтсон гэж хэлж болохоор байна. Шүүх “тээврийн хэрэгслийг эзэмшигч” гэснийг тус авто машины гэрчилгээг эзэмшиж байгаа этгээд гэж үзсэн дээрх шийдвэрүүдээс тодорхой харагдаж байна. Энэ нь онолын хувьд бол зөрчилтэй байдлыг бий болгоно. Тухайлбал, нэгдүгээрт, “эзэмшигч” гэдэг бол өмнө тайлбарласнаар тухайн үед авто машиныг бүрэн мэдэлдээ байлгаж байсан этгээд юм. Хууль зүйн герменевтик арга зүйн¹⁵⁵ дагуу хууль тогтоогчийн хүсэл зоригийн

¹⁵³ <http://shine.shuukh.mn/eruanhan/5713/view>

¹⁵⁴ file:///C:/Users/Data/Downloads/105-2016-0407-%D1%8D_2016-05-10_506%20(1).pdf

¹⁵⁵ Ловпаче.З.Х., Хуульзүйн герменевтик бол ойлгохуйн тухай шинжлэх ухааны бүлэг мөн.

илэрхийллийг таамаглавал авто машины гэрчилгээ эзэмшигч нь хариуцлага хүлээнэ гэсэн санаа зориг ажиглагдахгүй байна гэж дүгнэж болохоор байна. Хэрэв ийм байдлаар ойлгож хэрэглэхийг хууль тогтоогч хүссэн бол "өмчлөгч" гэж тодорхой болгох байсан. Хоёрдугаарт, шүүхийн энэ хэрэглээ нь хууль зүйн хариуцлага хүлээлгэх онолын зарчмыг зөрчдөг. Иргэний хуульд хариуцлагын янз бүрийн хэлбэрийг заасан байдаг. Тухайлбал, хохирлыг нөхөн төлүүлэх, анз, гүйцэтгээгүй үүргийг нөхөн биелүүлэх гэх мэт.

Иргэний эрх зүйд хохирол нөхөн төлүүлэх нь хариуцлагын нэг чухал хэлбэр юм.¹⁵⁶ Иргэний эрх зүйн хариуцлага нь хохирлыг арилгах, зөрчигдсөн эд хөрөнгийн болон эд хөрөнгөтэй холбогдсон харилцааны эрхийг нөхөн сэргээх агуулгыг илэрхийлнэ.¹⁵⁷ Энэхүү хууль зүйн хариуцлагыг тодорхой нөхцөл байдал бүрдэсний үндсэн дээр хүлээлгэдэг зарчимтай. Үүнд дараах үндэслэл хамаарна.

- Эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэл хийсэн байх
- Эрх зүйн зөрчил гаргагч нь гэм буруутай байх
- Эрх зүйн зөрчлийн улмаас хор хохирол учрсан байх
- Эрх зүйн зөрчил гарагч нь гэм буруутай байх, гэм буруу нь үйлдэл болон хор хохиролтой шалтгаант холбоотой байх гэсэн дөрвөн нөхцөлийг шаардана.

Гэтэл шүүх автомашин жолоодож яваад осол гаргаж, хор хохирол шууд учруулсан субъектыг гэм буруутайд тооцоод, тухайн үйлдлийн улмаас учирсан гэм хорыг өөр этгээдээр нөхөн төлүүлж байгаа нь хууль зүйн хариуцлага хүлээлгэх үндэслэл журмыг зөрчөөд зогсохгүй шүүхийн шийдвэр шударга, бодитой байх, гэм буруутай этгээд зөвхөн өөрөө хариуцлага хүлээх гэсэн онолын суурь зарчмууд ч харшилж байна.

Харин шүүхийг хуулийн хатуу үг, үсэгт захирагдаж, онолын баримжаагүй шийдвэр гаргасан гэж үзэх үндэслэл байгаа ч хууль бус шийдвэр гаргасан гэж дүгнэж боломгүй нь дараах зохицуулалтаас харагддаг.

- Иргэний хуулийн 89 дүгээр зүйлийн 89.2-т зааснаар "Өөр этгээдээс бүрэн эрх олгогдсоны дагуу түүний ашиг сонирхлын үүднээс эд хөрөнгийг тухайн үед өөрийн мэдэлд байлгаж байгаа этгээдийг эзэмшигч гэж үзэхгүй" Энэ тохиолдолд бүрэн эрх олгосон этгээд эзэмшигч байна гэсэн эзэмшлийн онолтой зөрчилтэй байдлыг бий болгосон зохицуулалт,
- Иргэний хуулийн 89 дүгээр зүйлийн 89.3 дахь хэсэг дэх "Өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлын дагуу хууль буюу хэлцлийн үндсэн дээр тодорхой хугацаагаар эд хөрөнгийг эзэмших эрх олж авсан буюу үүрэг хүлээсэн этгээд нь шууд эзэмшигч, эрх буюу үүргээ шилжүүлсэн этгээд нь шууд бус эзэмшигч байна" гэх ангилалын дагуу хуулийн 499.1-д шууд болон шууд бус эзэмшигчийн аль нь ч байх боломжтой хоёрдмол утга санаа илэрхийлж, 89.2-т заалтын дагуу бүрэн эрх олгосон этгээд эзэмшигч байх боломжтой бөгөөд эд зүйлийн бүрэн хараа хяналт, бодит эзэмшилдээ байлгаагүй шууд бус эзэмшигчийг хохирол төлүүлэхээр сонгон хууль зүйн хариуцлага хүлээлгэж болно.
- Иргэний хуулийн 499 дүгээр зүйлийн 499.4 дэх хэсэгт "Тээврийн хэрэгсэл ашиглагчийг өмчлөгч буюу эзэмшигч өөрөө томилсон буюу өөрөө түүнд уг хэрэгслийг шилжүүлэн өгсөн бол бусдад учирсан гэм хорыг өмчлөгч буюу эзэмшигч хариуцан арилгах үүрэгтэй" гэх заалтаар өмчлөгч гэж оруулж ирсэн нь гэм буруутай этгээд биш тээврийн хэрэгслийн хууль ёсны өмчлөгч хариуцлага хүлээхээр заасан. Мөн тус хуулийн 499.3 дахь хэсэг дэх "Хэн нэг этгээд өмчлөгч буюу эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр тээврийн хэрэгслийг ашигласнаас бусдад хохирол учирсан бол гэм хорыг тухайн этгээд хариуцах боловч өөрийн буруугаас тээврийн хэрэгслийг ашиглах боломж олгосон өмчлөгч буюу эзэмшигч хариуцлагаас чөлөөлөгдөхгүй" гэх зохицуулалт нь хуулийн хэрэглээнд хоёрдмол утга санааг үүсгэсэн. Энэ зохицуулалтыг өөрийн буруугаас ашиглах, эзэмших боломж олгоогүй тохиолдолд хариуцлага хүлээхгүй мэт ойлгож болох ч 499,4 дэх хэсэг нь энэ утга санааг үгүйсгэх нөхцөл байдлыг бий болгожээ.

Мөн хэн нэгний өмчлөлийн автомашиныг түрээсийн гэрээ байгуулж шилжүүлж авсан этгээд иргэний хуулийн ерөнхий заалтын дагуу буюу 93 дугаар зүйлийн 93.2 дахь хэсэг дэх "Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол хууль ёсны эзэмшигч эд хөрөнгийг эзэмшилдээ байлгах хугацаанд тухайн эд хөрөнгийн үр шимийг эзэмшинэ" гэсний дагуу түрээсэх хугацаанд олсон бүх үр шимийг хүртээд, үр дагаврыг хариуцахгүй гэвэл логикийн хувьд ч зөрчилтэй болно. Урвуу хамааралаар бол үр дагаврыг

¹⁵⁶ Т.Мөнхжаргал, "Монгол Улсын Иргэний эрх зүй" ерөнхий анги, УБ.,2003 он, 193 дахь талаас

¹⁵⁷ Ч.Нямсүрэн, "Эрх зүй ерөнхий онол, үндсэн ойлголт, тулгамдсан асуудал" УБ., 2010 он, 394 дэх талаас,

ч мөн хариуцах нь зүй ёсны асуудал юм. Гэтэл хуулийн зохицуулалтуудын дагуу бол түрээслэгч бус түрээслүүлэгч үр дагаврыг хариуцах боломжтой юм.

Дүгнэлт. Иргэний хуулийн зөрчилдөөнтэй зохицуулалтууд нь тус хуулийг нэг мөр ойлгож зөв хэрэглэхэд ээдрээтэй төвөгтэй байдлыг бий болгож байгаа нь дээрх онолын тайлбарууд болон шүүхийн практикаас ажиглагдаж байна. Үүнийг тоймлон үзвэл,

- Иргэний хуулийн 89 дүгээр зүйлийн 89.1-д заасан “Эд юмсыг хууль ёсоор мэдэлдээ авах” гэсэн санаа нь эзэмшлийн онолын тодорхойлолтыг үгүйсгэсэн тодорхойлолт болжээ.
- Иргэний хуулийн 89 дүгээр зүйлийн 89.2 дахь хэсэг дэх “Өөр этгээдээс бүрэн эрх олгогдсоны дагуу түүний ашиг сонирхлын үүднээс эд хөрөнгийг тухайн үед өөрийн мэдэлд байлгаж байгаа этгээдийг эзэмшигч гэж үзэхгүй. Энэ тохиолдолд бүрэн эрх олгосон этгээд эзэмшигч байна” гэсэн нь мөн л бусдын төлөө, бусдын нэрийн өмнөөс эд зүйлийг бодит байдлаар эзэмшиж байгаа эзэмшигчийг үгүйсгэсэн сонгодог онолтой зөрчилдөж, хуулийн хэрэглээнд төвөгтэй байдлыг үүсгэсэн.
- Иргэний хуулийн 89 дүгээр зүйлийн 89.3 дахь хэсгийн “.Өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлын дагуу хууль буюу хэлцлийн үндсэн дээр тодорхой хугацаагаар эд хөрөнгийг эзэмших эрх олж авсан буюу үүрэг хүлээсэн этгээд нь шууд эзэмшигч, эрх буюу үүргээ шилжүүлсэн этгээд нь шууд бус эзэмшигч байна” гэсэн заалт нь хоёрдмол утга санаа илэрхийлж, иргэний хуулийн 499 дүгээр зүйлийн 499.1-д заасан “эзэмшигч” субъектыг тодорхойлоход төөрөгдөл үүсгэсэн байж болох талтай.
- Мөн Иргэний хуулийн 499.3, 499.4 дэх заалтууд дахь “өмчлөгч буюу эзэмшигч” гэсэн нь тодорхой бус байдал үүсгэж болох талтай.
- Иргэний хуулийн 499 дүгээр зүйлийн 499.4 дэх хэсэгт Тээврийн хэрэгсэл ашиглагчийг өмчлөгч буюу эзэмшигч өөрөө томилсон буюу өөрөө түүнд уг хэрэгслийг шилжүүлэн өгсөн бол бусдад учирсан гэм хорыг өмчлөгч буюу эзэмшигч хариуцан арилгах үүрэгтэй гэх заалт нь мөн л хууль зүйн хариуцлага хүлээх үндэслэл, эрх зүйн суурь зарчмыг зөрчсөн зохицуулалт болжээ.

Иймээс иргэний хууль дахь эзэмшлийн эрх зүйн боловсронгуй болох, зөрчилдөөнт байдлыг арилгах саналыг талаар манай цөөн тооны судлаачид дэвшүүлсэн байдаг. Үүнээс үүдээд практикт ямар үр дагавар үүсэж байгааг багахан хэмжээнд тодруулахыг хичээлээ.

Судлаачдын саналыг харгалзан үзэж хуульд нэгдгээрт, сонгодог эзэмшлийн онолын баримжаатай тодорхой зохицуулалт хийх, мөн эзэмшлийн шууд болон шууд бус гэх ангилал хийх хэрэг эргэн харах шаардлагатай юм. Иргэний хуулийн 93 дугаар зүйлийн 93.2 дахь хэсэг дэх “Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол хууль ёсны эзэмшигч эд хөрөнгийг эзэмшилдээ байлгах хугацаанд тухайн эд хөрөнгийн үр шимийг эзэмшинэ” гэсэн зохицуулалтын хүрээнд үр дагаврыг хариуцах талаар зохицуулалт хийх, 499 дүгээр зүйлийн 499.3-д өөрийн буруугаас тээврийн хэрэгслийг ашиглах боломж олгосон гэх заалтаас бусдад нь зөвхөн “эзэмшигч” гэж тодорхой зохицуулалт хийж, хууль зүйн хариуцлага хүлээлгэх үндэслэл болон эрх зүйн суурь зарчимд нийцүүлэх талаас нь боловсронгуй болох шаардлагатай байна.

Өгүүлэлд жишээлэн авч үзсэн шийдвэрийн талаар зарим нэг практик хуульчдаас тодруулж асууж, ярилцахад шүүх энэ асуудлыг шийдэхдээ хохирол төлөх субъект нь автомашины гэрчилгээнд хууль ёсоор бүртгэлтэй этгээд гэж шийдвэрлэдэг. Тиймээс тэр шийдэл зөв гэх утга бүхий тайлбар өгч байна. Мөн олон шүүх энэ шийдлээр хандсан зэрэг нь жишиг болон тогтсон гэлтэй нөхцөл байдал анзаарагдаж байна. Эртний Ромын эрх зүйн хөрс суурин дээр хөгжиж ирсэн шинжлэх ухааны техник задаргаа, логик эрэмбэлэл, эрх зүйн онол болон арга зүйн хүчирхэг байдлаар өөрийн давуу чанарыг илтгэдэг эх газрын эрх зүйн бүлийг профессорын эрх зүй ч гэж нэрлэж ирсэн нь санамсаргүй тохиолдолд биш болов уу. Тиймээс хуулийн хэрэглээнд эрх зүйн онолын зарчмыг харгалзан үзэх нь шударга, бодитой, зүй ёсны шийдэл олох хамгийн чухал гарцын нэг мөн.

ХОРШООНЫ ТУХАЙ ОЙЛГОЛТ, ТҮҮНИЙ ҮҮСЭЛ ХӨГЖИЛ

Дэлхийн улс орнуудад хоршоо анх үүссэн түүхэн нөхцөл, шалтгаан хугацаа харилцан адилгүй байдаг. Хоршоо анх хаана хэзээ үүссэн, тухайн үеийн нөхцөл байдал ямар байв гэдэг асуудал хоршооллын хөдөлгөөнд оролцож буй хүн бүрийн анхаарлыг татсаар байгаа билээ.

Хоршоо гэдэг үг “хамтын ажиллагаа” (cooperataion) гэсэн утгатай, өргөн хүрээнд бол энэ нь аливаа нэг зорилгод хүрэхэд хэсэг хүмүүс буюу хэсэг бүлэг хүмүүс хамтын хүчээ нэгтгэхийг хэлнэ.

Монгол нутагт хоршоо үүсэж хөгжсөн нь эртнээс өөрийн гэсэн онцлогтойгоос гадна хоршооны үүсэл хөгжил нь монголын эдийн засаг, аж ахуйн амьдралтай салшгүй холбоотой юм. “Хоршоо” гэдэг үгийг монгол хэлний товч тайлбар тольд “санал хүчээ нэгтгэн хавсарч, эд хөрөнгөөр буюу биеийн хүчийг хамтруулан байгуулсан нэгдэл” хэмээн тайлбарласан нь монголчууд хэд хэдэн өрх, хот айл, саахалтаараа хамтран мал хариулах, оторлох, жин тээх, эсгий хийх, тариа түүх, үүц базаах, мал ноослох, хөөвөрлөх, хашаа хороогоо барих, жижиг гар үйлдвэр эрхлэх, ан гөрөө хийх зэрэг ажлыг хамтран гүцэтгэж ирсэнээс улбаатай юм.

Орос хэлний тайлбар тольд “хоршоо” гэдэг нь латин гаралтай үг бөгөөд аж ахуйн янз бүрийн салбаруудад хүмүүс тодорхой зорилгод хүрэхийн тулд хоорондоо хамтран ажиллаж буй хөдөлмөр зохион байгуулалтын хэлбэр” гэж тайлбарласан байна.

Хоршоо – Эдийн засгийн болон нийгэм соёлын нийтлэг хэрэгцээ хангах зорилгоор хэд хэдэн этгээд сайн дураараа нэгдсэн хамтын удирдлага хяналт бүхий дундын эд хөрөнгө дээр үндэслэн үйл ажиллагаа явуулахаар байгуулсан хуулийн этгээд” гэж судлаач Б.Улаанбаатар “Иргэний Эрх Зүйн Тайлбар толь” номондоо тодорхойлжээ.

Эдгээр толь болон бусад тайлбар толь бичигт тайлбарласныг авч үзвэл хүмүүс сэтгэл санаа, хөрөнгө хүч, хөдөлмөрөө нэгтгэн аж ахуйн хамтран нэгтгэн аж ахуйг хамтран эрхэлж байгаа байгууллагыг хоршоо гэсэн ойлголтыг ойлголтыг илэрхийлж байна. Хүмүүс ахуйн амьдралаа дээшлүүлэхийн тулд тодорхой ажил хөдөлмөрийг хамтран гүйцэтгэж ирсэн эрт үеийн бөгөөд энэ талаар улс орон бүр өөр өөрийн хууль тогтоомжиндоо хуульчлан бататгасан байдаг.

Монголын эртний ба дундад зууны үед хоршоо, хорших, хамтрах гэсэн ойлголт, практик үйл явц хүмүүсийн аж ахуйн амьдралын шаардлагаар бий болгон үүсэн хөгжиж иржээ. Харин түүний зохицуулалт нь ихэнхдээ олон арван жил зан заншлын хэм хэмжээгээр зохицуулагдаж иржээ. Энэ тухай эрдэмтэн Ж. Болдбаатар “Монгол улс өргөжин бэхжихийн хэрээр эрх зүйн болон заншлын хэм хэмжээ нь өөрсдийн онцлогоороо тодорч харилцан бие биедээ нөлөөлөн, монголын нийгмийн харилцааны нарийн төвөгтэй байдлыг зохицуулахад чухал үүрэг гүйцэтгэсэн юм” гэжээ.

Монгол улсад албан ёсны хоршоо байгуулах хөдөлгөөнийг 20-р зууны эхэн үетэй холбон судлаачид үздэг. Үндэсний хоршоо байгуулах албан ёсны саналыг анх 1916 онд Сангийн яамны дэд Сайд далай Чойнхор ван Цэдэнсодном гаргаж байжээ.

Тэрээр олон чуулган хошуу, шавийн баян гэр, лам ноёдоос мөнгө төгрөг татан авч худалдаа хоршоо нээлгэх асуудлыг хөндсөн байдаг.

Улсын дээд, доод хурал уг саналтай танилцаад улам боловсронгуй болгохыг шаардаж буцаасан байна. Үүний дараа 1917 оны 9-р сард Шүүх яамны эх зохиох түшмэл Цэдэвсүрэн “... олон хүний хувь мөнгийг хуралдуулан бараа таваарыг бөөнөөр худалдан авч ирүүлэн хямд үнээр худалдаалах, элдэв түүхий эдийг нэвтрүүлэх хоршоо байгуулан үйл ажиллагаа явуулах саналыг дахин Улсын дээд, доод хуралд тавьж дэмжүүлж байжээ. Үүний дагуу 1918 онд нийслэл хүрээнд 18 хүн хөрөнгө хоршин 15-н зүйлтэй дүрэм зохиож хоршооны даргаар Д. Чагдаржавыг сонгож байжээ.

Гэвч тухайн цаг үеийн хямрал 1919 онд хятадын гамин цэрэг, 1920 онд цагаантнууд монгол улсыг тус тус түрэмгийлж тусгаар тогнолыг бусниулсантай холбоотойгоор хоршооны хөгжилд нөлөөлж оршин тогтнох үндэсгүй болгожээ.

Харин 1921 оны хувьсгал ялсан анхны өдрөөс эхлэн ард түмний олон зуун жилийн хоцрогдлыг арилгах, аж амьдралыг дээшлүүлэх зорилгоор ядуу, дунд ардын гар урчуудыг түшиглэн, тэдний хөдөлмөрийг хорших, үндэсний хоршоо, худалдааны байгууллага бий болгох асуудалд ихээхэн ач холбогдол өгч 1921 онд Сангийн яамны дэргэд Хоршоо наймааны хэлтэсийг байгуулжээ.

1880 онд Их шавийн Чандмань отог, одоогийн Төв аймгийн Баян-Өнжүүл сумын нутагт төржээ. Монгол Ардын Нам, Монголын ардын Журамт цэрэг, хошуу шавийн төлөөлөгчдийн 1921 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн хамтарсан хурлаар “Ардын

Засгийн хэргийг бүгд Түр захиран шийтгэх газар” буюу Түр Засгийн газрыг байгуулж даргаар нь Д.Чагдаржавыг тохоож, улмаар Сангийн ба Эдийн засгийн яамны сайдын тушаалд томилсон ажээ. Тэрбээр энэхүү албыг ердөө 34 хоног хашсан байна. Сангийн яамнаас эрхлэн 1921 оны 10 дугаар сард өөрийн бүрэлдэхүүнд байсан Хоршоо худалдааны хэлтсийг Харилцан туслалцах хоршооны хэлтэс болгон зохион байгуулж, Ардын Засгийн газрын тогтоолоор даргад энэ ажилд дадлага туршлагатайг нь бодолцон түүнийг томилон Харилцан Туслалцах Хоршоо байгуулах хэргийг түүнд эрхлүүлж уг ажлыг нэн түргэн гүйцэтгэхийг даалгасан байна.

Ардын Харилцан Туслалцах хоршоонд 1921 оны 12-р сард анхны гишүүдийг элсүүлэн хоршооны Ерөнхий хороог байгуулж, тэргүүлэгчээр тэрбээр сонгогдсон байна.

1921 оны 11-р сард Богд хаан хоршооны хэргийг сайшаасан бичгийг аймаг хошуудад гаргаж байжээ.

1924 онд батлагдсан БНМАУ-ын Үндсэн хуулийн 3-р зүйлийн 9-д “жинхэнэ олон ардын аливаа эвлэл хоршоо зэргийг эрх чөлөөг хүндэтгэх эл явдалд тус улсаас элдэв тусламж үзүүлвэл зохино” гэж заасан нь монголд анх удаа хамтын өвчийг хуульчилсан гэж болно.

Анхдугаар үндсэн хууль батлагдсаны дараа олон салбар хууль батлагдсаны нэг нь 1926 онд “Иргэний хууль” болно. Энэхүү “Иргэний хуулийн” 3-р анги буюу “Аливаа эвлэл хоршоо буюу энгийн хүмүүсийн хоршоолон байгуулсан худалдаа үйлдвэрийн зэрэг газруудын эрхийн тухай” бүлгийн 85-р зүйлд “Энэхүү газрууд болвоос ард олны боловсролын хэрэг ба аливаа худалдаа үйлдвэрийн зэрэг явдлыг гол болгосон бодлого бүхий тул анх хоршоолсон хүмүүсийн завсардаан багуулж хууль ёсоор батлуулсан дүрэм буюу гэрээ бичгийг баримталж хууль ёсоор батлуулсан дүрэм буюу гэрээ бичгийг баримталж элдэв хэрэгт бүрэн эрхтэй ард лугаа хэдэн адил үүргийг хүлээвэл зохимой” гэжээ. Эдгээр хуулийн заалтын агуулага нь иргэд сайн дураараа эвлэлдэн нэгдэх, төрөл бүрийн чиглэлээр үйлдвэрлэл худалдаа эрхлэх, хоршоо байгуулах, үйл ажиллагаа явуулахдаа бусад субъектын нэгэн адил эрх эдэлж үүрэг хүлээх нөхцөл журмыг хуульчлан өгсөн эрх зүйн сурвалж болно.

1928 оны 1-р сард “хоршооллын ажиллах гар үйлдвэрлэлийг бэлтгэж боловсруулах нөхөрлөлийн дүрэм”-ыг Ардын сайд нарын Зөвлөлийн 3-р хурлаас баталжээ. Уг дүрэмд энгийн гар урчууд дархчуудыг нэгтгэн үйлдвэрлэл явуулж, үйлдвэрийн тоног төхөөрөмжөөр ханган, хангах үйлдвэрийн бүтээгдэхүүнийг борлуулах, нөхөрлөлд залуу боловсон хүчин бэлтгэх зэрэг зорилготойг тодорхойлсон байна. 1932 онд “Ардын үйлдвэрлэлийн нэгдлийн дүрэм” батлагдсан ба дүрэмд дараах чиглэлийн ажлыг хатран гүцэтгэх хэлбэрээр байгуулж болохыг заажээ. Үүнд :

1. Хамтран өвс хадахын тулд
2. Хувийн ба жасын малыг хамтран хариулахын тулд
3. Хамтран жин тээхийн тулд
4. Хамтарч малын хороо саравч барьж байгуулахын тулд
5. Хамтарч ан буюу загас барихын тулд
6. Хамтарч тариалангийн ажлыг явуулахын тулд нэгдэл байгуулж болохоор заасан юм.

Монголд үүсэж хөгжсөн хоршооллын нэг томоохон хэлбэр нь хөдөө аж ахуйн нэгдэл юм. 1920 оноос эхлэн засаг төрөөс удаа дараа заалт, удирдамж, чиглэл гаргаж байв.

1925 онд Богд хан аймгийн Ноён-Уул, Зүүнбүрэн, Ерөө гол зэрэг хошууны ядуус тариалангийн нэгдэл байгуулан ажиллаж байсан нь анхны нэгдлүүд байв.

1950-иад оны дунд үеэс хөдөө аж ахуйд хоршооллыг хөдөлгөөнийг өрнүүлэх талаар нам төрөөс арга хэмжээ авсан юм. 1955 онд намын төв хороо СНЗ-өөс ардын үйлдвэрлэлийн нэгдлийн сайдчуудын анхдугаар их хуралыг зарлан худалдуулж, ХАА-н нэгдлийг үлгэрчилсэн дүрмийг баталсан байна.

Дүрмийн агуулга нь нэгдлийг үүсэн байгуулах. Мал эд хөрөнгөө нийгэмчлэх, хамтын үйлдвэрлэлд гишүүдийн хөдөлмөр оролцоо, хөдөлмөрийн үнэлэмж, гишүүдийн эрх зүйг, нэгдлийг удирдлага, түүний эрх хэмжээ болон ХААН-ийн удирдах дээд байгууллагын тухай заасан байна.

Олон тооны жижиг нэгдлүүдийг нэгтгэн томруулах шаардлага амьдралаас урган гарсныг үндэслэн жалга довоор нэг байгуулагдсан 700 гаруй нэгдлийг томруулан цомхтгож 1959 оны эцэст 385 нэгдэлтэй болж, дунджаар нэг нэгдлийн мал 43 мянгад хүрч байв.

1959 онд хуралдсан Монгол Ардын Худьсгалт Намын Төв Хорооны IV бүгд хурал ардын аж ахуйтан хоршооллод нэгдэж гүйцэсний үрээр улс ардын аж ахуйн бүх салбарт социалист үйлдвэрлэлийн харилцаа эргэлт буцалтгүй боллоо гэж дүгнэжээ.

Доктор, профессор Т.Сэнгэдорж ХАА-н үйлдвэрлэлийн хоршооны эрх зүйн хэлбэрийг доорхи 3 үе шатанд хуваажээ. Үүнд :

1-р үе: Хөдөлмөрийн харилцан туслах энгийн нөхөрлөлийн үе /1928-1934/

2-р үе: Ардын үйлдвэрлэлийн нэгдлийн үе

/1934-1954/

3-р үе: ХАА-н нэгдлийн үе

/1954 оноос хойш/9

Энэхүү үечлэл нь ХАА-н үйлдвэрлэлийн хоршооллын түүхэн үе шатыг зүй зохистой нэгтгэн тодорхойлсон үечлэл болсон.

1964 онд СНЗ-ийн 535-р тогтоолоор "Үйлдвэрийн хоршооллын артелийн дүрэм"-ийг баталсан байна. Артел бол үйлдвэрийн хоршооллын үндсэн байгууллага бөгөөд түүний бүх хөрөнгө нь тус артелийн хамтын өмч байна.

Гишүүд орон байр суурь машин, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл зэрэг үйлдвэрийн хэрэгслийг сайн дурын үндсэн дээр артелийн бүх гишүүдийн хурлын шийдвэрээр нийгэмчилж байв.

1990-ээд оны үед монголд ардчилал гарч, 1992 оны МУ-н шинэ үндсэн хууль гарч, эх орондоо хүмүүнлэг иргэний ардчилсан нийгмийн цогцлон хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно гэж заасан билээ.

Үндсэн хуулийн энэ тунхаглал манай нийгмийн зохион байгуулалт оюун санаа, эдийн засаг, улс төрийн амьдралын бүхий л хугацааны хуучин зарчим болох нийгмийн нэг төрөл байдлыг эрмэлзсэн хамт олонч зохион байгуулалт, нэг үзэл суртал, нэгдмэл үзэл санаа, нийгмийн өмч, нийгмийн ашиг сонирхол, нэг намын удирдлагын нэгдмэл үзэл санаа, нийгмийн өмч, нийгмийн ашиг сонирхол, нэг намын удирдлагын үзэл суртлыг халж чадсан юм. Төрийн оролцоо хоршоонд нөлөөлөх нь багасаж үүнийг дагаад олон жилийн турш удирдуулж байсан хоршоо огцом уналтанд орсон байна.

1995-05-16 өдөр Хоршооны хууль батлагдан гарч үйл ажиллагаа дахин дорвитой явуулах боломж нээгдэж, тухайн цаг үеийн хөнжил, өөрчлөлттэй хамаарч нэмэлт өөрчлөлтүүд орсоор байлаа.

Ийнхүү МУ-д хоршооллын байгууллага үүсэж хөгжсөн бөгөөд өнөөгийн түвшингээс эргэн харахад олсон ололт, алдаа аль аль нь байсан.

Магистар М.Наранцэцэг ололт нь: " Хоршоо нь байгуулагдсанаар түүний эрх зүйн байдал, хөрөнгөө өмчлөх, захиран зарцуулах, гэрээ-эрх зүйн болон бусад аж ахуйн хөрилцаанд оролцохдоо эрх эдэлж, үүрэг хүлээх талаар төрөөс олон тооны эрхм зүйн байр суурь эзлэх болсон нь нэг ойлголт гэж үзэж байна.

Алдаа нь : МАХН-н баримт бичиг, төр засгийн хууль тогтоомжинд ард түмнийг сайн дурын үндсэн дээр хоршоонд нэгтгэнэ гэсэн заалт байв. Гэтэл амьдралд хоршоо холбоонд элсэн орохыг албадах, айлгах, айлгах, сүрдүүлэх зэрэг, захиргааны аргыг хэрэглэх явдал ихэнх нутагт гарч байснаас иргэд эд хөрөнгөө нуух, малаа зарах, нядлах бусдын нэр доор тоолуулах зэрэг сөрөг үр дагавар бий болгож байв.

Тухайн үед төр засгаас ардын аж ахуйтны малыг нийгэмчлж хоршоолсоноор иргэний өөрийн хөрөнгөө бүрэн хэмжээгээр өмчилж захиран зарцуулах эрхийг хязгаарласнаас болж мал сүргээ өсгөн нэмэгдүүлэх сонирхол% идэвхи санаачлага буурсан нь манай улсын малын тоо толгойг өсөн нэмэгдүүлэхэд саад учруулж

Ийнхүү манай улсад хоршооллын байгууллага нь 1921 оны Ардын хувьсгал ялсанаас хойш өөрийн гэсэн түүхэн үе шаттайгаар хөгжиж иржээ.

Монгол улсын хувьд хоршооллын үүсэл, хөгжлийг нэгтгэн авч үзвэл:

- Ардын хувьсгал ялсаны дараа буюу 1921 онд анх хоршооны дүрмийг баталсанаар мөн оны анхны эд хэрэглэгчдийн хоршоо үүссэн байна
- 1931 онд анхны гар үйлдвэрлэлийн хоршоолол үйл ажиллагаа явуулж эхэлсэн
- 1959 оноос Хөдөө аж ахуйн хоршооллын суурь тавигдсан
- 1986 оноос хөдөлмөрөө хорших үндсэн дээр анхны хөдөлмөрийн нөхөрлөлүүд байгуулагдан үйлдвэрлэл үйлчилгээний хоршоо үүссэн.
- 1996 оноос Хадгаламж зээлийн хоршоо хэлбэрийн анхны хөдөлгөөн өрнөж төрийн бус байгууллагын санаачлагаар үүссэн байна.
- Олон улсад хоршооны дараах төрлүүд байдаг. Үүнд :
 - о Анхдагч хоршоо
 - о Дундад хоршоо
 - о Хоршооны холбоод г.м үндсэн хэлбэрүүд байдаг. Хоршоог үйл ажиллагааны чиглэлээр дараах байдлаар ангилж болно. Үүнд
 - Үйлдвэрийн буюу хөдөлмөрийн хэлбэр
 - Үйлчлэн зуучлах зэрэг болно. Энэ хүрээнд хоршооны дараах хэлбэрүүд байна. Үүнд :
 - Эд хэрэглэгчийн хоршоо
 - Түүхий эд боловсруулалтын хоршоо
 - Үйлдвэрийн хоршоо

- Хангамж нэгтгэн нийлүүлэлтийн хоршоо
- Борлуулалтын хоршоо
- Үйлчилгээний хоршоо
- Хөдөө аж ахуйн хоршоо
- Хадгаламж зээлийн хоршоо
- Даатгалын хоршоо
- Харилцан туслалцах хоршоо
- Орон сууцны хоршоо
- Ажилчны хоршоо
- Олон төрөлт хоршоо
- Бүрэн хоршоо зэрэг болно

Манай улсын хувьд 1995 оны Хоршооны тухай хуулинд

- Анхан шатны хоршоо
- Дундад хоршоо
- Хоршоодын холбоо 12 гэсэн хэлбэртэй байж болохоор, мөн хуулийн 5-р зүйлийн нэгд хоршоо нь үйлдвэрлэлийн, үйлчилгээний, хэрэглэгчдийн гэсэн үндс эн төрөлтэй байна. 5-р зүйлийн 2-д Хоршоо нь үйл ажиллагааныхаа чиглэлээр

- Хөдөө аж ахуйн ханган борлуулах
- Мал аж ахуйн
- Түүхий эд боловсруулах
- Газар тариалангийн
- Эд хэрэглэгчдийн
- Аж үйлдвэрлэлийн
- Ахуйн үйлчилгээний
- Гар урчуудын
- Ажиллах хүчний
- Мөнгөн хадгаламж зээлийн
- Даатгалын
- Орон сууцны
- Тээврийн
- Эрчим хүчний
- Барилгын
- Соёл, боловсрол
- Эмнэлэг, эрүүл ахуйн үйлчилгээний зэрэг болон эдгээрийн хосолмол хэлбэртэй байж болно

гэж заасан байна. Харин 1998 оны хоршооны тухай хуулийн 3.2-д

- 1.2.1 түүхий эдийн
- 1.2.2 үйлдвэрлэлийн
- 1.2.3 хадгаламж зээлийн
- 1.2.4 боловсруулалт, хангамж, бэлтгэл нийлүүлэлтийн
- 1.2.5 үйлчилгээний
- 1.2.6 орон сууц барих зориулалтын
- 1.2.7 эд хэрэглэгчдийн
- 1.2.8 бусад 13 гэж тус бүрээр нь тодорхой зааж өгсөн бол хоршоон тухай хуулийн 3.5-р зүйлийн 2002-12-12-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр” ... хэд хэдэн төрийн үйл ажиллагааг нэгэн зэрэг эрлэх”¹⁴ – ийг зөвшөөрсөн байна. Өөрөөр хэлбэл өнөөдрийн хоршоонд олон төрлийн үйл ажиллагааг эрхлэхийг зөвшөөрсөн байгаа юм.

Олон улсын хоршоодын хөдөлгөөн

XIX зууны сүүлчээр капиталист орнуудад баян хоосны ялгааих гарч орлогын хомсдол бий болсон үеэс эхлэн аж үйлдвэржсэн орнуудад худалдаа, хангамж, зээлийн салбарт ядуувтар хэсгийн хүрээнд хоршоо үүссэн байна.

XIX зууны сүүлчийн хагаст хойд Англи, Шотландад үйлдвэржсэн, уурхай ихтэй нутагт хоршоо үүссэн. Түүний дараагаар Англи даяар Франц, Шведэд тэр дундаа хот суурин газар, Норвеги, Дани, Недерланд, Финландын хөдөө нутагт дэлгэрсэн гэдэг. XIX-ээр зуунаас эхээр Америкт хэрэглэгчдийн ба хөдөө аж ахуйн зээлийн хоршоо эхлэн хөгжиж нийтдээ өргөн дэлгэр болсон. Латин Америкийн орнуудад XX –р зууны эхэн үеэр цагаачид голчлон хоршоог үүсгэсэн гэж үздэг. Ази Африкийн хөгжиж буй орнуудад XIX-р зууны сүүлч XX-р зууны эхэн үеэр хөдөө аж ахуйн хоршоо үүссэн байна.

1. Англи

XVIII-р зуунд Англид гарсан аж үйлдвэрийн хувьсгал нь хөдөлмөрчин хүмүүсийн ахуйн амьдралыг доройтуулж, хүнсний өгрөм хэрэглээний бараа таваарын хомсдол үүссэн байна. Мөн хөдөө аж ахуйг хөгжүүлэх асуудлыг орхигдуулснаас болж цалин хөлс нь өндөр үнэтэй өөрийн хэрэгцээний хүнс болон бараа бүтээгдэхүүнийг худалдан авч чадахаа больжээ.

Ийм нөхцөлд 1844 онд Манчестр хотын хэсэг ажилчид сайн дураараа нэгдэн хоршоо гэгчийг анх санаачлан байгуулж түүгээрээ дамжуулан өргөн хэрэгцээний бараагаар өөрсдийг хэрэгцээг хангахаас гадна худалдан авсан хэмжээгээр ашгаас хүртэх боломжтой. Болсон байна. Дэлхийд анхны хоршоог байгуулсан эдгээр 28-н ажилчид "Рочдел"-ийн пионерууд гэж дэлхийд алдаршин, тэдний байгуулсан хоршооллын дүрэм, журам нь үеийн үед хоршооллыг гол үндэс зарчмын суурь болсноор иржээ. Дэлхийд Рочделийн зарчим гэж алдаршсан бөгөөд тэр цагаас хойг хэрэглэгчдийн хоршоолол гэлэг нэрээр баруун Европ төдийгүй олон оронд дэлгэрч хөгжсөөр ирсэн байна.

2. Франц

1789-онд Францын хөрөнгөтний хувьсгал федлын нийгмийн харилцааны үндсийг эвдэж улмаар төр улс, эдийн засаг, соёл амралтын хөгжилд чөлөөт байдлыг бий болгожээ. Аж үйлдвэрийг үүсгэн байгуулах явцад хөрөнгө хөдөлмөрөөрөө хорших хуучин тогтолцоо, зохион байгуулалт өөрчлөгдөж, ингэсний үр дүнд хөдөлмөрчид хохирч ажил олж хийхэд бэрх болж, хөдөлмөрийн хөлс буурч байсан энэ нөхцөлд социал-демократуудаар удирдуулсан францын хэсэг ажилчид үйлдвэрлэлийн жижиг хоршоодыг биеэ даан байгуулсан байна. Францын ажилчдын энэ санаачлага нь үйлдвэрлэл үйлчилгээгний хоршооллыг эхлэлийг тавьжээ.

3. Герман

XIX зууны II хагаст Германд мөнгө хүүлэгчдэд мөлжигдөж байсан тариачдын аж амьдрал, хөдөлмөрийн нөхцөл эрс хүндэрч, зээл авах бололцоогүй болж, хөдөө аж ахуйг хөгжүүлэх үйлдвэрийг өргөжүүлэх явц бэрхшээлд орсон байна. Тэр үеийн Германы эдийн засгийн болон философид энэ нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж үзээд зээлийн ашигтай шинэ систем боловсруулсан нь эдүгээ "Райфшцзений зээлийн хоршооны систем" хэмээн дэлхий даяараа алдаршсан олон улсын хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэхэд одоог хүртэл амжилттай хэрэгжиж буй систем юм. Зээлийн хоршоо нь ийнхүү одоогоос 150 гаруй жилийн тэртээ Германы Делитц хотын дарга Херман Шульцийн санаачлагаар үүссэн түүхтэй.

Баян хүмүүсийн мөнгийг татаж чадах өндөр хүүтэй, элсэлтийн татдар ихтэй 1000 гаруй зээлийн байгууллагыг байгуулж мөнгөний хэрэгцээтэй хүмүүст зээл олгодог байв. Яг тэр үед Германы нөгөө хэсэгт Фламерсфельд хотын дарга Вильям Райзайзен гуйлагчлалд орсон хүмүүст туслах оролдлого хийж байжээ. Үүнийг тодруулбал:

1. Зөвхөн зээлийн нийгэмлэгийн гишүүд л түүнээс зээл авч болно.
2. Зээлийг зөвхөн тооцоо судалгаатай бүтээлч зориулалтанд олгоно.
3. Тухайн хүний хүн чанар зээлийн хамгийн чухал баталгаа байна.

гэсэн зарчмыг баримталж байжээ. В.Райфайзен, Х.Шульц нар хоршооллын хөдөлгөөнийг үүсгэх, хоршооллын философийн зарчмыг бий болгоход маш чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Анхны зээлийн нийгэмлэг 1869 онд байгуулагдсан. Энэ нь цааш улам бүр хөгжсөөр Европ, хойд Америкт нэвтэрч 1901 онд АНУ-ын иргэн Альфонс Десжардинс гэдэг хүн анхны зээлийн хоршоог Хойд Америкт байгуулах санааг сэдэн 1909 он гэхэд олноор байгуулсан байлаа.

Хоршооллын хөдөлгөөн бусад улс оронд

XIX зууны эцэс XX –р зууны эхэн үед бие биедээ харилцан туслах буюу нийтийн болон м эргэжлийн үйлчилгээний чиглэлээр үүсэн бий болгосон хөдөө аж ахуйн хоршоод нь газрын шинэтгэлээс эхлээд өнөөгийн хөдөө аж ахуйн эрэн үед ч гэсэн зохих үүргийг гүйцэтгэсээр байна.

Ийнхүү бүтэн хагас зуун жил дотор хоршооллын хөдөлгөөн дэлхийн бараг бүх оронд түгэн дэлгэрч улам боловсронгуй болсоори олон улсын хэмжээний түвшинд хүрч ажилллаж байна.

Гагцхүү тухайн улс орны эдийн засгийн амьдрал хоршооллын хөдөлгөөн эдлэх байр суурь, гүйцэтгэх үүрэг л харилцан адилгүй байна. 1912 онд Англи-Энэтхэгийн хоршооны холимог модель бий болж хоршооны боловсорлыг төрөөс зохион байгуулан хоршооны комиссаруудыг бий болгон тэд хоршоологчдын сургалтын үйл ажилллагааг зохион байгуулж эхэлсэн байна.

Хоршооллын хөдөлгөөн нь улс орон тивийн хүрэнээс хальж 1895 онд Лондон, ОУ-ын хоршооллын байгууллага буюу Альянсийг байгуулжээ. /international Co-operative Alliance/. Уг байгууллагад Австрали, АНУ, Их Британи, Франц, Энэтхэг, Дани зэрэг улсаас гадна Орос Унгар 2 ажиглагчаар бүгд 14 орон оролцсон анхны конгресс болсон байна.

Олон улсын хоршооны альянс нь 100 гаруй орон, олон улсын 9, үндэсттэний 22 байгууллага болон монголын малчин америкийн тариачин, японы загасчин, хятадын нэхмэлчин зэрэг 800 сая гишүүнийг эгнээндээ нэгтгэж чадсан байна.

Герман улсын хадгаламж зээлийн хоршооны байгууллага болох ардын банк, Райффайзын банк, түүний салбарууд л гэхэд 30 сая үйлчлэгчтэй, 440 тэр бум дойч маркийн хөрөнгөтэй байна.

Канад хүн амын 49% АНУ-н 35% нь хадгаламж зээлийн хоршоонд хамрагдсан байна. Канадад үндэстний хуритлалын 15% нь хадгаламж зээлийн хоршооны мэдэлд байдаг байна. Хоршоо нь өөрийн хүчинд тулгуурлан үйл ажиллагаа явуулж өөрийгөө санхүүжүүлдэг байгууллага юм. НҮБ нь дараах чиглэлээр хоршоог дүгнэж байна.

1. Ажлын байрыг бий болгох, ядуурлыг бууруулах
2. Эдийн засаг, үр ашиг чадавхийг дээшлүүлэх
3. Нийгмийн тогтвортой байдал ардчиллыг бэхжүүлэх
4. Хүрээлэн буй орчныг зүй зохистой ашиглах
5. Нийгмийн тогтолцооны тогтвортой байдлыг хангах
6. Нийгэмд эмэгтэйчүүдийн оролцох үүрэг оролцоог нэмэгдүүлэх
7. Хүний нөөцийг хөгжүүлэхэд чухал гэж үзжээ

Олон улсын хоршооны альянс/ОУХА/

ОУХА 1946 онд НҮБ – ын зөвлөх статус бүхий анхны засгийн багууллага болсон. ОУХА-ын байгууллага нь дараах зарчмыг удирдлага болгодог

1. Өөрийн үйл ажиллагаандаа хоршооллын зарчмыг мөрдлөг болгодог бүх төрлийн хоршооллын байгууллагыг дэлхийд төлөөлөх
2. Хоршооллын зарчим арга ажиллагаагм дэлхийн давцанд суртчилах
3. Хоршооллын хөдөлгөөний ашиг сонирхол түүхий бүх хэлбэрээр хамгаалах
4. Бүх дэлхийд хоршооллыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх
5. Өөрийн бүрэлдэхүүнд байгаа байгууллагуудын хоорондын найрамдалт харилцааг дэмжих
6. Бүх төрлийн хоршооллын байгууллагуудын эдийн засгийн харилцааг үндэсний болон олон улсын хэмжээнд хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх
7. Бүх орнуудын ард түмний эдийн засаг нийгмийн дэвшилт өөрийн хувь нэмрийг оруулах
8. Бат бэх энх тайван, аюулгүй байдлыг тогтооход дэмжлэг үзүүлэх

Альянсыг удирдах байгууллага нь Конгресс, төр хороо гүйцэтгэх хороо нарийн бичгийн дарга нар байдаг. Жилд 2-с доошгүй явагддаг конгресс нь Альянсыг удирдах дээд байгууллага мөн бөгөөд Альянсийн бодлого чиглэлийг тодорхойлох, үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг боловсруулах болон дүрмийг батлах, өөрчлөх зэрэг асуудлыг шийдвэрлэдэг байна.

Альянс нь эдийн засгийн зорилго чиглэлтэй олон улсын байгууллагатай харилцан холбоотой ажилладаг.

Олон улсын хөдөлмөрийн байгууллага/ОУХБ/

2001 оны 7 сард Женев хотноо ОУ-н хөдөлмөрийн 89-р бага хурал хоршооны хөгжлийн асуудлаар хурамлсан. Уг бага хурал дэлхийн засгийн газар, эзэд, хоршоологчид, үйлдвэрчний байгууллагын төлөөлөгчид оролцжээ.

Хөгжлийн түвшингээс нь үл шалтгаалж

1. Шинэ уян хатан ажлын байр бий болгон орлогын эх үүсвэрийг бий болгох
2. Хүмүүсийн хоршооны үнэт зүйлсийн талаархи боловсрол мэдлэгийг хөгжүүлэх
3. Зах зээлийн сүлжээнд ороход нь санхүүгийн тусламж үзүүлэх
4. Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх
5. Ялгаварлан гадуурхах аливаа үзлийг хангах, нийгэм эдийн засгийн тааламжтай байдлыг нэмэгдүүлэх ёстой гэж үзсэн байна.

Хоршооны хөгжлийн долоон зарчим буюу манчестрийн тунхаглал

Хоршооны үйл ажиллагаа явуулахдаа мөрдлөг болгон хэрэглэдэг удирдамжуудыг хоршооны зарчим гэж ойлгож болох юм.

1. Сайн дурын нээлттэй гишүүнчлэл

Хоршоо нь арьс өнгө, нас хүйс, нийгмийн гарал үүсэл, улс төрийн үзэл бодол шашин шүтлэг ялгаварлахгүйгээр үйлчилгээнд нь хамрагдахыг хүссэн гишүүнчлэлийн хариуцлагыг хүлээн зөвшөөрсөн хүмүүст нээлттэй сайн дурын байгуулга юм.

2. Гишүүдийн ардчилсан хяналт

Хоршоо нь шийдвэр гаргах, бодлого боловсруулалт идэвхтэй оролцогч гишүүдээрээ хянуулсан ардчилсан байгуулга юм.

3. Гишүүдийн эдийн засгийн оролцоо

Гишүүд нь хоршооныхоо хөрөнгийг бүрдүүлэх, хянахад тэгш оролцоно. Гишүүд нь хөрөнгөө дараах зорилгоор хувааж болно.

Үл хуваагдах нөөц бүрдүүлж хоршоогоо хөгжүүлэх, хоршоотойгоо хамтарч ажилласан байдлаар нь гишүүддээ ногдол орлого хувиарлах, гишүүдийн зөвшөөрсөн үйл ажиллагааг санхүүжүүлэх гэх мэт.

4. Бие даасан байдал

Хоршоо нь бие даасан, гишүүдээрээ хянуулдаг , өөрөө өөрийгөө тэтгэх байгуулага юм. Хоршоо бусад байгуулагатай адил эрх тэгш эрхтэй гэрээ хэлцэл байгуулах, гадныы эх үүсвэрээр сан хөрөнгөө өсгөх эрх эдэлнэ. Энэ үйл ажиллагаандаа хоршоо нь гишүүдийнхээ оролцоо, ардчилсан хяналтыг хяналтыг бие даасан байдлаа хангана.

5. Боловсрол, сургалт мэдээлэл

Хоршоо өөрийгөө хөгжүүлэхэд үр бүтээлтэй хувь нэмэр оруулж чадах идэвхитэй гишүүд, сонгогдсон төлөөлөгч, менежрүүд, ажилтнууд болон гишүүд , тэдний үр хүүхдийг сургалтанд хамруулж мэргэжил боловсролыг нь дээшлүүлнэ. Хоршоод идэвхтэнүүддээ мэдээлэл өгч байна.

6. Хоршоод хоорондын хамтын ажиллгаа

Хоршоод нь бүс нутаг, үндэсний болон улсын түвшинд хатран ажилсанаар гишүүддээ илүү сайн үйлчилгээг үзүүлж хоршооллыг хөдөлгөөнийг бэхжүүлнэ.

7. Нийгмийн төлөө хангамж

Гишүүдийн хэрэгцээ хүслийг хангахын төлөө ажиллахын зэрэгцээ хоршоод нь өөрийн орон нутгийн тогтвортой хөгжлийн төлөө ажилладаг.